

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

ХУУЛЬ БОЛОВСРУУЛАГЧ, ТОГТООГЧДОД ЗОРИУЛСАН

Г А Р Ы Н А В Л А Г А



Их Британи, Умард Ирландын
Нэгдсэн Вант Улсын Элчин
Сайдын Яам



“Глоб Интернэшнл” ТББ

Улаанбаатар хот
2009 он

Энэхүү гарын авлагыг “Мэдээлэл авах боломжийг сайжруулан
авилгатай тэмцэх нь” төслийн хүрээнд эрхлэн гаргав.

Гарын авлагыг бэлтгэж, хэвлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Монгол
Улс дахь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Элчин
сайдын яаманд талархал илэрхийлье.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг VI хороо,
Эрх чөлөөний талбай, Дипломат 95 цогцолбор,
Ш/х: 211238-102

Утас: 976-11-324627, 976-11-324764

Утас/факс: 976-11-315326

Э-шуудан: globe@globeinter.org.mn,
hnaran@globeinter.org.mn,
burnee@globeinter.org.mn

Вэб: www.globeinter.org.mn, www.monitoring.mn

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	10
МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ: МАНАЙ АМЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	10
ХОЁРДУГААР БҮЛЭГ	19
ГАРЫН АВЛАГАД АШИГЛАСАН НЭР ТОМЬЁО	19
ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ: МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ЗАРЧМУУД	20
МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ЗАГВАР ХУУЛЬ	30
ЙОХАННЕСБУРГИЙН ЗАРЧМУУД: ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ, МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ	49
МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ	57
МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ЕВРОПЫН ХОЛБОО	57
ГУРАВДУГААР БҮЛЭГ. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ТӨРИЙН НУУЦ	94
1. " ТӨРИЙН НУУЦ БА МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ" ХУУЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН	94
2. "ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ НӨХЦӨЛ БОЛОМЖ" СУДАЛГААНЫ ТАЙЛАН	128
3. "ӨӨРЧЛӨЛТӨД ДУУДАХ НЬ" УРИАЛГА	141

ӨМНӨХ ҮГ

Уншигч таны амрыг эрж, энэхүү гарын авлагыг толилуулж байгаадаа бид баяртай байна.

Монголчууд урьд өмнө иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төрдөө үйлчилдэг захиргаадалтын нийгэмд аж төрж байлаа. Одоо бид төр нь иргэддээ үйлчилдэг, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь иргэддээ үйлчилж, төр, засгийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг ардчилсан тогтолцоонд амьдрах болжээ.

Иргэд өөрсдөө ардчилсан сонгуулиар төрөө бүрдүүлж, бидний сонгосон төр иргэдийн улс төр, эдийн засаг, нийгмийн эрхийг хангаж, Засгийн газраа томилон түүнд ард түмнийхээ аз жаргалтай, сэтгэл хангалуун, элбэг баян амьдрах хамгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх үүрэг ногдуулдаг. Иргэд мөн төр, засгийн газар, түүний бүтцийн байгууллагуудыг хувийнхаа халааснаас санхүүжүүлдэг.

Энэ нь иргэдэд төр, засаг амласнаа аль хэр биелүүлж байна, бидний мөнгөнөөс бүрдэж буй төсвөө аль хэр үр ашигтай зарцуулж байна гэдэгт хяналт тавих хууль ёсны эрх олгож байгаа билээ. Мэдээлэлгүйгээр ийм хяналт тавих аргагүй.

Мэдээллийг ардчиллын хүчилтөрөгч гэдэг. Иймд иргэд мэдэх эрхтэй. Олон нийт нь хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага зэрэг иргэний нийгмийн байгууламжуудаар дамжуулан хяналтаа хэрэгжүүлнэ. Энэ байгууламжууд хүчирхэг бус, үйл ажиллагаа явуулах нөхцөл орчин нь таагүй, хязгаарлагдмал бол хариуцлагатай байж чадахгүй, эсвэл буруу ташаа арга зам эрэлхийлэхэд хүрнэ. Иргэний нийгэм төлөвшөн хүчирхэгжих хөрс үгүй бол ардчилал эрүүл саруул байж үл чадна. Мэдээллийн эрх чөлөө хууль ёсоор баталгаажсан цагт бид зохих ёсоор хяналтаа тавих боломжтой болно.

Лондон хотноо төвтэй "Хөгжлийн Ухамсрын Сан" хэмээх олон улсын байгууллагын шинжээчид эдийн засгийн хүндрэл бэрхшээл нь иргэдийнхээ улс төрийн эрх чөлөөг хангах талаар амжилт олж чадаагүйтэй холбоотой гэж нотолж байна. Засгийн газрын ил тод байдал хангагдаагүй, улс төрийн хариуцлага сул, иргэдийнхээ улс төрийн бүх эрхийг адил тэгш хангаагүй нөхцөлд эдийн засгийн хөгжил тогтвортой байж чадахгүй гэж тэд үзэж байна.

Монгол улс 1992 онд батлагдсан Үндсэн хуулиндаа хүний эрхийг хуульчлан дээдэлж, нийгэмд хэвлэл мэдээллийн чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрснөөр хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн тогтолцоо бий болж, чөлөөт хэвлэлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг шинэчлэгдэж байгаа билээ.

Иргэдийн эрх ашгийг хамгаалах, нийгэмд үйлчлэх чиг үүрэг бүхий олон тооны төрийн бус байгууллага байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй нь Монгол дахь ардчиллын томоохон ололт юм.

1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдаж, цагдан хяналтыг (цензур) хориглож, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төр өмчлөх эрхийг хязгаарлан Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон нь чухал алхам болсон юм.

Хэвлэл мэдээлэл улам хөгжиж, иргэний нийгэм, олон нийтийг мэдээллээр хангаж, төр, засгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ жинхэнэ ёсоор биелүүлэх гол нөхцөл болсон эрх зүйн механизм, эдийн засгийн орчин хангалттай бус байна. Хэвлэл

мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодруулан баталгаажуулсан хэдий ч заалтууд нь хэрэгжихгүй байгаа нь өмнөхөөсөө ухарсан мэт зөрчилтэй байгаа юм. Энэ нь иргэдийн мэдээлэл хүртэх, олж авах эрх нь амьдрал дээр туйлын тодорхойгүй, захиргааны үзэмжээр шийдвэрлэх хэмжээнд байгааг нотолж байна.

Төрийн бус байгууллагын тухай хууль 1995 оноос үйлчилж эхэлсэн ч төр, засаг, бизнесийн хүрээний байгууллагуудаас ТББ-ыг дэмжих эдийн засаг, эрх зүйн механизм алга байна. Татварын тухай хуулиас нийгэм, соёлын арга хэмжээг дэмжихэд татварын хөнгөлөлт үзүүлдэг чухал заалтыг хассан нь санхүүгийн чадавхи сул төрийн бус байгууллагуудад сөрөг нөлөө үзүүлэхүйц буруу шийдвэр болсон юм.

"Глоб Интернэшнл" төрийн бус байгууллагаас 2001 онд Будапешт дахь Олон улсын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Хэвлэл мэдээллийн хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн "Хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн шинэтгэл" төслийн хүрээнд Монгол улсад үйлчилж буй хууль тогтоомжид судалгаа хийсэн юм. Энэ судалгаанд гол төлөв үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн байгууллагын ашиг сонирхолтой шууд холбоотой заалтуудыг түүвэрлэн нягтлан үзсэн юм. Судалгаа хийсэн 230 гаруй хуулийн 91-д нь хэвлэл мэдээлэлтэй шууд холбоотой заалтууд оржээ. Эдгээрээс 51 хуулийн зарим заалтын илүү хязгаарлалтыг халахуйц өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн юм. Энэхүү тайланд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Лондон хотноо төвтэй "19-р зүйл" (ARTICLE 19) байгууллагын шинжээчид дүн шинжилгээ хийж, "Шилжилтийн үеийн Монгол Улс. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөндсөн Монгол Улсын хуулиуд" хэмээх бүрэн тайлан гаргасан юм.

Мэдээллийн эрх чөлөө гэдэгт бид хоорондоо нягт холбоотой бүлэг (хэсэг) эрх, эрх чөлөөг хамруулан ойлгодог. Ардчиллыг бэхжүүлэхэд мэдээллийн эрх чөлөө хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Олон нийтэд үйлчилдэг байгууллагын мэдээлэл бол улс төрч, албан тушаалтнуудын тусын тулд бус харин олон нийтийн ашиг сонирхолд зориулагдсан юм. Мэдээллийг нууцлах чухал шаардлага үндэслэл байсан ч түүнийг хүн бүр олж авах, хүртэх боломжтой байх нь зүйтэй. Хамгийн чухал нь, мэдээллийн эрх чөлөө бол хариуцлага хүлээх чадвартай, ил тод Засгийн газрын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэ нь иргэдэд Засгийн газрын явуулж байгаа үйл ажиллагаа, авлигыг илрүүлэх, удирдлагын алдаатай ажлыг харах боломж олгоход голлох үүрэг гүйцэтгэнэ. Засгийн газар нээлттэй байх нь сонгогчид сонгуульт албан тушаалтныхаа үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд зайлшгүй шаардлагатай. Мөн шинэ бодлогын эсрэг тухай бүр эсэргүүцлээ илэрхийлэх жишээгээр ард иргэдэд өөрийн ардчилсан эрхийг үр өгөөжтэй эдлэхэд ч чухал билээ.

Улс орнуудад хууль тогтоомжоор дамжуулан мэдээллийн эрх чөлөөний эрхийг хангах талаар бодитой алхам хийх үүрэг хариуцлагыг төр өөрөө хүлээх нь нэмэгдэж байна. Үндсэн хуулийн заалтаар мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулж байгаа нь ард нийт өөрийн хүсэлтээр эрх мэдэлтнүүдийг сонгодог, ардчилсан үйл явцын хэвийн бөгөөд зохих хэм хэмжээ гэж үзэх улс төрийн соёлыг эрхэмлэх эрмэлзлэл юм. Мэдээлэл олж авах тухай хууль тогтоомж Үндсэн хуулийн заалтыг илүү баталгаажуулдаг. Ийм хууль үгүй бол чухамхүү яагаад мэдээллээ нууцалж буй үндэслэлээ Засгийн газар тодруулах шаардлагатай болдог ажээ. Энэ нь эргээд Засгийн газар өөртөө хариуцлага ногдуулж буй хэрэг юм. Унгар, Болгар, Орос, Чех, Албани, Эстони, Польш, Украин, Латви, Молдав, тэр бүү хэл хэвлэл мэдээллийн эрх чөлөө туйлын хязгаарлагдмалд тооцогддог

Кыргыз, Узбек улс гэх мэт Монголтой адил ардчиллын шилжилтийн явцад байгаа улс орон бүгд мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан хуультай болжээ. Зөвхөн Монгол улсад одоогоор ийм хууль алга байна.

Манай улс Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын үзэл санааг хүлээн зөвшөөрдөг. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, Хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын Пактад нэгдэн орсон юм. Үүгээрээ Монгол улс дээрх чухал баримт бичгийн хүний эрх, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой заалтуудыг дагаж мөрдөнө гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна.

Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай олон улсын Пактын 19-р зүйлд үзэл бодлоо хөндлөнгийн оролцоогүйгээр илэрхийлэх эрхийг дараах байдлаар тунхагласан байдаг. Тухайлбал:

1. Хүн бүр өөрийн үзэл бодлыг чөлөөтэй хөндлөнгийн шахалтгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаар үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
3. Энэхүү зүйлийн 2-т дурьдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлагыг ногдуулна. Энэ нь гагцхүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэдгээр нь:
 - а. Бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх
 - б. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалах зайлшгүй шаардлага

Манай Улс Үндсэн хуульдаа иргэдийнхээ "Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг" баталгаажуулсан байдаг. Мөн "иргэд төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй" гэсэн байна. Харин мэдээлэл хүртэх, олж авах эрх аль ч хуульд баталгаажаагүй байгаа билээ. Мөн манай Үндсэн хуулинд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг олон улсын баримт бичгүүдэд заасанчлан "хэвлэл мэдээллээр болон хил хязгаар үл хамааран" хангах тухай хамгийн чухал заалт орхигдсон байна.

Монгол улс Үндсэн хуулийнхаа 10-р зүйлийн 2-т "Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударга сахин биелүүлнэ", мөн зүйлийн 3-т "Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн нь одоогоор Монголын хуульд ороогүй байгаа мэдээллийн эрх чөлөөний талаарх олон улсын гэрээний заалтууд манай хуулийн хийдлийг нөхөх боломжтой гэсэн үг юм. Гэсэн ч амьдрал дээр, шүүхийн практикт дээрх заалтууд хэрэгждэггүй билээ.

Дээр дурьдсанчлан, манай улс нэгэнт гарын үсэг зурж, нэгдэн орсон эдгээр олон улсын баримт бичгийн заалтуудыг мөрдөх ёстой бөгөөд иргэдийнхээ суурь эрхийн талаар гагцхүү нарийн чанд, зайлшгүй л хязгаарлалт тавьж болох юм. Үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөө нь хүний суурь эрхийн нэг болохыг олон улсын баримт бичгүүдэд нотолсон байдаг. Гэтэл манай хуулиудын заалт хэтэрхий өргөн хүрээтэй үйлчилдэг нь харамсалтай.

Манай улс нууцыг 4 түвшинд хамгаалсан байна.

1. 1995 онд баталсан Төрийн нууцын тухай хуулиар хязгаарлалт тогтоосон байна. Уг хуулийн 5 дугаар зүйлд "улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээ, баримт бичиг, бусад зүйлийн нууцалбал зохих хэсэг", "гадаад бодлого, байр суурьтай холбоотой түүнчлэн Монгол улсаас, гадаад орнуудтай байгуулсан нууцалбал зохих гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төсөл"-ийг төрийн нууцад хамааруулахаар тодорхойлжээ. Төрийн нууцын жагсаалтын тухай хуулиар нийт 59 зүйлийг нууцлан хамгаалахаар баталжээ.

2. Иргэдийн хүний эрхийг баталгаажуулахтай холбогдуулан хувь хүний нууцыг 1995 онд батлагдсан "Хувь хүний нууцын тухай хуулиар" хамгаалсан байна. Энэ хуулийн 2, 3-р зүйлд тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг "хувь хүний нууц гэнэ" гээд нууцын төрлийг захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн гэж тодорхойлжээ. Авилгын эсрэг хуулийн 11.1 "Хөрөнгө, орлогын мэдүүлэг хувь хүний нууцад хамаарна" гэсэн бөгөөд ил болгох асуудлыг Хувийн нууцын тухай хуулиар зохицуулах юм байна.

Хувийн нууцыг хамгаалах асуудлыг үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөтэй сөргүүлэн тавихдаа олон нийтийн эрх ашгийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүлээсэн үүргийг харгалзан тэнцвэржүүлэх хэрэгтэй юм. Ардчилсан орны улс төр, олон нийтийн зүтгэлтнүүд өөрийнх нь хувийн нууцад жирийн хүмүүсийнхээс илүү халдана, албан тушаал нь өндөр, чухал байхын хэрээр шүүмжлэл, мэдээлэлд илүү ихээр өртөнө гэдгийг хүлээн зөвшөөрдөг байна.

Нэг талаас үзэл бодлын болон мэдээллийн эрх чөлөө, олон нийтийн мэдэх эрх, нөгөө талаас хувийн нууцын эрх хоёрыг дэнсэлж үзвэл нийгмийн хоточ нохой байх хэвлэлийн үүрэг илүү давуу болохыг Европын шүүх өөрийн зарчимд баримталдаг ажээ. Ардчилсан орнуудад сэтгүүлчид төр, засгийн газрын мэдээллийн санд буй, төрийн нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэлд нэвтрэх, үзэж танилцах хууль ёсны эрх эдэлдэг байна. Хувийн амьдралтай холбоотой мэдээллийн хувьд нийгмийн ач холбогдол бүхий мэдээлэл, өөрөөр хэлбэл, нийгэмд нэр хүндтэй хүмүүсийн тухай мэдээллийг олж авахыг хүмүүс илүү сонирхдог. Олон нийтийн шахалтаар бус, өөрсдийн сонголтоор удирдах албан тушаалд дэвшсэн хүмүүс нийгэмд өндөр байр суурь эзэлж, жирийн иргэдийг бодвол илүү хариуцлага хүлээдэг. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь олон нийтэд тэдний тухай мэдээллээр хангах, ажил хэргийг нь үнэлж дүгнэх боломж олгодог. Тийм ч учраас улс төрч, нийгмийн зүтгэлтэн, олны танил хүмүүсийн шүүмжлэлд өртөх хүрээ өргөн бөгөөд тэд үүнд тэвчээртэй хандах ёстой гэж олон улсын практикт үздэг. Гэхдээ мэдээлэл нь нийгэмд ач холбогдолтой, бодит үнэнд нийцсэн байх ёстойг бас харгалздаг юм.

3. Байгууллагын тухай хуульд "тухайн байгууллага өөрөө нууцын жагсаалтаа баталж мөрдөнө" гэсэн нь хамгийн энгийн мэдээллийг ч нууцад хамруулах боломжийг нээжээ.

4. Эрүүгийн хууль болон Геодези, зураг зүйн тухай хууль зэрэг зарим салбарын шинжтэй хууль тогтоомжид бас хязгаарлалтууд орсон байдаг.

Мэдээллийг чөлөөтэй хүртэх, хязгаарлалттай хүртэх гэсэн ардчиллын ерөнхий хоёр зарчмын үүднээс үзэхэд өнөөдөр манайд сэтгүүлч ч, жирийн иргэн ч аль нэг байгууллагаас хүссэн мэдээллээ олж авах боломжгүй байна. Харин хязгаарлалттай хүртэх зарчим хамгийн энгийн мэдээлэл олж авах төдийд л үйлчилж байгаа юм.

Энэ нь ялангуяа сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтийн өмнө "тэдний ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл түгээх"-ээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа юм. Хүний эрхийн тухай Олон улсын Пактуудад заасан шалгуураар нууцлах зүйлс улс орнуудад бий боловч түүнийг өргөсгөх буюу бүдүүвчлэх нь албан ёсны бүх мэдээллийг нууц гэж үзэхэд хүргэдэг. Энэ нь эрх зүйн сөрөг үр дагавартай байх нь тодорхой.

Ардчилсан улс орнуудад төр, засгийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл хүмүүст нээлттэй байх ёстой гэсэн зарчим баримталдаг.

Сэтгүүлчид бусад иргэдийн адил мэдээлэл олж авах эрхтэй бөгөөд мэдээллийн эх сурвалжаа нууцлах нь сэтгүүлчийн онцгой бөгөөд цорын ганц эрх юм. Үүнийг баталгаажуулсан хууль ч одоогоор Монгол улсад байхгүй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн мэдээлэл олж авах эрхийг хамгаалах, тэдний ашиг сонирхлыг дээдлэх талаар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг билээ. Энэ утгаар сэтгүүлч нь хувь хүнээс илүү үзэл бодлын эрх чөлөө эдэлдэг. Дэлхийн олон улсад мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах сэтгүүлчийн эрхийг дэмжиж хамгаалдаг байна. Австри, Франц, Герман, Швед зэрэг орон мэдээллийн эх сурвалжийн нууц байдлыг хамгаалах хатуу хуультай ажээ. Япон, Нигерийн шүүх эх сурвалжаа хамгаалахыг сэтгүүлчдэд зөвшөөрөхийн ач холбогдлыг тодорхой заасан байдаг. АНУ-д хэвлэл мэдээлэл, хувь хүмүүсийн эх сурвалжийн хамгаалалт өндөр түвшинд байдаг ажээ. Европын орнуудад сэтгүүлч саармаг мэдээ цацах нь багасч, шүүх ч тэднээс эх сурвалжийг нь албадан хэлүүлэхийг оролдох нь цөөрчээ. Ялангуяа эх сурвалжтай холбоотой асуудлаар шоронгоор сүрдүүлэх нь нэн ховор болсон байна.

Европын зөвлөл "Сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалжаа хамгаалах асуудал нь ардчилсан нийгэмд олон нийтийн хоточ нохой байх чухал үүргээ биелүүлэхэд нь хэвлэл мэдээлэлд боломж олгох үндсэн арга юм. Сэтгүүлчид эх сурвалжаа илчлэх албадлагад өртвөл олон нийтийн ашиг сонирхол бүхий хэрэг явдлын талаар мэдээлэл өгөх үүрэгт нь хүндрэл учирна. Иймд олон нийтийн болон хувь хүний ашиг сонирхол мухардмал шинжтэй болох нөхцөл байдал үүсч болзошгүй тул аливаа албадлагыг хязгаарлах ёстой" гэжээ. Эх сурвалжийн энэхүү хамгаалалтыг олон нийтийн ашиг сонирхол бүхий үйл явдал, хэрэг явдал, буруутай этгээд, буруутай үйлдлийг нотолсон, илчилсэн материалыг хэвлэл мэдээлэл ил тод болгох нь нийгэм эрүүл саруул байж, цэвэршихэд илүү чухал ач холбогдолтой гэж үзсэний үндсэн дээр хэрэгжүүлдэг байна.

УИХ-аас баталсан "Хүний аюулгүй байдлыг хангах зохистой засаглал" хэмээх Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөнд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн талаар судалгаа хийж, санал боловсруулах гэж заасан байна. Энэ нь сайн боловч саатаж байгаа нь харамсалтай.

Манайд өнөөдөр Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан хууль тогтоомж зайлшгүй шаардлагатай байна. Ингээгүй тохиолдолд Монгол Улс хүний эрхийг дээдлэн хүндэтгэдэг ардчилсан орон гэж үзэхэд учир дутагдалтай болно.

Олон улсын хууль эрх зүй, үндэсний аюулгүй байдал, хүний эрхийн асуудлаар мэргэшсэн олон улсын тэргүүлэх хуульч, шинжээчдийн хэсэг цугларан 1995 оны 10-р сарын 1-нд Мэдээллийн эрх чөлөөний талаарх Йоханнесбургийн зарчмуудыг баталсан юм. Эдгээр зарчимтай эл гарын авлагаас танилцаж болно.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль эхнээсээ л олон нийтийн мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах тодорхой зорилготой байх ёстой. Олон нийтэд үйлчилдэг

байгууллагууд мэдээлэл өгөх үүрэгтэй, хүн бүр мэдээлэл хүлээн авах зохих ёсны эрхтэй бөгөөд энэ эрхээ эдлэхдээ тухайн мэдээллийг олж авах хүсэлтээ тайлбарлах ёсгүй. Харин албан ажилтан мэдээлэл өгөхөөс татгалзаж байгаа шалтгаанаа аль ч шатанд тайлбарлах, түүнийгээ нотлох үүргийг хүлээнэ. Мэдээллийн эрх чөлөөний хуулийг төгс хэрэгжүүлэхийн тулд нууцын хууль зэрэг бусад хууль тогтоомжийг эргэн нягталбал зохино. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үзэл баримтлал, зарчмууд бусад хуулиас давуу эрхтэй байх ёстой.

Ийм ч учраас "Глоб Интернэшнл" ТББ-аас 2001 оноос эхлэн хэрэгжүүлсэн "Олон нийтийн мэдэх эрх. Мэдээллийн эрх чөлөө" төслийн үргэлжлэл болгон "Мэдээлэл авах боломжийг сайжруулан авилгатай тэмцэх нь" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ дашрамд манай төслийг санхүүжүүлж буй Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Элчин сайдын яаманд талархал илэрхийлье.

Энэхүү гарын авлага хууль боловсруулагч, тогтоогч төдийгүй хүний эрхийн болон нийгмийн ухамсрын түвшинг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, олон нийтэд чухал шаардлагатай лавлах материал болно гэдэгт итгэж байна.

Тэргүүн Х.Наранжаргал



Нэгдүгээр бүлэг

Мэдээллийн эрх чөлөө: Манай амлалт, өнөөгийн байдал

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн
Х.Наранжаргалын тавьсан илтгэл

*Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд...
НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн.
/НҮБ-ын Ерөнхий ассемблейн анхдугаар
чуулга уулзалтын 59-р тогтоолоос/*

2008 оны 12 сард дэлхий даяар Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойт тэмдэглэж байна. Иймд би НҮБ-ын Ерөнхий ассемблейн анхдугаар чуулга уулзалтын дээрх 59-р тогтоолыг эргэн санаж, илтгэлээ эхлээ гэж бодсон юм.

Мэдээллийг ардчиллын хүчилтөрөгч гэдэг. Хүний эрхийг дээдэлдэг нийгмийн амин сүнс нь нээлттэй мэдээлэл юм. Нээлттэй мэдээлэл нь мөн эрх чөлөө, шударга ёс, хөгжил дэвшлийн баталгаа билээ.

1. Манай амлалтууд

Хэдэн жилийн өмнө Монголд мэдээллийн эрх чөлөөний тухай яриа цөөн сэтгүүлчдийн хүрэнээс хальдаггүй байв. Харин засаг төрийн бодлогын түвшинд анх удаа 2000 оноос яригдаж эхэлсэн гэж болно.

УИХ-ын 2000 оны 45-р тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг Монгол Улсад хөгжүүлэх үндсэн чиглэлд “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлэх ажлыг зохион байгуулах” заалт орсон юм. Үүний дагуу уг хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагааны дунд хугацааны буюу 2001-2004 оны төлөвлөгөө батлагдсан юм. Энэ төлөвлөгөөний “Зохистой засаглал” бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 11.3.2-ын нэгд “Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн судалгаа хийж, санал боловсруулах” хэмээн заасан билээ.

2002 онд УИХ-ын баталсан Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2.3 зүйлд “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангах, олон нийтэд ил тод байх, бусад улс, олон улсын байгууллагын дэвшилтэт арга, туршлагыг харгалзах зарчмыг баримтална” гэжээ.

2003 онд УИХ-аар батлагдсан Хүний Эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн “Мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө” хэмээх 2.2.5-р зүйлийн нэг дэх хэсэгт зааснаар “Нууц хамгаалах хуулиудаар тогтоосон илүүц хязгаарлалтыг арилгах зэргээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, энэ талаар иргэд, хэвлэл мэдээллийн ажилтны хүсэлт шаардлагаар мэдээлэл гаргаж өгөх үүрэг хариуцлага, иргэдээс мэдээлэл олж авах, түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх” үүргийг Засгийн газар хүлээсэн байна.

Засгийн газар 2003 онд болсон Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон улсуудын олон улсын 5-р бага хурлын үеэр баталсан “Улаанбаатарын тунхаглал”-д “Ардчилал бол нээлттэй, ил тод нийгэм” болохыг хүлээн зөвшөөрч, “Нээлттэй, ил тод нийгэм мэдээлэл чөлөөтэй бүрдүүлэх, эрэлхийлэх болох түгээхийг хөхиүлэн дэмжинэ” гэж амалжээ.

Монголын Засгийн газрын 2004-2008 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт “иргэдийн аливаа мэдээлэл олж авах эрхийг хангах” тухай заажээ.

Монголын Засгийн газрын 2008-2012 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилтод “төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх”-эд оршино гэжээ.

Уг хөтөлбөрийн Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох зорилт хэмээх 4 дүгээр бүлэгт “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэхийн хамт иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, тогтвортой үйл ажиллагаа, ил тод байдал, төрийн албаны ур чадвар, хариуцлагын тогтолцоог өндөржүүлж, эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ” гэж заасан. Хөтөлбөрийн 4.1.10-д “Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн үзэл баримтлалд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлнэ”, 4.5.9-д “Олон нийтийн мэдээллийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” хэмээх амлалтууд орсон байна.

Засгийн газраас 2008-2012 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчмын нэг нь “Хөрөнгө, нөөцийг байршуулах, түүний зарцуулалтад хариуцлагатай, ил тод, тунгалаг байх зарчмыг дээдлэх” хэмээн амлажээ.

2. Иргэний нийгмийн оролцоо

Нээлттэй Нийгэм Форум, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, зарчим, олон улсын хэм хэмжээг таниулах сурталчлах, хуулийн төсөлд иргэд, иргэний нийгмийн байгууллагыг татан оруулах чиглэлээр тууштай ажиллаж байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас ННХ-гийн бүсийн хөтөлбөрийн дэмжлэгээр 2001-2002 онд “Монгол Улс шилжилтийн үед. Үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ”-г олон улсын “ХИХ зүйл” байгууллагатай хамтран хийв. Задлан шинжилгээний Тайлангийн 7-р бүлэгт “Монгол улсад төрийн байгууллагын нээлттэй байдал хангалтгүй байгаа нь гол бэрхшээл юм” хэмээн тэмдэглэж, мэдээллийн эрх чөлөөний хууль шаардлагатай болохыг зөвлөсөн юм.

Манай байгууллага 2002-2004 онд Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн, АНУ-ын ЭСЯ, Австралийн Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Олон нийтийн мэдэх эрх. Мэдээллийн эрх чөлөө” төсөл хэрэгжүүлэн, улс төрч, олон нийтийг хамарсан өргөн хүрээтэй кампанит ажил зохион байгуулж, анхны хуулийн төслийг ХЗДХЯ, бусад төрийн бус байгууллагатай хамтран боловсруулсан юм. Хуулийн төсөлд “ХИХ зүйл” байгууллага шинжилгээ дүгнэлт хийсэн билээ. 2005-2006 онд “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага “Мэдээллийн эрх чөлөө, төрийн нууц” олон улсын дугуй ширээний ярилцлага зохион байгуулж, иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэн түгээж, “Төрийн нууцын хуулийн шинэтгэл” төслийн хүрээнд төрийн

нууцын хуулийн харьцуулсан судалгаа, монголын хуулийн шинжилгээ хийж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсан юм.

2007 оны 6-р сард Нээлттэй Нийгэм Форум, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага хамтран хуулийн төсөл санаачлагч, иргэний нийгмийн байгууллагын уулзалт зохион байгуулж, иргэний нийгмийн төлөөллүүд УИХ-ын гишүүдийн боловсруулсан хуулийн төсөлд өгөв.

Нээлттэй Нийгэм Форумаас 2006-2007 онд төрийн ил тод байдлыг хангах чиглэлээр иргэний форумыг зохион байгуулж, ил тод байдлын эрх зүйн орчныг сайжруулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны нээлттэй байдлыг дээшлүүлэх, иргэний оролцоог хангах талаар иргэний нийгмийн зөвлөмжийг боловсруулан, засаг төрд хүргэсэн юм.

Төрийн мэдээллийг нээлттэй болгох нь иргэний хөдөлгөөнүүдийн зүгээс хүчтэй тавьж буй шаардлагын нэг билээ.

3. Өнөөгийн байдал

3.1 Эрх зүйн орчин

Манай хуулиудад дараах зарчмыг тунхагласан байна.

- Төрийн үйл ажиллагаа ил тод байна
- Зарим мэдээлэл ил, нээлттэй байлгах үүрэг ногдуулсан
- Заавал нийтлэх зарим мэдээлэл, бичиг баримтыг хуульчилсан

2001 онд монголын 232 хуульд хийсэн судалгаагаар мэдээллийн эрх чөлөө, санал бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хатуу хязгаарласан 51 хууль байсан. Үүнээс хойш мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан хуулийн тоо нэмэгдсэн. Жишээ нь, 2003 онд батлагдсан СӨХ-ны тухай хуулиар “Хяналтын зөвлөлийн гишүүн шалгасан баримт бичиг, тайлан, тэнцлийн нууцыг хадгалах үүрэгтэй (11.4) гэжээ.

2006 онд батлагдсан төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал, мэдээллийн эрх чөлөөг хангах чиглээр нэлээд шинэлэг зохицуулалт хийсэн Авлигын эсрэг хууль батлагдсан.

2007 онд манай хуульчдын Монголд үйлчилж буй 360 хуульд хийсэн судалгаагаар 120 гаруй хуулийн зүйл заалтаар мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчим, хэм хэмжээг зохицуулсан ажээ.

Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан хуулийг хэлэлцэхээр 2005 оны 11-р сард УИХ-ын хэлэлцэх асуудлын дэгд орсон байв.

Одоо манайд мэдээллийн эрх чөлөөний хуулийн гурван хувилбар бий.

- “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын анхны хувилбар. Үүнийг ХЗДХЯ, төрийн бус хэд хэдэн байгууллагын төлөөлөлтэй хамтарсан баг боловсруулсан
- Түүн дээр тулгуурласан ХЗДХЯ-ны хувилбар. 2006 оны 10-р сард ХЗДХЯ Засгийн газрын хуралдаанд оруулсан боловч мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл боловсруулах, хэвлэл мэдээллийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр хамтад нь хэлэлцэхээр хойшлогдсон.
- Мөн анхны хувилбарт тулгуурлан УИХ-ын нэр бүхий зургаан гишүүний боловсруулж, 2007 оны 5-р сарын 2-нд УИХ-д өргөн барьсан, “Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай” хуулийн төсөл

Энэ хууль батлагдвал өнөөгийн манай хууль тогтоомжид байгаа дор дурдсан сул талуудыг засах, арилгах боломжтой болох биз ээ. Үүнд:

- Мэдээлэл нээлттэй байх тухай Монголын хууль тогтоомжид эерэг заалтууд байгаа боловч гол төлөв зарчмын шинжтэй, тунхаглалын чанартай, зохицуулалт механизм нь сул, бүдэг учир хэрэгжих боломжгүй
- Манай хуулиудад мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт нь түлхүү байдаг.

Төрийн нууц, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн нууц мэдээллийн хүрээ өргөн, нууцлах хугацаа хэтэрхий урт. Нийт 59 зүйлээр тогтоосон нууц мэдээллийн 69.5 хувийг 40-60 жилээр, эсвэл байнгын хугацаагаар нууцалсан байна.

1995 оны 5 -р сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хуулиар нууц мэдээлэл тухайн байгууллагын хамгаалалтад байхаар тогтоосон. Мөн тухайн байгууллага нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөхийг үүрэг болгосон. /5.1/ Энэ хатуу заалтыг 6 дугаар зүйлээр зөөлрүүлэх оролдлого хийж, нууцлахыг хориглох мэдээллийн жагсаалтыг баталсан байна. Үүнд тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй ажээ.

Үндсэн хуулийн 16.17-д мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг бусдын "нэр төр, алдар хүндийг хамгаалах" үүднээс хязгаарлаж болно гэж заасан. Үүнийг олон улсын хэм хэмжээгээр ч хүлээн зөвшөөрдөг. Манай улсын Хувь хүний нууцын тухай хуульд хувийн нууцыг маш хүчтэй хамгаалсан. Үүнд нь сонгогдсон улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, албан хаагчид ч хамрагддаг.

Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Аудит, Геодези, зураг зүй, Арбитрийн гэх мэт бараг бүх хуульд нууц хамгаалсан заалтууд байдаг.

- Нууц задруулсан иргэнд ногдуулах шийтгэл өндөр
Нууц хамгаалах үүрэгтэй байгууллага, хариуцсан ажилтантай хэрнээ жирийн иргэнд нууц мэдээллийг задруулахгүй байх хатуу үүрэг ногдуулсан. Төрийн, байгууллагын, хувийн нууц задруулсан иргэн санаандгүйгээр үүнийг үйлдсэн ч доод тал нь гурав, дээд тал нь найман жил хоригдох ял хүлээнэ.
- Хуулиар нууцлах хугацаа дууссан ч мэдээлэл ил болдоггүй

Төрийн нууцын жагсаалтын тухай хуульд нууцын хугацаа дууссан байлаа ч мэдээллийг заавал УИХ-ийн шийдвэрээр ил болгоно. УИХ энэ үүргээ биелүүлдэггүй.

3.2 Бодит байдал

Мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдалд дүгнэлт өгөхийн тулд "Глоб Интернэшнл" төрийн бус байгууллагаас 2001-2007 онд хийсэн янз бүрийн судалгаанд түшиглэе.

“Олон нийтийн мэдэх эрх” судалгаа (2002-2003 он)

Судалгаанд 18-аас дээш насны 100 иргэн хамрагдсан юм. Тэдгээрийн 66 нь янз бүрийн шалтгаанаар төрийн байгууллагаас хүссэн мэдээллээ олж авч чадаагүй байна.

Мэдээлэл өгөхөөс татгалзсан үндэслэл	тоо	хувь
1. Ямар ч шалтгаангүй татгалзсан	13	19.7%
2. Тухайн мэдээлэл байхгүй	12	18.19%
3. Албан хэргийн бичиг баримтыг жирийн иргэнд өгөхгүй	11	16.6%
4. Удирдлага нь зөвшөөрөөгүй	10	15.15%
5. Мэдээллийг ашиглах зорилгоо тодруулан хэлсэн чинь өгөөгүй	7	10.6%
6. Төрийн нууц	5	7.6%
7. Байгууллагын нууц	5	7.6%
8. Завгүй байна	1	1.5%
9. Дутуу дулимаг хариулт өгсөн	1	1.5%
10. Өндөр төлбөр шаардсан	1	1.5%

“Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал” судалгаа (2002-2003)

Судалгаанд төрийн 47 байгууллага хамрагдсан. Үүнээс 29 байгууллага зорилго, зорилтоо "үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах", 23 нь "олон нийтийг мэдээллээр хангах" гэж тодорхойлсон байна. Харамсалтай нь, бодит байдал үүнтэй зөрчилдөж байв.

Судалгаанд хамрагдсан нийт байгууллагаас дор дурдсан зургаан байгууллага иргэн мэдээллийг чөлөөтэй авах боломжгүй гэжээ.

1. Тагнуулын төв газар
2. Сүхбаатар дүүргийн ИТХ
3. Иргэний нисэхийн ерөнхий газар
4. Төр засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газар
5. Сүхбаатар дүүргийн шүүх
6. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар

Төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрхээ хэн илүү эдэлж байгааг авч үзвэл:
(давхардсан тоогоор)

- Төрийн байгууллага 39%
- Төрийн албан хаагч албан шугамаар 35%
- ТББ, хувийн байгууллага албан ёсоор хүсэлт гаргавал 35%
- Иргэн зорилгоо тайлбарлавал 32%
- Иргэнд зөвхөн удирдах албан тушаалтан зөвшөөрвөл 13%
- Иргэн татвар төлөгчийн хувьд 11%

“Иргэний мэдээлэл олж авах нөхцөл боломж” судалгаа (2006 он)

Судалгаанд УИХ, Засгийн газар, түүний харъяа агентлаг, газар, яам, архив, шүүх, прокурор зэрэг 13 байгууллагаас иргэд 15 төрлийн мэдээлэл олж авахаар хүсэлт тавьсан. Үүнээс 11 нь ил тол байх ёстой мэдээлэл байв. Харин гурван мэдээлэл нь төрийн нууцад хамаардаг, нэг нь хуулиар нууцлах хугацаа нь дуусч, ил болох ёстой мэдээлэл байв.

Судалгааны явцад төрийн нууцад үл хамрах 12 мэдээллээс ердөө гурвыг олж авсан. Хүссэн мэдээллийн гурав нь хуулиар хамгаалагдсан төрийн нууц байсан боловч нэг нь нээлттэй болсон байв. Төрийн байгууллагууд хуулиар нууц бус есөн мэдээллийг өгөхөөс татгалзаж, гурван мэдээллийг өгөхөөс татгалзаагүй ч иргэд олж авч чадаагүй байна.

Мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгаан (9 мэдээллээс):

Төрийн нууц	6
Байгууллагын нууц	1
Иргэд танилцаж байсан практик байхгүй	1
Шалтгаангүйгээр татгалзсан	1
Татгалзаагүй боловч олж авч чадаагүй мэдээлэл:	
Вэб сайтад байгаа гэсэн боловч байхгүй	1
Судлаачдад төлбөртэй өгч болох, өндөр үнэтэй	1
Шалтгаангүй	1

“Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторинг (2007 он)

Манай байгууллага “Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, мэдээллийг хүртээмжтэй болгох, үйл ажиллагааг нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах” чиглэлээр Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудад өгсөн 8 зүйл бүхий зөвлөмжид Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр 2007 оны 7-р сарын 1-нээс 12-р сарыг дуустал мониторинг хийсэн юм. Мониторингийг хоёр үе шаттай хийж, төрийн 121 байгууллагын 189 ажилтан, 185 албан тушаалтан, 749 иргэнийг хамруулсан юм. 2007 оны 4-р сард гаргасан уг зөвлөмжийг судалгаанд хамрагдсан байгууллагын 41 хувь нь хэрэгжүүлэхээр ажиллаж, 12 хувь нь судлах шатандаа, 34 хувь нь тойм төдий мэдээлэлтэй, 13 хувь нь огт мэдээлэлгүй байв. Мониторингийн дүнгээс харахад, хоёр дахь шатны судлагаанд хамрагдсан төрийн 90 байгууллагын:

- 81 хувь нь байгууллагынхаа дүрэм, журмыг ил байрлуулсан
- 76 хувь нь үйл ажиллагаагаа танилцуулсан тараах материалтай
- 86 хувь нь мэдээллийн самбартай. Үүнээс 97 хувь нь энгийн, 3 хувь нь электрон самбартай

- 47 байгууллага вэб сайттай боловч 19 хувь нь ажилладаг

Судалгаанд хамрагдсан иргэдийн санал бодлыг судалж үзвэл 430 иргэний:

- 33 хувь нь хүссэн мэдээллээ авч чадаагүй талаар төрийн байгууллагад хандан гомдол гаргаж байсан боловч тэдний 52 хувь нь асуудлаа шийдвэрлүүлж чадаагүй байна.

- 68 хувь нь төрийн байгууллагын шийдвэр гаргах үндэслэл иргэдэд нээлттэй эсэх талаар мэдэхгүй гэсэн бол байгууллагын 88 хувь ил байдаг гэжээ
- Байгууллагын 63 хувь иргэдээс санал гомдол хүлээн авах утас ажиллуулдаг гэсэн бол иргэдийн дөрвөн хувь л энэ тухай мэдэж байв. 8-р сарын судалгаагаар 107 байгууллагын 51 хувь нь шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг авдаг гэсэн бол 10-р сард иргэдийн дөрвөн хувь үүнийг хүлээн зөвшөөрч байв

Дээрх судалгаанд үндэслэн мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдалд дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

- Төрийн байгууллага, түүний ажилтан мэдээлэл авахдаа жирийн иргэнээс давуу эрхтэй
- Иргэн мэдээлэл авахын тулд хүнд суртал, чирэгдэл зэрэг байнгын хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. Заавал албан бичиг, ямар нэг баримт бичиг шаарддаг, эсвэл анкет бөглөх хэрэгтэй
- Иргэн мэдээлэл авахын тулд заавал зорилгоо, ихэнх тохиолдолд бичгээр тайлбарлах ёстой
- Төрийн байгууллагад нэвтэрч орох туйлын хэцүү учир мэдээлэл хариуцсан хүнтэй нүүр тулж уулзах боломж үгүй. Иргэд жижүүр, харуулаар дамжуулан хэрэгтэй хүнтэйгээ холбогдоно. Эсвэл хэрэгтэй хүнээ олох гэж ихээхэн цаг зарцуулна. Зарим тохиолдолд холбогдох хүнтэй нь жижүүр, харуулаар дамжуулан ярих хэрэг гардаг
- Төрийн байгууллагууд хэвлэн нийтлэх үүргээ төдийлөн сайн ойлгодоггүй. Бэлэн мэдээллийг худалдаж, орлого олох сонирхолтой
- Төрийн албан хаагчид вэб сайтад бий гэж хэлэх нь моод болсон. Гэвч тэр мэдээлэл нь байдаггүй.
- Зарим албан хаагч ажил үүргээ мэддэггүй бололтой, бие бие рүүгээ чихдэг
- Төрийн ажилтны сэтгэлгээ хоцрогдсон. Иргэн ийм мэдээлэл ерөөсөө хүсдэггүй гэж гайхширдаг.
- Мэдээлэл олж авах нь иргэн бүрт адил тэгш бус. Төрийн байгууллага мэдээлэл өгөхдөө ялгаварладаг. Судлаач бол байгууллагаасаа албан бичиг авчрах ёстой.
- Мэдээлэл өндөр үнэтэй. Зарим газар 20 000-30 000 төгрөг шаарддаг.
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх үндсэн ажил хөдөлмөр эрхэлдэг сэтгүүлчид ч мэдээллийг албан ёсоор авч чаддаггүй

Жишээ 1. Эх сурвалж: “Өнөөдөр” сонин 2006.01.11№ 008

“Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр хадгаламжийн банкны хувьчлалын талаар янз бүрийн мэдээлэл цацагдаж буй. Түүнчлэн тус банкны улсын төсөвт төлсөн татварын хэмжээ буурсан гэх болсон билээ. Эдгээр мэдээллийн үнэн бодитой эсхийг тодруулахаар Үндэсний татварын ерөнхий газрын мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтсийн байцаагч Б.Батгэрэлтэй уулзаж хадгаламжийн банкны 2003-2005 онд улсад төлсөн татварын талаарх мэдээлэл авахыг хүссэн боловч татгалзсан хариу сонслоо. Хүсэлтээ албан бичгээр гаргах лүндэн буулгасныг ёсоор болговол “Манай даргаар гарын үсэг зуруулаад ир. Тэгвэл мэдээлэл өгнө” гэв. Улсын нууцад үл хамаарах хамгийн энгийн баримтыг журмын дагуу хүсээд тусыг эс олов. ҮТЕГ-ын удирдлага байгуулагадаа ийм хатуу дэг тогтоосон хэрэг үү, эсвэл байцаагч Б.Батгэрэл хүнд суртал гаргаж байна уу?”

Жишээ 2. Эх сурвалж: “Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний тайлан. 2006 он”

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Даштүдэв Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийнхөө үйл ажиллагаатай танилцаж, 2006 оны 6-р сарын 12-нд шалгалтын дүнгийн хурал хийж байхдаа аймгийн радио, телевизийн хоёр сурвалжлагчийг танхимаас гарахыг шаарджээ.

Г.Даштүдэв шалгалтын дүнгийн зарим мэдээллийг нийтэд мэдээлэхгүй, “нууц” гэсэн нэрийдлээр Өвөрхангай аймгийн “Ноён-Уул” FM радиогийн сурвалжлагч С.Мөнхдалайн диктафоныг хоёр ч удаа унтрааж, хурлын явцыг сурвалжилж байсан “Өвөрхангай” аймгийн телевизийн сурвалжлагч Г.Пунцагсүрэнг бичлэг хийлгүйгээр хуралд суух, эсвэл тэндээс гарахыг шаардсан байна. Малын хулгайчдын нэрийг хэлэхэд бэлэн байгаа тухай, мөн энэ хүмүүсийг илрүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах, Аймгийн цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн цаг хугацаандаа ирэхгүй хүлээлгэсэн зэрэг мэдээллийг Г.Даштүдэв “нууц” хэмээн тодорхойлжээ.

Жишээ 3. Эх сурвалж: “Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний тайлан. 2006 он”

Өмнөговь аймгийн засаг дарга М.Ядмаа 2006 оны 7-р сарын 27-нд “Алтан говь” телевизийн зураглаач М.Шинэхүүг Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга нарын хурлыг сурвалжилж байх үеэр “цаашид энэ телевизэд мэдээлэл өгөхгүй байх” үүргийг газар, хэлтсийн дарга нартаа өгчээ.

“Алтан говь” телевиз 2006 оны 7-р сарын 26-ны өдөр тус аймагт махны үнэ хэт өсч байгаа тухай мэдээлэхдээ махны худалдагч Долгорын “Аймгийн засаг дарга өөрийн ах дүү нартаа мөнгө гарган өгч, өөр аймгуудаас мах авчирч заруулсан” гэсэн утгатай ярилцлагыг оруулсан байна. Энэ мэдээллийг телевизээр дамжуулсаны маргааш ноён М.Ядмаа махны худалдагч Долгорыг өрөөндөө дуудан, “ярьсан зүйлдээ залруулга хийхгүй бол шүүхэд өгнө” хэмээн хэлтсийн дарга нарынхаа хамтаар сүрдүүлжээ.

4. Хуулийн хэрэгцээ, шаардлага

Манай улс иргэдийнхээ мэдээлэлтэй байх эрх, мэдээллийн эрх чөлөөг Үндсэн Хуулиараа баталгаажуулсан. Иргэддээ мэдээллээр үйлчлэх нь төрийн үндсэн үүргийн нэг юм. Энэ үүргээ манай засаг төр төдийлөн хангалттай биелүүлж чадахгүй байгааг эрх зүйн орчны өнөөгийн байдал, төрийн байгууллагын хандлага, байдлын дүр төрхийг харуулсан судалгаа, иргэдийн санаа бодол нотолж байна.

Иргэддээ мэдээллээр үйлчлэх нь ардчиллын мөн чанар, зарчим, соёлын салшгүй хэсэг юм. Ардчилсан нийгмийн зарчмыг манай өнөөгийн байдалтай харьцуулж үзье.

Ардчилсан нийгэмд	Монголын нийгэмд
1. Бүх мэдээлэл иргэдэд ил, нээлттэй байна	Мэдээлэл нууц. Мэдээллийг хязгаарлах уламжлал, сэтгэхүйгээс салаагүй
2. Зарим хязгаарлалт хийж болно. Үүнд: -Бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх -Үндэсний аюулгүй байдал, Нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зайлшгүй шаардлагатай бол мэдээллийг хязгаарлаж болно	Зарим мэдээлэл нээлттэй байж болно Эрүүл мэнд, байгаль орчин, гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл ил байж болно. Төрийн байгууллагын зарим бичиг баримт, зарим мэдээлэл нээлттэй
3. Нууцыг заавал хуулиар тогтооно	Төрийн нууцыг заавал хуулиар тогтооно Байгууллага өөрөө нууцаа тогтооно Тодорхой хуулиудад байгууллагын нууцыг хамгаална

Монгол Улс олон улсын өмнө авсан амлалт, үүргээ шударгаар сахин биелүүлэх нь нэр төрийн хэрэг юм. Гэтэл бид:

- Үндсэн Хуулиа ч, мөн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактын үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан 19-р зүйлийг бүдүүлгээр зөрчдөг
- НҮБ-ын гишүүн боловч баталсан гэрээ, конвенци, бусад баримт бичиг, тунхаг, тунхагийн зарчмыг зөрчдөг, зөвлөмжийг хүлээн авдаггүй
- Олон улсын байгууллага, донор байгууллагын зөвлөмжийг ч үл тоодог

Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах нь нийгмийн сэтгэлгээ, сэтгэл зүй, соёл, эрхзүйн томоохон шинэтгэл юм. Иймд энэ хууль нь Монгол Улсад ардчиллыг гүнзгийрүүлэх, хүний эрхийг зохих ёсоор хангах, авлига, хээл хахууль, гэмт хэрэг, хүчирхийлэл, бусад зүй бус үйлдэлтэй тэмцэх, нийгмийн шударга ёсыг тогтоож, эрүүл саруул хөгжлийг урагшуулахад томоохон эргэлт болно.

*Засгийн газар нь ил тод бус, улс төрийн хариуцлага сул, иргэдийнхээ улс төрийн бүх эрхийг адил тэгш хангаагүй нөхцөлд эдийн засгийн хөгжил тогтвортой байж чадахгүй.
Ухамсрын Төлөвшлийн Сан, Лондон*

Хоёрдугаар бүлэг

Гарын авлагад ашигласан нэр томъёо

- public's right to know - олон нийтийн мэдэх эрх
- Freedom of information - мэдээллийн эрх чөлөө
- free flow of information - мэдээллийн чөлөөт урсгал
- right to access - хүртэх эрх
- right to obtain information - мэдээлэл авах эрх
- right to obtain information from public authorities - төрийн байгууллагаас мэдээлэл авах эрх
- access to information - мэдээлэл хүртэх (олж авах)
- government- held information - засгийн газрын мэдэлд байгаа мэдээлэл
- information relating to national security - үндэсний аюулгүй байдалтай хамааралтай мэдээлэл
- public interest in disclosure - нээлттэй болгох олон нийтийн сонирхол
- information in the public domain - олон нийтийн хүрээний мэдээлэл
- disclosure of secret information - нууц мэдээллийг ил болгох
- protection of journalists' sources - сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах
- duty to publish - хэвлэн нийтлэх үүрэг
- information Commissioner - мэдээллийн комиссар
- information Officer -мэдээллийн ажилтан
- whistleblowers - мэдээлэгч

**ARTICLE 19**

GLOBAL CAMPAIGN FOR FREE EXPRESSION

**ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ: Мэдээллийн
эрх чөлөөний хууль зүйн зарчмууд****ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ЦУВРАЛУУД****19-р зүйл байгууллага. Лондон****ISBN 1 902598 10 5****1999 оны 6 сар****ТАЛАРХАЛ**

Эдгээр зарчмуудыг “19 дүгээр зүйл” байгууллагын хуулийн хөтөлбөрийн захирал Тоби Мендель боловсруулав. Эдгээр нь “19 дүгээр зүйл” байгууллагаас удаан хугацаанд явуулсан судалгаа, дүн шинжилгээ, санал солилцоо ба дэлхийн олон оронд байдаг түнш байгууллагуудтай хамтран ажилласан өргөн туршлагын үр дүн юм. Уг баримт бичгийг “19 дүгээр зүйл” байгууллагын харилцаа холбоо хариуцсан ажилтан Илана Кравиц хянан тохиолдуулж хэвлэлд бэлтгэн, өмнөх үгийг “19 дүгээр зүйл” байгууллагын гүйцэтгэх захирал Эндрью Пуддефат бичлээ.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ.

- 1-Р ЗАРЧИМ. Дээд зэргээр нээлттэй байх
- 2-Р ЗАРЧИМ. Хэвлэн нийтлэх үүрэг
- 3-Р ЗАРЧИМ. Нээлттэй засаглалыг дэмжих
- 4-Р ЗАРЧИМ. Үл хамаарлуудыг хязгаарлах хүрээ
- 5-Р ЗАРЧИМ. Мэдээлэл хүртэх үйлийг хөнгөвчлөх процесс
- 6-Р ЗАРЧИМ. Хураамж
- 7-Р ЗАРЧИМ. Нээлттэй хуралдаан
- 8-Р ЗАРЧИМ. Нээлттэй байхыг нэн тэргүүнд тавих
- 9-Р ЗАРЧИМ. “Мэдээлэгчийг” хамгаалах

ӨМНӨХ ҮГ

Мэдээлэл хэмээх зүйл нь ардчилалд хүчилтөрөгч нь болж байдаг. Хэрэв хүмүүс нийгэмдээ болж буй үйл явдлыг мэдэхгүй эсвэл удирдагчдынх нь үйл ажиллагаа нуугдмал байх аваас тэд нийгэмдээ дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй. Мэдээлэл бол зөвхөн хүмүүст хэрэгтэй зүйл төдийгүй, мөн шилдэг сайн засаглалын амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм. “Муу” засаглал амиа аварч гарахын тулд нууцлагдмал байх хэрэгтэй болдог. Гэвч энэ нь үр ашиггүй, үрэлгэн байдалд хүргэж, авилгалыг газар авахуулдаг билээ. Нобелийн шагналт эдийн засагч Амартия Сений судалснаар ардчилсан засгийн газартай, харьцангуй чөлөөт хэвлэлтэй оронд хэзээ ч нийтийг хамарсан өлсгөлөн гарч байгаагүй байна. Мэдээлэл нь хүмүүст засгийн газрынхаа үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах боломж олгодог бөгөөд дээрх мөн уг ажиллагааг зүй зохистой, мэдээлэл сайтайг өөрөөр хэлбэл бодитоор хэлэлцэх үндэс болдог.

Гэхдээ ихэнх засгийн газар үйл ажиллагаагаа нууцаар явуулахыг эрхэмлэдэг байна. Свалид засгийн газар гэдгийг заасан үгсийн нэг нь “догшин нууц” гэсэн утгатай байдаг. Тэр ч бүү хэл, ардчилсан засгийн газрууд хүртэл зарим ажлаа олон нийтийн нүднээс далдуур хийх эрмэлзэлтэй байдаг. Ингэхдээ засгийн газрууд нууцаа хадгалах шалтгааныг ямагт олж байдаг бөгөөд наад захын жишээ гэвэл үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, нийгмийн дэг журам, олон нийтийн ашиг сонирхол гэх мэтийг дурьдаж болно. Харамсалтай нь ихэнхдээ засгийн газрууд ард түмнийг төлөөлж албан ёсны мэдээллийг хадгалж байгаа гэж үзэхээсээ илүүтэйгээр өөрсдийн эрх мэдэлд байгаа мэдээлэлд өөрсдийн өмч мэт ханддаг.

Тийм ч учраас, “19 дүгээр зүйл” байгууллага олон улсын энэхүү багц зарчмыг боловсруулсан бөгөөд ямар ч иргэн өөрийн орны хуульд албан мэдээллийг олж авах эрхийг хангалттай баталгаажуулж чадсан эсэхийг харьцуулан үзэх олон улсын стандартыг бий болгохыг зорьсон билээ. Эдгээр зарчмууд нь ямар арга замаар засгийн газар дээд зэргийн нээлттэй байдалд хүрэх тухай аргачлалыг олон улсын шилдэг стандарт, практикт нийцүүлэн ойлгомжтой, тодорхой гаргаж өгч байна.

Зарчмууд нь стандартын нэгэн адил чухал зүйл мөн боловч дангаараа бол хангалтгүй юм. Тиймээс тэдгээрийг нийгмийн идэвхтнүүд, хуульчид, сонгогдсон төлөөлөгчид

болон төрийн албан хаагчид хэрэглэж байх шаардлагатай. Эдгээр зарчмуудын ач холбогдлыг нь ойлгодог, засаглалыг ил тод болгохыг хүсдэг хүмүүс эдгээр зарчмуудыг нийгэмд тулгардаг онцгой нөхцөл байдалд тохируулан хэрэглэж байх нь зүйтэй. Дэлхий даяар засаглал, түүний хариуцлагыг сайжруулах, ардчиллыг бэхжүүлэх үйлст хувь нэмэр болгох үүднээс бид эдгээр зарчмуудыг нийтэлж байна.

СУРВАЛЖ

Эдгээр зарчмууд нь мэдээллийн эрх чөлөөнд нөлөө үзүүлж байдаг үндэсний болон олон улсын журамд тодорхой стандартыг тогтоож өгч байна. Эдгээр зарчмууд нь мэдээллийн эрх чөлөө болон албан ёсны мэдээлэл олж авах эрхийн талаарх үндэсний хууль тогтоомжид зориулагдсан хэдий ч уг зарчмуудыг НҮБ, Европын Холбоо зэрэг засгийн газар хоорондын байгууллагуудад хадгалагдаж буй мэдээллийг олж авахад ч нэгэн адил хэрэглэж болно.

Эдгээр зарчмууд олон улсын болон бүс нутгийн хууль тогтоомж, стандартууд, улс орнуудын өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг хуулийн практик, /үндэсний хууль тогтоомж, шүүхийн шийдвэрт тусгалаа олсон байдаг/ олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий зарчмууд дээр суурилсан. Уг зарчмууд нь “19 дүгээр зүйл” байгууллагын удаан хугацаанд явуулсан судалгаа, дүн шинжилгээ, санал солилцоо ба дэлхийн олон оронд байдаг түнш байгууллагуудтай хамтран ажилласан өргөн туршлагын үр дүн юм.

1-Р ЗАРЧИМ. ДЭЭД ЗЭРГЭЭР НЭЭЛТТЭЙ БАЙХ

Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зохицуулалт нь мэдээлэл дээд зэргээр нээлттэй байх зарчимд үндэслэгдэх ёстой.

Дээд зэргээр нээлттэй байх зарчим ёсоор төрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа бүх мэдээлэл нь олж авахад хялбар, нээлттэй байх ёстой бөгөөд зөвхөн тодорхой хязгаарлагдмал тооны нөхцөл байдалд л энэ зарчмыг хэрэглэхгүй байж болно. /4-р зарчмыг үз/ Энэхүү зарчим нь мэдээллийн эрх чөлөөний үндсэн үзэл баримтлалын гол цөм бөгөөд түүнийг Үндсэн хуульд тусгаж, албан ёсны мэдээлэл олж авах явдал бол иргэний үндсэн эрх гэдгийг тодорхой болгох нь зүйтэй. Хууль, эрх зүйн хамгийн гол зорилго бол мэдээллийн дээд зэргийн нээлттэй байдлыг практикт хэрэгжүүлэх явдал юм.

Аливаа төрийн байгууллага мэдээллээ нээлттэй байлгах үүрэгтэй ба үүнтэй уялдан нийгмийн гишүүн бүр мэдээлэл хүлээн авах эрхтэй. Тухайн улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа бүх хүн уг эрхийг эдлэх ёстой. Уг эрхийг хангахдаа хувь хүнээс тухайн мэдээллээс ямар зүйлийг тусгайлан сонирхож байгаагаа илэрхийлэхийг шаардах ёсгүй. Төрийн байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдол бүртээ татгалзсан шалтгаанаа тайлбарласан зохих үндэслэлээ гарган тавихыг хариуцна. Өөрөөр хэлбэл, тухайн төрийн байгууллагын нээлттэй болгохоос татгалзаж буй мэдээлэл нь хойшид дурьдагдах үл хамаарлуудын хүрээнд багтсан байх ёстой.

Тодорхойлолтууд

“Мэдээлэл”, “төрийн байгууллага” гэсэн ойлголтуудыг өргөн хүрээнд тодорхойлох нь зүйтэй.

“Мэдээлэл” гэж аливаа төрийн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд бүх хэлбэрээр хадгалагдаж байгаа /баримт бичиг, хуурцаг, электроник мэдээлэл г.м/ ямар ч эх сурвалжаас авсан байж болох /тухайн байгууллага буюу өөр байгууллагаас бэлтгэсэн/ болон хэзээ хийгдсэнээс үл хамааруулан бүхий л материалыг хэлнэ. Тэрчлэн энэ хуулийн зохицуулалт нь тусгайлан ангилсан мэдээ мэдээлэлд ч нэгэн адил хамаарна.

Мэдээллийг нээлттэй болгох үүднээс, “төрийн байгууллага” гэсэн ойлголтыг хэрэглэхдээ албан ёсны томилолтоос гадна явуулж буй үйл ажиллагааг нь мөн анхаарсан. Энэ үүднээс уг тодорхойлолтод орон нутгийн эрх барих байгууллагыг оролцуулан засгийн газрын бүхий л шатны байгууллагууд, сонгогдсон байгууллага, тусгай мандаттай ажилладаг байгууллага, улсын үйлдвэрийн газар, төрийн мэдлийн корпораци, “хагас” төрийн бус байгууллага, шүүхийн байгууллага, олон нийтэд үйлчилдэг хувийн байгууллага /зам засвар, төмөр зам г.м/ зэргийг оруулсан болно. Хэрэв хувийн байгууллага олон нийтийн амин чухал ашиг сонирхолд хамаатай байгаль орчин, эрүүл мэнд г.м-ийн талаар мэдээлэл хадгалж байгаа бол дээрх тодорхойлолтод нэгэн адил хамрагдана. Засгийн газар хоорондын байгууллагуудад ч энэхүү баримт бичигт тодорхойлсон зарчмууд мөн хамаарна.

Мэдээллийн эх сурвалжийг устгах

Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж, хүртээмжийг баталгаажуулах хэрэгтэй гэсэн зарчим дээр үндэслэн мэдээлэл хүртэхэд саад болох ба хадгалагдаж буй мэдээллийг санаатайгаар устгах нь гэмт хэрэг мөн гэдгийг хуулиар тогтоох ёстой. Түүнчлэн төрийн байгууллагууд мэдээллийг хадгалж, хамгаалах наад захын стандартыг хуулиар тогтоох нь зүйтэй. Төрийн байгууллагууд олон нийтийн мэдээллийг зохих ёсоор хадгалж хамгаалахын тулд хангалттай хэмжээний хөрөнгө зарцуулж, анхаарал тавих учиртай. Мэдээллийг туйлшруулах болон өөрчлөн засварлах аливаа оролдлогоос сэрэмжлэх үүднээс дотор нь байгаа мэдээлэл төдийгүй түүнийг хадгалж буй эх сурвалжуудыг ч нээлттэй байлгах ёстой.

2-Р ЗАРЧИМ. ХЭВЛЭН НИЙТЛЭХ ҮҮРЭГ

Төрийн байгууллагууд нь чухал мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүргийг хүлээнэ.

Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулна гэдэгт төрийн байгууллагууд зөвхөн мэдээлэл олж авах хүсэлтэд хариу өгөөд зогсохгүй мөн нөөц бололцоо, хүчин чадлынхаа хэмжээгээр олон нийтийн сонирхлыг ихээр татсан онцгой мэдээллийг хэвлэн нийтэлж, тарааж байх үүргээ гүйцэтгэх ажиллагааг багтаадаг. Чухам ямар мэдээллийг хэвлэх нь тухайн төрийн байгууллагаас шалтгаална. Хуулиар хэвлэн нийтлэх ерөнхий үүрэг ба хэвлэгдэж олон нийтэд хүрч байх ёстой мэдээллийн төрлийг тогтоож өгнө.

Төрийн байгууллагууд нь наад зах нь доор дурдсан төрлийн мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэг хүлээнэ:

- Тухайн төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл, түүний дотор зардал, зорилго, тайлан тооцоо, стандарт, үр дүн г.м, ялангуяа тухайн байгууллагын олон нийтэд үзүүлдэг шууд үйлчилгээ
- Олон нийтээс тухайн төрийн байгууллагад шууд хандан мэдээлэл хэрхэн хүсэх буюу гомдол гаргах зэрэг тухай
- Байгууллагын томоохон хэмжээний бодлого, хууль зүйн төсөлд олон нийтийн зүгээс санал бодлоо оруулахад дагах журам, аргачлал

- Тухайн байгууллагад хадгалагдаж буй мэдээллийн төрөл зүйл, хэлбэр
- Олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материалын хамт

3-Р ЗАРЧИМ. НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ

Төрийн байгууллагууд нээлттэй засаглалыг идэвхийлэн дэмжих ёстой.

Мэдээллийн эрх чөлөөг хууль зүйн зохицуулалттай болгохын тулд олон нийтийг мэдээлэл хүртэх эрхээ эдлэх тухай мэдээллээр хангах, засаглалын хүрээнд нээлттэй байх дэг жаягийг дээшлүүлэх явдал нэн тэргүүнд тавигдах ёстой. Нэлээд олон орны туршлагаас харахад хариуцлага муутай иргэний алба хамгийн дэвшилттэй хууль тогтоомжийн ч хүчийг бууруулдаг байна. Тэгэхээр дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь мэдээллийн эрх чөлөөний чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Гэхдээ тухайн орны иргэний алба нь хэрхэн зохион байгуулагдсан, мэдээллийг нээлттэй болгоход саад болдог гол хүчин зүйлс, олон нийтийн ухамсрын ерөнхий төвшин зэргээс шалтгаалан хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг харилцан адилгүй зохион байгуулах хэрэгтэй болдог. Тэгэхээр энэхүү хууль нь эрх зүйн тогтолцооны зорилгыг дэмжсэн ажилд тохиромжтой нөөц бололцоо зарцуулж, бүрэн анхаарлаа хандуулахыг шаардсан байх ёстой юм.

Олон нийтийн боловсрол

Аливаа орон өөрийн мэдээллийн эрх чөлөөний хуульд наад зах нь олон нийтийн боловсрол, мэдээлэл олж авах эрхийн тухай мэдээллийг тараах, мэдээллийн хүрээ, түүнийг олж авах арга хэлбэрийн тухай заасан байх ёстой. Сонин тараалт болон бичиг үсэгт тайлагдалтын хэмжээ доогуур улсад мэдээлэл түгээх, боловсрол олгох явдалд радио телевиз маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хотын уулзалт, зөөврийн кино зэрэг бүтээлч хувилбаруудыг мөн нээн илрүүлэх хэрэгтэй. Иймэрхүү үйл ажиллагааг олон нийтийн байгууллагууд дангаараа хийхээс гадна мэдээлэл өгөх асуудлаар тусгайлан томилогдож, санхүүждэг албан ёсны байгууллага гүйцэтгэвэл илүү үр дүнтэй.

Албаны нууцыг хадгалах заншлыг авч үзэх нь

Засгийн газрын “нууцаа” хаалттай байлгадаг тогтсон хэв маягийг эвдсэн хэд хэдэн механизмыг хуулиар хангаж өгөх ёстой. Үүнд төрийн байгууллагууд өөрийн ажилтнуудад зориулж мэдээллийн эрх чөлөөний тухай сургалт зохион байгуулж байх ч мөн багтана. Уг сургалт нь мэдээллийн эрх чөлөөний хамрах хүрээ, ач холбогдол, мэдээлэл олж авах журам, дараалал, мэдээллийн эх сурвалжийг хэрхэн үр дүнтэй хадгалах ба олж авах, шүгэлдэгчийг хамгаалах хүрээ, ямар төрлийн мэдээллийг тухайн байгууллага хэвлэн нийтлэх үүрэгтэй зэрэг асуудлыг хөндөх ёстой.

Мөн олон нийтийн боловсролын асуудлыг хариуцсан албан ёсны байгууллага засаглалын хүрээнд нээлттэй байдлыг дээшлүүлэхэд өөрийн үүргийг гүйцэтгэх ёстой. Тэр байгууллага нь мэдээллээ тараах ажиллагааг сайн гүйцэтгэж буй төрийн байгууллагыг урамшуулах, нууцлаг асуудалд хандсан кампанит ажил өрнүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулж буй байгууллагыг дэмжих, мэдээллээ нууцалдаг этгээдүүдийг шүүмжлэх зэрэг санаачилга гарган ажиллаж болно. Өөр нэг боломж гэвэл парламент буюу парламентийн байгууллагад жил бүр ололт болон шийдвэрлэх асуудлууд, түүний дотор олон нийтэд мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх, “Мэдээллийн эрх чөлөөний зарчмууд: Олон нийтийн мэдээлэл авах эрх”-ийн талаар доголдолтой байгаа асуудлууд,

мэдээллийн чөлөөт урсгал, дараагийн жилд авах арга хэмжээ зэргийг багтаасан албан ёсны тайланг боловсруулж өргөн барих байж болно.

4-Р ЗАРЧИМ. ҮЛ ХАМААРЛЫН ХЯЗГААРЛАЛТЫН ХҮРЭЭ

Хуулийн үл хамаарлуудыг маш ойлгомжтой, нарийн тодорхойлох ёстой бөгөөд олон нийтэд “аюултай”, “ашиг сонирхолд нь харш” гэсэн хатуу сорилоор давхар шалгана.

Аливаа төрийн байгууллага тухайн мэдээлэл үл хамаарлын хүрээнд багтаж байна гэж үзсэнээс бусад тохиолдолд мэдээлэл авахыг хүссэн хүсэлт бүрийг биелүүлэх ёстой. Төрийн байгууллагын удирдлага нь мэдээллийг нууцлах З хэсэгт сорилын шаардлагыг үндэслэлтэй баталсан тохиолдолд аливаа мэдээллийг өгөхөөс татгалзах эрхтэй.

Гурван хэсэгт сорил

- Уг мэдээлэл хуульд заасан хууль ёсны зорилгод хамаатай байх
- Мэдээллийг задлах нь дээр дурдсан зорилгод заналхийлж, ихээхэн аюул учруулахаар бол
- Дээрх зорилгод учрах аюул занал нь тухайн мэдээллийг нээлттэй болгох олон нийтийн ашиг сонирхлоос илүү их бол зэрэг багтана.

Ямар ч төрийн байгууллагын үйл ажиллагааны ихэнх хувь нь үл хамаарлын хүрээнд багтдаг байсан ч гэсэн хуулийн үйлчлэх хүрээнээс огтоос ангид байж болохгүй. Энэ нь засаглалын бүхий л салбар /гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх/, түүний бүхий л үйл ажиллагаанд /аюулгүй байдлын ба батлан хамгаалах байгууллагууд/ нэгэн адил хамаарна. Мэдээллийг задлахгүй байх нь тухайн тохиолдлоос шалтгаална.

Засгийн газрууд өөрсдийн гэм буруутай үйлдлийг нуун дарахын тулд мэдээлэл өгөхөд хаалт, саад хийх явдлыг хуульд хэзээ ч зөвшөөрөхгүй.

Үл хамаарлын хууль ёсны зорилго

Мэдээллийг хаалттай байлгаж буй шалтгааны хууль ёсны зорилгын бүрэн жагсаалтыг хуульд тусгах ёстой. Энэхүү жагсаалт нь аливаа баримт бичгийг хаалттай байлгах шаардлагатай хууль зүйн үндэс бүхий ашиг сонирхлыг багтаах учиртай бөгөөд зөвхөн хуулийг бэхжүүлэх, хувийн нууц, үндэсний аюулгүй байдал, худалдааны болон бусад нууц, засгийн газрын шийдвэр гаргах процессын үр ашигтай, нэгдмэл байх зэрэг асуудлаар хязгаарлагдана.

Хууль ёсны ашиг сонирхолд үл харшлах мэдээллийг дээрх жагсаалтад оруулахаас сэргийлж үл хамаарлуудыг маш нарийн тодорхойлох хэрэгтэй. Тэдгээрийн баримт бичгийн хэлбэр маягаас илүүтэйгээр агуулгыг нь харгалзан гаргана. Энэхүү стандартад нийцүүлэхийн тулд үл хамаарлуудыг боломжтой бол цаг хугацааны хязгаарлалттай байлгах. Жишээ нь, мэдээллийг үндэсний аюулгүй байдалд заналхийллнэ гэсэн үүднээс нууцласан бол үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн тухайн аюул алга болсноор тухайн үл хамаарал хүчингүй болж болно.

Ноцтой хор хохирол учрах нь гарцаагүй үед л татгалзах ёстой

Мэдээлэл нь зөвхөн хуульд тусгалаа олсон хууль ёсны зорилгын хүрээнд хамаарч байх нь хангалттай бус. Төрийн байгууллага уг мэдээллийг задласнаар тэрхүү хууль ёсны зорилгод хор хохирол учрах болно гэдгийг нотлон харуулах ёстой. Зарим үед мэдээллийг нээлттэй болгох нь учрах хохирлоос ч илүү ашигтай байж болох юм. Жишээ

нь, армид бий болсон авлигын тухай мэдээлэл эхэндээ үндэсний батлан хамгаалахыг сулруулах аюултай мэт санагдавч, цаашдаа авлигыг устгаж, армийг бэхжүүлэхэд тустай. Мэдээллийг нууцалж, хаалттай байлгах нь хууль ёсны үндэслэлтэй гэдгийг батлахын тулд тухайн мэдээллийг задлавал хууль ёсны зорилгод ноцтой хор хохирол учруулна гэдгийг харуулах ёстой.

Олон нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих

Мэдээллийг нээлттэй болгох нь хууль ёсны зорилгод хор хохирол учруулахаар байсан хэдий ч түүнийг нээлттэй болгосноор олох ашиг нь хор хохирлын хэмжээнээс давж гарахаар бол уг мэдээллийг задлах ёстой. Жишээ нь, зарим мэдээлэл хувийн нууцтай холбоотой мэт санагдаж байвч түүний зэрэгцээ энэ нь засгийн газар дахь өндөр хэмжээний авлигыг илэрхийлж байж болно. Энэ тохиолдолд хууль ёсны зорилгод учрах хор хохирлыг уг мэдээллийг олж авахад гарах ашиг сонирхолтой харьцуулж үзэх ёстой. Хэрэв олон нийтийн эрх ашиг илүү чухал байвал тухайн мэдээллийг нээлттэй болгох асуудлыг хуулиар хангаж өгөх ёстой.

5-Р ЗАРЧИМ. МЭДЭЭЛЭЛ ХҮРТЭХ ҮЙЛИЙГ ХӨНГӨВЧЛӨХ ПРОЦЕСС

Мэдээлэл авах хүсэлтийг хурдан шуурхай, шударгаар шийдвэрлэх ёстой бөгөөд аливаа татгалзсан хариу бүрийг үндэслэлтэй нь хамт нээлттэй байлгах ёстой.

Мэдээлэл авах хүсэлтийг 3 үе шатанд шийдвэрлэх бөгөөд үүнд, тухайн төрийн байгууллагын дотоод хүрээнд, бие даасан засаг захиргааны байгууллагад давж заалдах, шүүхэд давж заалдах гэсэн шатууд багтана. Шаардлагатай нөхцөлд тодорхой бүлгийн хүмүүст, жишээ нь уншиж бичиж чаддаггүй, мэдээлэл бичигдсэн хэлээр ярьдаггүй, эсвэл хараагүй гэх мэт тахир дутуу хүмүүст мэдээллийг бүрэн дүүрэн хүргэх арга хэмжээг авна.

Төрийн байгууллага бүр олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангаж чадахуйц нээлттэй, хүртээмжтэй дотоод тогтолцоог бий болгох шаардлагатай. Ингэхдээ, мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хууль сахиулах үүрэгтэй ажилтныг томилно.

Төрийн байгууллагууд нь урьд нь хэвлэгдсэн мэдээлийн талаар гаргасан, эсвэл тодорхойгүй, дэндүү өргөн хүрээг хамарсан, ахин боловсруулах шаардлагатай хүсэлт тавьсан өргөдөл гаргагчид туслах үүрэг хүлээнэ. Нөгөө талаар, төрийн байгууллага үндэслэлгүй, зүй зохисгүй хүсэлтэд татгалзсан хариу өгч байх хэрэгтэй. Төрийн байгууллага өмнө нь хэвлэгдсэн мэдээллийг гарган өгөх албагүй боловч энэ тохиолдолд тухайн өргөдөл гаргагчид хэвлэгдсэн эх сурвалжийн талаар чиглүүлэх заавар өгөх ёстой.

Хуульд хүсэлтийг шийдвэрлэх цаг хугацааны нарийн хязгаарлалт, аливаа татгалзсан хариунд хангалттай шалтгаан бичиж хавсаргах зэргийг тусган оруулах ёстой.

Давж заалдах

Тохиромжтой нөхцөлд, төрийн байгууллагын ажилтны гаргасан шийдвэрийн талаар тухайн хүсэлт гаргагчаас уг байгууллагын илүү мэдэл, хянах эрх бүхий ажилтанд хандах эрх, тогтолцоог хуульд тусгаж өгнө.

Ямар ч тохиолдолд хувь хүнд буюу хүсэлт гаргагчид төрийн байгууллагаас мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд уг хүн бие даасан захиргааны байгууллагад давж

заалдах эрхийг хуулиар хангах учиртай. Энэ нь Омбудсмен эсвэл Хүний Эрхийн Хороо зэрэг одоо байгаа байгууллагууд буюу эсвэл уг зорилгын үүднээс тусгайлан байгуулсан байгууллага байж болно. Аль ч тохиолдолд уг байгууллага тодорхой стандартыг хангаж, тодорхой эрх мэдэлтэй байна. Түүний бие даасан байдал албан ёсоор болон түүний дарга, удирдах зөвлөлийг сонгох журмаар давхар баталгаажна.

Томилгоог төлөөлөгчдийн байгууллагаас, бүх намын төлөөлөлтэй парламентийн хорооноос ч юм уу хийх ба ингэхдээ олон нийтэд нээлттэй, тэдний оролцоог /жишээ нь, нэр дэвшүүлэхэд/ авах ёстой. Ийм байгууллагад ажиллахаар томилогдсон хувь хүн мэргэжлийн өндөр стандартыг хангасан, бие даасан байдал, өндөр ур чадвартай, сонирхлын бүлгийн зөрчилдөөнд автагдахгүй байх ёстой.

Эрх бүхий байгууллага нь мэдээлэл өгөхөөс татгалзсан асуудлаар давж заалдсан өргөдлийг шийдвэрлэхдээ аль болох түргэн шуурхай, бага төлбөртэйгээр хийх ёстой. Ингэснээрээ олон нийтэд уг процедур хүртээмжтэй байж, хэт удаан хойшлуулснаар мэдээлэл авах хүсэлтийн гол зорилгыг алдагдуулахаас сэргийлэх ач холбогдолтой.

Эрх бүхий байгууллага давж заалдсан өргөдлийг хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй байх бөгөөд түүний дотор гэрчийн этгээдүүдийг асуух, хамгийн гол нь тухайн төрийн байгууллагаас мэдээлэл, мэдээллийн эх сурвалжийг шаардлагатай бөгөөд хууль ёсны гэж үзсэн тохиолдолд авах эрхтэй байна.

Эрх бүхий байгууллага өргөдлийг хянан шийдвэрлэхдээ түүнийг авч хэлэлцэхгүй байх, төрийн байгууллагаас мэдээллээ нээлттэй болгохыг шаардах, төрийн байгууллагаас хурааж авсан аливаа төлбөрийн хэмжээг зохицуулах, хууль бус үйлдэл хийсэн төрийн байгууллагад торгууль ногдуулах буюу давж заалдсан өргөдөлтэй холбогдон гарсан зардлыг төрийн байгууллагаар төлүүлэх шийдвэр гаргаж болно.

Түүнчлэн эрх бүхий байгууллага гэмт хэргийн холбогдолтой гэж үзэх буюу эсвэл мэдээллийг санаатайгаар устгасан гэж үзсэн тохиолдолд асуудлыг шүүхэд шилжүүлж болно.

Өргөдөл гаргагч, төрийн байгууллага хоёрын аль аль нь эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн эсрэг шүүхэд давж заалдах эрхтэй. Шүүх нь давж заалдсан өргөдлийн дагуу өмнөх шатны эрх бүхий байгууллага зөв шийдвэр гаргасан эсэхийг шалгахад гадна уг хэргийг бүхэлд нь авч үзэх хэрэгтэй юм. Ингэснээр бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлээд зогсохгүй мэдээллийн эрх чөлөөнд тууштай хандах үндсийг бүрдүүлэх юм.

6-Р ЗАРЧИМ. ХУРААМЖ

Хувь хүмүүс мэдээлэл авах хүсэлт гаргахад өндөр үнээр нь саад болох ёсгүй.

Төрийн байгууллагад хадгалагдаж буй мэдээллийг олж авах үнэ төлбөр нь хүсэлт гаргахаар шийдсэн хувь хүн төлөх боломжгүй өндөр үнэтэй байх ёсгүй. Үүнд мэдээллийн эрх чөлөөний хуулийн хамгийн гол цөм бол мэдээлэлд нээлттэй хүрэх явдлыг хөхиүлэн дэмжих явдал билээ. Нээлттэй байхын хожим өгөх үр ашиг нь үнэ төлбөрөөс хамаагүй илүү байдаг гэдэг нь аль хэдийнээ нотлогдсон зүйл мөн. Нэлээд олон орны туршлагаас үзэхэд мэдээлэл олж авахдаа мөнгө төлөх нь мэдээллийн эрх чөлөөт байдлын зардлыг нөхөн төлөх үр ашигтай арга биш гэдэг нь харагдсан байна.

Дэлхийд дээрх төлбөрийг мэдээлэл олж авах хүсэлтэд саад болохгүйгээр тогтоохын тулд олон төрлийн систем хэрэглэдэг. Зарим орны хуульд 2 шатлалтай системийг

хэрэглэдэг ба энэ нь гаргасан хүсэлт бүрт тогтсон төлбөрөөс гадна уг мэдээллийг олж өгөхөд гарсан бодит зардлаас хамаарсан хэлбэлзэлтэй хураамж юм. Сүүлчийнх нь хувь хүний болоод олон нийтийн эрх ашигт зориулан мэдээлэл олж авахыг хүссэн тохиолдолд нэлээд хэмжээгээр ашиглагддаг.

7-Р ЗАРЧИМ. НЭЭЛТТЭЙ ХУРАЛДААН

Төрийн байгууллагуудын хуралдаан олон нийтэд нээлттэй байх ёстой.

Мэдээллийн эрх чөлөө нь олон нийт нь засгийн газар олон нийтийн нэрийн өмнөөс юу хийж байгааг мэдэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхтэй байхыг мөн багтаана. Тиймээс мэдээллийн эрх чөлөөг хуулиар зохицуулахдаа эрх барьж буй байгууллагуудын бүх хурал олон нийтэд нээлттэй байх ёстой гэсэн зарчмыг баримтлах ёстой.

Дээр дурьдагдсан “эрх барьж буй” байгууллага гэдэг ойлголтод шийдвэр гаргах эрх бүхий байгууллагыг хамааруулсан ба зөвлөгөө өгөх төдий эрхтэй байгууллагыг оруулаагүй. Улс төрийн зөвлөл буюу нэг улс төрийн намын гишүүдийн хурлыг “эрх барьж буй” байгууллага гэж үзээгүй.

Нөгөө талаас, сонгогдсон байгууллагууд, тэдгээрийн зөвлөлийн хурал, төлөвлөгөөний зөвлөл, олон нийтийн ба боловсролын байгууллагын удирдах зөвлөл, төрийн мэдлийн үйлдвэрлэлийн хөгжлийн агентлаг зэргийг багтааж болох юм.

Энд “хуралдаан” гэж албан ёсны хурал, тодруулбал олон нийтийн асуудлаар төрийн байгууллага албан ёсоор хуралдахыг ойлгоно. Уг хурал албан ёсны эсэхийг түүний кворум, албан ёсны хурлын дэгийн үйлчлэл зэргээр нь тодорхойлно. Олон нийтэд жинхэнэ ёсоор оролцох бололцоо олгохын тулд хурлын тухай зарлах ёстой бөгөөд хуулиар уг зарыг хурал болохоос хангалттай хугацааны өмнө урьдчилан тараана гэж заах шаардлагатай.

Хуралдааныг хаалттай явуулж болох ба ингэхдээ мөрдөгдөж буй дүрэм журамд нийцүүлнэ. Хуралдааныг хаалттай явуулах аливаа шийдвэр олон нийтэд нээлттэй байх ёстой. Хуралдааныг хаалттай явуулах шалтгаан нь өмнө дурьдсан нээлттэй байх зарчмын үл хамаарлын жагсаалтаас илүү өргөн боловч хязгааргүй биш. Хаалттай хуралдах шалтгаанууд нь тухайн тохиолдол бүрт харилцан адилгүй буюу олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хууль сахиулах, мөрдөх ажиллагаа, ажиллах хүчний асуудал, хувийн эрх чөлөө, худалдааны асуудал, үндэсний аюулгүй байдал зэрэг байж болно.

8-Р ЗАРЧИМ. НЭЭЛТТЭЙ БАЙХЫГ НЭН ТЭРГҮҮНД ТАВИХ

Дээд зэргээр нээлттэй байх зарчимтай харшилдсан аливаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох ёстой.

Уг хуулийг баталбал мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай бусад хууль тогтоомж түүний заалтуудыг аль болох тохируулах шаардлага гарна. Хэрэв энэ нь боломжгүй бол олон нийтийн мэдээлэлтэй холбоотой бусад хууль тогтоомжууд мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн байх ёстой. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасан үл хамаарлуудын хязгаарлалт нь төгс ойлгомжтой байх ёстой бөгөөд ингэснээрээ бусад хууль тэдгээрийг өргөжүүлж хэрэглэхээс сэргийлнэ. Ялангуяа, нууцын тухай хуульд мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу

задлах шаардлагатай мэдээллийг задласан албан тушаалтныг хууль бус үйлдэл хийсэн хэмээн заах ёсгүй.

Цаашид мэдээлэлтэй холбоотой бүх хуулийг мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн тулгуур зарчмуудад нийцүүлэн багцлахыг эрмэлзэх учиртай.

Түүнчлэн нууцлах ангиллын мэдээллийг сайн санааны үүднээс, мэдээллийн эрх чөлөөний зарчмын үүднээс тодорхой үндэслэлтэй задалсан аливаа ажилтанд ял зэмлэл тооцох ёсгүй. Эс бөгөөс ямар нэг ял зэмлэл хүртэхээс сэрэмжилсэн ажилтан ажлаа хангалттай сайн хийж чадахгүй болж улмаар энэ тухайн байгууллага мэдээлэл нуун дарагдуулах нэг завшаан болно.

9-Р ЗАРЧИМ. “МЭДЭЭЛЭГЧИЙГ” ХАМГААЛАХ

Гэм буруутай үйлдлийн тухай мэдээлэл тарааж буй хувь хүмүүс буюу “шүгэлдэгчийг” хамгаалах ёстой.

Гэм буруутай үйлдлийн тухай мэдээлэл тарааж буй хувь хүмүүс буюу “шүгэлдэгчид”ийг хуулийн, захиргааны эсвэл ажил олголттой холбоотой аливаа шийтгэлээс хамгаалах ёстой.

“Гэм буруутай үйлдэл” гэдэгт гэмт хэрэг үйлдэх, хууль ёсны үүргээ зөрчих, шударга ёсыг хөсөрдүүлэх, авлига ба шударга бус явдалд автах, төрийн байгууллагыг ноцтойгоор завхруулан удирдах зэргийг багтаан ойлгоно. Үүнд мөн хувь хүний гэм буруутай үйлдэлтэй холбоотой эсэхээс үл хамааран эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд учруулж буй аюул заналыг багтаан үзнэ. “мэдээлэгч” нь хэрэв сайн санааны үүднээс, тухайн мэдээлэл үнэн бөгөөд гэм буруутай үйлдлийг илчилж чадна гэдэгт итгэлтэй байсны үүднээс хандсан тохиолдолд хамгаалалт эдлэх эрхтэй болно. Уг хамгаалалт нь өөр тохиолдолд бол хуулийн болон ажлын шаардлагыг зөрчихөөр байсан үед ч нэгэн адил үйлчилнэ.

Зарим оронд “мэдээлэгчийг” уг мэдээллээ тодорхой хувь хүн, байгууллагад гаргаж өгсөн нөхцөлд хамгаална гэдэг. Энэ зарчмыг ерөнхийд нь хэрэглэж болох боловч, олон нийтийн эрх ашигт хамаатай асуудал бол уг мэдээллийг хувь хүмүүст тэр ч бүү хэл мэдээллийн хэрэгсэлд гаргаж өгсөн тохиолдолд ч “мэдээлэгчийг” хамгаалах ёстой.

Энд “олон нийтийн эрх ашиг” гэж мэдээллийг задлах нь хор хохирлоосоо илүү ашиг авчрах, амин чухал ашиг сонирхлыг хамгаалахын тулд мэдээллийг өөр маягаар тараах шаардлагатай нөхцлүүдийг хамруулж ойлгоно. Тухайн буруутай үйлдлийг зохих журмаар илрүүлэн, шийдвэрлэх боломжгүй, маш онцгой шалтгаантай, цаашилбал нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулж байгаа эсвэл тухайн мэдээг дэлгэн тавихгүй бол гэм буруутай үйлдлийн баталгаа арилах аюултай зэргийг багтааж дээрх нөхцөлд мэдээлэл тараасан хүмүүсийг хууль ёсны хамгаалалтанд авна гэж зааж өгнө.



МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ЗАГВАР ХУУЛЬ

Танилцуулга

Мэдээллийн эрх чөлөө нь олон улсын эрх зүйгээр баталгаажсан байдаг бөгөөд Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд заасан үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний нэг хэсэг болдог. Дэлхийн олон улс орон энэхүү эрхийг хууль ёсны болгоход анхаарал тавьж буй бөгөөд энэ нь Үндсэн хуулиндаа мэдээлэл авах эрх чөлөөг баталгаажуулан оруулах буюу уг эрхийг хэрэгжүүлэх тодорхой механизмыг хангаж чадахуйц практик ач холбогдолтой хууль батлан гаргах зэргээр илэрч байна.

Мэдээллийн эрх чөлөөний тухай “загвар” хууль нь “Article 19” байгууллагаас хэвлэн гаргасан “Олон түмний мэдээлэл авах эрх: Мэдээллийн эрх чөлөөний хууль, эрх зүйн үндсэн зарчмууд” бүтээл болон олон улсын бусад олон тооны мэдээллийн эрх чөлөөний хуулиуд зэрэгт тусгагдсан олон улсын шилдэг практик дээр үндэслэсэн билээ. Уг бүтээлээр нэн ялангуяа Зүүн Азийн орнуудын мэдээллийн эрх чөлөөний хэрэгцээ, шаардлагад хариулт өгөхийг зорьсон бөгөөд тиймээс ч нийтийн эрх зүйн хуулийн төсөл бичих арга хэлбэрийг тусгасан болно.

Түүний зэрэгцээгээр, уг “загвар” хууль нь энэ хүрээний нийтлэг стандартыг төлөөлж буйн хувьд иргэний эрх зүйт бусад орнуудад ч мөн хамаатай.

Энд дурдагдаж буй “загвар” хэмээх нэр томъёог хэрэглэхдээ улс орнууд үүнийг өөрийн хууль, эрх зүйд хатуу тогтсон бэлэн загвар болгон ашиглаасан гэсэн санаа агуулаагүй. Орон бүрийн мэдээллийн хэрэгцээ, мэдээллийн тогтолцоо нь өөр байдаг учир түүндээ тохирсон хуультай байх ёстой. Тиймээс “загвар” хэмээх нэр томъёог энд дурдсан заалтуудыг багтаасан хууль амьдрал дээр мэдээллийг илүү нээлттэй болгох, мэдээлэл авах эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадна гэсэн утгаар хэрэглэв.

Мэдээллийн эрх чөлөөний тухай загвар хууль нь (цаашид “хууль” гэх) төрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа мэдээллийг хүсэлт гарган хууль ёсоор олж авах эрхийг хангаж байгаа юм. Хүн бүр энэ эрхээ эдлэхийг шаардаж болох бөгөөд мэдээллийн болон төрийн байгууллагуудыг өргөн дэлгэр тодорхойлсон.

Уг хуулиар аливаа эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах шаардлагатай уялдан хувийн байгууллагуудад хадгалагдаж байгаа мэдээллийг олж авах хязгаарлагдмал эрхийг мөн олгосон. Ингэснээр их хэмжээний чухал мэдээллүүд хувийн байгууллагуудад хадгалагдаж байдаг учир тэднийг хуулийн хүрээнээс гаргах нь мэдээллийн эрх

чөлөөг нэлээдгүй боогдуулсан болохыг хүлээн зөвшөөрсөн Өмнөд Африкийн хууль тогтоомжийн жишээг дагасан хэрэг.

Процедурын хувьд, хуульд энэхүү хуулийн зорилтыг хангах үүрэг бүхий мэдээлэл хариуцсан ажилтныг томилох шаардлагыг төрийн байгууллагуудад тавьсан. Гэхдээ, мэдээлэл авах хүсэлтийг тухайн байгууллагын аль ч албан тушаалтанд хандан тавьж болно. Хүсэлтийг 20 хоногийн дотор, хүсэлтийн хэмжээ нь хэрэв уг хугацаанд багтаааргүй их бол хугацааг 40 хоног болгон сунгана. Хэрэв тухайн мэдээлэл хүний амь нас, эрх чөлөөтэй холбоотой бол 48 цагийн дотор гаргаж өгөх ёстой. Хүсэлт гаргаж буй этгээд уг мэдээллийг ямар хэлбэрээр авахыг эрхэмлэж буйгаа тодорхой дурдах ёстой. Хураамж нь уг мэдээллийг олж бэлэн болгоход гаргасан бодит зардлаас хэтрэх ёсгүй бөгөөд хувь хүн болон олон нийтийн эрх ашгийн үүднээс уг хүсэлтийг тавьсан бол хураамж төлөхгүй байж болно.

Хамгийн гол нь энэ хуульд мэдээлэл өгөхөөс татгалзсан аливаа шийдвэрийг хянан үзэх бүрэн эрхтэй, бие даасан Мэдээллийн Коммиссарыг энэхүү хуулийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг дээшлүүлэх ерөнхий мандаттайгаар томилох нөхцлийг хангаж өгсөн. Коммиссар нь өргөдөл, гомдол хүлээж авахаас гадна хуулийн биелэлтэд өөрийн зүгээс хяналт тавина. Тэрээр аливаа байгууллагаас мэдээллээ ил тод болгохыг шаардах, тэр ч бүү хэл энэхүү хуулийн заалтыг зөрчсөн этгээдэд торгууль ногдуулах эрхтэй.

Хуульд нэлээд тооны үл хамаарлыг олон улсын практиктай нийцүүлэн оруулсан ба тэдгээр нь хувийн мэдээлэл, худалдааны ба итгэмжлэгдсэн мэдээлэл, эрүүл мэнд ба аюулгүй байдал, хуулийн шаардлага, батлан хамгаалах, бодлого тодорхойлох зэрэг болно. Гэхдээ эдгээр нь олон нийтийн амин чухал эрх ашиг, цаг хугацааны хязгаарлалтаас хамааран хүчингүй болж болно.

Хуулийн 3-р бүлэгт төрийн байгууллагын нэлээд тооны эерэг үүрэг, түүний дотор зарим төрлийн мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэг, Коммиссараас гаргасан хэрэгжүүлэх журамд нийцүүлэн мэдээллийг зохистой хадгалах зэргийг багтаасан.

Хуулийн 6-р бүлэгт “мэдээлэгчид” буюу гэмт үйлдлийн тухай мэдээлэл тараасан хүмүүсийг хамгаалах асуудлыг тусгасан бөгөөд хэрэв сайн санааны үүднээс, мэдээллийн үнэн зөв гэдэгт зохих итгэл үнэмшилтэйгээр, уг мэдээлэл гэмт үйлдэл, эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд учрах хохирлын талаар нотолгоо болж чадна гэсэн үүднээс тухайн мэдээллийг задалсан тохиолдолд уг хамгаалалт хүчинтэй.

Мэдээллийн эрх чөлөөний тухай загвар хууль нь хүсэлтийн дагуу мэдээллийг сайн санааны үүднээс задалсан хүмүүсийг хамгаалж, санаатайгаар мэдээлэл олж авахад саад учруулсан, эсвэл мэдээллийг устгасан этгээдүүдэд гэм бурууг ногдуулах учиртай.

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ЗАГВАР ХУУЛЬ

Бүлгүүдийн зохион байгуулалт

БҮЛЭГ I. ТОДОРХОЙЛОЛТ, ЗОРИЛГО

1. Тодорхойлолт
2. Зорилго

БҮЛЭГ II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХАДГАЛАГДАЖ БУЙ МЭДЭЭЛЛИЙГ ОЛЖ АВАХ ЭРХ

3. Мэдээллийн эрх чөлөө
4. Мэдээлэл олж авах үндсэн эрх
5. Мэдээллийг нээлттэй болгохыг хориглох буюу хязгаарлах
6. Төрийн болон хувийн байгууллагууд
7. Хадгалагдаж буй мэдээлэл
8. Мэдээлэл авах хүсэлт гаргах
9. Хүсэлтэд хариу өгөх хугацаа
10. Хүсэлтэд хариу өгөх цаг хугацааны хязгаарлалт
11. Бичгээр хариулт өгөх
12. Хураамж
13. Мэдээллийг дамжуулах арга хэрэгсэл
14. Зүй зохисгүй, давтагдсан, утгагүй хүсэлтүүд

БҮЛЭГ III. НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

15. Хуулийг хэрэглэх гарын авлага
16. Мэдээлэл хариуцсан ажилтан
17. Хэвлэн нийтлэх үүрэг
18. Хэвлэн нийтлэх үүргийн тухай гарын авлага
19. Мэдээллийг хадгалах
20. Ажилтнуудыг сургах
21. Мэдээллийн Коммисарт тайлагнах

БҮЛЭГ IV. ҮЛ ХАМААРЛУУД

22. Олон нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих
23. Аль хэдийн олонд түгсэн мэдээлэл
24. Мэдээллийг хэсэгчлэх
25. Хувийн мэдээлэл
26. Хууль ёсны давуу эрх

27. Худалдааны болон итгэмжилсэн мэдээлэл
28. Эрүүл мэнд ба аюулгүй байдал
29. Хуулийн шалтгаан
30. Батлан хамгаалах, аюулгүй байдал
31. Олон нийтийн эдийн засгийн ашиг сонирхол
32. Төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагаа
33. Цаг хугацааны хязгаарлалт

БҮЛЭГ V. МЭДЭЭЛЛИЙН КОММИСАР

34. Мэдээллийн Коммисарыг томилох
35. Бүрэн эрхт байдал, эрх мэдэл
36. Цалин, зардал
37. Ажилтнууд
38. Ерөнхий үйл ажиллагаа
39. Тайлагнах
40. Коммиссарыг хамгаалах

БҮЛЭГ VI. КОММИССАРЫН ЭРХ МЭДЭЛ

41. Коммиссарт гомдол гаргах
42. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх
43. Шийдвэрийг шууд хэрэгжүүлэх
44. Коммиссарын мөрдөн шалгах эрх
45. Коммиссарын гаргасан шийдвэр, тушаалыг давж заалдах
46. Коммиссарын гаргасан шийдвэр, тушаалын заавал биелүүлэх чанар

БҮЛЭГ VII. “МЭДЭЭЛЭГЧ”

47. “Мэдээлэгч”

БҮЛЭГ VIII. ЭРҮҮГИЙН БОЛОН ИРГЭНИЙ ХАРИУЦЛАГА

48. Сайн санааны үүднээс мэдээллийг задлах
49. Эрүүгийн эрх зүйн зөрчил

БҮЛЭГ IX. БУСАД ЗҮЙЛ

50. Журам
51. Тайлбарлах
52. Хуулийн нэр ба үйлчилж эхлэх хугацаа

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ЗАГВАР ХУУЛЬ

Энэхүү хууль нь олон нийтийн эрх ашигт нийцүүлэн мэдээллийн чөлөөт байдлыг дээд зэргээр хөгжүүлэх, хүн бүрийн мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах, уг эрхийг сахин хамгаалах хамгийн үр ашигтай механизмыг бий болгоход чиглэгдэнэ.

Хуулийг дор дурдсанаар (Парламент г.м зохих эрх бүхий байгууллагын нэр) тогтоов.

БҮЛЭГ I: ТОДОРХОЙЛОЛТ, ЗОРИЛТ

1.Тодорхойлолт

1.1. Энэхүү хуульд хам бичвэр өөрөөр шаардахүй бол:

- а. “Комиссар” гэж хам бичвэрээс шалтгаалан 5-р бүлэгт заасан мэдээллийн Комиссарын алба эсвэл уг албыг гүйцэтгэгч,
- б. “Мэдээллийн ажилтан” гэж энэхүү хуулиар тусгай үүрэг хариуцлага хүлээж буй, 16 зүйлийн 1-д заасны дагуу төрийн байгууллага бүрт томилогдсон хувь хүн,
- в. “Ажилтан” гэж эрх бүхий байгууллагад орон тооны болон орон тооны бус, бүтэн цагаар буюу хагас цагаар ажиллаж буй аливаа этгээд,
- г. “Сайд” гэж засгийн газрын хууль сахиулах үүрэг хүлээсэн сайд,
- д. “Хувийн байгууллага” гэж 6-р дэд зүйлийн 3-т тодорхойлсон байгууллага
- е. “Төрийн байгууллага” гэж 6-р дэд зүйлийн 1 ба 2-т тодорхойлсон байгууллага
- ё. “Хэвлэн нийтлэх” гэж мэдээллийг олон нийтэд зориулан хэвлэх, радио телевизээр цацах, электроник хэлбэрээр тараах,
- ж. “Хувь хүний мэдээлэл” гэж тэрхүү мэдээллээс танигдаж болох амьд буй хүнд хамаатай мэдээлэл
- з. “Хадгалагдаж буй мэдээлэл” гэж 7-р зүйлд тодорхойлсон мэдээлэл

2. Зорилго

2.1. Энэхүү хуулийн зорилго нь:

- а. Төрийн байгууллагуудад хадгалагдаж буй мэдээллийг тэрхүү мэдээлэл нь олон нийтэд хүртээмжтэй байх ёстой гэсэн зарчмын үндсэн дээр чөлөөтэй олж авах эрхийг хангах, мэдээлэл олж авах эрхийн үл хамаарлууд нь хязгаарлагдмал бөгөөд тодорхой байх тийм мэдээллийг нээлттэй болгохдоо засгийн газраас бие даасан байх
- б. Хязгаарлагдмал, онцгой тохиолдолд аливаа эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах шаардлагатай уялдан хувийн байгууллагуудад хадгалагдаж байгаа мэдээллийг олж авах эрхийг хангах.

БҮЛЭГ II: ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН БАЙГУУЛЛАГУУДААС МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ЭРХ**3. Мэдээллийн эрх чөлөө**

- 3.1. Хүн бүр мэдээллийн эрх чөлөөг эдлэх эрхтэй бөгөөд түүний дотор энэхүү хуульд заасан үндэслэлээр төрийн байгууллагуудаас мэдээлэл олж авах эрхтэй.

4. Мэдээлэл олж авах үндсэн эрх

- 4.1. Энэ хуулийн 2, 3-р бүлэгт заасны дагуу төрийн байгууллагаас мэдээлэл авахыг хүссэн аливаа хүн доорх эрхийг эдэлнэ:
- а. төрийн байгууллагад хүссэн мэдээллийнх нь эх сурвалж хадгалагдаж байгаа эсэх талаар мэдэгдэл авах
 - б. хэрэв төрийн байгууллагад уг мэдээлэл хадгалагдаж буй тохиолдолд түүнийг дамжуулан авах
- 4.2. Аливаа эрхийг хэрэгжүүлэх буюу хамгаалахтай холбогдуулан хувийн байгууллагаас мэдээлэл авах хүсэлт тавьсан хүн зөвхөн энэхүү хуулийн 2, 3-р бүлгийн тохирох заалтуудын дагуу уг мэдээллийг олж авах буюу дамжуулан авах эрхтэй.

5. Мэдээллийн нээлттэй байдлыг хориглох, хязгаарлах эрх зүйн зохицуулалт

- 5.1. Энэхүү хууль бусад хуулиар төрийн буюу хувийн байгууллагаас задруулахыг хориглосон буюу хязгаарласан мэдээлэлд хамаарахгүй.
- 5.2. Энэхүү хуулийн ямарваа нэг заалт бусад хууль, бодлого, практикаар ил тод болгосон мэдээллийг хязгаарлахад ашиглагдах ёсгүй.

6. Төрийн болон хувийн байгууллагууд

- 6.1. Энэ хуульд дурдагдаж буй төрийн байгууллага гэдэг нь:
- а. Үндсэн хуулиар буюу үндсэн хуулийн харьяанд байгуулагдсан,
 - б. Парламентийн хуульчилсан актаар байгуулагдсан,
 - в. Засгийн газрын аль нэг шат буюу салбарын хэсэг болдог,
 - г. Засгийн газар, төрийн мэдэлд байдаг, үйл ажиллагааг нь хянадаг, санхүүжүүлдэг,
 - д. Хууль ёсны болон төрийн албан үүрэг гүйцэтгэдэг байгууллага
- 6.2. Сайд олон нийтэд зориулан үйл ажиллагаагаа явуулж буй аливаа байгууллагыг тушаал гарган төрийн байгууллагад тооцож болно.
- 6.3. Энэхүү хуулийн зорилтын үүднээс доорх үйл ажиллагааг эрхлэн явуулж буй төрийн бус байгууллагыг хувийн байгууллага гэнэ:
- а. худалдаа, бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй
 - б. хуулийн этгээд

7. Хадгалагдаж буй мэдээлэл

- 7.1. Энэхүү хуульд зааснаар хадгалагдаж буй мэдээлэл гэдэгт хэлбэр, эх сурвалж, хийгдсэн огноо, албан ёсны статус, тухайн байгууллагаар хийгдсэн эсэх, ялгаж ангилсан эсэхээс үл хамааран бүхий л төрлийн мэдээллийг ойлгоно.
- 7.2. Доорх тохиолдолд төрийн буюу хувийн байгууллага мэдээллийг хадгалж байгаа гэж үзнэ:
 - а. төрийн буюу хувийн байгууллага уг мэдээллийг өөр бусад этгээдийн нэрийн өмнөөс хадгалж буйгаас бусад тохиолдолд
 - б. өөр этгээд төрийн буюу хувийн байгууллагын нэрийн өмнөөс тухайн мэдээллийг хадгалж байгаа

8. Мэдээлэл авахыг хүсэх

- 8.1. 4-р зүйлд заасныг үндэслэн төрийн буюу хувийн байгууллагын албан тушаалтанд бичгээр илэрхийлсэн бөгөөд тухайн байгууллага уг мэдээллийг хадгалж буй эсэхийг мэдэхийг хүссэн хүсэлтийг мэдээлэл авах хүсэлт гэж ойлгоно. Ингэхдээ уг хүсэлт нь хангалттай нарийвчилсан, туршлага бүхий ажилтан зохих чармайлтын дүнд тодорхойлж чадахуйц байх ёстой.
- 8.2. 4-р зүйлийн 1-д заасны дагуу гаргасан хүсэлт 1-р заалтын шаардлагыг хангахгүй бол уг хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан 5-р заалтад заасны дагуу тухайн хүсэлтийг 1-р заалтад дурдсан шаардлагыг хангахуйц болгоход үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ёстой.
- 8.3. Тухайн хүн бичиг үсэг үл мэдэх болон тахир дутуу байдлаасаа шалтгаалан хүсэлтээ бичгээр илэрхийлэх боломжгүй бол хүсэлтийг амаар хүлээн авсан албан тушаалтан 5-р заалтад нийцүүлэн өөрийн нэр, албан тушаалыг оролцуулан бичгээр буулгах бөгөөд нэг хувийг хүсэлт гаргагчид өгнө.
- 8.4. 4-р зүйлийн 2-т заасан мэдээлэл авах хүсэлтэд уг мэдээллээр хэрэгжүүлэх буюу хамгаалах эрхийг тодорхой зааж, ямар учраас энэ зорилгод уг мэдээлэл шаардлагатай байгааг тодорхой бичих ёстой.
- 8.5. Мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан түүнийг 2, 3-р заалтад нийцүүлэн Мэдээлэл хариуцсан ажилтанд шилжүүлж болно.
- 8.6. Төрийн буюу хувийн байгууллага хүсэлтийг тодорхой хэлбэрээр тавих шаардалага тавьж болох бөгөөд ингэхдээ тэр хэлбэр нь хүсэлтийг удаан хугацаагаар хойшлуулах, эсвэл хүсэлт гаргагчид хэтэрхий төвөг учрахаар байх ёсгүй.
- 8.7. Хүсэлтийг хүлээн авсан төрийн буюу хувийн байгууллага хүсэлтийг хүлээн авсан тухай хүсэлт гаргагчид нотолсон бичиг өгөх ёстой.

9. Хүсэлтэд хариу өгөх цаг хугацааны хязгаарлалт

- 9.1. 3-р дэд зүйлд заасан төрийн ба хувийн байгууллага 4-р зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдээлэл олж авах хүсэлтийг аль болох түргэн хугацаанд, хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан шийдвэрлэх ёстой.

- 9.2. Олж авахыг хүссэн тухайн мэдээлэл нь хувь хүний эрх чөлөө, амь насыг хамгаалахтай холбоотой гэдэг нь илэрхий бол, хүсэлтэд 48 цагийн дотор хариу өгнө.
- 9.3. Төрийн болон хувийн байгууллага нь тухайн хүсэлт нь олон тооны эх сурвалжийг багтаасан эсвэл түүнд хариу өгөхийн тулд маш их хэмжээний эх сурвалжаас хайлт хийхэд хүрсэн бөгөөд тухайн байгууллага ажлын 20 өдөрт багтаан гаргах боломжгүй бол хариу өгөх хугацааг сунгах тухай эхний 20 өдөрт багтаан бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ямар ч тохиолдолд сунгах хугацаа нь 40 ажлын өдрөөс хэтрэх ёсгүй.
- 9.4. 1-р дэд зүйлд заасан нөхцлийг хангаж чадаагүй бол хүсэлтэд татгалзсан гэж тооцогдоно.

10. Бичгээр хариулт өгөх

- 10.1.4-р зүйлийн 1-д заасан мэдээллийг олж авах хүсэлтийг 9-р зүйлд заасны дагуу гаргасан бол хариултыг бичгээр өгөх ба доорх зүйлийг багтаасан байна:
- а. хүсэлтэд өгсөн хариуны аливаа хэсэг бүрт гарсан зардал, мэдээллийг дамжуулсан арга хэлбэрээс шалтгаалан 11-р зүйлд заасан зохих хураамж
 - б. энэхүү хуулийн 5-р бүлэгт зааснаар хүсэлтийн аль нэг хэсэгт татгалзсан хариу өгсөн бол тэр тухай зохих шалтгаанууд
 - в. тухайн төрийн байгууллагад уг мэдээллийн эх сурвалжийг хадгалагдаж, эс хадгалдагдаж байгаатай холбоотой гаргасан татгалзал, татгалзсан баримт, зохих шалтгаан
 - г. хүсэлт тавьсан хүний давж заалдах аливаа эрх
- 10.2.4-р зүйлийн 2-д заасан мэдээллийг олж авах хүсэлтийг 9-р зүйлд заасны дагуу гаргасан бол хариултыг бичгээр өгөх ба доорх зүйлийг багтаасан байна:
- а. хүсэлтэд өгсөн хариуны аливаа хэсэг бүрт гарсан зардал, мэдээллийг дамжуулсан арга хэлбэрээс шалтгаалан 11-р зүйлд заасан зохих хураамж
 - б. хүсэлтийн хариу өгөөгүй хэсэг бүрт татгалзсан зохих шалтгаан
- 10.3. Тухайн хүсэлтэд хариу өгсөн аливаа хэсэгтэй холбогдуулан уг мэдээллийг 11-р зүйлд заасны дагуу дамжуулна.

11. Хураамж

- 11.1. Төрийн буюу хувийн байгууллага 4-р зүйлд заасны дагуу мэдээлэл дамжуулахдаа 2, 3-р заалтын дагуу тодорхой нөхцөлөөр, тухайн мэдээллийг хайж олох, бэлтгэх, дамжуулахтай холбогдон гарсан жинхэнэ өртгөөс хэтрээгүй хураамж төлөхийг хүснэ.
- 11.2. Хувийн нууц болон олон нийтийн эрх ашигт нийцүүлэн тавьсан хүсэлтээс хураамж авахгүй.
- 11.3. Сайд Коммиссартай зөвлөлдсөний үндсэн дээр доорх журмыг тогтооно:
- а. хураамжийг хэрхэн тооцох
 - б. тодорхой нөхцөлд хураамж төлөхгүй байх

в. хураамж нь тодорхой хэмжээнээс хэтрэхгүй байх

11.4.1-р заалтад дурдсанчлан төрийн байгууллага тухайн хураамжийг хураан авахад гарах зардал нь уг хураамжаас давах нөхцөлд хураамж төлөхийг шаардахгүй.

12. Мэдээллийг дамжуулах арга хэрэгсэл

12.1. Хүсэлт гаргагч 2-р заалтад дурдсан хэлбэрээр мэдээллийг авахыг эрхэмлэж байгаа бол 4-р зүйлд заасны дагуу төрийн болон хувийн байгууллага уг мэдээллийг дамжуулахдаа 3-р заалтад зааснаас бусад тохиолдолд мэдээллийг хүссэн хэлбэрээр нь гарган өгөх үүрэгтэй.

12.2 Хүсэлтэд мэдээллийг дамжуулахдаа юуг эрхэмлэж буйгаа дурдаж болно:

- а. эх сурвалжийн жинхэнэ хуулбарыг байнгын буюу бусад хэлбэрээр авах
- б. тухайн байгууллагад хэрэглэгддэг ердийн багажаар эх сурвалжийг шалган үзэх боломж олгох
- в. өөрийн багажийг ашиглан эх сурвалжийг хуулбарлах
- г. дуун буюу дүрсэн хэлбэрт мэдээлэлд агуулагдаж буй үгсийг бичүүлж авах
- д. тухайн байгууллагад ашиглагддаг ердийн техникээр хэвлэмэл, дүрс, дуун хэлбэрт мэдээллийн агуулгыг бичүүлж авах
- е. таталган бичиг буюу бусад кодлосон маягаар бичсэн материалыг бичүүлж авах

12.3. Төрийн болон хувийн байгууллага доорх тохиолдолд хүсэлт гаргагчийн хүссэн хэлбэрээр мэдээллийг дамжуулахаас татгалзаж болно:

- а. ингэх нь тухайн байгууллагын үр ашигтай үйл ажиллагаанд саад учруулахаар бол
- б. мэдээллийн хадгалалтад сөргөөр нөлөөлөхөөр бол

12.4. Мэдээллийн эх сурвалж нэгээс олон хэл дээр хадгалагдаж буй тохиолдолд хүсэлт тавьсан хүний тухайлан заасан хэл дээр нь гаргаж өгнө.

14. Зүй зохисгүй, давтагдсан, утгагүй хүсэлтүүд

14.1. Төрийн болон хувийн байгууллага нь зохисгүй эсвэл нэг хүнээс ирүүлсэн адил төстэй хүсэлтэд хариу өгөх албагүй.

14.2. Төрийн болон хувийн байгууллага нь өөрсдийнх нь нөөц бололцооноос ахадсан хүсэлтэд хариу өгөх албагүй.

БҮЛЭГ III. НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

15. Хуулийг хэрэглэх гарын авлага

15.1. Комиссар нь энэхүү хуулиар олгогдсон эрхийг үр ашигтай хэрэгжүүлэх явдлыг хөнгөвчилсөн мэдээллийг багтаасан хялбар гарын авлагыг бололцоо бүрдмэгц бүхий л албан ёсны хэл дээр хэвлүүлж, уг гарын авлагыг хүртээмжтэй хэлбэрээр олон нийтэд таарах үүрэгтэй.

15.2.1-р заалтад дурдсан гарын авлагыг шаардлагатай бол байнга шинэчлэж байна.

16. Мэдээлэл хариуцсан ажилтан

16.1. Төрийн байгууллага бүр мэдээлэл хариуцсан ажилтныг томилох ёстой ба олон нийтэд түүний нэр, эрхлэх ажил, холбоо барих хаяг зэргийг ил тод мэдээлнэ.

16.2. Мэдээлэл хариуцсан ажилтан нь энэхүү хуульд тусгайлан заасан бусад үүргээс гадна доорх хариуцлагыг хүлээнэ:

- а. төрийн байгууллагад мэдээллийг хадгалах, архивлах, устгахтай холбоотой бүх ажлыг үр дүнтэй болгох
- б. төрийн байгууллагад ирж буй мэдээллийг хүлээн авах, мэдээлэл авахыг хүсч буй хувь хүмүүст туслах, мэдээллийн нээлттэй байдалтай холбогдуулан хувь хүмүүсээс гаргасан гомдлыг хүлээн авах гол үүргийг гүйцэтгэнэ.

17. Хэвлэн нийтлэх үүрэг

17.1. Төрийн байгууллага бүр олон нийтийн ашиг сонирхолд зориулж дор хаяж жил бүр доорх мэдээллийг /гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй/ хэвлэн тараах ёстой. Үүнд:

- а. зохион байгуулалт, эрхлэх ажил, үүрэг, санхүү
- б. олон нийтэд шууд зориулдаг ажил үйлчилгээтэй холбоотой мэдээлэл
- в. тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан олон нийтийн зүгээс хүсэлт, гомдол гаргах механизм, түүнчлэн тухайн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, түүнд өгсөн хариултын товчоо
- г. тухайн байгууллагын мэдээлэл хадгалах тогтолцоо, хадгалагдаж буй мэдээллийн төрөл, хэлбэр, хэвлэн нийтлэдэг мэдээллийн төрөл, мэдээлэл олж авах хүсэлт тавихдаа мөрдөх зарчим зэргийг багтаасан хэрэглэхэд хялбар гарын авлага
- д. дээгүүр албан тушаалтнуудын эрх мэдэл, үүргийн тодорхойлолт, шийдвэр гаргахдаа мөрддөг дэг
- е. олон нийтэд шууд хамаатай шийдвэр, бодлогын агуулга, уг бодлого шийдвэрийг гаргасан шалтгаан, зохих тайлбар, тулгуур материалын хамт
- ё. тухайн байгууллагын бодлого тодорхойлох, эрхээ хэрэгжүүлэх ажиллагаанд олон нийтийн зүгээс нөлөөлөх буюу төлөөллөө бий болгох аливаа арга хэрэгсэл, процедур

18. Хэвлэн нийтлэх үүргийн тухай гарын авлага

18.1. Коммиссар нь:

- а. 17-р зүйлд дурдсанчлан төрийн байгууллагын үүрэг хариуцлагын наад захын стандартыг тогтоосон гарын авлагыг нийтлэх
- б. хүсэлтийн дагуу төрийн байгууллагад хэвлэн нийтлэх үүрэгтэй холбоотой зөвлөгөө өгөх

19. Мэдээллийг хадгалах

- 19.1.Төрийн байгууллага бүр энэхүү хуульд заасны дагуу болон 3-р дэд зүйлд заасан Мөрдөх журамд нийцүүлэн мэдээлэл олж авах эрхийг хөнгөвчлөхүйц арга хэлбэрээр өөрт байгаа мэдээллийг хадгалах үүрэгтэй.
- 19.2.Төрийн байгууллага бүр хувийн мэдээллийг засварлах талаар зохих процедуртай байх ёстой.
- 19.3.Коммиссар нь сонирхогч талуудтай зохих ёсоор зөвлөлдсөний дүнд мэдээллийг хадгалах, зохион байгуулах, устгахтай холбоотой Мөрдөх журмыг гаргаж, тодорхой хугацааны дараа шинэчлэх ёстой бөгөөд мөн мэдээллийг / Олон нийтийн архив г.м зохих архивийн байгууллага/ -д шилжүүлнэ.

20. Ажилтнуудыг сургах

- 20.1.Төрийн байгууллага бүр мэдээллийн эрх болон энэхүү хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлаар өөрийн ажилтнуудад зориулан зохих сургалтыг явуулж байх ёстой.

21. Мэдээллийн Коммиссарт тайлагнах

- 21.1.Төрийн байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтан бүр тухайн төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар Коммиссарт энэхүү хуульд нийцүүлэн жил бүр тайлагнах ёстой бөгөөд тайлан нь доорхи мэдээллийг агуулсан байх ёстой:
 - а. мэдээлэл авах талаар ирүүлсэн нийт хүсэлт, тэдгээрт өгсөн хэсэгчилсэн болон бүрэн хариулт, татгалзалт зэргийн тоо
 - б. мэдээлэл авах хүсэлтэд хэсэгчлэн буюу бүрнээр татгалзахдаа энэхүү хуулийн чухам аль зүйл заалтыг илүүтэй хэрэглэсэн
 - в. мэдээлэл дамжуулахыг татгалзсантай холбогдон гарсан давж заалдсан тоо
 - г. мэдээлэл авах хүсэлтээс олсон хураамжийн хэмжээ
 - д. 17-р зүйлд /хэвлэн нийтлэх үүрэг/ заасан үйл ажиллагаа
 - е. 19-р зүйлд /мэдээллийг хадгалах/ заасан үйл ажиллагаа
 - ё. 20-р зүйлд /ажилтнуудыг сургах/ заасан үйл ажиллагаа

БҮЛЭГ IV. ҮЛ ХАМААРЛУУД**22. Олон нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих**

- 22.1.Энэхүү бүлгийн аливаа заалтаас үл хамааран төрийн байгууллага нь хамгаалагдаж буй ашиг сонирхол мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох ашиг сонирхлоос давж гараагүй тохиолдолд уг мэдээлэл өөрт нь хадгалагдаж буй эсэхийг нотлохоос татгалзах, эсвэл мэдээллийг дамжуулахаас татгалзах эрхгүй.

23. Аль хэдийн олон нийтэд түгсэн мэдээлэл

23.1. Энэхүү бүлгийн аливаа заалтаас үл хамааран төрийн байгууллага нь аль хэдийн олон нийтэд түгсэн мэдээллийг дамжуулахаас татгалзах ёсгүй.

24. Мэдээллийг хэсэгчлэх

24.1. Энэ бүлэгт заасанчлан олж авахыг хүссэн мэдээлэл нь үл хамаарлын хүрээнд багтаж байвал түүнээс бололцоотой нөхцөлд үл хамааралд орохгүй хэсгийг нь хэсэгчлэн авч хүсэлт гаргагчид дамжуулна.

25. Хувийн мэдээлэл

25.1. Тухайн байгууллага хэрэв ингэх нь гуравдагч этгээдийн тухай хувийн мэдээллийг зохисгүйгээр нээлттэй болгоход хүргэнэ гэж үзвэл уг мэдээлэл өөрт нь байгаа эсэхийг нотлохоос татгалзах буюу мэдээллийг дамжуулахаас татгалзаж болно.

25.2. 1-р дэд зүйл доорх тохиолдолд үл хэрэглэгдэнэ:

- а. гуравдагч этгээд мэдээлэл тараахыг зөвшөөрсөн
- б. хүсэлт гаргасан этгээд нь гуравдагч этгээдийн асран хамгаалагч, ойрын төрөл садан буюу нас барсан гуравдагч этгээдийн гэрээслэл гүйцэтгэгч бол
- в. гуравдагч этгээд 20 буюу түүнээс олон жилийн өмнө нас барсан
- г. тухайн хувь хүн албан тушаалтан, төрийн албан хаагч байсан бөгөөд уг мэдээлэл нь түүний албан үүрэгтэй нь холбоотой бол

26. Хууль ёсны давуу эрх

26.1. Тухайн байгууллага хэрэв мэдээлэл эхнээсээ хуулийн дагуу давуу эрхээр хамгаалагдсан бол уг давуу эрхийг эзэмшигч түүнийг хүчингүй болгоогүй тохиолдолд дурдсан мэдээллийг хадгалж байгаа эсэхээ нотлох буюу түүнийг дамжуулахаас татгалзах эрхтэй.

27. Худалдааны болон итгэмжилсэн мэдээлэл

27.1. Тухайн байгууллага доорх тохиолдолд мэдээллийг дамжуулахаас татгалзах эрхтэй:

- а. мэдээллийг гуравдагч этгээдээс авсан ба түүнийг дамжуулах нь итгэлийг эвдсэн хэрэг болох бол
- б. мэдээллийг гуравдагч этгээдээс итгэмжлэн авсан бөгөөд:
 - i. худалдааны нууц агуулсан ба
 - ii. түүнийг дамжуулах нь гуравдагч этгээдийн худалдааны болон санхүүгийн ашиг сонирхолд хор хохирол учруулахаар бол
- в. мэдээллийг өөр улс буюу олон улсын байгууллагаас итгэмжлэн авсан бөгөөд түүнийг дамжуулах нь өөр улс буюу олон улсын байгууллагатай харилцах харилцаанд хор хохирол учрахаар бол

28. Эрүүл мэнд ба аюулгүй байдал

28.1.Тухайн байгууллага ингэх нь уг хувь хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлэл учруулна гэж үзвэл дурдсан мэдээллийг хадгалж байгаа эсэхээ нотлох буюу түүнийг дамжуулахаас татгалзах эрхтэй.

29. Хуулийн шалтгаан

29.1.Тухайн байгууллага доор дурдсан зүйлд хор хохирол учруулна гэж үзвэл уг мэдээллийг хадгалж байгаа эсэхээ нотлох буюу түүнийг дамжуулахаас татгалзах эрхтэй:

- а. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх буюу илрүүлэх
- б. гэмт хэрэгтнийг баривчлах, мөрдөх
- в. хууль ёсыг хэрэгжүүлэх
- г. аливаа татвар, хураамжийг тодорхойлох, хурааж авах
- д. цагаачлалыг хянах үйл ажиллагаа
- е. аливаа иргэний болон эрүүгийн шүүхийн үйл ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан эсэхийг төрийн байгууллагаас тодорхойлох

30. Батлан хамгаалах, аюулгүй байдал

30.1.Тухайн байгууллага ингэх нь /улсын нэрийг бичих/ улсын үндэсний батлан хамгаалах буюу аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулна гэж үзвэл дурдсан мэдээллийг хадгалж байгаа эсэхээ нотлох буюу түүнийг дамжуулахаас татгалзах эрхтэй.

31. Олон нийтийн эдийн засгийн ашиг сонирхол

31.1.Тухайн байгууллага ингэх нь засгийн газрын /улсын нэрийг бичих/ улсын эдийн засгийг удирдах үйлст ноцтой хор хохирол учруулна гэж үзвэл дурдсан мэдээллийг хадгалж байгаа эсэхээ нотлох буюу түүнийг дамжуулахаас татгалзах эрхтэй.

31.2.Тухайн байгууллага ингэх нь төрийн байгууллагын хууль ёсны худалдааны болон санхүүгийн ашиг сонирхолд ноцтой хор хохирол учруулна гэж үзвэл уг мэдээллийг хадгалж байгаа эсэхээ нотлох буюу түүнийг дамжуулахаас татгалзах эрхтэй.

31.3.1 болон 2-р заалтууд нь аливаа бүтээгдэхүүн буюу байгаль орчны туршилтын үр дүнтэй холбоотой мэдээлэл эсвэл олон нийтийн аюулгүй байдал, байгаль орчны эрсдлийг илрүүлсэн мэдээлэлд үл хамаарна.

32. Төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагаа

32.1.Тухайн байгууллага дор дурдсан тохиолдолд мэдээллийг хадгалж байгаа эсэхээ нотлох буюу түүнийг дамжуулахаас татгалзах эрхтэй:

- а. засгийн газрын бодлогыг үр дүнтэй боловсруулах, хөгжүүлэхэд ноцтой хохирол учруулахаар бол

- б. цаг нь болоогүй байхад мэдээлснээр уг бодлогыг амжилттай хэрэгжүүлж дуусах явдал тасалдах
 - в. төрийн байгууллагын дотор чөлөөтэй, ил тод зөвлөлдөх, санал бодлоо солилцох зохистой үйл явцыг ноцтой бууруулах
 - г. төрийн байгууллагын хэрэглэж буй хөндлөнгийн хяналт, сорилтын процедурын үр дүнг ноцтой бууруулах
- 32.2.1-р заалт баримт, баримтын дүн шинжилгээ, техникийн мэдээ мэдээлэл, статистикийн мэдээнд хамаарахгүй.

33. Цаг хугацааны хязгаарлалт

- 33.1.26-31-р зүйлийн заалтууд зөвхөн мэдээлэл авахыг хүссэн хүсэлтэд хариу өгсөн даруйд буюу өгсөний дараа хор хохирол учрахаар нөхцөлд хүчинтэй.
- 33.2.27-р зүйлийн в, 29, 30, 31-р зүйлүүд 30 жилээс дээш хугацаагаар хадгалагдсан мэдээлэлд хамаарахгүй.

БҮЛЭГ V. МЭДЭЭЛЛИЙН КОММИССАР

3.4. Мэдээллийн Коммиссарыг томилох

- 34.1. Коммиссарыг /улсын тэргүүний нэр/ /хууль тогтоох байгууллагын нэр/-ын гуравны хоёрын саналаар нэр дэвшүүлснээр томилох бөгөөд ингэхдээ доорх зарчмуудыг үндэслэл болгоно:
- а. нэр дэвшүүлэх ажиллагаанд олон нийтийг оролцуулах
 - б. ил тод, нээлттэй байдал
 - в. нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг хэвлэх
- 34.2. Доорх тохиолдолд тухайн хүнийг Коммиссараар томилж үл болно:
- а. төрийн алба хашдаг, улс төрийн намын ажилтан, төв болон орон нутгийн засгийн газарт сонгуулийн буюу томилолтын албан тушаал эрхэлдэг, эсвэл
 - б. олон улсын нийтээр зөшөөрсөн хууль зүйн зарчмын үүднээс гэмт хэрэгт шийтгүүлж байсан, ноцтой гэмт хэрэг, шударга бус гэмт хэрэг, хулгайн хэрэг үйлдэж байсан бөгөөд уг гэмт хэрэгтээ өршөөл эдлээгүй бол
- 34.3. Коммиссар нь 7 жилийн хугацаатай томилогдох ба дээд тал нь 2 удаа албан тушаалдаа улирч болох бөгөөд /хууль тогтоох байгууллагын нэр/-ын гуравны хоёрын саналаар түүнийг /төрийн тэргүүний нэр/ албан тушаалаас нь огцруулж болно.

35. Бүрэн эрхт байдал, эрх мэдэл

- 35.1. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Коммиссар нь аливаа хувь хүн, хуулийн этгээд, түүний дотор засгийн газар, түүний агентлагуудаас үйл ажиллагаа, захиргааны хувьд бие даасан байна.

35.2. Коммиссар нь энэхүү хуулиар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шууд болон нэмэлт эрх мэдэл, түүний дотор бүрэн эрхт хуулийн этгээд байх, өмч олж авах, хадгалах, зарцуулах эрх эдлэнэ.

36. Цалин, зардал

36.1. Коммиссар нь Дээд Шүүхийн /эсвэл зохих шүүхийн нэр/ ижил хэмжээний цалин авч, үүрэгт ажлаа гүйцэтгэхтэй холбогдон гарах аялалын болон томилолтын зохих зардлыг гаргуулна.

37. Ажилтнууд

37.1. Коммиссар нь үүрэгт ажлаа гүйцэтгэхтэй холбогдуулан албан тушаалтан, ажилтнуудыг томилж болно.

38. Ерөнхий үйл ажиллагаа

38.1. Энэхүү хуулиар олгогдсон эрх мэдэл, үүрэг хариуцлагаас гадна Коммиссар нь доорх үүргийг хэрэгжүүлж болно:

- а. төрийн байгууллагуудын энэхүү хуульд заасан үүргээ биелүүлж байгаа эсэхийг хянах, тайлагнах
- б. төрийн байгууллагуудад ерөнхийд нь буюу тухайлан шинэчлэл хийх асуудлаар зөвлөгөө өгөх
- в. мэдээллийн эрхийн талаар болон энэхүү хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагын ажилтнуудтай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах
- г. энэхүү хуулийг зөрчсөн талаар эрх бүхий байгууллагад хандах
- д. энэхүү хуулийн шаардлага болон хуульд заасан хувь хүний эрхийн талаар сурталчлах

39. Тайлагнах

39.1. Коммиссар нь санхүүгийн жил дууссаны дараа 3 сарын дотор /хууль тогтоох байгууллагын нэр/-ийн өмнө энэхүү хуульд заасны дагуу жилийн тайлангаа гаргаж, санхүүгийн жилийн хугацаанд хийсэн үйл ажиллагаа, хөндлөнгийн хяналтын тооцоог тайлагнана.

39.2. Коммиссар нь шаардлагатай гэж үзсэн цагтаа /хууль тогтоох байгууллагын нэр/-ийн өмнө бусад тайланг гарган өгч болно.

40. Коммиссарыг хамгаалах

40.1. Энэхүү хуулиар олгогдсон эрх мэдэл, ажил үүргээ хэрэгжүүлж байх үедээ Коммиссар буюу түүний нэрийн өмнөөс ажиллаж буй этгээд эрүүгийн болон иргэний шүүхээр шийтгэгдэх ёсгүй.

40.2. Гүтгэлэгийн тухай хуулийн үүднээс, энэхүү хуулийн дагуу мөрдөн шалгаж буй асуудлаар хэлсэн буюу өгсөн аливаа мэдээллийг түүнийг өгөхдөө гэмт санаа агуулсан гэж үзээгүй тохиолдолд задруулахгүй байх ёстой.

БҮЛЭГ VI. КОММИССАРЫН ЭРХ МЭДЭЛ**41. Коммиссарт гомдол гаргах**

- 41.1. Мэдээлэл авах хүсэлт тавьсан аливаа хүн төрийн болон хувийн байгууллага 2-р бүлэгт заасан үүргээ биелүүлээгүй гэж үзвэл Коммиссарт хандаж болно. Үүнд төрийн байгууллага:
- а. 4-р зүйлд заасантай харшилж, тухайн мэдээллийг хадгалж буй эсэхээ нотлох, дамжуулахаас татгалзсан
 - б. 9-р зүйлд заасан хугацаанд багтаан мэдээлэл авах хүсэлтэд хариу өгч чадаагүй
 - в. 10-р зүйлд заасны дагуу мэдээлэл авахыг хүссэн хүсэлтэд бичгээр хариу өгч чадаагүй
 - г. 10-р зүйлийн 3-т заасныг үл баримтлан мэдээллийг цаашид дамжуулаагүй
 - д. 11-р зүйлийг үл баримтлан, хэтэрхий өндөр хураамж авсан
 - е. 12-р зүйлд заасныг үл баримтлан мэдээллийг хүссэн хэлбэрээр нь дамжуулаагүй

42. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх

- 42.1. Коммиссар нь 2-р заалтын дагуу 41-р зүйлд дурдсан өргөдлийг аль болох хойшлуулалгүй, ямар ч тохиолдолд ажлын 30 өдөрт багтаан шийдвэрлэх ёстой ба ингэхдээ өргөдөл гаргагч болон холбогдох төрийн буюу хувийн байгууллагад саналаа бичгээр илэрхийлэх бололцоо олгоно.
- 42.2. Коммиссар нь доорх тохиолдолд өргөдлийг авч хэлэлцэхгүй байж болно:
- а. үндэслэлгүй, зүй зохисгүй, хууль бус гэдэг нь илт өргөдөл
 - б. өргөдөл гаргагч төрийн болон хувийн байгууллагын дотоод дахь давж заалдах мехнаизмыг үр ашигтай хэрэглэж чадаагүй
- 42.3. 41-р зүйлд заасан аливаа өргөдөлд тухайн төрийн буюу хувийн байгууллага 2-р бүлэгт заасан үүргийнхээ дагуу ажилласан эсэхийг хангалттай нотлох ёстой.
- 42.4. Коммиссар нь 1-р заалтын дагуу шийдвэр гаргахдаа:
- а. өргөдлийг хэрэгсэхгүй байх
 - б. төрийн болон хувийн байгууллагыг 2-р бүлэгт заасан үүргээ биелүүлэх алхам хийхийг шаардах
 - в. төрийн байгуулагаас өргөдөл гаргагчид учирсан аливаа хохирлыг нөхөн төлөхийг шаардах
 - г. төрийн байгууллага энэ хуулийн 2-р зүйлд заасан үүргээ маш ноцтойгоор буюу санаатайгаар тасалдуулсан бол торгууль оногдуулах
- 42.5. Коммиссар нь давж заалдах эрхийг нь оролцуулан өргөдөл гаргагч, төрийн буюу хувийн байгууллагын талаар бичгээр шийдвэр гаргана.

43. Шийдвэрийг шууд хэрэгжүүлэх

- 43.1. Коммиссар нь төрийн байгууллагад саналаа бичгээр гаргах боломж олгосны эцэст тухайн байгууллага 3-р бүлэгт заасан үүргээ биелүүлээгүй эсэх талаар шийдвэр гаргана.
- 43.2. Коммиссар 1-р заалтны дагуу шийдвэр гаргахдаа төрийн байгууллага 3-р бүлэгт заасан үүргээ биелүүлэхэд шаардлагатай доорх арга хэмжээг авахыг шаардаж болно:
- мэдээлэл хариуцсан ажилтныг томилох
 - зарим мэдээлэл болон зарим төрлийн мэдээллийг хэвлэн нийтлэх
 - мэдээллийг хадгалах, ашиглах, устгах, эрх бүхий архивийн байгууллагад шилжүүлэхтэй холбогдсон зарим практикийг өөрчлөх
 - мэдээллийн эрхийн тухай ажилтнууддаа явуулах сургалтыг сайжруулах
 - 21-р зүйлд заасны дагуу түүнд жил бүр тайлан гаргаж өгч байх
 - 3-р зүйлд заасан үүргээ маш ноцтойгоор буюу санаатайгаар тасалдуулсан бол торгууль оногдуулах
- 43.3. Коммиссар нь төрийн байгууллагын талаар давж заалдах эрхийг нь оролцуулан бичгээр шийдвэрээ гаргана.

44. Коммиссарын мөрдөн шалгах эрх

- 44.1. 42, 43-р зүйлд заасны дагуу шийдвэр гаргахын тулд Коммиссар нь мөрдөн шалгах бүрэн эрх, түүний дотор нотлох баримт гаргаж өгөхийг шаардах, гэрчүүдээс мэдүүлэг авах эрхтэй.
- 44.2. Коммиссар нь 1-р заалтад дурдсан мөрдөн шалгалтын явцад энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамрах бүхий л мэдээллийг шаардах эрхтэй бөгөөд, ийм төрлийн мэдээллийг ямар ч үндэслэлээр Коммиссарт өгөхөөс татгалзаж болохгүй.

45. Коммиссарын гаргасан шийдвэр, тушаалыг давж заалдах

- 45.1. Өргөдөл гаргагч, эсвэл холбогдох төрийн буюу хувийн байгууллага 42, 43-р зүйлд заасны дагуу Коммиссарын гаргасан шийдвэр, эсвэл 44-р зүйлийн 1-д заасан тушаалыг бүрэн хянуулахаар 45 хоногийн дотор шүүхэд давж заалдах эрхтэй.
- 45.2. 42-р зүйлд заасан шийдвэртэй холбоотой аливаа давж заалдах өргөдөлд тухайн төрийн буюу хувийн байгууллага 2-р бүлэгт заасан үүргийнхээ дагуу ажилласан эсэхийг хангалттай нотлох ёстой.

46. Коммиссарын гаргасан шийдвэр, тушаалын заавал биелүүлэх чанар

- 46.1. 45-р зүйлд заасан давж заалдах эрхийн 45 хоногийн хугацаа өнгөрмөгц, Коммиссар нь 42, 43-р зүйлд заасны дагуу гаргасан шийдвэр, эсвэл 44-р зүйлийн 1-д заасны дагуу гаргасан тушаалыг мөрдөхгүй байгаа талаар шүүхэд бичгээр баталж болох ба шүүх энэ нь түүнийг үл хүндэлсэн хэрэг мөн гэж үзэж болно.

БҮЛЭГ VII. "МЭДЭЭЛЭГЧИД"**47. "Мэдээлэгч"**

47.1. Аливаа хууль, ажил үүргээ зөрчсөнөөс үл хамааран гэмт үйлдэл, эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд учирч буй ноцтой аюулын талаар мэдээллийг задалсан хувь хүн уг үйлдлийг хийхдээ сайн санааны үүднээс, тухайн мэдээлэл үнэн гэдэгт итгэлтэйгээр хийсэн тохиолдолд хууль, захиргаа, ажил эрхлэлттэй холбоотой аливаа шийтгэл хүлээхгүй.

47.2. 1-р заалтад дурдсан гэмт үйлдэл гэдэгт гэмт хэрэг үйлдэх, хуулиар хүлээсэн үүргээ зөрчих, хууль ёсыг зөрчих, авлига буюу шударга бус явдалд автах, төрийн байгууллагын ажлыг ноцтойгоор завхруулах зэргийг багтаан ойлгоно.

БҮЛЭГ VIII. ЭРҮҮГИЙН БОЛОН ИРГЭНИЙ ХАРИУЦЛАГА**48. Сайн санааны үүднээс мэдээллийг задлах**

48.1. Ямар ч хүн энэхүү хуульд заасан аливаа эрх мэдэл, үүргээ сайн санааны үүднээс хэрэгжүүлэх, гүйцэтгэхтэй холбоотой хийсэн аливаа үйлдлийнхээ төлөө иргэний болон эрүүгийн хэрэг, хөдөлмөр эрхлэлтийн аливаа шийтгэл хүлээх ёсгүй.

49. Эрүүгийн эрх зүйн зөрчил

49.1. Доорх зүйлийг санаатайгаар үйлдвэл эрүүгийн эрх зүйн зөрчил хэмээн үзнэ:

- а. энэхүү хуулийн 2-р бүлэгт заасныг үл мөрдөн аливаа мэдээллийг олж авахад хаалт хийх
- б. энэхүү хуулийн 3-р бүлэгт заасны дагуу аливаа төрийн байгууллага үүргээ хэрэгжүүлэхэд нь хаалт хийх
- в. Коммиссарын үйл ажиллагаанд төвөг учруулах
- г. хууль ёсны зөшөөрөлгүйгээр мэдээллийг устгах

49.2. 1-р заалтад дурдсан эрх зүйн зөрчил үйлдсэн аливаа этгээдэд /тохирох хэмжээг бичих/ хэмжээний мөнгөн торгууль, буюу/эсвэл 2 жилээс илүүгүй хугацаагаар хорьж шийтгэнэ.

БҮЛЭГ IX. БУСАД ЗҮЙЛ**50. Журам**

50.1. Сайд, Коммиссартай зөвлөлдсөний үндсэн дээр журам гаргаж /тохирох хэвлэлийн нэр/-д нийтлүүлнэ. Үүнд:

- а. 12-р бүлгийн 2-т зааснаас гадна мэдээлэл дамжуулах бусад хэлбэрийн тухай
- б. 20-р зүйлд заасан ажилтнуудыг сургах тухай
- в. 21-р зүйлд зааснаар Коммиссарт гаргаж өгөх тайлан
- г. энэхүү хуулиар шаардагдах аливаа тайлбар
- д. энэхүү хуульд нөлөөлөх захиргааны болон процедурын аливаа асуудал

51. Тайлбарлах

51.1. Шүүх бүр энэхүү хуулийн заалтыг тайлбарлахдаа, тухайн заалтаар мэдээллийн эрх чөлөөг хамгийн сайн хамгаалж чадахуйц тайлбар гаргах ёстой.

52. Хуулийн нэр ба үйлчилж эхлэх хугацаа

52.1. Энэхүү хуулийг Мэдээллийн Эрхийн тухай /оныг бичих/ оын хууль гэж нэрлэж болно.

52.2. Энэхүү хууль нь /ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайд зэрэг тохирох албан тушаалтныг бичих/-ийн тунхагласан өдрөөс буюу эсвэл батлагдан гарснаас хойш 6 сарын дараа хүчин төгөлдөр болно.



ЙОХАННЕСБУРГИЙН ЗАРЧМУУД: ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ, МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ

1996 оны 11-р сар

Дугаар 3

Энэ баримт бичгийг анх 1995 оны 10-р сард 19 зүйл байгууллага, Хэвлэлийн хяналтын эсрэг олон улсын төвөөс зохион байгуулсан зөвлөлгөөний дараа Йоханнесбург дахь Витвотерсрэндын Их сургуулийн Салбар эрх зүйн төвтэй хамтран хэвлэв.

I. ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

1-р Зарчим: Үзэл бодлын эрх чөлөө, түүнийг илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө

1.1 Зарчим: Хуульд заасан

1.2 Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах нь

1.3 Зарчим: Ардчилсан нийгэмд шаардлагатай

2-р Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхол

3-р Зарчим: Онц байдал

4-р Зарчим: Ялгаварлан гадуурхахыг хориглох

II. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БУЮУ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТУУД

5-р Зарчим: Үзэл бодлыг хамгаалах нь

6-р Зарчим: Үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх

7-р Зарчим: Үзэл бодлоо илэрхийлэхийг хамгаалах нь

8-р Зарчим: Үйл ажиллагаа нээлттэй байх нь дангаараа үндэсний аюулгүй байдалд аюул учруулах

9-р Зарчим: Үндэстний цөөнхийн буюу бусад хэл ашиглах

10-р Зарчим: Гуравдагч этгээдээс үзэл бодлоо илэрхийлэхэд хууль бусаар хөндлөнгөөс оролцох

III. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАХ

11-р Зарчим: Мэдээлэл авах эрхийн ерөнхий зарчим

12-р Зарчим: Аюулгүй байдлын шалтгаанаар үл хамаарах тохиолдлын нарийн хүрээтэй тодорхойлох

13-р Зарчим: Ил болгох олон нийтийн сонирхол

14-р Зарчим: Мэдээлэл өгөхөөс татгалзсаныг бие даан авч үзэх эрх

15-р Зарчим: Нууц мэдээллийг ил болгох ерөнхий дүрэм

16-р Зарчим: Төрийн албанаас олж авсан мэдээлэл

17-р Зарчим: Олон нийтийн хүрээний мэдээлэл

- 18-р Зарчим: Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах
- 19-р Зарчим: Хориотой газруудад нэвтрэх
- 20-р Зарчим: Хуулиар хамгаалах ерөнхий журам
- 21-р зарчим: Зөрчигдсэн эрхийг сэргээх хэрэгслүүд
- 22-р зарчим: Хараат бус шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх
- 23-р зарчим: Урьдчилсан хяналт
- 24-р зарчим: Тохироогүй шийтгэл
- 25-р зарчим: Эдгээр зарчим, бусад жишгийн хоорондын холбоо

ОРШИЛ

Эдгээр Зарчмуудыг 1995 оны 10-р сард 19-р зүйл байгууллага, Хэвлэлийн цагдан хяналтын эсрэг олон улсын төв (International Centre against Censorship) олон улсын эрх зүй, үндэсний аюулгүй байдал, хүний эрхийн мэргэжилтнүүдээс Йоханнесбург дахь Витвотерсрэндэн Их сургуулийн Салбар эрх зүйн төвтэй хамтран батлав.

Зарчмуудыг олон улсын ба бүс нутгийн эрх зүй, хүний эрхийг хамгаалах жишиг, үүсч байгаа төрийн практик (дотоодын шүүхийн шийдвэрүүдэд тусгагдсан зэрэг), олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн ерөнхий зарчмуудад үндэслэв.

Эдгээр Зарчмууд нь Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хязгаарлалт, хэсэгчлэн хүчингүй болгосон заалтын Сиракузын Зарчмууд, Онц байдлын үе дэх хүний эрхийн Парисын хэм хэмжээний наад захын жишиг үргэлжлэн үйлчлэхийг тэмдэглэж байна.

УДИРТГАЛ

Энэхүү Зарчмуудыг боловсруулахад оролцогчид:

Нэгдсэн үндэстний байгууллагын Дүрэмд тунхагласан зарчимд зааснаар хүн төрөлхтний бүх гишүүний угаас заяасан нэр төр, тэгш бөгөөд салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, дэлхийн энх тайвны үндэс болохыг ХАРГАЛЗАН,

Хүмүүс дарангуйлал, дарлалын эсрэг эцсийн арга хэмжээ болгож бослого гаргахгүй бол хүний эрхийг хуулиар хамгаалах ёстой гэдэгт ИТГЭЛТЭЙ БАЙЖ,

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан нийгэмд амин чухал, түүний хөгжил дэвшил, сайн сайхан, түүнчлэн хүний бусад эрх, үндсэн эрх чөлөөг эдлэхэд зайлшгүй шаардлагатайг ДАХИН БАТАЛЖ,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенци, Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчмууд, Хүний ба ард түмнүүдийн эрхийн тухай Африкийн дүрэм, Хүний эрхийн тухай Америкийн конвенци, Хүний эрхийн тухай Европын конвенцийн холбогдох заалтыг ХАРГАЛЗАН,

Хүний эрхийн болон үндсэн эрх чөлөөний ихэнх хамгийн ноцтой зөрчлийг засгийн газрууд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шаардлагаар зөвтгөдгийг ТОДОРХОЙ МЭДЭЖ,

Ард түмэн өөрийн засгийн газрын үйл ажиллагааг хянаж ардчилсан нийгэмд бүрэн оролцох бололцоотой байгаа бол тэд засгийн газрын мэдэлд байгаа мэдээлэлтэй танилцах заавал бололцоотой байх ёстойг САНАН,

Засгийн газруудыг үндэсний аюулгүй байдлаар шалтаглан эдгээр эрх чөлөөг эдлэх явдлыг үндэслэлгүйгээр хязгаарлуулахгүй байхын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөнд үндэсний аюулгүй байдлын сонирхлын үүднээс тавьж болох хязгаарлалтын хүрээ бага байх ёстойг хүлээн зөвшөөрөх явдлыг дэмжихийг ХҮСЧ,

Эдгээр эрх чөлөөг эрх зүйн хэрэгслээр, нарийн боловсруулсан, хууль дээдлэх зарчмын байвал зохих шаардлагыг хангасан хуулиудаар хамгаалах шаардлагатайг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ,

Эдгээр эрх чөлөөг хараат бус шүүхээр хамгаалах шаардлагатайг ТЭМДЭГЛЭН,

Дараахь Зарчмуудыг БАТАЛЖ, үндэсний, бүс нутгийн ба олон улсын түвшинд зохих байгуллагуудад эдгээрийг өргөн тараах, зөвшөөрөх, хэрэгжүүлэх явдлыг дэмжих арга хэмжээ авахыг зөвлөж байна.

I. ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

1-р Зарчим: үзэл бодлын эрх чөлөө, түүнийг илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө

- (a) Хүн бүр үзэл бодлоо хөндлөнгийн оролцоогүй илэрхийлэх эрхтэй.
- (б) Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, үүнд төрөл бүрийн мэдээлэл, санааг амаар болон бичгээр, хил хязгаар харгалзахгүйгээр урлагийн буюу өөрийн сонгон авсан бусад хэлбэрээр хүлээж авах, бусадтай хуваалцах эрхтэй.
- (в) Энэ зүйлийн (б)-д заасан эрхийг эдлүүлэхийг олон улсын эрх зүйгээр тогтоосон тодорхой үндэслэлээр, түүний дотор үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үндэслэлээр хязгаарлаж болно.
- (г) засгийн газар, хязгаарлалтыг хуулиар тогтоосон бөгөөд тэр нь ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай гэдгийг нотолж чадсанаас бусад тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөнд үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарлалт тогтоож болохгүй. Хязгаарлалт үндэслэлтэй болохыг нотлох үүргийг засгийн газар хүлээнэ.

1.1 Зарчим: Хуульд заасан байх

- (a) үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт бүрийг хуулиар тогтоосон байвал зохино. Хууль нь олж танилцах боломжтой, бүрхэг бус, нарийн, хувь хүн тодорхой аль нэг үйлдлийг хууль бус болохыг урьдаас мэдэх боломжтойгоор бичигдсэн байвал зохино.
- (б) Хуульд эрх хэмжээг хэтрүүлэхийн эсрэг зохих хамгаалалт, үүний дотор хязгаарлалт үндэслэлтэй эсэхийг хараат бус шүүх буюу трибуналаар хянаж байх тухай заасан байвал зохино.

1.2 Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах нь

Үндэсний аюулгүй байдлын үүднээс засгийн газраас зөвтгөх гэж буй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөний аливаа хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах жинхэнэ зорилго, нотлохуйц үр дүнтэй байх ёстой.

1.3 Зарчим: Ардчилсан нийгэмд шаардлагатай

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай болохыг тогтоохын тулд засгийн газар дор дурдсаныг нотлох ёстой:

- а) тухайн асуудлаар мэдээлэл илэрхийлэх нь үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхолд ноцтой аюул учруулж байгаа;
- б) тогтоосон хязгаарлалт нь уг сонирхлыг хамгаалахад байж болох хамгийн наад захын арга хэмжээ мөн;
- в) хязгаарлалт нь ардчилсан зарчимд нийцэж байгаа.

2-р Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхол

- а) Зөвтгөх гэж буй үндэсний аюулгүй байдлын сонирхол нь түүний жинхэнэ зорилго буюу нотолж болохуйц үр дүн нь үндэсний аюулгүй байдалтай холбоогүй, жишээлбэл, засгийн газрыг эвгүй байдалд орох буюу буруу үйл ажиллагааг нийтэд илэрхий болохоос хамгаалах, түүний төрийн байгууллагуудын ажиллагааны тухай мэдээллийг нуух, эсхүл тодорхой нэгэн үзэл суртлыг нуух, эсхүл хувь хүний дургүйцлыг дарахад чиглэгдсэн байвал хууль ёсны бус байна.

3-р Зарчим: Онц байдал

Албан ёсоор, хууль ёсоор дотоодын ба олон улсын эрх зүйн дагуу тунхагласан улсын оршин тогтноход аюул учруулж буй нийтийн онц байдлын үед төр үзэл бодлоо илэрхийлэх буюу мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж болох боловч зөвхөн тухайн нөхцөл байдалд шаардлагатай хэмжээнд, олон улсын эрх зүйн дагуу засгийн газрын хүлээсэн бусад үүрэгт нийцсэн нөхцөл, хугацаагаар тийнхүү хязгаарлаж болно.

4-р Зарчим: Ялгаварлан гадуурхахыг хориглох

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөг ямар ч тохиолдолд, түүний дотор үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарласан нь арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, яс үндэс, бусад байдлаар ялгаварлан гадуурхахтай холбоотой байж болохгүй.

II ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БУЮУ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТУУД

5-р Зарчим: Үзэл бодлыг хамгаалах нь

Хэнийг ч болов түүний үзэл бодол, итгэл үнэмшлийнх нь төлөө хориглох, эрхийг нь хязгаарлах буюу шийтгэж үл болно.

6-р Зарчим. Үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх

15, 16-р Зарчимд нийцүүлэн үзэл бодлоо илэрхийлэхийг зөвхөн засгийн газар дор дурдсан байдлыг нотолж чадсан тохиолдолд үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэж шийтгэж болно:

- а) зайлуулах боломжгүй хүчирхийлэл өдөөх зорилготой;
- б) тийм хүчирхийлэл өдөөх магадлалтай;
- в) үзэл бодлоо илэрхийлсэн, тийм хүчирхийлэл гарч болох магадлалын хооронд шууд холбоо байгаа.

7-р Зарчим: Үзэл бодлоо илэрхийлэхийг хамгаалах нь

15, 16-р Зарчимд нийцүүлэн үзэл бодлоо тайван байдлаар илэрхийлснийг үндэсний аюулгүй байдалд аюул учруулж байна гэж үзэх, аливаа хориглол, шийтгэл хүлээлгэж болохгүй. Үндэсний аюулгүй байдалд аюул учруулахгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх гэж дор дурдсаныг хэлэх бөгөөд үүгээр хязгаарлахгүй:

- (i) засгийн газрын бодлогыг буюу засгийн газрыг өөрийг нь хүчирхийллийн бус аргаар өөрчлөхийг дэмждэг;
- (ii) тухайн орон, төр, түүний бэлгэдэл, засгийн газар, түүний байгууллага, төрийн албан тушаалтнуудыг шүүмжилсэн, доромжилсон;
- (iii) цэргийн алба буюу цэргийн үүрэг, тодорхой нэгэн зөрчилдөөнийг үл зөвшөөрсөн буюу зөвшөөрснийг дэмжсэн, эсхүл улс хоорондын зөрчлийг зохицуулахад хүч хэрэглэх, тийнхүү хүч хэрэглэхээр заналхийлэх;
- (iv) олон улсын хүний эрхийн буюу олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн жишгийг зөрчсөн гэх тухай мэдээлэл дамжуулахад чиглэсэн.

б) Хэнийг ч болов шүүмжлэл нь зайлуулах боломжгүй хүчирхийлэл өдөөх зорилготой байгаагүй бол тухайн улс, төр, түүний бэлгэдэл, засгийн газар, түүний байгууллага, төрийн албан тушаалтнуудыг шүүмжилсэн, доромжилсны нь төлөө шийтгэж үл болно.

8-р Зарчим. Үйл ажиллагаа нээлттэй байх нь дангаараа үндэсний аюулгүй байдалд аюул учруулах

Үзэл бодлоо илэрхийлснийг засгийн газраас дан ганцхан үндэсний аюулгүй байдал буюу түүнтэй холбоотой сонирхолд аюул учруулж байгаа гэж үзсэн байгууллагаас гаргасан буюу тийм байгууллагын тухай гэдгээр хориглож, шийтгэж үл болно.

9-р Зарчим. Үндэстний цөөнхийн буюу бусад хэл ашиглах

Үзэл бодлоо бичгээр буюу амаар илэрхийлсэн алиныг ч тодорхой хэл дээр, ялангуяа үндэстний цөөнхийн хэл дээр хийгдсэн гэдгээр хориглож үл болно.

10-р Зарчим. Гуравдагч этгээдээс үзэл бодлоо илэрхийлэхэд хууль бусаар хөндлөнгөөс оролцох

Засгийн газрууд, бүлэг буюу хувь хүн бусдыг үзэл бодлоо тайвнаар илэрхийлэхэд хууль бусаар хөндлөнгөөс оролцохоос сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй. Тухайлбал,

Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэхгүй байлгах зорилготой хууль бус ажиллагааг буруушаах, гэм буруутай этгээдийг мөрдөн шалгах, хариуцлагад татах үүрэгтэй.

III. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАХ

11-р Зарчим. Мэдээлэл авах эрхийн ерөнхий зарчим

Хүн бүр төрийн байгууллагаас мэдээлэл авах, түүний дотор үндэсний аюулгүй байдлын холбогдолтой мэдээлэл авах эрхтэй. Энэ эрхийг засгийн газар хязгаарласан нь хуулиар тогтоосон бөгөөд ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай гэдгийг нотолж чадахаас бусад тохиолдолд хязгаарлаж үл болно.

12-р Зарчим: Аюулгүй байдлын шалтгаанаар үл хамаарах тохиолдлыг нарийн хүрээтэй тодорхойлох

Төр, үндэсний аюулгүй байдлын холбогдолтой бүх мэдээллийг авахыг хориглох бус харин хуулиар үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах шаардлагын үүднээс хаалттай байлгах мэдээллийн хязгаарлагдмал ангилал тогтооно.

13-р Зарчим: Ил болгох олон нийтийн сонирхол

Мэдээлэл авах эрхийн талаарх хууль, шийдвэрүүдэд мэдээлэлтэй байх нийтийн сонирхолд эн тэргүүний ач холбогдол өгнө.

14-р Зарчим: Мэдээлэл өгөхөөс татгалзсаныг бие даан авч үзэх эрх

Төр, мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэхэд тохиромжтой арга хэмжээ батлах үүрэгтэй. Эрх баригчид мэдээлэл авахыг хориглосон бол түүний шалтгааныг бичгээр зааж тийнхүү хориглосон нь үндэслэлтэй эсэхийг хараат бус байгууллага авч үзэх эрх, үүний дотор тийнхүү хориглосон нь хууль ёсны эсэхийг шүүхээр хянах эрх олгоно. Хянах эрх бүхий этгээд хориглосон мэдээллийг авч үзэх эрхтэй байна.

15-р Зарчим. Нууц мэдээллийг ил болгох ерөнхий дүрэм

Хэнийг ч үндэсний аюулгүй байдлын үндэслэлээр мэдээлэл задруулсан гэж

- 1) тийнхүү задруулсан нь үндэсний аюулгүй байдалд бодит хор учруулаагүй буюу учруулах магадлалгүй, эсхүл
- 2) мэдээллийг мэдэж байх олон нийтийн сонирхол нь задруулсны хор уршгаас давуу байвал шийтгэж үл болно.

16-р Зарчим: Төрийн албанаас олж авсан мэдээлэл

Мэдээллийг мэдэж байх олон нийтийн сонирхол нь түүнийг задруулсны хор уршгаас давуу байвал хэнийг ч төрийн алба хаах явцдаа олж авсан мэдээллийг задруулсан үндэслэлээр ямар нэгэн байдлаар хохироож болохгүй.

17-р Зарчим: Олон нийтийн хүрээний мэдээлэл

Мэдээллийг нэгэнт олон нийтэд аливаа аргаар мэдээлсэн бол хууль ёсны эсэхээс үл хамааран ямар нэгэн үндэслэлээр цаашид нийтлэхийг зогсоох оролдлого нь олон нийтийн мэдэж байх сонирхол түүнээс давуу байна.

18-р Зарчим: Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах

Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нь сэтгүүлчийг мэдээллийнхээ эх сурвалжийг хэлж өгөхийг албадах үндэслэл болгож болохгүй.

19-р Зарчим: Хориотой газруудад нэвтрэх

Мэдээллийг чөлөөтэй дамжуулж хүлээж авахад тавьсан аливаа хязгаарлалт нь хүний эрх болон хүмүүнлэгийн эрх зүйн зорилгыг биелүүлэхэд саад болохоор байж болохгүй. Тухайлбал, засгийн газрууд сэтгүүлчид буюу хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн жишгийг сахиж байгаа эсэхийг хянах мандат бүхий засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудад хүний эрх буюу хүмүүнлэгийн эрх зүйн зөрчил гарсан, гарч байна гэж үзэх үндэслэлтэй газруудад нэвтрэн орохыг хориглож болохгүй. Засгийн газрууд сэтгүүлчид, тийм байгууллагын төлөөлөгчдийг хүчирхийлэл гарч байгаа буюу зэвсэгт мөргөлдөөн болж байгаа газруудад тэнд байх нь бусдад аюултайгаас бусад нөхцөлд нэвтрүүлэхгүй байж болохгүй.

IV. ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧИМ БА БУСАД АСУУДАЛ**20-р Зарчим: Хуулиар хамгаалах ерөнхий журам**

Мэдээллийг илэрхийлэхтэй холбогдсон аюулгүй байдалтай холбоотой хэрэгт яллагдсан хүн бүр олон улсын эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг болох хуулийн бүх хамгаалалтыг эдлэх эрхтэй. Эдгээрт дараахь хамаарах бөгөөд үүгээр хязгаарлахгүй:

- а) гэм буруугүйд тооцогдох зарчим;
- б) дур зоргоор баривчлагдахгүй байх эрх;
- в) өөрийг нь холбогдуулж байгаа хэрэг, түүний нотолгооны талаар өөрийн нь мэддэг хэл дээр даруй мэдэгдэх эрх;
- г) өөрийн сонгож авсан өмгөөлөгчтэй даруй харьцах эрх;
- д) боломжит хугацаанд хэргээ шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрх;
- е) өөрийгөө өмгөөлөхөд бэлтгэх зохих хугацаатай байх;
- ж) хараат бус, нөлөөнд үл автсан шүүхээр хэргээ нээлттэй хянан шийдвэрлүүлэх эрх;
- з) яллах талын гэрчүүдийг байцаах эрх;
- и) өөрт нь өмнө нь гаргаж өгч үгүйсгэх бололцоо олгоогүй нотлох баримтыг шүүх хуралдаанд гаргуулахгүй байх эрх;
- к) шүүхийн шийдвэрийг хянаж хүчингүй болгох эрх бүхий хараат бус шүүхэд давж заалдах эрх;

21-р зарчим: Зөрчигдсөн эрхийг сэргээх хэрэгслүүд

Аюулгүй байдалтай холбоотой хэрэгт ялагдсан хүн бүр Habeas corpus, amparo зэрэг бүх хэрэгсэл ашиглах бололцоотой байна.

22-р зарчим: Хараат бус шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх

а) Шүүгдэгчийн сонгосноор аюулгүй байдалтай холбоотой хэргийг тангарагтны шүүхээр (тийм шүүхтэй газарт) эсхүл жинхэнэ ёсоор бие даасан шүүгчид хянан шийдвэрлэвэл зохино. Аюулгүй байдалтай холбоотой гэмт хэрэгт холбогдсон хэргийг шүүгчийн албан тушаалд байх хугацаа нь баталгаагүй шүүгчдээр хянан шийдвэрлэснийг хараат бус шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн хамгийн ноцтой зөрчилд тооцогдоно.

б) Ямар ч тохиолдолд энгийн хүний аюулгүй байдалтай холбоотой хэргийг цэргийн шүүхээр хянан шийдвэрлэж болохгүй.

в) Ямар ч тохиолдолд энгийн хүн, цэргийн албан хаагчийн хэргийг тусгайлан байгуулсан дотоодын шүүхээр хянан шийдвэрлэж болохгүй.

23-р зарчим: Урьдчилсан хяналт

Үзэл бодлоо илэрхийлэхийг үндэсний аюулгүй байдлыг хамгаалах сонирхлын үүднээс 3-р зарчимд заасан нөхцөлд тус улсын амьдралд аюул учруулсан нийтийн гамшигт байдлаас бусад тохиолдолд урьдчилан хянаж болохгүй.

24-р зарчим: Тохироогүй шийтгэл

Аюулгүй байдалтай холбоотой хэрэгт хувь хүн, хэвлэл мэдээллийн цэг, улс төрийн ба бусад байгууллагад үйлдсэн хэргийн хүндэд тохироогүй шийтгэл, хориглол, ял оногдуулж үл болно.

25-р зарчим: Эдгээр зарчим, бусад жишгийн хоорондын холбоо

Эдгээр зарчмыг олон улсын, бүс нутгийн буюу дотоодын хууль, жишгээр хүлээн зөвшөөрсөн ямар нэгэн хүний эрх, эрх чөлөөг хориглосон буюу хязгаарласан мэтээр тайлбарлаж болохгүй.



МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Мэдээллийн эрх чөлөө ба Европын холбоо¹

Мэдвэл зохих хууль ба эрх

Олон улсын гэрээнд тулгуурласан Европын холбооны хууль тогтоомж нь олон нийтэд мэдээлэл авах эрх чөлөөг олгодог боловч ил тод байдлыг хайж байдаг сэтгүүлчдийн хувьд зарим талдаа хязгаарлагдмал байдаг. Европын холбооны шүүгчид энэ байдлыг харгалзан өөрсдийнхөө хэр хэмжээний хүрээнд ил тод байдлыг хэрэгжүүлдэг. Хүний Эрхийн тухай Европын Конвенц нь Европын холбооны хууль тогтоомжид шууд хамааралгүй боловч Европын холбооны шүүгчид энэ талаар маш тодорхой авч үздэг ба Конвенц нь Европын холбооны гишүүн орнуудын хууль, эрх зүйн тогтолцооны тодорхой хэсгийг бүрдүүлдэг байна. Уг конвенц нь үг хэлэх эрхийг хамгаалдаг хэдий ч албан бичиг баримтийг ашиглах тал дээр хангалтгүй юм. Энэ талаар Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах санал гарч байсан бөгөөд мэдээллийн эрх чөлөөний зорилго нь шүүх, хууль эрх зүйн гэхээсээ улс төрийн хандлагад чиглэгдсэн байдаг.

Хүмүүнлэгийн тухай хууль ба Европын холбооны хуулийн тогтолцоо

Холбооны үндсэн тогтолцоо нь худалдаа арилжааны асуудлыг чухалчилдаг. Нийгмийн хууль хүний эрхийн хуультай зохицон үндсэн гол чиглэл нь болж өгдөг байна. Худалдаа арилжааны асуудал хүний эрхийг илүү өргөн хүрээнд авчирч тавьдаг учир дээрх хуулиар бүтээгдэхүүн болон үйлчилгээг чөлөөтэй нэвтрүүлэх талаар ихээхэн анхаардаг.

Люксембург дэх Европын Шүүх Танхимыг (цаашид “ЕШТ” гэх) Страсбургт орших Европын Хүний Эрхийн Шүүхээс ялгаж ойлгох хэрэгтэй. ЕШТ нь нийгмийн хуулийг ард түмэнд хүргэж хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. 1989 оноос хойш Европын Анхан Шатны Шүүх байгууллага нийгмийн хуулийн зарим нэгэн хэсэгт ЕШТ-ийн үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэх болсон. Уг холбооны гишүүн орнуудад ЕШТ-ийн шийдвэр дотоодын шийдвэрээс илүү хүчинтэй. Сайдын Зөвлөл, Парламент, Хороо гэсэн холбооны улс төрийн гурван байгууллага 1977 оны хамтын хэлэлцээрээр үндсэн эрх үүргээ баталсан бөгөөд мөн Европын Актад (1987) эдгээр байгууллагууд “үндсэн эрх ялангуяа эрх чөлөө, эрх тэгш байдал, нийгмийн эрх ашгийг эрхэмлэн ардчиллыг хөгжүүлэх үйлсэд хамтран ажиллана” гэдгээ тодорхойлсон юм.

Маастричд (Maastricht) энэ мэдэгдлийг шинэчлэн гаргасан. Энэ мэдэгдлийг хэрэгжүүлэхдээ, ЕШТ гишүүн орнуудын хуулийн уламжлалт нийтлэг шинж болон тэдний гарын үсэг зурсан гэрээ хэлэлцээрт тулгуурладаг. Үүний дундаас Хүний эрхийн тухай Европын Конвенци хамгийн чухал нь юм. Үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулсан Конвенцийн 10-р зүйл нь ЕШТ-ийн хууль, эрх зүйн эх сурвалжид хэдийнээ багтжээ. Хүний эрхийн хуулийн энэ гол хэсэг нь үндсэн эрхийг зөрчсөн асуудлуудын талаар Зөвлөлийнхөө эсрэг тэмцэлдсээр ирсэн. Үүнийг Зөвлөлийн хуулийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, Зөвлөлийн багц хуулийг тогтоох үндэсний арга хэмжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ. Хэрэв нийгмийн хуулийн хэрэгжилт нь зөрчилтэй, эсвэл

¹ EFJ-The Right to Know and the European Union. <http://www.ifj.org/regions/europe/efj/en/eusurvey.html>.

аливаа үндэстэн уг зүйлд үл нийцэх арга хэмжээ явуулсан тохиолдолд ЕХШ 10-р зүйлийг баримтална. Гэвч гишүүн орны дотоодын хууль нь Зөвлөлийн хуулийн цар хүрээнд хамрагдаагүй тохиолдолд ЕШТ хөндлөнгөөс оролцдоггүй.

Хүний эрхийн тухай Европын Конвенц

Хүний Эрхийн тухай Европын Конвенцийн 10-р зүйлд “хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гэжээ. Үүнд хил хязгаарын ялгаа болон нийгмийн удирдлагыг үл харгалзан мэдээлэл хүлээн авах ба түгээх эрх багтана. Гэвч энэ эрх чөлөөг дагалдах “үүрэг хариуцлага, хязгаарлалт”-ыг 10-р зүйлд зааж өгсөн байдаг. Тухайлбал: ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай улс үндэстний аюулгүй байдал, газар нутгийн нэгдэл, нийгмийн аюулгүй байдал болон эмх замбараагүй байдал, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс хуулиар эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарладаг байна.

Эрх чөлөөг хязгаарлах өөр нэгэн шалтгаан нь эрүүл мэнд ба ёс суртахуун, хувь хүний нэр хүнд ба эрх чөлөө, хувийн нууцыг хадгалах болон “шүүхийн удирдах эрх ба шударга ёсыг” тогтоох явдал юм.

Европын Хүний Эрхийн Шүүх (цаашид “ЕХЭШ” гэх) нь олон нийт мэдээлэл түгээхийг хүсэж буй хэн нэгний мэдээллийг сонсох эрхтэй гэж үздэг. 1979 онд “Sunday Times” сонин “Thailidomide” эмийн (энэ эмийг жирэмсэн эхчүүд хэрэглэдэг байсан боловч хожим энэ нь хүүхдийн бойжилтыг сааруулж тахир дутуу болгодгийг тогтоосон) сөрөг үр дагаврыг олон нийтэд мэдээлснээр хуулиар уг сонины үйл ажиллагааг зогсоосон. Гэвч ЕХЭШ үүнд Британы шүүхийг буруутгасан бөгөөд “Sunday Times”-ийн зорилго бол ард түмэнд мэдээлэл хүргэх явдал байсан юм.

Засгийн газар, яам, агентлаг гэх мэт төрийн байгууллага мэдээлэл задруулахыг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд шүүх үүнд болгоомжтой хандах нь зүйтэй юм. 1987 онд Швейцарын шүүх сэтгүүлчдэд газрын бүртгэлийн тухай мэдээлэл өгөхөөс татгалзсан нь тухайн нөхцөлд зөв шийдвэр байсан. Тэдний хуулиар асуудлыг сонирхох тодорхой шалтгаан бүрдсэн тохиолдолд мэдээллээр хангана хэмээн заасан бөгөөд сэтгүүлчдийн зорилго үүнтэй үл нийцнэ гэж үзсэн. Үүнийг ЕХЭШ хүлээн зөвшөөрсөн юм. Гэвч ЕХЭШ нь 10-р зүйлд албан мэдээлэл ашиглах эрхийг бүрмөсөн хязгаарлаагүй гэж үздэг.

Ерөнхий дүгнэлт

Өнөөдөр Европын Конвенц болон Европын Холбооны хуулиудад засгийн газар болон төрийн байгууллагаас мэдээлэл олж авах хууль эрх зүйн хангалттай үндсийг бүрдүүлж өгч чадахгүй байгаа юм.

Европын Холбооны хүрээнд мэдээлэл олж авах эрх

Зарим гишүүн орнууд Брюсселийн албан ёсны нууцын тухай шийдвэрийг эсэргүүцэж, өөрчлөхийг хүсдэг. Эдгээр эсэргүүцлийн зарим нь тухайлбал, 1996 оныг албаны нууцыг хадгалах журмыг дахин шалгах жил болгосон гэх мэт эерэг үр дүнд хүрсэн. Энэ нь бусад хүмүүс хатуу байр суурь баримталсан шийдвэр гаргахаас өмнө өөрсдийн нэн тэргүүний чухал зарчмуудыг илэрхийлэх боломж бидэнд олгож байна.

Нууцын тухай хууль тогтоомж

Сайдын зөвлөл хууль тогтоогчийн хувьд дүрэм, заавар, шийдвэрээрээ гишүүн орнуудыг хуулийн дагуу удирдан зааварладаг. Хорооноос ирүүлсэн саналын дагуу Зөвлөл энэ үүргийг гүйцэтгэдэг.

1992 онд Сайдын Зөвлөл хорооны бичиг баримттай танилцах тухай Бермингэм, Эдинбургэд хэлэлцсэн бөгөөд 1993 онд Данийн засгийн газар хэвлэлийг нээлттэй байлгахыг уриалсан юм.

Эцэст нь тус Зөвлөл 1993 оны 12 сард нээлттэй байдлыг ихээхэн хязгаарласан журмыг баталсан билээ.

Өнөө үед Сайдын Зөвлөл доторх зарим үл сөргөлдөх маргааныг нийтэд нээлттэйгээр зохион байгуулдаг бөгөөд үйл ажиллагааныхаа журмын дагуу жилд доод тал нь 2 удаа нийтийн маргаан явуулахыг зөвшөөрсөн бөгөөд хэрэв явуулахаар бол сайдууд зөвшилд хүрэх ёстой байдаг.

Шийдвэрийн протоколыг журамд тэдгээрийг нууц байлгах ёстой гэсэн заалт байдаг. Хуулийн дагуу Зөвлөлийн шийдвэр гаргахад ашигласан хэлэлцүүлгийн баримтуудыг нууцалдаг бөгөөд олон нийт Зөвлөл эсвэл Хорооны бичиг баримтын ерөнхий бүртгэлтэй танилцах боломжгүй юм. Гэвч Европын Холбооны бусад бичиг баримттай танилцах өргөдөл нь товч тодорхой байх ёстой. Нийтийн байгууллагуудад баримтаа олонд мэдээлэх эсэхээ шийдэх сарын хугацаа олгодог. Татгалзсан хариу авсан тохиолдолд өргөдөл гаргагч шийдвэрийг дахин хянаж үзэх хүсэлтээ сарын хугацаанд өргөн барьж болно. Өргөдөл гаргагч ахин татгалзсан хариу авсныг ЕХ-ны байгууллагад мэдэгдэх хүртэл бас нэг сар болдог. Энэ тохиолдолд шалтгааныг тодорхойлвол зохино.

Шүүхийн үйл ажиллагааг хамруулан цаашид давж заалдах, шүүхийн түшмэлд санал хүсэлтээ илэрхийлж болно. Татгалзах болсны шалтгаан нь олон янз байх бөгөөд энэ нь тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны тэмдэглэл, баримтын нууцыг хадгалах сонирхлоос хамаардаг.

Дотроос тавьсан шүүмжлэл

Данийн засгийн газар нээлттэй байх явдлыг удаашруулж байгааг ил тод шүүмжлэн Эдинбургэд тохиролцсон амлалт талаар болсныг онцлон тэмдэглэсэн байдаг. “Зөвлөл зарим салбарт Холбооны иргэдэд шууд хамааралтай хууль батлах эрхтэй юм. Иймээс шүүх ажиллагаан дээр Зөвлөлд оруулсан Хорооны санал нь анхны нээлттэй хэлэлцүүлэгт заавал ордоггүй нь ноцтой асуудал мөн”.

Шууд сонгогддог Европын Парламент нээлттэй байдлыг дэмждэг бөгөөд 1992 онд Фэйот Шпитцэлийн тайлан АНУ-ын Мэдээллийн Эрх Чөлөөний тухай акттай төстэй удирдамж боловсруулахыг Хорооноос шаардсан. Парламентийн дэмжлэгтэй энэ тайлан Нийгэм, үндэсний байгууллагуудын тухай мэдээ мэдээллийг баталгаатай авахыг санал болгосон. Энэ тайлан мөн сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон “шүгэл үлээгч нар”-ыг хамгаалах үзлийг дэмжив.

1996 онд Парламент ЕХ-нд ил тод чиг бодлогыг хэрэгжүүлэх, ЕХ-ны баримт бичгийг хэрэглэх дүрэм журам бий болгох, Сайдын Зөвлөлийн хуралдааныг нээлттэй байлгах талаар санал хураасан аж.

Финни, Шведийн засгийн газрын аль аль нь илүү нээлттэй ил тод байдлыг уриалсан юм. 1995 оны 2-р сарын тайланд багтсан Финнийн санал Скандинавын

хөршүүдийнхээсээ илүү боловсронгуй, гүнзгий бөгөөд олон улсын хэлэлцээрүүдэд эргэлт гаргаж ч болзошгүй юм.

Финнийн санал нь албан бичиг баримтын нууцын тухай асуудлаар гараагаа эхэлсэн бөгөөд Финни “ЕХ-ны бичиг баримтыг ашиглах ерөнхий дүрэм, журам нь үндсэн хуультай нийцэж байх шаардлагатай” гэсэн санал дэвшүүлсэн байна.

Европын нийгмийн гэрээнд шинэ 214а-р зүйлийг боловсруулан үүнийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Скандинавын болон Нидерландын хуулиас жишээ авч албаны нууц бичиг баримтыг тодорхойлох журмыг тогтоох явдал Финнийн саналын гол зорилго нь байсан юм. Бичиг баримт тодорхой ангилагдаагүй тохиолдолд Зөвлөлийн хэлэлцээр ил тод, нээлттэй явагдах хэрэгтэй. Мөн Финлянд “Үйл ажиллагааны нууц болон хэсэг бүлэг нөхдийн сонирхлыг авч үзэхийн оронд олон нийтэд хамааралгүй бичиг баримтыг ангилан цэгцэлж, шаардлагатай үед тэдгээртэй танилцахыг татгалзаж мөн зөвшөөрөх талаар шийдвэр гаргаж байх хэрэгтэй” гэсэн санал дэвшүүлсэн.

Мөн зөвлөлд “үйл ажиллагааг нээлттэй ил тод болгож, гишүүн орнууд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох” саналыг тавьсан байна. Зөвлөлийн хэлэлцээр, түүнээс гарсан тунхаглалын протоколыг олонд нээлттэй байлгах хэрэгтэй. Бичиг баримт болон хувилбарын үндсийг бүрдүүлж олон нийтэд дэлгэн тавих нь зүйтэй гэж Финлянд улс зөвлөсөн байна.

Мөн Финлянд улс сүүлийн үед бүртгэгдсэн хуулийн төслийн төлөвлөгөөний жагсаалт, Зөвлөлд ажиллах бүрэлдэхүүнийг мэдээлж байхыг шаардсан юм. Гадны бичиг баримт (засгийн газар болон тусгай сонирхогч хэсгийн тавьсан санал г.м) нууцлагдмал хадгалагддаг заншлыг төгсгөл болгох нь зүйтэй гэж үзжээ.

ЕХ-ны бүрэлдэхүүн, ажиллах хэсэг, Кореперийн зорилго, хөтөлбөр, ЕХ-ны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг ил тод мэдээлвэл зохих бөгөөд түүнчлэн ЕХ-ны албан бичиг баримтын тухай Шведийн саналыг хэрэгжүүлж болох хэдий ч энэ нь Зөвлөлийн ил тод байдлын хувьд Финляндынх шиг гүнзгий боловсронгуй биш юм. Дээрхи арга хэмжээ нь ЕХ-ны бүрэлдэхүүн мэдээлэл хүлээн авах болон боловсруулах үйл ажиллагааг тодорхойлсон байдаг.

Хуулийн тэмцэл

Засгийн газрын нөлөөний нэгэн адил ЕХ-ны хуулийн арга хэрэгсэл мэдээлэл түгээх цар хүрээг тэлэхэд тодорхой хувь нэмэр оруулж чадна. 1995 онд Британийн сонин “Guardian”-ийн хэргийн үеэр анхан шатны шүүх (цаашид “ЕАШШ” гэх) Сайдын зөвлөлийн хэт их нууцлагдмал байдал нийгмийн хуульд сөргөөр нөлөөлж болзошгүйг анхааруулсан байдаг. Брюсселийн сонины сурвалжлагч Джонн Карвел 1994 онд Сайдын Зөвлөлөөс зарим нэгэн бичиг баримттай танилцах хүсэлт тавьсан боловч Хөдөө аж ахуйн Сайдын Зөвлөл татгалзсан байна. Энэ нь “Зөвлөлийн үйл ажиллагааны дотоод дүрмийн дагуу боломжгүй” гэсэн хариулт өгсөн юм.

Гэвч үйл ажиллагааны дотоод дүрмийн зүйл ангид “эсэргүүцэх боломжтой” гэсэн хэллэг хэрэглэсэн байдаг. Дани, Нидерландын Засгийн газар, Европын Парламентаас дэмжлэг авсан Карвел албан бичгийн нууц болон ил тодыг харьцуулж үзэлгүйгээр Зөвлөл шууд эсэргүүцсэн хэмээн гомдол гаргасан юм. ЕХАШШ “Guardian”-ийг дэмжиж “бичиг баримттай танилцах хүсэлт тавьсан тохиолдолд сонирхлыг харгалзан үзэж” ил тод байдал болон нууцыг дэнслэн тооцоолох хэрэгтэй гэж үзсэн. Гэвч уг заавар

засгийн газарт мэдээлэл ашиглах хүсэлтийг няцаах өргөн боломж олгосон байдаг. Хэрэв тухайн асуудал нь хавсралт хуулийн шинжтэй эсвэл лавлагаа хийгдэх шатанд байгаа тохиолдолд нууцыг хадгалах мөн олон улсын худалдаа, үйлдвэрлэлийн нууц мэдээллийг задруулахгүй байх үүднээс нууцыг хадгалж болно.

Олон нийтэд зарлахыг эсэргүүцэх шийдвэр гаргах “хуулийн болон засаг захиргааны нөхцлүүд” байдаг. Гэвч зааварт ийм нөхцлүүдийг нарийн тодорхой зааж өгч чаддаггүй. Заавар гаргагчид олон нийтэд зарлах боломжгүй байх үндэслэлүүдийг тогтоож болох байсан хэдий ч үүнийг тусгаагүй ажээ.

Харин цөмийн зэвсгийн нууцыг зөвхөн Холбооны хүрээнд хадгалах, ангилах тодорхой үндсийг заасан Евроатом гэрээнд Евроатомын төрөлд хамрагдах мэдээллийг ангилжээ. Нарийн чанд дэглэм өсөх дарааллаар 4-н зангилаа болгон Евро-хориглол, Евро-албаны нууц, Евро-нууц, Евро-маш нууц гэж хуваасан. Засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр олон нийтэд батлан хамгаалахын мэдээлэл тараах эрх байхгүй. Энэ нь ЕХ ангилал хийсэн цорын ганц салбар юм. Одоо Европын холбооны улсууд болон бусад орнуудад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг үндсэн хуулиараа хэрхэн баталгаажуулсан хийгээд мэдээлэл олж авах эрх, нууцын талаарх хууль, эрх зүйн зохицуулалтын талаар авч үзье.

1.Австри улс

Хөрш орнуудтай нь харьцуулбал Австрид үг хэлэх эрх чөлөөг илүү хүндэтгэн үздэг. Энэ нь Европын Хүний Эрхийн Конвенцид Австри нэгдмэл саналаар гарын үсэг зурсан хийгээд Үндсэн хууль нь дээрх Конвенцтэй нэгдмэл үзэл санаатай байдагтай холбоотой юм. Гэвч тус улсад хэвлэл мэдээллийн эзэмшлийн талаар маргаантай байгаа бөгөөд энд өдөр тутмын сонины хоёр том урсгал дангаар ноёрхдог. Австрид хэвлэлийг зөв зохистой дэмжих замаар зарим хэсэгт хэвлэлийн системийг задлах арга хэмжээ авч байна.

Үндсэн хуулийн баталгаа

1867 онд Австрийн үндсэн хууль батлагдсан бөгөөд 1920 оны Холбооны Үндсэн хуультай зохицуулан өөрчилсөн юм. Уг хуулийн 13-р зүйлд *“Хүн бүр өөрийн сонирхлоо дагах эрхтэй. Хэвлэл бол хяналтын юм уу зөвшөөрөл олгох алба биш”* гэж заасан байдаг.

Мөн мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн тайлбар ч байдаг. Холбооны хуулийн 20(4)-р зүйлд “Бүх холбоо, муж, орон нутгийн засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болон бүх корпораци нууцыг нь хуулиар хамгаалаагүй тохиолдолд үйл ажиллагааныхаа явцыг ард түмэнд мэдээлж байх ёстой” гэж заажээ. Австри улс 1958 онд Хүний Эрхийн Европын Конвенцид гарын үсэг зурсан бөгөөд үүнийг 1964 онд хууль болгон баталсан. Саяхныг хүртэл Үндсэн хуулиараа баталсан эрх чөлөөг “хуулийн үйл ажиллагааны хүрээн дэх эрх” гэж авч үздэг байсан бөгөөд Үндсэн хуулийн шүүх эрх ашгийг илүү хамгаалах тал дээр анхааран ажиллаж, Европын Хүний Эрхийн Шүүхийн үндэслэлийг мөрдөж эхлээд байна.

Улмаар Австри 1978 онд Иргэний болон Улс төрийн эрхийн Олон Улсын Пактад (цаашид “ИУТЭОУП” гэх) нэгдэн орж, 1987 оноос ИУТЭОУП-ын дагуу хувь хүнд НҮБ-ын Хүний Эрхийн Хороонд Австрийн эсрэг санал шүүмжлэл мэдүүлэх эрхийг олгосон байна. ИУТЭОУП нь Үндсэн хуульд хамааралгүй ба үүнийг шүүхэд шууд утгаар нь хэрэглэх боломжгүй юм.

Нууцын тухай хууль тогтоомж

Холбооны Үндсэн Хуулийн 20/3/-р зүйлд үндэслэн гаргасан мэдээлэлтэй танилцах дүрэмийн тухай Эрүүгийн хуулийн 225-р хэсэгт заасан байдаг. Тус улсын Засаг захиргаа болон Шүүхийн зүгээс албаны нууцыг ил тод болгох хандлагыг баримталж байна.

Нууцыг задруулах, албан бичиг баримтыг мэдээлэх хоёрыг ялган тайлбарласан байдаг. Үүнд, хэрэв төрийн албан хаагч нууцыг задруулсан тохиолдолд тухайн хүн хариуцлага хүлээнэ. Нэгэнт задарсан мэдээллийг сонин хэвлэл нийтлэх эрхтэй байдаг. Сүүлийн хэдэн жилд энэ талаар идэвхтэй мэдээлсээр ирсэн. Гэвч уг нууцыг тарааснаар улс үндэстний аюулгүй байдал, түүний олон улсын харилцаанд хүндрэл учруулбал 225-р заалтын дагуу гэмт хэрэг гэж үздэг. Энэ тохиолдолд шүүх мэдээлэх эрх чөлөө, үндэстний аюулгүй байдал хоёрыг дэнслэн үзэх хэрэгтэй болдог. Сүүлийн жилүүдэд ийм хэдэн тохиолдол цөөн гарчээ. Мэдээлэл авах эрх гэдэг нь мэдээлэл цуглуулах газарт орох эрхийг авсан тохиолдолд засгийн газар сурвалжлагчдын цуглуулсан мэдээг хянах эрхгүй байдаг юм. Мөн 1987 онд жагсаал цуглаан хийж байсан хүмүүсийн фото зургуудыг цагдаа нар устгасан явдлыг шүүх хууль бус үйл ажиллагаа гэж үзсэн байдаг.

Мэдээлэл олж авах эрх

Холбооны хүрээнд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд мэдээлэлтэй танилцах харилцааг нарийн заасан бөгөөд хүсэлт тавигч мэдээлэлтэй танилцах зөвшөөрөл авч чадаагүй бол Засаг захиргааны шүүхэд хандаж болохоор заасан байна. 1981 оны Хэвлэлийн хуулиар шүүхийн үйл ажиллагааг нээлттэй болгосон. Гэвч Австрид энэ өөрчлөлтийн талаар маргаантай байдаг. Түүнчлэн хэвлэлийн мэдэгдэлийн сенсааци, “хэвлэлийн шүүх хурал” гэж байдаг байна. Мөн хуулийн 31-р зүйлд сурвалжлагчийн нууцыг тууштай хамгаалсан бөгөөд Хэвлэн нийтлэгчид, редактор, сэтгүүлчид болон бусад хэвлэлийн ажилтан мэдээллийн агуулгын талаар шүүхийн өмнө мэдэгдэл хийхээс татгалзах эрхтэй. Шүүхийн даалгавраар гэмт хэрэг илрүүлэхээс бусад тохиолдолд сонин, телевизийн үйл ажиллагааг тагнан тандахыг хориглодог ба тагнан тандвал шүүхээс доод тал нь 10 жилийн хорих ял оноодог. Хэвлэлийн хуулийн өөр нэг эерэг тал нь нэр төрийг гутаах явдлыг зохицуулсан бөгөөд энэ нь сэтгүүлчид зөвхөн өөрсдийнхөө ажлыг хийж байгаа эсэхийг батлах шалтгаан болсон юм.

2. Финлянд улс

Финляндын хууль, эрх зүйн түүх зөвхөн 1917 оноос буюу тус улс тусгаар тогтносноос хойш эхэлжээ. Энэ нь Финлянд эхлээд Швед дараа нь Оросд эзлэгдсэн байсантай холбоотой. Энэ үед Финляндчуудын хамгийн гол шаардаж байсан зүйл бол хэвлэл мэдээллийн эрх чөлөө байлаа. Тиймээс ч тусгаар тогтнолоо зарласны дараа хамгийн түрүүнд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хуулчилсан аж. Финлянд нь нэг хүнд ногдох сонин, сэтгүүлийнхээ тоогоор дэлхийд гуравт ордог юм. Шведтэй мөн адил Финляндчууд мэдээллийн эрх чөлөөг их эрхэмлэдэг бөгөөд Финляндын Засгийн газар Европын Холбооны энэ асуудалд хандах хандлагыг нь шүүмжилдэг аж.

Үндсэн хуулийн баталгаа

Финляндын Үндсэн Хуулийн 10 дугаар зүйлд үг хэлэх эрхийг баталгаажуулсан байдаг. Үүнд: *“Финляндын иргэн бүр үгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, мөн хэний ч урьдчилсан шалгалт, хяналтгүйгээр бичгээр болон зургаар илэрхийлсэн материалыг хэвлүүлэн нийтлүүлэх эрхтэй”* гэжээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг 1919 онд баталсан. Энэхүү хуулинд: *“Финляндын иргэн бүр ямарваа нэгэн бичвэр материалыг хэрвээ энэ хуулийн зүйл заалтуудтай харшлаагүй бол олон нийтийн удирдлагуудын зүгээс урьдчилсан шалгалт хяналтгүйгээр нийтлүүлэх эрхтэй”* гэж заасан байдаг.

Энэ хуулийн анхны хувилбарт сонин сэтгүүлийг хаах, сэтгүүлчдийн баримт бичгийг хураан авах тухай заалтууд орсон байж. Гэвч энэ заалтуудыг өөрчилсөн байна. Одоо бол Финляндад хэвлэн мэдээлэх эрхийг хаах явдал нь хууль бус юм.

Нууцын тухай хууль тогтоомж

Мэдээлэлд хүрэх боломжийг 1951 онд батлагдсан *“Албан ёсны баримт бичгийг хэвлэх тухай хууль”*-иар олгосон юм. Үүнээс хойш энэ хуулинд зарим өөрчлөлтүүд орж байсан. Уг хуулийн тодорхой хэдэн заалтад мэдээлэлд хүрэх боломжгүй тохиолдлуудыг дурьдсан байдаг. Мөн уг хууль батлагдсан жил гарсан зарим зарлиг, тогтоолууд мөн иймэрхүү тохиолдлуудыг тусгасан бөгөөд эдгээр нь хуультайгаа адил хүчинтэй байдаг.

Энэхүү хуулийн дагуу албан ёсны баримт бичгүүд гэдэг нь Лүүнд хальсан дээр буулгасан болон компьютержсэн материал орно/ олон нийтийнх, хэрвээ уг материал хаалттай материалуудын жагсаалтанд ороогүй бол, бүх шатны төрийн удирдлагын мэдэлд байгаа болон шашны байгууллагын мэдэлд байгаа баримт бичгийг хэлнэ.

Баримт бичигтэй танилцах боломжийг баталгаажуулж, хүсэлт гаргасан хүмүүст нь тухайн баримтыг нь олгох үүрэгтэй төрийн албан тушаалтан байгууллага бүрт байдаг ажээ. Тухайн хүссэн материалын албан ёсны хуулбар, хэсэгчлэн авсан хуулбараар эсвэл тэрхүү баримт бичгүүдтэй танилцахад зориулсан албан ёсны хэрэгслүүдээр хангах үүрэгтэй. Мөн материал хүсэгчдэд “албан ёсны харилцаа холбооны хэрэгсэлээр” баримт бичгийг нь хүргүүлж болох ажээ. Материал хүсэгч гадаадын иргэн биш бол тухайн байгууллага уг хүний тухай мэдээллийг шаардахгүй байж болно. Ийм тохилдолд тухайн байгууллага хүссэн мэдээллийг нь өгөх эсэхээ маш болгоомжтойгоор шийдвэрлэнэ. Хэрвээ материал хүсэгч татгалзсан хариу авбал тухайн татгалзсан байгууллагадаа давж заалдах цаашилбал, хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд Дээд шүүхэд давж заалдах эрхтэй юм. Арай доод шатны байгууллагаас татгалзсан хариу авсан бол орон нутгийн шүүхэд хандаж болох ажээ. Иймэрхүү асуудлыг шүүх богино хугацаанд шийддэг боловч хуулинд тусгайлан хугацаа заагаагүй байдаг. Мөрдөн байцаах болон цагдаагийн байгууллагын мэдэлд байгаа хавтаст хэргүүд шүүхэд шилжээгүй бол эдгээрийг олон нийтэд мэдээлэхийг хоригложээ. Мөн “боловсрогдож байгаа” болон дотоод хэрэгцээний баримт бичгүүд, түүнчлэн меморандум гэх мэт материалууд нууцын зэрэглэлтэй байдаг.

Хэрэв олон улсын аюулгүй байдал, гадаад таатай харилцаа, батлан хамгаалахтай холбоотой материалыг шаардлагатай гэж үзвэл нууцлаж болох ажээ. Ерөнхийлөгч болон Төрийн Консул нар шийдвэрлэж байгаа асуудлынхаа талаарх мэдээллийг тодорхой хугацаанд нууцлах эрхтэй байдаг.

Гадаад Явдлын Яам болон Төрийн Консулын Гадаад хэргийг Хариуцсан Зөвлөлийн баримт бичгүүд 1994 оны 12 дугаар сар хүртэл нууцын зэрэглэлтэй байв. Энэ үед гадаад хэрэгтэй холбогдолтой материалуудыг “уламжлалт гадаад бодлогын” болон “менежментийн” гэж хоёр ангилжээ. Эхний ангилалд багтсан баримт бичгүүдийг нууц хэвээр нь үлдээж сүүлийнхийг нь олон нийтэд хүртээлтэй болгохоор шийдвэрлэсэн байна. Дээрх шийдвэр гарсны дараахан Төрийн Консул Европын холбоонд өргөн баригдаж байгаа хуулийн төслүүдийн талаарх мэдээлэл иргэдэд хүртээлтэй байх ёстойг анхаарсан шийдвэр гаргажээ. “Хуулийн төслийн агуулга, явц” зэргийг олон нийтэд

мэдээлж, Финляндын Европын Холбоонд өргөн барьж байгаа хуулийн саналуудыг аль болох ил тод байлгахгаар Финляндын засгийн газар ажиллаж байна. Батлан хамгаалах хүчний асуудалтай холбоотой зэвсэгт хүчний нийлүүлэлт, дайны болон иргэний хамгаалалтын төлөвлөгөө гэх мэт нь нууц байна. Дайны үед “улс үндэстний батлан хамгаалахын асуудлыг аюултай байдалд оруулж болзошгүй” цэрэг зэвсгийн мэдээллийг ил гаргахыг хориглодог.

3.Франц улс

Франц улс бол хэвлэл мэдээллийг хүчтэй зохицуулах шаардлагагүй цөөнх улс орнуудын нэг юм. Үүний нэг шалтгаан нь тус улсын эрх зүйн тогтолцоо нь хэвлэл мэдээллийн эрхийг зөрчсөн гэж үзэж буй хүмүүсийн гомдлыг харьцангуй шуурхай, үр дүнтэй, боломжийн хэлбэрээр барагдуулах боломжийг олгодогт оршиж байна. Бас нэг шалтгаан бол Францын хэвлэл мэдээллийнхэн Солонгын хэргүүд (Rainbow Affairs) болон сүүлийн үед гарсан цус солилтын хэрэг зэрэг дээгүүр болж буй зохисгүй буруу явдлуудыг илрүүлсэнд түүнд нийт олны зүгээс итгэх итгэл бий болсон явдал юм.

Үндсэн хуулийн баталгаа

Хэдийгээр тасралтгүй биш ч гэсэн Франц улсад Хэвлэлийн эрх чөлөө нь 1789 оны Хүний болон Иргэний Эрхийн Тунхаглалаас хойш бий болсон уламжлалтай билээ. Энэхүү Тунхаглалын 11 дүгээр заалт нь Францын 4 дэх Бүгд Найрамдах Улсын 1958 оны Үндсэн хуулийн Оршилын нэг хэсгийг бүрдүүлсэн бөгөөд үүнд **“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүний хамгийн үнэт эрх чөлөө юм. Иймээс хүн бүр чөлөөтэй ярих, бичих, хэвлэх эрхтэй бөгөөд чингэхдээ энэхүү эрх чөлөөгөө буруугаар ашигласан бол тус хуульд заасан тохиолдлуудад хариуцлага хүлээх болно”** гэж заажээ.

Францын үндсэн хуулийн шүүх болох Үндсэн хуулийн Зөвлөл нь Үндсэн хуультай харш ямар ч хуулийг хүчингүй болгох эрхтэй ба түүний шийдвэрийг заавал биелүүлэх ёстой. Тус Зөвлөл нь үзэл бодлын эрх чөлөө нь хүний бусад эрхийн гол баталгаануудын нэг мөн гэж тогтоосон бөгөөд хэвлэлийн плюрализмыг Үндсэн хуулийн гол зорилго болгоход энэхүү эрх чөлөө нь хэвлэлийн хэрэглээ, үйлдвэрлэлийн аль алинд хамаарах болно гэж заажээ.

Үндсэн хуулийн 55 дугаар заалтаар олон улсын гэрээнүүд нь дотоодын хууль тогтоомжийг давамгайлах бөгөөд тэдгээрийг бүх түвшний шүүхийн байгууллага нь (зөвхөн дээд түвшний гээд зогсохгүй) хэрэглэх үүрэгтэй. Иймээс Францын шүүх байгууллагуудад Европын Хүний Эрхийн Конвенц, Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт нь Францын өөрийн үндсэн хуулиас илүү давамгайлах нөлөөтэй билээ. Францын иргэд хувийн гомдлоо НҮБ-ын Хүний Эрхийн Хороо болон Европын Хүний Эрхийн Комисст өргөн барих эрхтэй юм.

Нууцын тухай хууль тогтоомж

Албаны мэдээлэл авах эрх нь үндсэндээ эрх зүйн гурван актаар зохицуулагдана. Эдгээрээс захиргааны бичиг баримтанд хүрэх тухай 1978 оны 7 сарын 17-ны тогтоол нь сэтгүүлчийн хувьд хамгийн чухал. Энэхүү тогтоолыг 1979 оны 7 сарын 11-ний Хууль дагалдан үйлчилнэ. Энэ хуулиар захиргааны байгууллагуудаас мэдээлэл олгохоос татгалзах болсон үндэслэлээ гаргаж өгөхийг шаардана. Албаны мэдээллийг зохицуулах гуравдахь эрх зүйн акт болох 1978 оны 1 дүгээр сарын 6-ны Мэдээлэл болон Эрх чөлөөний тухай хууль нь компьютер болон хавтаст хэрэгт буй хувь хүний мэдээлэлд

нэвтрэх асуудлыг зохицуулна. Захиргааны мэдээлэлд нэвтрэх тухай хууль тогтоомжууд нь дор хаяж онолын түвшинд “хүн бүрт мэдээлэлд хүрэх эрхийг бий болгоно. Гэхдээ практик дээр энэ нь дутагдалтай байгааг сэтгүүлчид олж харсаар байна. Нээлттэй байх тухай журамд хамаарагдахгүй тохиолдлууд нь маш өргөн хүрээтэй тодорхойлсон бөгөөд үйл явцын хугацаа нь онцгой урт байгаа юм.

Мэдээлэл олгохоос дараах үндэслэлээр татгалзаж болно: (1) засгийн газар, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нууцлал, (2) үндэсний батлан хамгаалах болон гадаад харилцаа, (3) улсын валют болон нийтийн зээл, (4) улсын аюулгүй байдал болон нийгмийн аюулгүй байдал (5) шүүх болон шүүхийн өмнөх үйл явц (6) хувийн хэргийн нууцлал, (7) арилжааны болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нууцлал болон (8) татварын болон гаалийн албан шалгалт үзлэг. Хуулиар мэдээлэлд нэвтрэх тухай ирүүлсэн гомдлыг шалгах үүрэг бүхий Захиргааны мэдээлэлд нэвтрэх тухай Комиссыг (CADA) байгуулна.

Тус байгууллага нь системийн үйл ажиллагааны жилийн тайланг гаргах бөгөөд мэдээлэл эрж буй хүмүүст зааварчлага өгнө. Гэхдээ хэдийгээр энэ нь өндөр эрх мэдэл бүхий шүүхийн болон улс төрийн албан тушаалтнуудаас бүрддэг ч мэдээлэл олгохыг тушаах эрхгүй байгууллага юм. Мэдээлэл олгохоос татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагч эхлээд CADA-тай зөвлөлдөх ёстой бөгөөд CADA тухайн байгууллагыг мэдээлэл өгөхийг ятгаж хүсэлт тавина. Энэхүү эхний шат амжилтгүй болсон тохиолдолд өргөдөл гаргагч захиргааны шүүхэд хандана. Гэхдээ энэ үйл явц маш их сунжрах магадлалтай. Татгалзагч байгууллага нь анхлан татгалзах болсон тухай шалтгаанаа өгөх үйл явц 2 сар хүртэл үргэлжлэнэ. Захиргааны шүүх өргөдлийг барагдуулж, асуудлыг шийдвэрлэтэл 6 хүртэл сар шаардагдана. Ийм урт хугацаа шаардагдах учраас сэтгүүлчид ихэнхдээ энэ үйл явцыг орхидог нь гайхах зүйлгүй.

Мэдээллийн хууль нь иргэдэд өөрийн тухай мэдээллийг агуулсан хавтас хэргийг үзэх мөн алдаатай мэдээллээс хамгаалах эрхийг олгоно. Энэ хуулиар мэдээллийг хамгаалах үндэсний комиссыг байгуулдаг.

Эрүүгийн төрөлжсөн хууль нь мөн зарим төрлийн мэдээллийг задруулахыг хориглодог. Уг хуулийн 76 дугаар зүйлийн дагуу батлан хамгаалахын мэдээллийг задруулахыг үндэсний аюулгүй байдалд аюул учруулна гэж үзээд хориглосон байдаг.

Төрийн бүх албан хаагчид төрийн нууцлалыг чанд сахих үүрэгтэй бөгөөд үүнд “нийгмийн эрх ашиг”-ийн үүднээс буруу зохисгүй ажиллагаануудын талаар мэдээллийг төрийн албан хаагчид, Улсын Прокурорын газарт мэдэгдэх үүрэгтэй. Францын хууль нь сонинуудад урьдчилсан хязгаарлалт тогтоож, хураан авахыг зарим тохиолдолд зөвшөөрөх бөгөөд ийм төрлийн үйл ажиллагаа нэн ховор тохиолдоно. “Цус солилт”-ын хэргийн дуулианы үеэр “Paris weekly” сонин хэрэгт холбогдсон эмч болон өөр нэгэн сонин сэтгүүлч хоорондын ярианы хэсгүүдийг нийтэлжээ. Яриаг мөн АНУ-д дэлгэрүүлэн нийтэлсэн байна. Хэрэгт холбогдсон эмч хувийн нууцыг задруулсан гэсэн үндэслэлээр “Paris weekly” сонинг хураахыг шаардаж байв. Хэдийгээр шүүх уг яриаг нийтлэх нь гурван тусдаа үндэслэлийн дагуу хууль бус үйлдэл мөн гэж үзсэн боловч тус сонинг хураах шийдвэр гаргахаас татгалзсан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хуулийн 1993 оны нэмэлт өөрчлөлтөөс хойш, хэвлэл мэдээллийн газруудын эд хөрөнгөд үзлэг хийх үед цагдаагийн ажилтны хамт шүүгч буюу улсын прокурор “Үзлэг нь сэтгүүлчийн ажлыг чөлөөтэй эрхлэх эрхэд аюул учруулахгүй байх, мөн мэдээллийг хүргэхэд садаа болох буюу цаг алдан хүргэхээс сэргийлэх”-ийн үүднээс заавал байлцах болсон.

1993 он хүртэл, хэдийгээр шүүгчид мэдээллийн эх сурвалжаа мэдэгдэхээс татгалзсан сэтгүүлчдийг шийтгэх нэн дургүй байсан ч сэтгүүлчийн нууцлалын эрхийн эрх зүйн хамгаалалт байгаагүй билээ. 1993 оны 1 дүгээр сард Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт бол 109(2) дугаар зүйл: “Сэтгүүлчийн ажлаа гүйцэтгэх явцдаа өөрийн цуглуулсан мэдээллээ гэрч сэтгүүлч нь задруулахгүй байх эрхтэй.” гэж заасан байна.

4.Герман улс

Герман улсын мэдээллийн эрх чөлөөний талаар баримталж буй байр суурь нь дээр дурьдсан Скандинавын орнууд болон нууцлалыг хэт чухалчладаг гэж хэлж болмоор Британи болон Ирландын байр суурины дунд оршино. Холбооны Герман Улсын түүх, ялангуяа хүйтэн Дайны цагт эзэлж байсан түүний байр суурь нь тус орны Үндсэн хуульд илэрхийллээ олсон үзэл санаа ба шүүхийн практик хоёрын хооронд зөрүү, мөргөлдөөн үүсэхэд хүргэсэн байна.

Энэ шалтгаанаар, хэвлэлийн эрх чөлөө болон мэдээллийн эрх чөлөөг хөндсөн асуудлууд нь Үндсэн Хуулийн Шүүх дээр байнга хатуу тэмцлийн үр дүнд шийдвэрлэгддэг байв. Хамгийн чухал хэргүүдээс 1996 оны “Der Spiegel”-ийн хэрэг мөн 1981 оны гүнтер Валрафын хэргийг хэлэлцсэн явдал юм.

Үндсэн Хуулийн 5(1) дүгээр зүйлд **“Хүн бүр өөрийн үзэл бодлоо амаар, бичгийн болон дүрсийн хэлбэрээр илэрхийлэх, түгээх эрхтэй бөгөөд олон нийтийн хүртээл болсон мэдээллийг ямар ч саадгүйгээр олж авах эрхтэй. Хэвлэлийн эрх чөлөө болон радио телевизийг ашиглан мэдээлэх эрх чөлөөгөөр хангагдсан байна. Хэвлэлийг хянан шалгах явдлыг хориглоно”** гэж заажээ. “Мэдээллийг ямар ч саадгүйгээр олж авах” эрх нь мэдээллийн эрх чөлөөний Үндсэн хуулийн баталгаа гэсэн утгаар ойлгогдоно. Эдгээр эрхэд тавьсан зарим хязгаарлалтыг 5(2) дугаар зүйлд “эдгээр эрх нь иргэний хувийн болон хүүхдийн эрхийн хамгаалалтыг зохицуулах хууль тогтоомжийн заалтуудаар хязгаарлагдана” гэж заасан байдаг. 18 дугаар зүйлд “үзэл бодлоо илэрхийлэх эрхээ ялангуяа хэвлэлийн чөлөөт ардчилсан тогтолцооны үндсийг эвдэх зорилгоор буруугаар ашигласан тохиолдолд эдгээр үндсэн эрхийг Холбооны улсын Үндсэн хуулийн Шүүхээр шийдвэрлэсэн хэлбэрээр хасна” гэж заасан байна. Гэхдээ 19 дүгээр зүйл “ямар ч тохиолдолд үндсэн эрхийг бүр хасч болохгүй” гэж мөн заасан байдаг. Холбооны улсын Үндсэн Хуулийн Шүүх нь хэвлэлийн эрх чөлөөг “хүний эрхийн хамгийн онцгой чухал эрх бөгөөд ардчилсан тогтолцооны гол амин үндэс” мөн хэмээн тодорхойлжээ. Энэ утгаараа, Үндсэн Хуулийн Шүүх нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хувь хүний эрхээс илүү ардчиллын суурь байгууллага гэж үзэж байна. Хэвлэлийн зөвшөөрөл нэвтрүүлэх, мэдээллийн эх сурвалжийг хаах, хэвлэлийн тооны хязгаарыг улс төрийн үзэл бодлын дагуу тогтоох арга хэмжээнүүд нь Үндсэн хуульд харш үйл ажиллагаа юм.

Германы Үндсэн хуулийн болон үзэл бодлын эрх чөлөөний нэрт зүтгэлтэн, профессор Улрих Карпен “Төрийн нууцлалын сонирхол, мэдээллийн эрх чөлөөний сонирхол мөргөлдөх тохиолдолд Германы шүүх талуудын сонирхлыг тэнцвэржүүлэх зорилгоор пропорциональ тестийг хэрэглэх болно” гэж бичжээ. Гурван талт энэхүү тестийг хэрэглэхэд засгийн газар нь өөрийн дэвшүүлж буй саналыг зохистой, шаардлагатай, пропорциональ гэдгийг нотлох үүрэгтэй. Тэрээр нэмж хэлэхдээ “Эцсийн дүгнэлтийг гаргахад аль талын сонирхол давамгайлж буй талаар ямар нэгэн эргэлзээ гарсан тохиолдолд хэвлэлийн эрх чөлөөний сонирхлыг илүү түлхүү анхаарна” гэжээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн үйлчлэх хүрээнд Германы иргэдээс гадна бусад бүх хүмүүс мөн адил хамаарна. Бодит байдлаар авч үзвэл үзэл бодлын илэрхийллийг хамгаалахын зэрэгцээ мөн түүнд агуулагдаж буй хийгээд түүний зорьж буй нөлөөлөл давхар хамгаалагдаж байгаа юм. Яагаад гэвэл үзэл бодлын илэрхийллийн утга учир нь орчин тойрондоо оюун санааны нөлөө үзүүлэх, олон нийтийг тодорхой үзэл бодолтой болгох, түүнд итгэл үнэмшлийг олгоход оршдог юм. Үзэл бодлыг чөлөөт байдлаар бий болгох явдал нь харилцааны үйл явцад хэрэгждэг. Үүний тулд нэг талаас үзэл бодлоо илэрхийлж түгээх эрх чөлөө, нөгөө талаас илэрхийлсэн үзэл бодлыг хүлээж авах, өөрөөр хэлбэл мэдээлэл авах эрх чөлөө байх шаардлагатай. Үндсэн Хуулийн 5 дугаар зүйлийн 1-ийн заалт нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнийг түгээх ба мэдээлэл авах эрхийг хүний үндсэн эрхийн хэмжээнд баталгаажуулж байгаагийн зэрэгцээ мөн харилцааны үйл явцыг /процессыг/ үндсэн хуулиар хамгаалах зорилгыг тавьж байгаа юм.² ХБНГУ-ын бавари муж улс нь нийтийн мэдээллийн хэрэгслээр Германд тэргүүн байранд ордог. Ажлын 10 байрны нэг нь энэ салбарынх. Германы мэдээллийн программын бүх ажилтнуудын 33 % нь Баварид ажилладаг.

Германы сонин сэтгүүл гаргадаг компаниудын тавны нэг нь Баварид байдаг ба тэд 250 гаруй нэрийн сонин, бараг 1450 сэтгүүл гаргадаг. Өдөрт 3 сая сонин борлуулагддаг, Баварид 2800 хэвлэх үйлдвэр, 1000 орчим ном, сэтгүүлийн хэвлэлийн газар ажилладаг. Нийт Германы хэмжээгээр хэвлэгддэг номын дөрөвний нэг нь эндхийн бүтээгдэхүүн юм. Европын номын нийслэл гэгддэг Мюнхен хот нь Нью-Йоркийн дараа ордог дэлхийн хоёр дахь том номын хот билээ. Баварид улсын чанартай радио, телевизийн программаас гадна хувийн радио, телевиз олноор ажилладаг. Жишээ нь, Радио антени-Бавари, Германи даяар цацагддаг кабелийн программ, Радио-эгшиг болон орон нутгийн чанартай олон радио нэвтрүүлгийн программтай. Телевизийн программ л гэхэд: РТЛ-2, ДСФ, ТМ-3, ДФ-1, Кабель-1, Прозибен зэрэг нь Мюнхенээс явуулдаг.³

Нууцын тухай хууль тогтоомж

Германы мэдээллийн нууцлалын тухай хуулийн заалтууд нь энэ талаарх тусгай хуулинд биш харин мэдээллийн тухай хуулийн онцгой нөхцлийн заалтуудад тодорхойлогдсон байна. Харамсалтай нь, эдгээр хангалттай тодорхой бус бөгөөд 19 дүгээр зүйлийн дагуу нууц буюу нууцлалын журмын тухай нарийвчилсан тодорхойлолт байхгүй байна. Эрүүгийн Хуулийн 93 дугаар хэсэгт зааснаар улсын нууц гэж зөвхөн тодорхой тооны хүмүүс авах эрхтэй, Холбооны Улсын аюулгүй байдалд учирч болзошгүй ноцтой хохирлоос сэргийлэх зорилгоор гадаад улс орнуудаас нууцлагдах ёстой тоо баримт, мэдээлэл, зүйлүүдийг хэлнэ.

1968 онд 95 дугаар хэсэгт өөрчлөлт орсоноор сэтгүүлчдийг эх орноосоо урвасан хэргээр шийтгэх илүү хэцүү болсон. Гэвч, улсын нууцыг эрх бүхий бус хүмүүст хүргэсэн, олон нийтэд түгээсэн, ингэснээрээ улсын гадаад аюулгүй байдалд ноцтой хохирол учруулсан иргэнийг эх орноосоо урвасан хэргээр хариуцлага хүлээлгэнэ. Хэвлэл мэдээллийн байгууллагуудад зэвсэгт хүчний техник, төхөөрөмж, батлан хамгаалахын төлөвлөгөөг нийтлэхийг хориглоно.

Мөн 93(2) хэсэгт харин улсын нууцын тодорхойлолтыг илүү хязгаарлаж өгч байна. Чөлөөт ардчилсан тогтолцооны эсрэг болон зэвсэг хорогдуулах хэлэлцээрийг зөрчин

2 ХБНГУ-ын Пассау хотын их сургуулийн хуулийн факультетийн референдар Мориц Лоренц. "ХБНГУ-ын Үндсэн Хуулийн 5.1.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь" "Эргэцүүлэл" сэтгүүл. УБ. 2000. №7.106 дахь тал.

3 Ханнс Зайделийн сан. "Бавари".. УБ. 1999 он.

бусад оролцогч талуудаас нууцалсан тоо баримтуудыг улсын нууц гэж тооцохгүй. Хэрэв тухайн мэдээллийг нууц байсан атал биш гэж итгэж байсан эсвэл бусдыг аврах зорилгоор нийтэлж болно.

Мэдээлэл олж авах эрх

Германы мужуудын хэвлэлийн хууль нь албаны баримт бичиг, мэдээлэл авах эрхээр тусгайлан хангана. Жишээ нь, Гамбург хотын мужийн хэвлэлийн хуулийн 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллагууд нь Хэвлэл, Радио телевизийн төлөөлөгчдөд нийгмийн үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай хэрэгцээт мэдээллийг өгөх үүрэгтэй бөгөөд мэдээлэл өгөхийг хориглосон ерөнхий тогтоолууд нь” хүлээн зөвшөөрөгдөх ёсгүй” ба төрийн албан хаагчид албаны мэдэгдэл хийхдээ хэвлэл мэдээллийн бүх төлөөлөгчидтэй адил тэгш харьцах үүрэгтэй” гэж заажээ. Хуучин Холбооны бүгд Найрамдах Герман Улсын бүх мужууд адил төстэй мэдээлэл авах эрхийн баталгаа өгч байгаа ба хуучин Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын мужууд тэдгээрийг дагаж баталгаагаа өөрчилж байна.

Берлин хотын муж нь мэдээлэл олгохоос татгалзсанаас буюу хуурамч мэдээлэл өгсөнөөс хохирол учирсан тохиолдолд шүүхэд хандахыг зөвшөөрч байна. Гэвч дээрхид хамаарахгүй онцгой тохиолдлуудыг өргөнөөр тодорхойлсон учир албан байгууллагууд ямар ч мэдээлэл өгөхөөс татгалзаж болох боломж бүрдсэн байна. Мэдээж бүх мужуудад хяналт шалгалтанд байгаа хэргийн талаарх мэдээллийг хамгаалах шаардлагатай ердийн хамгаалалт бий. Гэхдээ, жишээ нь Гамбургт “нууцлалын хуулийн хүрээнд хамаарагдах буюу хамгаалах хэрэгтэй олон нийтийн болон хувийн онцгой сонирхол, эрх ашигтай холбогдсон мэдээллийн тухайд гэвэл тэдгээрийг олгох хүсэлтийг хүлээн авах ёсгүй” байна.

“Нууцлалыг зохицуулах” буюу “хамгаалах хэрэгтэй хувийн эрх ашиг, сонирхол” гэсэн нэр томъёонууд нь тус мужийн хэвлэлд байнга тохиолддог билээ. Эцэстээ эдгээр олон нэр томъёо нь нэг зүйлээ олон дахин давтаж, хууль тогтоомжууд нэг зүйлийн талаар хэт нурших хандлагатай болж байна: “Нууц учир нууц юм” гэж хэлж буй мэт. Германы хуульд сэтгүүлчдэд мэдээллийнхээ эх сурвалжийг задруулахаас татгалзах хязгаарлагдмал эрх олгодог. Эрүүгийн байцаан шийтгэх Хуулийн 53 дугаар бүлэгт мэргэжлийн шугамаар сонин, сэтгүүл болон радио нэвтрүүлгийг бэлтгэх ажилд оролцож буй хүмүүс тухайн мэдээлэл нь хэвлэлийн, нэвтрүүлгийн зориулалттай бол түүний эх сурвалжийг мэдүүлэхээс татгалзах эрхтэй” гэж заасан байна. Харин, жишээлбэл, цэргийг оргоход хөхүүлэн дэмжих, нас барсан хүний нэр хүндийг гутаах, иргэдийг гүтгэх зэрэг үйлдлийг хийсэн сэтгүүлчид Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчиж шийтгэх хуулийг зөрчиж байгаа бөгөөд улмаар Үндсэн хуулиар олгогдсон хэвлэлийн эрх чөлөөгөө алдахад хүрнэ. Хэвлэлийн материалыг хураан авахыг хориглосон төрөл бүрийн заалт бий. Гэвч, “Шпигель”-ийн хэргийн үед эрх мэдэлт байгууллагууд эдгээр заалтыг тун бага харгалзсан байна. 1962 онд Гамбургийн энэхүү сэтгүүлд НАТО-гийн цэргийн хээрийн сургууль дээр Холбооны Герман Улсын зэвсэгт хүчин ямар сул байсныг өгүүлсэн өгүүлэл гарав.

Үүний улмаас холбооны Прокурор тус сэтгүүлийн эрхлэгч Рудольф Аугштайныг болон түүний зарим ажилтнуудыг баривчлав. Цагдаагийн ажилтнууд дөрвөн долоо хоногийн турш тус сэтгүүлийн газрын архивыг шалгаж, “Шпигель”-ийн хэргийн тухай хэвлэлийн материалуудыг хайж, хураасан байна. Холбооны Улсын Үндсэн Хуулийн Шүүх Аугштай болон түүний хамтран зүтгэгчдийн хэргийг хянан үзээд, бараг

хэрэгсэхгүй болгон шүүх хуралд ч оруулаагүй байна. Гэхдээ, Шүүх эрх хөндөгдсөн тухай тус сэтгүүлийн газрын гаргасан гомдлыг няцаан буцаасан байна. Энэ хэргийн талаар шүүгчдийн санал дөрөв дөрвийн харьцаатай тэгш хуваагдсан байсан бөгөөд эрх бүхий байгууллагуудын хэвлэлийн материалыг хураах, шалгах эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлав.

Германы шүүгчдийн хэвлэлийн эрх чөлөөнд хэрхэн ханддаг талаар дүгнэлт хийхэд Валрафын хэргийг авч үзэх нь маш чухал. 1997 онд, Валраф нууц нэрээр доод зиндааны хэмээн тооцогддог Билд-Цайтунг /Bild- Zeitung / сэтгүүлд ажиллаж байсан бөгөөд түүнийхээ дараа тус сэтгүүлийн газарт ажилласан тухайгаа ном болгон бичсэн байна. Ингэхдээ тэрээр тус сэтгүүлийн нэр хүндийг олны өмнө унагааж, мэргэжлийн маш доод түвшинд ажилладгийг илчилсэн байна. Тус сэтгүүлийн компани, хүч эрх мэдэл бүхий Шпрингер Групп түүний эсрэг нэхэмжлэл гаргасан боловч 1981 онд ялагдал хүлээсэн. Холбооны улсын дээд шүүх олон нийтийн эрх ашгийг илүү чухал гэж үзэн Валрафын хэрэглэсэн зальт аргыг чухалчлан авч үзсэнгүй.

Шүүх хэвлэлийн хариуцлага үүргээ умартсан сэтгүүлийн газрыг илчилсэн явдал нь зүй ёсны асуудал юм гэсэн дүгнэлтэд хүрч, ийм төрлийн дутагдлыг шүүмжилж санал бодлоо солилцох замаар илрүүлсэн нь Үндсэн хуулийн зарчимтай нийцэж байна гэж үзэв. Мөн Хэвлэлийн газрын ийм төрлийн дутагдал нь түүнийг хууль бус аргаар илрүүлсэн явдлаас илүүгээр хуульд сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Хэдийгээр Шүүх дээрх дүгнэлтэд хүрсэн ч Валраф шүүхийн танхимаас огт шийтгэлгүйгээр гарсангүй. Шүүгчид хувийн нууцлалыг үндэс болгон түүнийг Билд сэтгүүлийн эрхлэгчийн гэрт зочлохдоо олж илрүүлсэн зүйлсийн тухай тайлагнахыг хориглов.

Холбооны улсын үндсэн хуулийн шүүх нэмэлт дүгнэлтэдээ Дээд шүүхийн 1984 онд гаргасан дүгнэлтийг хүчингүйд тооцсон нь сонирхолтой явдал болсон байна. Үндсэн хуулийн шүүхийн үзэж буйгаар хэвлэлийн нууцын зарчмын дагуу Валраф Билд сэтгүүлийн хэвлэлийн хурлын протоколыг хавсруулан оруулах ёсгүй байв.

Ерөнхий дүгнэлт

Хэдийгээр Германы хууль мэдээлэл олгохоос татгалзсан тохиолдлыг шүүхээр хянан шалгахыг зөвшөөрдөг ч асуудлыг шийдвэрлэх үйл явцыг хянах, түргэлүүлэх эрх мэдэл бүхий бие даасан омбудсмен буюу шүүхийн байгууллага байхгүй байна. Холбооны Үндсэн Хуулийн Шүүх мэдээлэл авах эрхийг хамгаалдаг нь ойлгомжтой, энэ шатанд хүртэл их цаг хугацаа шаардагдана. Сэтгүүлчдийн асуудлын талаар улс төрийн уур амьсгал, хандлага таатай биш байдаг нь харамсалтай юм.

5. Бельги улс

Зан заншлын олон хэлбэр, холбооны улсын тогтолцооноос шалтгаалан Бельгийн улс төр, хууль эрх зүйн асуудал ихээхэн төвөгтэй. Валлона, Фландерс, нийслэл хот Брюссель гэсэн гурван бүс нь холбооны хуулийг бүрдүүлдэг бөгөөд тус тусын хууль эрх зүйн тогтолцоо, Хэвлэлийн хуультай бөгөөд бүс болгон хуулиа бие даан мөрддөг байна.

Үндсэн хуулийн баталгаа

Бельгийн Үндсэн хууль 1831 онд батлагдсан бөгөөд саяхан шинэчлэгдсэн юм. Үндсэн хуулийн 18-р зүйлд: "***Хэвлэл бол эрх чөлөөтэй, түүнийг хянан цагдах үзэгдэл байж болохгүй***", 14-р зүйлд: "***хувь хүнд бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй***

илэрхийлэх эрх олгоно " гэж заажээ. Дахин засварласан Үндсэн хуулийг 1994 оны 2 сарын 17-нд батлан, 1995 оны 1 сарын 1-нээс мөрдөж эхэлсэн бөгөөд үүний 33-р зүйлд **"хууль, дүрэм, журмаар ямар нэгэн болзол тавиагүй тохиолдолд хүн бүр засаг захиргааны бүх бичиг баримтыг ашиглаж, хуулбарлаж болно** " гэж заасан. Энэ нь мэдээлэлтэй танилцах эрхийг шүүхийн өмнө ч тодорхой болгож өгсөн.

Хүний Эрхийн тухай Европын Конвенц нь Бельгийн дотоод хуулийн нэгэн хэсэг болсон бөгөөд Бельгийн хууль тогтоомжийн дагуу ажилладаг Бельгийн шүүх хувь хүний эрхийг илүү хамгаалж байгаагаас бусад тохиолдолд Страсбургийн шүүхийн гаргасан шийдвэр Бельгийн хуульд давамгайлдаг. Зөвхөн Дээд Шүүх л Страсбургийн шүүхийн гаргасан шийдвэрийг няцаах эрхтэй. Шүүхийн доод шатны байгууллага нь ч Хүний Эрхийн тухай Европын Конвенцийн дагуу хуулийг баримтлах ёстой.

Мэдээлэл олж авах эрх

Өнөөгийн Засаг захиргааны нээлттэй байдлын тухай хууль нь 1991 онд батлагдсан бөгөөд уг хууль тухайн улсын иргэн, цагаач хэн бүхэнд тэдний мэдээллийн сонирхлоос үл хамааран эрх тэгш үйлчилдэг, үүний зэрэгцээ мужийн захиргааны байгууллага болон "Засгийн газрын удирдлагад хамааралтай, аливаа төрлийн, бүх мэдээлэл"-д энэ хууль үйлчилдэг. Хуулиар удирдлагын тогтолцооны талаар үнэгүй болон төлбөртэй мэдээлэл, зөвлөгөө өгөх үүргийг засгийн газрын болон орон нутгийн удирдлагад даалгасан.

Ингэснээр хүсэлт тавигч хаана, хэнд өргөдөл гаргахаа мэдэх боломжтой болно. Хүсэлт тавигч нэр хаягаа бичиж, асуултаа тодорхой зааж, боломжтой бол хайж байгаа мэдээллээ дурьдвал зохино. Хүсэлт ойлгомжгүй, хэтэрхий ерөнхий байвал хүлээж авахгүй. Хүсэлт гаргагч хадгалагдаж буй бичиг баримтыг үзэж, үүний талаар тайлбар авах эсвэл хуулбарлах зөвшөөрөл авдаг. Удирдлага 30 хоногийн дотор хариу өгөх ёстой бөгөөд үүнийг 15 хоногоор сунгаж болно. Энэ хугацаанд хариу өгөхийг татгалзах буюу удаашруулвал дараагийн арга хэмжээ авч эхэлнэ.

Аюулгүй байдал, бусдын эрхийг хамгаалах, олон улсын харилцаа, нийтийн тайван байдал, үндэсний батлан хамгаалах, гэмт хэргийн мөрдлөгийн улмаас мэдээлэл ашиглахыг эсэргүүцэж болно. Холбооны эдийн засаг, санхүүгийн асуудал бас өөр нэгэн татгалзах шалтгаан болж, хувийн нууц байдлаар өгсөн мэдээллийг хамгаална. Мөн мэдээлэгчийн нэр, танилцуулгыг нууцалж болно. Нөгөөтэйгүүр хувийн нууц хуулиар хамгаалагдсан бөгөөд Холбооны засаглалын үйл явц нууц юм. Бүрэн бус бичиг баримтыг олонд зарлавал буруу ташаа ойлголт өгөх нөхцөлд тэдгээрийг нууцална.

Хуулиар хүсэлт гаргагч авсан мэдээллээ худалдахыг хориглоно. Хүсэлт гаргагчид хуулийн дагуу дэмжлэг, туслалцаа өгөх, үйл ажиллагааны талаар мэдээлэх зорилгоор Засаг Захиргааны Бичиг Баримттай Танилцах Комиссыг (цаашид "ЗЗББТК" гэх) байгуулсан байна. Анхны хүсэлт нь няцаагдвал өргөдөл гаргагч дахин хянаж үзэх санал тавьж, ЗЗББТК-т энэ тухайгаа даруйхан мэдэгдэх хэрэгтэй ч Комисс няцаалт өгсөн Удирдлагад саналаа хэлнэ. Гэвч тэд тушаах эрхгүй. Нийт 105 өдөр хүртэл хугацаанд хүсэлтийг хүлээж аваагүй бол асуудлыг шүүхэд шилжүүлнэ.

Ерөнхий дүгнэлт

Энэ судалгаанд хамрагдсан мэдээлэлтэй танилцах хуулиудаас хамгийн урт хүлээлгийн хугацааг Бельгийн хуулиар олгосон байна. Үйл ажиллагааг хянах зорилготой ЗЗББТК нь хамгийн сайн зөвлөгч байгууллага юм. Гэвч Бельгийн хууль эрх зүйн үйл ажиллагаанд дүгнэлт өгөхөд арай эрт байна.

6.Их Британи

Парламентийн хязгааргүй эрхийн хүрээнд шүүх үндсэн эрх чөлөөг орхигдуулсан шийдвэрийг няцаах эрхгүй, мөн энэ талаар гарсан хууль байхгүй учраас Английн сэтгүүлчдийн нөхцөл байдал тийм ч таатай бус байна. Хууль зөвхөн тэдний юу хэвлэж, мэдээлж болох хязгаарыг тогтоосон. Британид хэвлэлийн эрх чөлөө зөвхөн энэ хязгаарын хүрээнд учир дутагдалтай оршдог. Английн засгийн газар маш нууцлагдмал хөшгийн ард үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Үндсэн хуулийн баталгаа

Өнөөдөр Англид аливаа эрх түүний дундаас хэвлэлийн эрхийг нааштайгаар тусгасан Эрхийн тухай тунхаг (Bill of Rights) бий болгох талаар маргаан гараад байна. Сөрөг намынхан энэ саналыг нааштай хүлээн авах хандлагатай байгаа юм. Хэрэв энэ бүтэлгүй болвоос үндсэн эрхийн талаарх асуудлын ганц найдвар нь Английн олон улсын хүний эрхийн гэрээнд гишүүн орон болсон явдал болох юм.

Англи Хүний эрхийн тухай Европын Конвенцид оролцоходоо Страсбургийн шүүхийн шийдвэрийг анхаарч, түүнийг дагаж мөрдөхөө амласан. Европын бүх улсуудын дотроос Британи хамгийн их шүүмжлэгддэг орон юм. Умард Ирландын асуудал шүүмжлэлийн ихэнх хувийг эзэлдэг. Энд хуулийн шинэчлэлт хийхээс зайлсхийсэн зөрчилдөөн, тэмцэл гарах тохиолдолд хүний эрхийг олгох тухай асуудлыг багтаасан гэрээний зүйл ангийг хөндөж байна. Билл Гүүдвин Англид байгуулагдсан Сэтгүүлчдийн Үндэсний Холбоотой хамтран онцгой тохиолдолд хамрагдаагүй мэдээллийн эх сурвалжийг нээлттэй болгох уриалга гаргасан. Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах эрх хуулийн эмхэтгэлд багтана хэмээн найдаж болно.

Нууцын тухай хууль тогтоомж

1989 оны Албаны Нууцын тухай хуулиар үндэсний нууцыг задруулах нь гэмт хэрэг бөгөөд дээд тал нь 2 жил хүртэл хугацаагаар шоронд хорих ял онооно хэмээн заасан. Аюулгүй байдал, батлан хамгаалал, гадаад харилцаа, хуулийн хөгжилтийн тухай засгийн газрын бичиг баримтыг нийтэлснээр дээрх үйл ажиллагаанд саад, бэрхшээл учруулваас гэмт хэрэг гэж үзнэ. Иймэрхүү хязгаарлалт маш өргөн хүрээтэй. Үүнээс ч муу мэдээ бол энд "нийтийн эрх ашиг" буюу "ёс суртахууны эрх үүргийг" хамгаалдаггүй. Өнгөрсөн болон одоогийн аюулгүй байдлыг хангах, тагнуулын албаны байдлаас үзэхэд энэ албатай холбоотой аливаа мэдээлэл задруулвал, тухайн мэдээлэл үнэхээр нууц мөн эсэхийг үл харгалзан гэмт хэрэгт тооцдог.

Хуульд бүх дээд албаны ажилтан, гэрээ хийгчид, тэдний ажилтан албан хаагчдийг хамардаг. Нууц задарсан тохиолдолд улс ямар хохирол гарсан болон гарч болзошгүйг заавал тогтоодог. Албаны Нууцын тухай Хуулиар бичиг баримт хамгаалагдсаныг мэдсэн хэрнээ хэвлэн мэдээлсэн тохиолдолд төрийн ажилтан бус хүн ч хариуцлагад татагдана. Сэтгүүлчид хуулиар хамгаалагдсан бичиг баримтад халдсан хэрэгт холбогдсоор ирсэн бөгөөд нэг Америк сэтгүүлч 1970 онд Англиас хөөгдсөн юм.

АНУ-ын цөмийн зэвсгийн тухай мэдээлэл гаргасны улмаас төрийн ажилтан Сара Тисдал 6 сарын ял эдэлсэн. Төрийн ажилтан Клив Понтин маш чухал мэдээг тараасан явдал засгийн газарт маш том сануулга болсон. Малвины арлуудын төлөө Аргентинтай хийсэн байлдааны үеэр Английн эзэн хааны Тэнгисийн явган цэргүүд Аргентинийн "Белграно" усан онгоцыг живүүлэхэд, Понтин Тетчерийн засгийн газар дайны журмыг зөрчсөн тухай мэдээлэл задруулсан.

Англичууд дайсны онгоц руу довтлох бүсийн хязгаарыг тогтоосон байсан бөгөөд “Белграно” энэ бүсийн гадна талд явж байсан юм. Энд 600 гаруй Аргентинчууд амь үрэгдсэн. Потинг мэдээ задруулсан гэж үзэн эрүү үүсгэсэн. Тисдалтай адилгүй нь тэрээр шүүгчдийн бүрэлдэхүүний өмнө байцаагдсан. Түүнийг яллахыг дээд шүүхээс шахсан боловч түүний буруугүй нь нотлогдсон. Үнэндээ Нууц үйл ажиллагааг олон нийт хүчтэй эсэргүүцэж, шүүхийн тогтоол нь Английн төрийн удирдлагад аюул учруулахуйц хүчин зүйл болж хувирсан байдаг.

7. Дани улс

200 жилийн турш хаалттай байсны эцэст буюу 1849 онд либерал Үндсэн хууль батлагдсанаар Дани улсын хэвлэл мэдээлэл 1940-1945 онуудыг (энэ үе Дани улс фашист Германд эзлэгдээд байсан үе) эс тооцвол одоо хүртэл эрх чөлөөтэй байгаа юм. Швед болон Финляндыг Европын холбоонд элсэхээс өмнө Дани улс тус холбоондоо хамгийн нээлттэй улсад тооцогдож байлаа. Гэвч Баруун Европын стандартыг дагах болсноос хойш энэ нь тийм ч чухал үзүүлэлт биш болжээ. Сүүлийн жилүүдэд Данийн сэтгүүлчдийн сэтгэлийг хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдаж байгаа явдал ихээхэн зовоож байна.

Үндсэн хуулийн баталгаа

Үндсэн хуулийн 77 дугаар зүйлд зааснаар /1953 оноос хойш/: ***"Хүн бүр өөрийн бодол санааг амаар болон бичгээр илэрхийлэн нийтлүүлэх эрхтэй бөгөөд үүнээс улбаалан гарсан үр дагаврын хариуцлагыг хуулийн дагуу хүлээх болно. Хяналт шалгалт болон бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээг дахин авч хэрэгжүүлэхгүй болно"*** гэжээ. Хэдийгээр эдгээр үгс сэтгүүлчдийн хувьд найдвар төрүүлж байгаа ч Дээд Шүүхийн зарим гол гол шийдвэрүүд хэвлэлийн эрх чөлөөг энэхүү 77-р зүйлд зааснаас арай л дутуу үнэлээд байгаа мэт санагдуулж байгаа юм. Данийн сэтгүүлчид бусад холбооны гишүүн орнуудын мэргэжил нэгтнүүдийнхээ нэгэн адил өөрсдийн эрхийг хамгаалахын тулд дотоодын хууль сахиулах байгууллагаас бус харин олон улсын шүүхээс илүүтэйгээр шалтгаалахад хүрээд байна.

Копенгагены нисэх онгоцны буудал дахь цагдаагийнхан цагаачидтай хэрхэн харьцаж байгааг илрүүлэхээр 1980-аад оны үед сэтгүүлч Мартин Брэм хуурамч төрсний гэрчилгээ үйлдэн Ираны цагаачийн дүрд хувирчээ. Дээд Шүүх түүний энэхүү үйлдлийг нийгмийн эрх ашгийн төлөө байсан гэж үзсэн боловч түүнийг цагдаагийнхан цагаачидтай хэрхэн ёс бусаар харьцаж байсныг илрүүлснийг үл харгалзан хуурамч баримт бичиг үйлдсэн хэмээн буруутган их хэмжээний мөнгөн торгууль тавьжээ.

1985 онд хэвлэлийн эрх чөлөөг эргэлзээтэй байдалд оруулсан нэгэн үйл явдал болсон юм. Тэр жил нэгэн Данийн радио арьс өнгөөр ялгаварлан үзэх үзлийн тухай нэвтрүүлэг явуулж нэвтрүүлгийнхээ явцад арьс өнгөөр ялгаварласан, танхай үг хэллэг хэрэглэж буй бүлэг этгээдүүдийн яриаг нэвтрүүлжээ. Хэдий уг нэвтрүүлгийн зорилго арьс өнгөөр ялгаварлах үзлийг өчүүхэн ч дэмжээгүй байсан ч Дээд Шүүхийн таван шүүгчээс дөрөв нь уг нэвтрүүлэг арьс өнгөөр ялгаварлан гадуурхах тухай хуулийг зөрчсөн хэмээн үзээд нэвтрүүлгийн зохиогчдыг торгожээ. Эцэст нь энэ хэргийг Данийн Сэтгүүлчдийн Холбооны тусламжтайгаар Европын Шүүхэд давж заалдсан бөгөөд саяхан Европын Хүний Эрхийн Шүүх уг хэргийг сэтгүүлчдийн талд шийдвэрлэжээ.

Нууцын тухай хууль тогтоомж

Дани Улс Нууцлалын тухай албан ёсны хуульгүй юм. Тэгэхдээ мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжид энэ асуудлын тухай тусгасан нь их байдаг. Цаашилбал, Гадаад бодлогыг хамарсан батлан хамгаалах, аюулгүй байдлын хүрээн дэх нууцлалыг хуульчилсан байдаг. Эрүүгийн хуулийн дагуу бол нууцлалын зэрэглэлтэй материалыг тараасан хэн ч бай б хүртэл сарын шийтгэл хүлээх ёстой. Гэвч энэ заалт зарчим талаасаа илүү үйлчилдэг бөгөөд бодит амьдрал дээр бараг хэрэглэгддэггүй билээ.

Одоо үед хэрвээ аливаа нэгэн нууц материал ил болсон бол түүнийг хэвлэн нийтлэх нь хууль зөрчсөн хэрэг биш болоод байгаа билээ. Гэхдээ хэрэв энэхүү материал нь улсын аюулгүй байдалд хамаарахгүй тохиолдолд л шүү дээ.

Мэдээлэл олж авах эрх

1970 оноос хойш Данийн сэтгүүлчид олон нийтийн удирдлагын баримт бичгүүдтэй танилцах боломжтой болсон билээ. 1987 онд Олон Нийтийн Удирдлагын Баримт Бичигтэй танилцах тухай Хууль /ОНУББХ/ батлагдсанаар энэхүү боломж улам нэмэгдсэн юм. 1991 онд Европын Холбооны баримт бичгүүдтэй танилцах боломж олгосон заалт уг хуулинд нэмж оруулжээ. Мөн сэтгүүлчид уг материалуудыг компьютержсэн байдлаар авах боломжтой хэдий ч мэдээлэл хүсэгч уг материалыг интернетээр юмуу он-лайннар авахгүй зөвхөн хуулбар эсвэл хэвлэсэн байдлаар авч болох ажээ.

Бүх яамд, газар, хэлтэс болон орон нутгийн удирдлагын байгууллагууд, олон нийтийн байгууллага, компани, аж ахуйн нэгжийг бүртгэдэг газрууд энэхүү хуулинд хамрагддаг юм байна. Сэтгүүлчид уг хуулийн дагуу дээр дурьдсан аль ч байгууллагаас мэдээлэл, баримт хүсэх эрхтэй бөгөөд хэрэв хүссэн материалын зарим хэсгийг ямарваа нэгэн шалтгаанаар хаан дарагдуулахыг оролдвол тэр үлдсэн хэсгийг ч мөн олон нийтэд ил тод болгох эрхтэй ажээ. Мэдээлэл хүсэгчдэд тухайн байгууллага 10 хоногийн дотор хариу өгөх ёстой бөгөөд энэхүү хариуг өгөхдөө хүссэн мэдээллээр хангах эсвэл хүндэтгэх шалтгаантайгаар татгалзах явдал байж болно. Татгалзсан тохиолдолд мэдээлэл хүсэгч нь шүүхэд хандах эрхтэй. Зарим тохиолдолд иймэрхүү хэргүүдийг Парламентийн Удирдлагын Төлөөлөгч /Омбудсмен/ шийддэг.

Энэ хуулийн нэг дутагдалтай тал нь мэдээлэл хүсэгч нь ямарваа нэгэн баримт мэдээлэл хүсэхийнхээ өмнө уг материалынхаа талаар нарийн мэдэх эсвэл нэрийг нь мэдэж байх ёстой гэнэ. Зөвхөн материалын нэр болон доторх агууламжийг нарийн мэдэж байж л хүссэн баримт бичиг мэдээлэлдээ хүрэх боломжтой. Данийн Сэтгүүлчдийн Холбоо албаныхныг өөрсдийн эзэмшилд байгаа баримт бичгийн жагсаалтын гаргаж өгч байх үүргийг нь хуульчлахыг оролдож ирсэн билээ. Ихэнх орон нутгийн удирдах байгууллагууд зөвхөн үүнийг л хийдэг гэнэ.

Энэхүү баримт бичигтэй танилцах тухай хууль үйлчлэхгүй байх тохиолдол маш их байдаг нь харамсалтай. Хууль тогтоомжтой холбоотой баримт бичгүүдтэй Парламентад өргөн баригдахаас нь өмнө танилцана гэсэн ойлголт байдаггүй. Парламентийн Удирдлагын Зөвлөлийн гишүүн асан Ларс Нордсков Нилсен энэ тухай бичихдээ: “Ардчилсан нийгмийн ойлголтоор улс төрийн ямар нэгэн шийдвэрийн үндэс суурь бий болоход олон нийтийн мэдээлэл, олон нийтийн маргаан, шүүмж чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч үүнтэй үйл ажиллагаа маань уялдахгүй байна” гэжээ.

Бүрэн гүйцэд боловсрогдсон буюу бэлэн болсон баримт бичгүүдийг нэг байгууллагаас нөгөөд шилжих хооронд сэтгүүлчид тэдгээртэй танилцах эрхтэй боловч “дотоод үйл ажиллагааны зориулалттай баримт бичгүүдийг” ил гаргах эрхгүй аж. Маш олон төрлийн

материал энэ нэрийн дор үйлдэгддэг бөгөөд сэтгүүлчдийн мэдээлснээр сүүлийн үед засгийн газрын эрх мэдэлтнүүд хоорондоо гүйцэд боловсрогдсон баримт бичгээр бус “дотоод үйл ажиллагааны” гэгдэх эдгээр баримт бичгүүдээр илүүтэйгээр харилцах болжээ. 1990 оны 2 дугаар сард Омбудсмен нь тусгай зөвлөлийн боловсруулсан баримт бичиг энэ хуулийн хүрээнд хамрана гэсэн шийдвэр гаргажээ.

Уг шийдвэрийг гаргах болсон шалтгаан нь 1987 онд нэгэн сэтгүүлч тусгай зөвлөлөөс мэдээлэл авахыг хүсээд татгалзсан хариу авсан учир тэрээр гомдол мэдүүлжээ. Омбудсмен ийнхүү шийдвэрлэснээр хэрэв баримт бичгүүд тусгайлан сайд нарын хэмжээнд бэлтгэгдээгүй зөвхөн төрийн ажилтны хэрэгцээний хэмжээнд боловсрогдсон бол уг материал сэтгүүлчдэд хүртээмжтэй байх мэдээллийн тоонд багтана гэжээ.

Ерөнхийдөө, энэхүү хуулийн дагуу сэтгүүлчид төрийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал нь тийм ч санаснаар зүйл биш юм гэж дүгнэжээ. Сэтгүүлчдийн зүгээс ирж байгаа хамгийн түгээмэл шүүмжлэл бол төрийн байгууллагууд хүссэн материалыг нь хуулиар тогтоосон эцсийн хугацааг нь хүртэл аль болох өгөхгүйг хичээдэг гэжээ. Харин Европын Холбооны талаарх материал эрэлхийлсэн мэргэжил нэгтнүүдийн хувьд энэ тал дээр арай нааштай замыг туулсан байдаг аж. Европын Холбооны баримт бичгүүд автоматаар нууцийн зэрэглэлтэй болдог байсныг 1991 онд өөрчиллөө. Гэвч өөрчлөлтийн үр дүн нь өнгөцхөн зүйл байв. Бодит амьдрал дээр ихэнх тохиолдолд “нууц байх болно” гэдэг үг зөвхөн “нууц байж болно” гэдгээр солигджээ.

Энэ мэтчилэн хуулийн холбогдох өөрчлөлтүүдийн үг хэллэг нь ч нэлээн үлбэгэрдүү болсон байв. Жишээ нь 12:1 дүгээр зүйлд Европын Холбооны “техникийн үйлдвэр болон боловсруулалт, үйл ажиллагааны болон бизнесийн явц” зэрэг асуудалтай холбоотой мэдээллийг нууцлана гэжээ. Хуулийн 13:1 дэх заалтад хэрэв Данийн Засгийн газар “тухайн хэргийн онцлогоос шалтгаалан хувь хүн болон олон нийтийн эрх ашгийн төлөө нууцалж” байна гэж үзвэл Европын Холбооны тухай мэдээллийг өгөхөөс татгалзаж болно гэж заажээ. Энэ бол нэлээн өргөн хүрээтэйгээр нууцлалыг баталгаажуулсан заалт болж байна. Гэвч үүн дээр бас нэмэгдэнэ. “Олон нийтийн удирдан зохион байгуулах, хянах, зохицуулах, төлөвлөх үйл ажиллагааны хэрэгжилтийг” мэдээлэхээс татгалзаж болохыг мөн хуулиар баталгаажуулж өгчээ. Түүнчлэн “олон нийтийн санхүүгийн асуудлууд”, “олон нийтийн арилжаа наймааны асуудлуудыг” хамруулж болох нээ.

Дээрх байдлыг харгалзан үзээд Европын Холбооны асуудлыг хариуцсан Парламентийн Хороо Европын Холбооны талаарх материалуудын хэвлэл мэдээлэлд илүү олдоцтой болгох тал дээр шургуу ажиллажээ. Дээр дурьдсанчлан Европын Холбооны талаар материал эрэлхийлэгч Дани эсвэл Брюссель дэх сэтгүүлчдийн хувьд Данийн Засгийн газрын тухай мэдээлэл хайгчидтай харьцуулбал арай л дардан зам туулсан байх аж.

Шүүх хуулийн дагуу шүүх хурлын явцыг чөлөөтэй мэдээлж болдог. Гэвч энд ч гэсэн зарим хориглосон зүйл байх юм. Зарим тохиолдолд шүүгдэгч болон хохирогчийн тухай мэдээллийг тараахыг хориглодог ажээ. Мөн уг хуулинд сэтгүүлчдийн мэдээлэл олж авсан эх сурвалжийг хамгаалах заалт байдаг. Гэвч дахиад л бас эрхийг нь хаасан тохиолдлууд байна. Хэрэв тухайн хэрэг 4 ба түүнээс дээш жил хорих ялтай бол уг хэргийг сурвалжилсан сэтгүүлчээс хэргийн тухай мэдээллийн эх сурвалжийг хаанаас олж авсныг шаардаж болох ажээ. Хэрэв шүүгчдийн үзэж байгаагаар эх сурвалжийг нуун дарагдуулсан нь шударга бус бол тэр сэтгүүлч хуулийн шийтгэл хүлээнэ. Гэхдээ Данийн сэтгүүлчид ийм шахалтанд бараг орж байгаагүй гэдгийг тэмдэглэх нь чухал юм.

Сэтгүүлчдийн өмчлөлд байгаа материалыг эрэн сурвалжлах эсвэл хүчээр авах явдал нь эх сурвалжийг хамгаалах эрхийг ноцтой зөрчиж байна гэсэн үг. 1993 оны Дээд

Шүүхийн шийдвэр гарсанаас хойш Данийн Цагдаа зөвхөн энэхүү үйлдлийг хийх эрхтэй болсон юм.

Ерөнхий дүгнэлт

Европын хэмжүүрээр бол Дани улс хамгийн нээлттэй оронд тооцогдсоор байна. Гэвч Данийн сэтгүүлчид Засгийн газрынхаа болон хууль шүүхийн байгууллагуудын нээлттэй байдлын тухай үзэлд нь нэлээд шүүмжлэлтэй хандсаар байгаа билээ. Европын Холбооны хувьд Данийн шүүхийн “арьс өнгөөр ялгаварлах үзэлтэй” холбоотой радио нэвтрүүлгийн талаар гаргасан шийдвэр нь маш чухал юм. Европын Холбооны шүүх уг хэргийг няцааж хэрэгсэхгүй болгосон билээ. Данийн Хууль зүйн сайд 1993 онд мэдэгдэхдээ “хэрэв Европын Холбооны хууль манай засгийн газрын гаргасан шийдвэрийн эсрэг байх юм бол холбогдох эрүүгийн хуулийн заалтууд ямар ч утга учиргүй болох биш үү” гэжээ. Яг энэ хэлсэнчлэн уг хэрэг болжээ. Тиймээс Данийн улс төр болон хууль хяналтын байгууллагууд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлыг дутуу үнэлсээр байх уу гэдгийг шийдэх цаг иржээ. Швед, Финлянд Европын Холбоонд элссэн нь Данийн хувьд холбоотонтой байх боломжийг олгож өгч байна. Европын хэмжээнд Дани улс нь мэдээллийг нээлттэй байлгах асуудал дээр бусад орнуудтай хамтран ажиллаж байна.

8. Голланд улс

Голландад мэдээлэл олж авах эрхийг хуулиар хангаж өгдөг.

1815 оноос хойш санал бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуулиар баталгаажуулсан бөгөөд тус улсын хэвлэл нь Европын хамгийн чөлөөтэй хэвлэлүүдийн нэг юм. Нэр төр гутаах тухай хуульд олон нийтийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлэх явдлыг огт хориглоогүй бөгөөд мөн түүнчлэн нэр төрөө сэргээх нөхөн олговор буюу торгуулийн хэмжээ харьцангуй бага байдаг байна.

Үндсэн хуулийн баталгаа

Голланд улс нь өөрийн Үндсэн хуульдаа мэдээллийн эрх чөлөөний талаар тусгасан дэлхийн цөөн орны нэг нь юм. Үндсэн хуулийн 110-р зүйлд **“Засгийн газрын байгууллагууд өөрсдийн хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхдээ Парламентийн тухай хуулийн заалтуудтай уялдуулан олон нийтийг мэдээлэл олж авах эрхийг хангах ёстой”** хэмээн заажээ.

Мөн түүнчлэн үндсэн хуульд мэдээллийг цензурдэх болон хориглох тухай асуудлын эсрэг байр суурьтай хатуу заалтууд байдаг. Мөн хуулийн 7-р зүйлд **“Хуулийн дагуу хүн бүхний хүлээх үүрэг хариуцлагыг урьдчилан цензурдэлгүйгээр тэдний бодол санаагаа хэвлэлийн хэрэгслээр дамжуулан илэрхийлэхэд хэн нэгэн нь урьдчилан зөвшөөрөл шаардах ёсгүй”** гэж заажээ. Дээрх заалтыг баримтлан “радио, телевизийн нэвтрүүлгийн агуулагыг урьдчилан хянах ” тухай асуудлыг зохицуулдаг. Голланд улс Үндсэн хуулийнхаа 93 зүйлд Хүний Эрхийн тухай Европын конвенц болон Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын заалтуудаас оруулсан байдаг.

Нууцын тухай хууль тогтоомж

Эрүүгийн хуулийн 98-р заалт болон дараах заалтуудад улсын нууцыг алдагдуулах тухай тус улсын Дотоод хэргийн яамнаас гаргасан журамд маш нарийн тодорхойлсон байдаг ба улмаар зөвхөн цөөн тооны албан ёсны хүмүүс нарийн тогтоосон журмын

дагуу нууц эсэхийг нь шийдэх эрхтэй байдаг. Хоёрдугаарт бүх яамд Дотоод хэргийн яамтай зөвшилцсөний үндсэн дээр нууц мэдээллийн жагсаалтыг гаргах ёстой. Эцсийн дүнд шүүх өөрт олгогдсон эрхийн дагуу баримт бичгийг хянан үзэж хуулийн баталгаа болон мэдээлэл олж авах дүрэм журамтай уялдуулан тухайн мэдээллийг нууцлах эсвэл ил гаргах эсэх шийдвэрийг гаргана.

Мэдээлэл олж авах эрх

1978 онд гарсан Олон нийт мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийг нэрийг нь өөрчлөлгүйгээр 1992 оны 5-р сард шинэчлэн батлан мөрдөж байна. Тус хууль нь яамдууд, орон нутгийн эрх барих дээд байгууллагууд, хотын захиргаад, ус зохицуулалтын газар болон аж үйлдвэрийн салбарын зохицуулагч байгууллагууд өөрсдийн салбарын хүрээнд засгийн газраас зааж өгсний дагуу эрэмблэгдсэн, компьютерт бичигдсэн болон хэвлэмэл мэдээллийн талаар асуудлыг мөн уг хуульд зааж өгсөн.

Данийн хууль тайлбарлагчид мэдээлэл тархалтыг дотор нь “эерэг” ба “сөрөг” гэж ялган үздэг байна. “Жинхэнэ ардчилсан засгийн газрын ашиг сонирхолд нь нийцэж байвал” мэдээллээр тогтмол хангах хуулиар албаны хүмүүст эрх олгогддог аж. Байгууллага болгон нууцлалтай болохыг зорих болсон энэ үед нээлттэй байдалд чиглэсэн эерэг шийдвэр байх явдал нь энэ хуулийн хамгийн чухал онцлог юм. Албан бичиг хэрэг нийтийн шинжтэй байж, нийтийн ашиг сонирхол нууц задлахын эсрэг байгаагаас бусад тохиолдолд нээлттэй байх ёстой гэсэн үндсэн зарчим Нидерландад үйлчилдэг.

Нээлттэй байх зарчимд гарах хязгаарууд дунд “туйлын ба харьцангуй” гэсэн хоорондоо ялгаатай хоёр хязгаарлалт байна. Хаант засаглалын эв нэгдэлд аюул занал учруулах буюу улсын аюулгүй байдалд хор хохирол учруулах асуудал нь туйлын шинжтэй хязгаарлалт болох ба үүнтэй холбоотой мэдээ мэдээлэл нь Засгийн газрын хэмжээнд нууцлалын түвшинд хадгалагдана. Шүүхэд гаргасан нэхэмжлэлийг шүүгч хянан үзээд тухайн мэдээлэл, жишээ нь улсын аюулгүй байдалд бодитойгоор аюул учруулахгүй гэдгийг олж тогтоож болно. Мэдээлэл нээлттэй байх явдал нууцлагдсан төрийн эрх ашгаас даваагүй тохиолдолд харьцангуй хязгаарлалт бий болно.

Бусад улс орон, олон улсын байгууллагатай харилцах харилцаа, улсын буюу улсын байгууллагуудын эдийн засгийн ашиг сонирхол, гэмт хэргийн мөрдөн байцаалт, ялын дээд хэмжээний гүйцэтгэл, хувийн нууцтай холбоотой баримт материалуудад харьцангуй хязгаарлалт тохиолддог байна. Эдгээр асуудлаар мэдээллийг олж авахын тулд хүсэлт гаргагч нь мэдээллийг олон нийтэд ил тод болгох нь учруулах хор хохирлоос хир зэрэг ач холбогдолтой байж болохыг нотлох шаардлагатай байдаг.

Дотоод хэрэгцээнд зориулагдсан баримт материалууд маш нууц байдаг. Гэвч тодорхой бодлогын талаарх улс төрийн хувийн санал бодолтой холбоотой мэдээллийг олон нийтэд ил болгохыг өөрөө зөвшөөрсөн л бол тухайн эзнийг нь дурьдахгүй байх хэлбэрээр нийтийн хүртээл болгож болдог. Төрийн албан хаагчид болон зөвлөх хоорондын хувьд мэдээллийг ил болгох асуудал нь тэдгээр албаны хүмүүсийн санал бодлыг нийтэд зарлах гэж байгааг урьдчилан өөрсдөд нь мэдэгдсэн эсэхээс шалтгаалдаг. Мэдээлэл авахыг хүссэн өргөдлийг холбогдох байгууллага хүлээн авч шийдвэрлэх хугацаа хоёр хүртэл долоо хоног байх бөгөөд хэрвээ бичгээр хариуг нь өгөх болбол дахиад хоёр долоо хоног сунгаж болдог.

Мэдээлэл авахыг хүссэн өргөдөл нь татгалзсан хариу өгсний улмаас 1978 оны хууль болон одоо үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу шүүхэд мэдүүлэх заргыг нэг

шүүгчийн бүрэлдэхүүнтэй захиргааны шүүхээр шийдвэрлүүлнэ. Энэ төрлийн шүүх өмнөх хууль тогтоомжийн дагуу 1976 онд байгуулагдсан байна. Асуудлын үүссэн шалтгаан нь процедур өөрчлөгдсөнтэй холбоотой байсан хэдий ч шүүх үйл ажиллагааг харьцангуй түргэн, албан бус маягаар тодорхой зарим нэг улсын практикаас эсрэг явагддаг мэт санагддаг.

1980 оноос 1992 оны хооронд хуучин хуулиар захиргааны шүүх 650 орчим хэргийг шийдвэрлэсэн. Хэдийгээр нийт хурлын тоо цөөхөн байсан ч шүүхээр орсон бүх хэрэгт мэдээллийг ил болгохыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж байжээ. Одоогийн хуулиар мэдээлэл авах бололцоо өргөн болсон. Нидерландын Үндэсний Омбудсманы алба мэдээллийн эрх чөлөөний асуудлаар нэлээд анхаарах болсон. Энэ байгууллагын үйл ажиллагааны үр дүнд шүүхийн өмнөх шатанд гэмт хэргийн талаар мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох тухай журмуудын төслийг Хууль зүйн яамны сайд боловсруулан гаргаад байна.

Ерөнхий дүгнэлт

Сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг хамгаалах талаар саяхан Нидерландад нэгэн мэтгэлцээн болсон. Нидерландын сэтгүүлчдийн холбоо бие даасан сэтгүүлч гишүүдийн тухай хуулийг 1993 оны төслөөр нь оруулж хэлэлцүүлэхийг дэмжсэн боловч зарим сэтгүүлчид ийм хэлбэрийн хамгаалалт бий болгосноор нийтлэлийн биеэ даасан байдалд хууль зүйн үүднээс гүнзгий нөлөөлөх болно гэж эмээсэн байр суурьтай байна.

9.Итали улс

Италийн сурвалжлагчид түргэн өөрчлөгдөж буй Улс төр, хууль эрх зүйн орчинд ажиллаж байна. Иймд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд мөн адил хувьсан өөрчлөгдөх шаардлагатай болоод байгаа юм. Хувийн телевизийн нэг компани нь Ерөнхий сайдын хувийн эзэмшлийнх байсан нь тогтоогдсон болон сонин унших хүмүүсийн тоо буурсан зэрэг нь үндсээр нь өөрчлөлт хийх нөхцөл байдлыг үүсгэжээ. Хууль эрх зүйн түвшинд албан ёсны мэдээлэл авах нөхцөл байдал сайжирч байна. Гэхдээ Итали улсын хувьд улс төрийн системийг нээлттэй болгох талаар шаардах тухай асуудал эрт хэвээр байна.

Үндсэн хуулийн баталгаа

Итали улсын үндсэн хуулийн 21 зүйлд **"хүн бүр үг хэлэх болон бусад мэдээллийн хэрэгслээр өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Хэвлэл нь хянах арга хэмжээ болон урьдчилан хязгаарлах зүйлд хамаарахгүй болно"** гэж заасан байдаг.

Нууцын тухай хууль тогтоомж

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн олон заалтанд улсын болон цэргийн нууцыг хамгаалах тухай заасан байдаг. Сурвалжлагчид эдгээр заалтыг зөрчвөл хатуу шийтгэл хүлээнэ. Ийм тохиолдолд арван жил шоронд хорихоор шийтгэх нь ердийн зүйл юм.

Мэдээлэл олж авах эрх

"Хэвлэлийн болон шүүмжлэлийн эрх чөлөө нь хязгаарлах ёсгүй сэтгүүлчийн эрх болно" гэж хуулиараа заасан байдаг ч гэхдээ энэ эрх чөлөө нь онолын хувьд биелшгүй зүйл болно. Энэ хуульд байгаль орчин болон бүс нутгийн асуудлаас бусад зүйлээр улсын баримт бичиг, мэдээллийн авах баталгааны тухайд юу ч заагаагүй юм.

Иргэд 1986 оны 349 Хуулийн дагуу Байгаль орчны яамнаас байгаль орчинтой холбогдох мэдээлэл, материалыг хувилж авах эрхтэй. Гэхдээ хууль бусад засгийн газрын яам тамгын газруудаас мэдээлэл авах эрхгүй болно. Италийн хуулиар бүс нутгийн, орон нутгийн, хотын засаг захиргаанаас мэдээлэл, баримт бичиг авах эрхийг баталгаажуулсан байдаг. Ийм мэдээлэл авах хүн хуулийн дагуу өөрийн хүсэлтийг илэрхийлнэ. Хуулийн дагуу мэдээлэл авах боломжгүй болсон хүмүүс шүүхэд мэдүүлэх эрхтэй болдог.

Сэтгүүл зүйн нууцлалыг Италид тодорхой түвшинд хүлээн зөвшөөрсөн байдаг. 69 Хуулийн дагуу эрхийн тухай товч дурьдсан боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 200-р зүйлд хамгаалалтын тухайд тодорхой зүйл алга байна. Энэхүү заалт эмч, лам болон хуульчдад нууцлалын давуу эрхийг олгодог байна. Бүртгэгдсэн сэтгүүлчид ердийн тохиолдолд шууд эх сурвалжийн нэр эсвэл хэний тухай өгүүлж буй талаар нууцалж болно.

Энэхүү нууцлал нь хэрвээ шүүгч шаардвал хамгаалалт хүчингүй болно. 80-аад оны дундуур нэгэн сэтгүүлч Милан хотод олон тооны баривчлага явагдах тухай мэдээлээд эх сурвалжийн нэрийг хэлэхээс татгалзсан учир 2 жил шоронд хорих ялаар шийтгүүлсэн байна. Гэвч Дээд шатны шүүх шийтгэлийг хүчингүй болгосон юм.

10. Швед

Хэвлэлийн эрх чөлөөг дээдэлж, албан баримт материалуудтай танилцах эрх нь хангагдсан байдаг учраас Швед улс магадгүй дэлхий дээр хамгийн нээлттэй орон байж болох юм. Энэ байдал бүр 1766 оноос хойш заншил болон тогтсон гэдгийг энд тэмдэглэн хэлэх хэрэгтэй болов уу. Шведэд гарсан төрийн эргэлтийн дараагаар буюу 1772 оноос 1812 оны хооронд хэвлэлийн эрх чөлөөнд хандах хандлага өөрчлөгдсөн бөгөөд XIX зуунд хэд хэдэн удаа хэвлэлийн эрх чөлөөнд халдсан ч урьд заншлаасаа ухраагүй. Гэсэн хэдий ч европын бусад орнуудтай харьцуулбал Швед үлгэр жишээч орны хэвээр байсаар байна. 1949 оноос хойш Шведийн Засгийн газрын нээлттэй байх явдал тэгш байсаар иржээ. Саянаас тус улс Европын Холбоонд элссэн нь зарим хүндрэлтэй асуудлуудтай тулгарахад хүргэсэн. Финляндаас болж үүссэн асуудлаас үүдэн Шведийн Засгийн газар Европын Холбооны байгууллагуудыг өөрчлөн шинэчлэх саналыг дэвшүүлээд байна. Сэтгүүлчдийн бодож байгаагаас илүү хор хохирол учруулахгүй хэдий ч энэ талаар бүр анхнаас нь үйл явцыг мэдээлж байхаар тогтоод байгаа юм.

Үндсэн хуулийн баталгаа

Нээлттэй байх зарчим бол Шведийн Үндсэн хуулийн үндсэн хэсэг байдаг. Засгийн газрын тухай хууль /1974/, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль /1949/, Үг хэлэх эрх чөлөөний тухай хууль гэсэн 3 хууль нь Шведийн үндсэн хуулийн бүрдэл хэсэг болдог байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, өөрөөр хэлбэл, мэдээлэл дамжуулах эрх чөлөө, үзэл бодол, бодол санаа, сэтгэлийн хөөрлөө амаар, бичгээр, үйл хөдөлгөөнөөр болон бусад арга хэлбэрээр илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө, өөрөөр хэлбэл, мэдээлэл олж авах, хүлээж авах, бусдын хэлсэн ярьсан зүйлтэй танилцах эрх чөлөөг засгийн газрын тухай хуулиар бүх иргэдэд баталгаажуулсан байна. Санаа бодлыг албадан гаргуулахыг хориглосон бөгөөд Шведийн нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэд эдгээр эрх чөлөөг эдэлнэ.

Засгийн газрын тухай хуулиар олгогдсон эрхийг зөвхөн аливаа ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хязгаарлаж болно. Үзэл бодлоо

илэрхийлэх мэдээлэл авах эрхүүдийг зөвхөн үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нийгмийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг, хэлмэгдүүлэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор хязгаарлаж болно. Эдгээр эрхтэй холбоотой хэргүүдэд хамгийн өргөн боломж олгож буй эрх чөлөөний ач холбогдлыг харгалзан үзэх ёстой байдаг. Засгийн газрын тухай хуулийн үг хэллэг ихэвчлэн ерөнхий байдаг бол хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалсан тодорхой заалттай байдаг.

Энэ хуулиар аливаа бичмэл материалыг хэвлүүлэх, үүнийхээ төлөө мөрдөгдөн мөшгөгдөхгүй байх эрхийг баталгаажуулах бөгөөд нийтэд хүргэх мэдээллийг хязгаарлахгүйгээр нийтийн дэг журмыг сахихаар тогтоосон хуулийн дагуу тохиолдлоос бусад тохиолдолд дээрх эрхийг аливаа төрийн байгууллагын зүгээс тавих хориг саадгүйгээр эдэлнэ. Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн 2-р бүлэг нээлттэй зарчмын талаарх үндсэн хуулийн заалтуудыг илүү тодорхой бөгөөд тусгай хэлбэрээр тайлбарлаж байна. Санал бодлоо чөлөөтэй солилцох олон түмнийг гэгээрүүлэх явдлыг дэмжих зорилгоор Швед дэх субъект бүр албан хэргийн баримт материалтай чөлөөтэй танилцаж болно гэжээ.

Дараах зүйлстэй холбоотой мэдээлэлтэй танилцахыг хориглоно. Үүнд:

- Шведийн вант улсын буюу түүний гадаад улс болон олон улсын байгууллагатай харилцах харилцааны аюулгүй байдал
- Санхүүгийн төвлөрсөн бодлого, мөнгөний бодлого буюу вант улсын гадаад валютын арилжааны бодлого
- Төрийн байгууллагын хяналт шалгалт буюу бусад хяналтын үйл ажиллагаа
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мөрдөн байцаалтын эрх ашиг
- Хувь хүний халдашгүй байдлыг хамгаалах буюу хувийн хэвшлийнхний санхүүгийн байдал ургамал, ан амьтдын төрөл ангийг хамгаалах зэрэг болно.

Эдгээр хязгаарлалтыг маш нарийн ангилсан байх ёстой ба парламент эсвэл засгийн газар эдгээр хязгаарлалтаас үл хамааран холбогдох мэдээллийг нийтэд ил болгохыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж болдог байна. Энэ утгаар Шведийн шүүх байгууллагуудад парламентийн үйл ажиллагаанд онцгой анхаарал тавьж ажилладаг байна. Дээд шүүх болон захиргааны дээд шүүхийн шийдвэрүүд нь заншлын шинжтэй байдаг ба Шведэд үндсэн хуулийн шүүх гэсэн тусгай байгууллага байхгүй учраас шүүх байгууллага болгон үндсэн хуулийг илэрхий зөрчсөн хэргийг авч хэлэлцэх эрхтэй байдаг байна. Хэрвээ тухайн асуудал нь үндсэн хууль зөрчсөн эсэх нь тогтоогдоогүй бол дээд шүүх болон захиргааны дээд шүүх өөрөөр тайлбарлах ёсгүй байдаг.

Парламент ийм төрлийн асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулахыг санаачлах хүртэл парламентийн хэлэлцэх асуудлын жагсаалтад ороод байж байдаг байна. Швед улс Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Хүний эрхийн тухай европын Конвенцийн аль алиныг нь соёрхон баталсан. НҮБ-ын хүний эрхийн хороо хүний эрхийн европын комиссын аль алинд иргэний зарга мэдүүлэхийг зөвшөөрдөг байна. Гэсэн хэдий ч эдгээр гэрээ конвенцууд нь дотоодын хууль тогтоомжтой адил эрх хэмжээ байдаггүй гэсэн ерөнхий хандлага зонхилдог. Сэтгүүл зүйн зорилгод энэ нь магадгүй сайн ч байж болох юм.

Нууцын тухай хууль тогтоомж

Мэдээлэл олж авах эрх

Шведийн үндсэн хуульчилсан хууль тогтоомжид нууцлалын тухай мэдээлэл олж авах заалтуудыг нэлээд нарийн хэлбэрээр томъёолсон байдаг. Шведийн иргэн бүр Стокольм дахь ерөнхий сайдын байранд нэвтрэх, ерөнхий сайдад захидал илгээмж хүлээх эрхтэй байдаг. Онцгой шалтгаан байхгүй бол хүссэн мэдээллийг заасан хугацаанд өгөх ёстой байдаг.

Мэдээллийг ил болгохыг хориглох тухай асуудлыг Нууцын тухай /1980 онд батлагдсан/ хуулиар хуульчилдаг ба түүний ангиллыг хэвлэн нийтлэх эрх чөлөөний тухай хуулиар тайлбарладаг. Мэдээлэл авахыг хүсээд татгалзсан хариу авсан хэн болгон захиргааны шүүхийн байгууллага, цаашлаад захиргааны дээд шүүхэд зарга мэдүүлэх эрхтэй байдаг. Мэдлэг олж авах эрхтэй холбоотой нэмэлт хамгаалалтыг энэ төрлийн маргаанд оролцох эрхтэй Омбудсмены шүүх /Парламентийн/ байгууллага олгодог. Цэргийн болон аюулгүй байдалтай холбоотой нууц мэдээллийг илчилсэнээр ял хүртэж болох ба энэ төрлийн ял хүртэх нь маш ховор байдаг. Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулаагүй бол нууцлалын тухай хуулийг зөрчиж мэдээлэл ил болгосны төлөө төрийн албан хаагч буюу хэвлэн нийтлэгчийн аль алинд нь ял гэм тулгахад хүргэдэггүй. Хэрвээ ял зэмлэл хүртэх бол ганцхан мэдээлэлтэй холбоотой төрийн албан хаагчаас гадна хэвлэн нийтэлснээсээ болж хэвлэл мэдээлэл ажилтан ял хүртэнэ.

Шведийн хуулиар гэмт хэргийн мөрдөн байцаалтын, таслан шийдвэрлэх арга хэмжээний болон баривчилгааны хугацааг нарийн тогтоож өгсөн байдаг. 1970-аад оны эхээр мөрдөх товчооны /тагнуулын алба/ нэгэн ажилтан мөрдөх товчооны талаарх мэдээллийг хоёр сэтгүүлчид өгчээ. Мөрдөх товчооны талаар өгүүлсэн материал сэтгүүлчид гарч, хожим нь хэвлэгдсэн байна. Энд холбогдсон мөрдөх товчооны ажилтан болон хоёр сэтгүүлч уг хэргийн улмаас есөн сараас нэг жил хүртэлх хугацаагаар хорих ял авсан. Гэхдээ энэ явдал нь ном хэвлэн нийтлэх эсвэл сэтгүүлд материал гаргахыг хориглосон үйлдэл байсангүй.

Хэвлэн нийтлэх эрх чөлөөний тухай хуулиар эх сурвалжийг илчлэхийг хориглосон байдаг ба ингэх ганц тохиолдол байдаг нь дээрх тохиолдол буюу гэм буруутай этгээдээс өөрийн гэм буруугүй гэдгийг нотолсон мэдээллийг шаардах үед гардаг. Хэрвээ сэтгүүлчид олсон мэдээллийн эх сурвалжаа зориудаар нуун далдлавал эрүүгийн хариуцлага хүлээхэд хүрдэг. 1988 онд "Dagens Nyheter" сонины нэгэн сурвалжлагчаас шүүх хурлыг даргалагч хэдийгээр шүүхийнхэн мэдэж байсан хэдий ч мэдээллийн эх сурвалжаа хэлэхийг хүсчээ.

Харин сэтгүүлч энэ асуулт үндсэн хуулинд нийцэхгүй хэмээн хариулахаас татгалзахад шүүх даргалагч асуултаа буцаасан байна. Харамсалтай нь Шведийн нээлттэй байх онолд ч гэсэн хязгаарлалтууд байдаг байна. 1989 онд батлагдсан худалдааны нууцлалын тухай хуулиар хувийн хэвшлийн салбарт ажилладаг хэн нэгний талаарх нууц материал задрахад хурвал энэ нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүргэдэг. Худалдааны нууцлалын тухай хуулиар компанийн хууль бус үйл ажиллагаатай холбогдсон ажилтнуудыг шийтгэж байхаар анх хууль хэлэлцэх үед ярьж байжээ. Энэ хууль батлагдан гарсны дараагаар зэвсэг үйлдвэрлэдэг "Vofors" компанитай холбоотой гарсан удаан яригдсан шуугианд хэрэгт хүчтэй цохилт болж энэ асуудал илэрсэн.

Ноцтой буюу хууль бус үйл ажиллагаа явуулсан ажилчдыг илчлэхийг зөвшөөрсөн нэмэлт энэ хуулинд хожим нь оржээ.

Ерөнхий дүгнэлт

"Bofors" компанитай хамтран ажиллаж байсан хувь хүмүүс, байгууллагуудаас тун амархан мэдээлэл олж авч гаршсан шведийн хэвлэл мэдээллийхний тодорхой хувь нэмрээр эл хэрэг илэрсэн гэж ихэнх хууль тайлбарлагчид үздэг. Хээл хахууль өгөх замаар "Bofors" компани энэтхэгийн засгийн газартай гэрээ байгуулсан тухай мэдээллийг тус компанид инженерээр ажилладаг Ингвар Братт задруулснаар энэхүү дуулиант хэрэг мандсан. Шведийн засгийн газар эл асуудлыг судалж үзээд Шведийн ямар ч хуулийг зөрчөөгүй гэж мэдэгджээ.

Гэхдээ хэвлэл мэдээллээр гарсан мэдээлэлтэй холбоотой илтгэх хуудсанд байсан хэсгүүдийг нийтэд мэдэгдэхээс татгалзсан байна. 1989 оны 10-р сард Энэтхэгийн нэгэн сонинд хууль бус төлбөр хийгдсэн гэдгийг нотолсон урьд нь хэвлэгдсэн илтгэх хуудсанд байгаагүй тийм шинэ мэдээлэл бүхий материалыг нийтлэжээ. 6 сарын дараа даралт шахалтын улмаас Шведийн засгийн газар илтгэн хуудсыг бүтнээр нь хэвлэжээ. Нээлттэй зарчмаар олгогдсон боломжууд байсаар байтал Энэтхэгийн сэтгүүлчид Шведийн үзэг нэгт нөхдийгөө энэ асуудлаар шахан шаардаж байсан нь сэтгүүл зүй гэдэг нь бүхэлдээ эрэл хайгуул байсаар байх болно гэдгийг бид бүхэнд анхааруулсан сургамжтай дохио юм.

11. Люксембург

Люксембург улс 400000 хүн амтай бөгөөд тус улсын 5 сонин, /нэг нь Францын сонинны Люксембург дэх хэвлэл/ нэвтрүүлгийн станц зэрэг нь тус бүс нутгийн мэдээллийн хэрэгслийн нэгэн адил үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг. Хүн бүр бараг бие биеэ мэддэг энэ улсад түрэмгий мэдээлэл гэж үгүй бөгөөд хязгаарлалтыг соёлтой байдлаар хийдэг. Гэхдээ дээр нь нэмэхэд Люксембургийн хууль, эрх зүйн систем сэтгүүлчдэд нилээд хатуу ханддаг.

Үндсэн хуулийн баталгаа

1868 оны Үндсэн хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд уг хуулийн 24-р зүйлд ***"Бүх зүйлд үг хэлэх болон хэвлэлийн эрх чөлөө баталгаажсан болно..."***, мөн дээр нь нэмэхэд ***"Хэвлэлийн хяналтыг хэзээ ч нэвтрүүлэхгүй байж болно"*** гэж заасан байдаг.

Нууцын тухай хууль тогтоомж

мэдээлэл олж авах эрх

1869 онд гаргасан хуулиар хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан байдаг. Үүнд гэмт хэргийн тухай жагсаалт байх ба мөн үүнд Гранд Дюк Засгийн газрын албаны хүмүүсийн хувьд чиглэсэн үйлдэл болон шийтгэлийн жагсаалт ордог байна. Хэдийгээр өнөөдөр эдгээр заалтыг хэрэглэхгүй байгаа ч хуулийн номонд хэвлэлийн эрх чөлөөний тухай тунхаг хэвээр байгаа. Энэ нь тэр чигээрээ сөрөг талтай бөгөөд зөвхөн хязгаарлалт байгаагаас ямар ч эрх эсвэл эерэг зүйл үгүй болно. Мөн албан ёсны баримт бичгийн тухай мэдээлэл авах эрх чөлөөний тухай ямар ч хууль эрх зүйн зохицуулалт байхгүй юм.

Нэр төр гутаах тухай хууль, эрх зүйн зохицуулалт их хатуу бөгөөд сэтгүүл зүйн хязгаарлалтын хэлбэрээр ажилладаг. Нэхэмжилж буй этгээд бараг автоматаар хохирол нэхэмжлэх эрхтэй болдог. 1993 онд “Тагэблат” сонинд нэгэн сэтгүүлч мод тарих төслийн 63 ажилтны аль нэг хээл хахууль авсан хүний нэрийн заагаагүйгээр хээл хахууль авсан тухай нийтэлсэн бөгөөд бүх 63 ажилтан нэхэмжлэл гаргасан ба бүгд нөхөн төлбөр авч шүүх дээр ялалт байгуулсан байна. Сэтгүүлчид нотлох баримт гаргах боломж өгөлгүйгээр шийтгэл оноосон байна. Хэдийгээр хохирлын хэмжээ ёс төдий байсан ч хэвлэл мэдээллийн ажилтнуудад анхаарал сэрэмжлүүлэг болсон байна.

Хариу мэдэгдэл хийх эрхийн тухай хууль нь мөн нэгэн адил хэлбэрээр зохицуулдаг. 1869 оны хуулийн 23 дугаар зүйлийн дагуу *“нэрээр нь эсвэл шууд бус байдлаар сонин дээр нэр нь гарсан хүн үнэ төлбөргүйгээр тухайн нийтлэлээс хоёр дахин их зүйлийг хариу болгон бичих эрхтэй”* гэж заасан байна.

Хариу мэдэгдэл хийснээрээ тухайн хүн нийтлэлийн эх хувилбар нь болгоомжгүй буюу алдаатай байсныг батлахыг оролдож болно. Хариу нийтлэлийн үгний тооны хязгаар нь 1000 байдаг боловч түүний үр нөлөө нь тодорхой хэмжээний хохирол учруулдаг. Үүнтэй адил төстэй явдал телевизэд мөн тохиолдож байна.

Ерөнхий дүгнэлт

1989 онд сэтгүүлчид болон хэвлэлийнхэн дээрх байдлыг өөрчлүүлэхээр лоббидож, улмаар засгийн газраас уг асуудлыг шийдвэрлэж өгсөн. Гэвч түүнээс хойш бидний мэдэж байгаагаар ямар нэгэн шинэчлэлт хийгдээгүй болно.

12. Грек

Европын бусад орнуудтай харьцуулбал Грект сэтгүүлчид болон төр, засгийн хоорондын мөргөлдөөн сүүлийн жилүүдэд хамгийн ихээр тохиолдож байна. 1991 онд Мицотакисын Засгийн газар зарим сонины эрхлэгчдийг баривчилсан нь тэд улс төрийн хяналтад захирагдахаас татгалзасантай холбоотой юм. 1975 он хүртэл засгийн эрхэнд байсан цэргийн дэглэмт Жунтагийн үйлдсэн улс төрийн шарх өнөөг хүртэл арилаагүй байна.

Грек улс нэг хүнд ногдох сонин, сэтгүүлийн тоогоороо Европт тэргүүлж байгаа билээ. Ойролцоогоор 20 шахам өдрийн сонин байна. Хэвлэлийнхэн маш дайчин сэтгэлгээтэй байх хандлагатай ч Улсын телевизийн “ERT” суваг төрийн оролцоонд өртдөг бөгөөд үүнээс гадна ихэнхдээ чанарын хувьд доогуур телевизийн 30 гаруй станц ажиллаж байна.

Үндсэн хуулийн баталгаа

Үндсэн Хууль үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангадаг ч энэ нь зөвхөн хуулийн дагуу байна. Түүний 14 дүгээр зүйл тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал эрхийг агуулж байна: *“Хүн бүр улсын хуулийн дагуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бичгийн хэлбэрээр хэвлэлээр түгээх эрхтэй”*. Үүнээс гадна, Үндсэн хуулиар хяналт болон “бусад хязгаарлах арга хэмжээ”-г хязгаарладаг. 1990 онд шинээр сонгогдсон консерватив засгийн газар зэвсэгт босогчдын бүлгийн мэдэгдлүүдийг хэвлэн нийтлэхийг хориглох тухай хууль гаргасан явдал нь дээрх баталгаануудын үнэ цэнийг тодорхой хэмжээгээр унагасан билээ. Энэхүү хуулийг зөрчсөн тохиолдолд 1 жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл болон 250 000 ам.долларын торгууль төлөх шийтгэл ногдуулахаар заасан.

“11 дүгээр сарын 17” хэмээх бүлэг Афинд болсон аллага болон дайралтуудын талаар хийсэн мэдэгдлээ тус хууль гарсаны дараагийн жилийн 6 дугаар сард нэр төртэй гэж тооцогддог Төв-зүүний “Элэвтеротипа” сонинд нийтэлсэн байв. Үүний дараа хэдхэн цагийн дотор тус сонины эрхлэгч Серафим Финтанидисыг баривчлан дараа нь суллажээ. Дараагийн өдөр нь зургаан сонины эрхлэгч Финтанидистай сэтгэл санаа нэг байгаагаа илэрхийлэн мөн мэдэгдэлийг дахин нийтэлж баривчлагдсан байв.

Эдгээр долоон сонины эрхлэгч нар Афинд Дээд шатны шүүхийн өмнө ял тулгагдсан бөгөөд шүүх тэднийг хууль бусаар баривчлагдсан гэсэн гомдлыг няцаасан байна. Хяналтын хуулийн дагуу тэд буруутайд тооцогдсон бөгөөд тэдэнд 5 хүртэлх сараар хорих ял эсвэл торгууль төлөх шийтгэл ногдуулсан байна. Торгууль төлөхөөс татгалзсан учир тэднийг шоронд хорьсон байна.

Олон Улсын Сэтгүүлчдийн байгууллагын оролцооны үр дүнд тэд 11 хоногийн дараа суллагдсан юм. Торгуулийн төлбөрийн үлдсэн хэсгийг Афины Өдрийн Сонины Сэтгүүлчдийн Холбоо болон Сонин Хэвлэгчдийн Холбоо хамтран төлсөн байна. Энэхүү хямралын үеэр, Грекийн нэгэн томоохон сэтгүүлч засгийн газар шүүхийн үйл ажиллагаанд хутгалдан шүүхийг хатуу шийтгэл оногдуулахыг дэмжсэн гэж мэдэгдэв.

1993 оны хавар дахин таван сонины эрхлэгч хяналтын хуулийн дагуу буруутайд тооцогдсон боловч шүүх хурал удаа дараалан хойшлогдов. Удалгүй тэр жилдээ Мицотазкисын засгийн газар засгийн эрхээс буусан байна. Сөрөг хүчин засгийн эрхэнд гарснаар сэтгүүлчдийн эрх чөлөөнд учрах аюул занал буурсан ч, шүүхийн байгууллагууд үндсэн хуулийн эрх чөлөөнд хэрхэн хандаж буй талаар ноцтой асуудлууд гарсаар байна.

Нууцын тухай хууль тогтоомж

Мэдээлэл олж авах эрх

1986 оноос хойш зарчмын хувьд төрийн бичиг баримттай танилцах эрх бий болсон. Хүсэлт гаргагч нь тухайн асуудалд сонирхолтой байгаагаа нотлох ёстой. Мэдээлэл олгохоос татгалзсан тохиолдолд тухайн байгууллага нэг сарын дотор татгалзах болсон шалтгаанаа мэдэгдэнэ. Компьютерчилсэн мэдээлэлд энэ хууль хамаарахгүй.

Хувийн нууцыг хадгалах шалтгаанаар мэдээлэл өгөхөөс татгалзаж болно. Гэхдээ Ерөнхийлөгч болон асуудлыг эрхэлсэн сайд хуулийн хүчингүй болох хэсгийг албаны сонинд нийтлэх замаар хамтран нэвтрүүлж болно. Европын холбооны улс орнуудын мэдээллийн эрх чөлөөний зохицуулалтын талаар Данийн Сэтгүүлчдийн Холбоо болон Данийн Сонин Хэвлэгчдийн Холбооны хийсэн судалгаанаас үзэхэд Грекийн хэвлэлийн эрх чөлөөний хуулийн заалтууд нь “ардчилсан нийгэмд шаардагдах зохих хэмжээнээс илүү өргөн тодорхойлогдсон байна” гэдэг нь тодорхой байв.

Грект мэдээллийн эх сурвалжийн хамгаалалт байхгүй. Гүтгэлэгтэй холбоотой хэрэгт сэтгүүлч холбогдох өгүүллэгтээ өөрийн мэдэгдэлээ үнэн зөв гэдгийг нотлох үүрэгтэй. Иймээс сэтгүүлчид зарим тохиолдолд мэдээллийн эх сурвалжаа илчлэх, задруулах давхар дарамттай болж байна. Эх сурвалжийг илрүүлэх нь сэтгүүлчийг зөвхөн шүүхийг үл хүндэтгэх явдлаас хамгаалахаас гадна түүнийг мөн гүтгэлгээс хамгаалах ч 1967 оноос хойш эх сурвалжаа задруулаагүй явдал Грекийн сэтгүүлчдэд итгэх итгэлийг нэмэгдүүлж байгаа билээ.

Ерөнхий дүгнэлт

Грект хэвлэлийн эрх чөлөө дарамтад байгаа нь тодорхой байна. Энэ нь зөвхөн хяналтын асуудалтай холбогдон гарч буй биш, олон салбарт гарч байна. Грекийн сэтгүүлчид өөрсдийн зорилгоо биелүүлэхийн тулд шоронд ороход ч бэлэн байгаа юм.

13. Португали

Хэвлэлийн эрх чөлөөний тухай асуудал урган гарч ирэхэд Үндсэн хуулийн гоё сайхан үгс ба түүний хэрэгжилтийн хооронд гүнзгий ангал үүссэн байхыг сүүлийн хэдэн жил Португалийн сэтгүүлчид олж мэдэрчээ. Сэтгүүлчдийн мэдээлэл олж авах эрхийг Үндсэн хуулиараа баталгаажуулна гэсэн байдалд шууд эсрэг үйлчлэх зарим нэг маш нарийн хязгаарлалтай хууль тогтоомжууд саад тотгор болж байна.

Үндсэн хуулийн баталгаа

Үндсэн хуулийн 37-р зүйлд: *“Хүн бүр өөрийн бодол санаагаа үгээр, үйл хөдөлгөөнөөр буюу аливаа бусад арга хэлбэрээр илэрхийлэх, таниулах эрхтэй ба түүнчлэн хавчин гадуурхуулгүйгээр чөлөөтэй мэдээлэл хийх, мэдээлэл олж авах, мэдээлүүлэх эрх эдэлнэ”* хэмээн заажээ. “Сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалжид хүрэх эрх хангагдсан байна” гэж мөн хуулийн 38-р зүйлд зааснаар мэдээлэлд хүрэх эрхийг дахин тодотгон өгчээ.

Цаашлаад 48-р зүйлд /1989 онд оруулсан нэмэлт/: *“Иргэн бүр төр, засгийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээлэл авах, төрийн үйл ажиллагааны удирдлага зохицуулалтын асуудлаар Засгийн газар буюу холбогдох бусад эрх бүхий албан тушаалтнуудад санал бодлоо илэрхийлэх эрхтэй”* гэж заасан байна.

Хэвлэл, мэдээллийн асуудал эрхлэх төв байгууллага Үндсэн хуулийн 39-р зүйлд заасны дагуу “улс төр, эдийн засгийн хүчнүүдээс олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хамааралгүй, бие даасан байх” явдлыг хангах зорилгоор 1990 онд байгуулагдсан.

Нууцын тухай хууль тогтоомж

Үндсэн хуулиар хангагдсан баталгаа байсаар байтал Парламент 1993 онд Төрийн нууцын тухай нарийн хязгаарлалт бүхий заалттай хуулийг баталсан. Улс орны тусгаар тогтнол, төрийн эв нэгдэл, дотоод ба гадаад аюулгүй байдалд хохирол, аюул учруулж болохуйц мэдээлэлд энэхүү хуулиар хязгаарлалт тогтоожээ. Тодорхой нэг хэсэг баримт мэдээлэл нууцын ангилалд нэгэнт орвол тэр нь дөрөв хүртэлх жил хаалттай байхаар хуульчилжээ.

Төрийн нууц хэмээн зарлах эрхтэй дараах албан тушаалтнууд байх ба үүнд: Ерөнхий сайд, Засгийн газрын бүх гишүүд, Португалийн Ерөнхийлөгч, парламентийн дарга, орон нутгийн засаг захиргааны удирдлагууд зэрэг болно. Хойшлуулшгүй, яаралтай нөхцөлд Португалийн мэдээллийн албаны захирлууд, зэвсэгт хүчний командлагч аливаа нэг асуудлыг нууцын зэрэглэлийн ангилалд оруулж мөн болдог байна.

Нууцын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор хяналтын шүүх байгуулагдсан. Гурван хүний бүрэлдэхүүнтэй энэхүү байгууллага нь Захиргааны дээд шүүхийн ерөнхийлөгч, Засгийн газар болоод сөрөг хүчинг төлөөлсөн тус бүр нэг төлөөлөгчөөс бүрдэнэ.

Хэвлэлмэдээллийнбайгууллагуудынтөлөөлөгчидэнэхүүаргахэмжээг “дарангуйлалыг ханхалуулсан түгшүүрт үйлдэл” хэмээн тодорхойлоход дээд байгууллагаас ямар нэгэн тайлбар хийгээгүй байна.

Хууль гарснаар сэтгүүлчид болон 1995 онд засгийн эрхийг алдсан Социал демократ нам хоорондын зөрчлийн эрин үеийг эхлүүлжээ. Олон тооны хэвлэл мэдээллийн ажилтнууд тэр Засгийн газрын үйл ажиллагааны золиос болж, зарим нэг нь ажлаасаа хүчээр халагдсан байна. 1993 онд Засгийн газар сэтгүүлчдийг парламентийн ордны зарим хэсэгт оруулахыг хориглон хязгаар тогтоосон нь парламентад ажиллаж байсан сэтгүүлчид эсэргүүцэл илэрхийлэн ажил хаяхад сөрөг хүчнийхэн тэднийг дэмжжээ. Сарын дараагаар Засгийн газар буулт хийж, сэтгүүлчдийг төрийн ордонд чөлөөтэй явахыг зөвшөөрсөн байна.

Мэдээлэл олж авах эрх

Хэвлэлийн тухай хууль нь сэтгүүлчдэд мэдээлэл олж авах эрхийг жирийн иргэдийг бодвол давуу байдал олгож байна. Гэтэл энэхүү эрх нь Нууцын тухай хуулиар бүхэлдээ хязгаарлагдсан мэт санагдаж байгаа юм. Улс орны аюулгүй байдал эсвэл улсын компани буюу иргэдийн хувийн нууцад хамаарах мэдээлэл гэх мэтийн нууцлалын асуудлыг өөр ямар нэг хуулиар албадан хуульчилбал мэдээлэлд нэвтрэх давуу эрхэнд хамаарахгүй гэж Хэвлэлийн тухай хуулийн 4-р зүйлд заажээ.

Ерөнхий дүгнэлт

Социал демократуудаас болж Португалид бий болсон Үндсэн хуулийн зарчим ба хуулийн хэрэглээний хоорондын зааг нь Гранд Каньёны хавцал мэт санагдаж болох юм. 1995 онд болсон сонгуулиар социалистууд засгийн эрх авснаар Португалийн сэтгүүлчид Засгийн газартайгаа илүү эрүүл харилцаатай болсон байна.

14. Испани

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн зарчмыг зөрчилгүйгээр Франкогийн дарангуйлалыг устгаж, Эскади дахь зөрчилдөөнтэй байдлыг намжаахыг Испани улс эрэлхийлж байна. Өмнө нь тавьж байсан зорилт одоогийнхоосоо илүү амжилттай хэрэгжиж байсан байна. Баскийн зөрчилдөөнтэй холбогдуулан тавьж буй цензурын шинжтэй арга хэмжээнүүдийг Хойд Ирландын асуудлаарх Вэстминстэр ба Дублинээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдтэй харьцуулан авч үзэхэд сонирхолтой байх болов уу.

Үндсэн хуулийн баталгаа

1978 онд батлагдсан Испанийн Үндсэн хуульд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хоёр арга замаар хангахаар заасан бөгөөд үүнд юуны өмнө үндсэн эрх, эрх чөлөөтэй холбоотой үндсэн хуулийн заалтууд орж байна. Дээр нь Европын хүний эрхийн шүүх мэтийн олон улсын эрх бүхий хуулийн байгууллагуудаас гаргасан хууль тогтоомжуудыг Испанийн шүүх баримтлан хэрэглэх ёстой гэх замаар Испанийн хууль тогтоомжид олон улсын хүний эрхийн гэрээнүүдийг хамруулж болно. “Бодол санаа, үзэл бодлоо амаа, бичгээр буюу аливаа бусад арга хэлбэрээр чөлөөтэй илэрийлэх, түгээн дэлгэрүүлэх”, “түгээн дэлгэрүүлэх аливаа арга хэлбэрийг ашиглан үнэн зөв мэдээллийг хүлээн авах, харилцах” гэсэн эрхүүдийг Үндсэн хуулийн 20-р зүйлээр баталгаажуулсан байна. Түүнчлэн “ямарваа нэгэн цензураар хязгаарлаж болохгүй” гэсэн нь энэ бүх эрхээ

эдлэхэд баталгаа болдог байна. Уг зүйлд цааш нь өгүүлэхдээ: “Эдгээр эрх чөлөөг энэ бүлэгт заасан эрхүүдийг хангах зорилгоор, мөн үндсэн хуулийг хэрэгжүүлэх хавсралт хуулийн заалтууд, ялангуяа нэр төр, хувийн нууц, хэн нэгний нэр хүндийг ашиглах явдалд хяналт тавих, хүүхэд, залуучуудыг хамгаалахад чиглэгдсэн эрхүүдээр хязгаарлаж болно” гэж заажээ.

Үндсэн хуулийн шүүх үндсэн эрх, эрх чөлөө болон Испанийн хууль тогтоомжууд Үндсэн хуулинд хир нийцэж байгаа зэрэгтэй холбогдсон асуудлуудыг хянан шийдвэрлэдэг. Үндсэн хуулийн энэ заалтын дагуу гаргасан гомдол бусад гомдлыг бодвол илүү түргэн шуурхай шийдвэрлэгддэг байх ёстой юм байна. 20-р зүйлд илэрхийлэх ба мэдээллийн гэсэн хоёр биеэ даасан эрхийг хооронд нь ялгаж тайлбарладаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах ганцхан тохиолдол нь “илэрхийлсэн үзэл бодол буюу саналд нь холбоотой бус, илэрхийлсэн зүйлд нь хамааралгүй яриангүй гүтгэлгийн шинж чанартай мэдэгдэл” хийхэд үүсдэг байна.

Мэдээллийн эрх чөлөөг мэдээллийн шинж чанартай, үнэн бодит баримт материалыг солилцоход хамаарна гэж нилээд нарийн чанд тодорхойлсон байдаг. Төрийн хэрэгт иргэдийн бодит оролцоог хангах Үндсэн хуулийн заалтуудын эцсийн зорилгыг харуулах үүднээс мэдээллийн шинж чанартай байх шалгуурыг гаргаж ирсэн байна. Гэтэл “үнэн бодит”-той байх шалгуураар үнэн зөвийг нь нотлоогүй материалыг тогтоон тодруулдаггүйгээр барахгүй сэтгүүлчдэд баримт мэдээллээ нягтлахдаа нэлээд хичээл зүтгэл гаргах давхар дарамтыг бий болгожээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд төрийн зүгээс халдашгүй байлгах үүднээс л эдгээр хамгаалалтын чанартай арга хэмжээнүүд хэрэгжих бөгөөд хувь хүмүүсээс энэ эрх чөлөөнд халдах асуудал хамаарахгүй аж. Гэсэн хэдий ч олон нийтийн санаа бодлыг хэвлэл мэдээллийнхэн мэдээлэхэд тэдний үүрэг оролцоог эргэн тооцох талаар тусгай хамгаалалтаар хангагдсан байдаг байна.

“Терроризмыг дэмжих” нь эрүүгийн хуулийн 268-р зүйлд заасны үндэсний аюулгүй байдал гэсэн нэрийг барьж цензурдэж болох шалтаг шалтгаануудын нэг юм. “ETA” хэмээх босогчдын бүлгийн мэдэгдэлийг хэвлүүлсний төлөө Баск мужийн “EGIN” сониныг шүүхдсэн тохиолдлыг 1986 онд Үндсэн хуулийн шүүх хянан хэлэлцсэн байна. Үндсэн хуулийн шүүх бага суудлын хуралдаанаараа тус сонинг терроризмыг өмгөөлөн хамгаалсан байсан тул буруутай гэж үзжээ. Уг мэдэгдэл терроризмыг өмгөөлөн хамгаалсан боловч сонины газар мэдэгдэлд ямар нэгэн тайлбар хийлгүйгээр хэвлэсэн гэсэн үндэслэлээр шүүх шийдвэрээ эргэн хянасан байна.

Үндсэн хуулиар албан хэргийн баримт материалуудад нэвтрэх эрхийг тусгайлан олгодог. “Улсын аюулгүй байдал, батлан хамгаалах хэрэг, гэмт хэргийн мөрдөн байцаалт, хувийн нууцад хамаарахаас бусад захиргааны архив болон бүртгэлийн материалуудад иргэд нэвтрэх” эрхийг тус хуулиар зохицуулна гэж Үндсэн хуулийн 105-р зүйлд заасан байна.

Нууцын тухай хууль тогтоомж

мэдээлэл олж авах эрх

1978 оны хуулинд /1968 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан 9/68 тоот хуулийг шинэчлэн найруулж 48/78 тоот хуулийг 1978 оны 11 дүгээр сарын 7-нд баталсан/ нууцлал болон түүнд нэвтрэх тухай заалтууд нэлээд их хэмжээгээр агуулагдаж байгаа аж. Мэдээ мэдээллийг нууцын холбогдох ангиллын дагуу “хадгалагдах” буюу “нууц”

гэж хоёр ангиллын аль алианаар нь ангилж болдог байна. Улсын аюулгүй байдал, батлан хамгаалах хэрэг хохирч, аюул занал учирч болзошгүй тохиолдолд нууцлалыг бас хэрэглэж болдог байна. Иргэний холбогдолтой асуудлыг зөвхөн Сайд нарын зөвлөл, цэргийн холбогдолтой асуудлыг зөвхөн цэргийн дээд командлагч тус тус ангилж болдог.

Үндсэн хуулийн 20-р зүйлийн дагуу 1978 оны хуулиар шүүх байгууллагын материалыг ангилах эрхийг олгосон байна. Учир нь мэдээлэлд нэвтрэх эрх чөлөө нь бусад тохиолдлуудаасаа тэргүүлэх шинжтэй байж үндсэн эрх мэт харагдаж байна.

Хэрвээ сэтгүүлч мэтийн эрх мэдэлгүй хүн нууцалсан материалтай танилцах бол эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй. Хэрвээ хэвлэл мэдээллийнхэн тодорхой нэг нууц материалаас мэдээлэл олж авбал тэд энэ материалын нууцлалын шинжийг тодорхой мэдээлж байх ёстой байдаг. Нууц баримт материалыг зөвшөөрөлгүй олж авах, хуурамчаар үйлдэх, хувилах, илчлэхэд ял зэмлэл хүртээдэг бөгөөд ийм үйлдэл хийсэн төрийн албан хаагч болон түүнийг хэвлэн нийтэлсэн сэтгүүлчийн аль аль нь хэрэгт холбогдоно.

Ерөнхий дүгнэлт

Хэдийгээр сэтгүүл зүйн нууцлалыг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрдөг ч өөр ямар нэгэн хуулиар энэ эрхийг нь тодотгон тодруулсан зүйл заалт байдаггүй байна. Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах тухай нэг л журам Франкогийн үед мөрдөгдөж байсан байна. “Мэргэжлийн нууцлал”-ыг хадгалах сэтгүүлчийн “үүрэг”-ийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ “нийтийн сайн сайхны тусын тулд шүүх засаглалтай хамтран ажиллах үүрэг”-тэй холбоотой онцлог жич зүйл гардаг. Европын хүний эрхийн шүүхийг Билл Гудвин даргалж байгаа болохоор дээрх тодорхойлолт нь маш тодорхой бус байна.



Ардчилал хөгжсөн улс орнуудын Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн харьцуулсан судалгаа

	Америкийн Нэгдсэн Улс	Канад	Швед	Шинэ Зеланд	Өмнөд Африк	Финланд	Их Британи
1. Хуулийн нэр	Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль	Мэдээлэл хүртэх хууль (1980)	Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль (1766)1949	Албан ёсны мэдээллийн тухай хууль (1982)	Мэдээлэл хүртэхийг дэмжих тухай (2000)	Засгийн газрын үйл ажиллагаа нээлттэй байх тухай хууль. (1999)	Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (2000)
2. Олон нийтийн мэдээлэл хүртэх эрхийн баталгаа	Канадын иргэн, болон байнгын оршин суугч (цагаачлалын хуулийн дагуу) захир-гааны байгууллагад байгаа ямар ч мэдээллийг хүртэх эрхтэй	Олон нийтийн санаа бодлоо чөлөөтэй солилцох, тэднийг гэгээрүүлэх үүднээс хүн бүр албаны баримт бичгийг чөлөөтэй хүртэх эрхтэй	Хүн бүрийн тухайн хүнд хамааралтай мэдээлэл хүртэх явдлыг хангах	Үндсэн хуулиар баталгаажсан мэдээлэл хүртэх эрхийг баталгаажуулах	Хүн бүр олон нийтийн эзэмшлийн албан ёсны мэдээллийг хүртэх эрхтэй	Хүн бүр захиргааны албан тушаалтанд байгаа мэдээллийг хүсэлтийн дагуу бичгээр авах эрхтэй.	
3. Нээлттэй засгалалыг дэмжсэн заалт				Сайн засгалалыг дэмжих, албан тушаалтнуудын хариуцлагыг дээшлүүлэх	Захиргааны нээлттэй, хариуцлагатай байх соёлыг хэвшүүлэх,	Засгийн газрын мэдээллийн удирдлагыг сайжруулах, сайн туршлага нэвтрүүлэх, түүний нээлттэй байдлыг дэмжих	
4. Нээлттэй хуралдаан						Парламентийн хуралдаан, хотын зөвлөгөөн, шүүх, шашны хуралдаанд оролцох эрхтэй	

5.	Мэдээлэлд хүртэх ангилалттай								X	X	X
6.	Мэдээлэлд хязгаарлалсан ангилалттай	X			Тусгай хуулиар				X	X	X
7.	Мэдээлэл хүсэх журам		Бичгээр		Бичгээр				Бичгээр		Бичгээр
8.	Мэдээлэл хүртэх үйл хөнгөвчилсөн заалттай	X			X				X		
9.	Хүсэлтэд хариу өгөх хугацаа	20 хоног, Шаардлагатай бол 10 хоног сунгана	30 хоног, Шаардлагатай бол сунгана		10 хоног, Шаардлагатай бол 20 хоног		30 хоног, 30 хоног сунгах		2 долоо хоног Шаардлагатай нөхцөлд 1 сар		20 хоног
10.	Мэдээлэл олж авах төлбөр	Зохиох хэмжээнд хувилсан, хайсан зэрэг шууд зардал	25 доллар хүртэл болон нэмэлт төлбөр байж болно.		Мэдээлэлтэй холбоотой хайсан болон бэлтгэсэн зардал		Зохиох боломжгүй төлбөртэй байх, хувилсан, хайсан,		Хэвлэх, хувилгах, хүргэх зардал байж болно.		Төрийн нарийн бичгийн даргаас гаргасан журмын дагуу
11.	Гомдол гаргах журам	Дээд шатны албан тушаалтан, Шүүх	Иргэн Мэдээллийн комисст 30 хоногт, Шүүхэд 45 хоногт Мэдээллийн комисс мэдээлэл нээлттэй болгох талаар шүүхэд гомдол гаргаж болно.		Засгийн газар, Шүүх		Дээд шатанд гомдол 60 хоногт гаргах, Шүүхэд 30 хоногт		Захиргааны журмаар гомдол гаргах, Захиргааны дээд шүүхэд хандах		Мэдээллийн комиссар, Мэдээллийн Трибунал, Шударга ёсны Шүүх
12.	Мэдээллийн эх сурвалжийг хамгаалсан заалттай эсэх										
13.	Захиргааны байгууллагын мэдээллийг хэвлэн	Улирал тутам, байнга	Жилд 2 удаа блютень				X		X		X

Ардчиллын шилжилтийн үеийн улс орнуудын Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн харьцуулсан судалгаа

	Болгар	Польш	Узбекстан	Эстони	Молдав	Орос	Латви	Украйн
1. Хуулийн нэр	Олон нийтийн мэдээлэл хүртэх тухай хууль (2000)	Захиргааны мэдээлэл олж авах тухай хууль (2001)	Мэдээлэл хүртэх эрхийг баталгаажуулах тухай (1997)	Олон нийтийн мэдээллийн хууль (2000)	Мэдээлэл хүртэх тухай Хууль (2000)	Мэдээлэл, мэдээлээр хангах, мэдээллийг хамгаалах тухай хууль (1995)	Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (1998)	Мэдээллийн хууль (1992)
2. Олон нийтийн мэдээлэл хүртэх эрхийн баталгаа	Болгарын иргэн бүр энэ хуульд заасны дагуу мэдээлэл хүртэх эрхтэй.	Хүн бүр олон нийтийн мэдээлэл хүртэх эрхтэй.	Иргэн бүр мэдээлэл хүлээн авах эрхтэй. Энэ нь хүн бүрийн мэдээлэл хайх, хүлээн авах, судлах, дамжуулах, тараах эрхийг хамгаална.	Олон нийт, иргэн бүр ардчилал, эрх зүйт төр, нээлтэй нийгмийн зарчмын үндсэн дээр олон нийтийн хэрэгцээнд зориулагдсан мэдээллийг хүртэх боломж, захирагчаны байгууллагын Үргээ биелүүлж байгаад хяналт тавих боломжийг хангах	Хүн бүр албан ёсны мэдээллийг хайх, олж авах, тараах эрхтэй	Иргэн, байгууллага, өөрийгөө удирдах орон нутгийн захиргааны байгууллагад байгаа мэдээллийг хүртэх эрхийг баталгаажуулна.	Олон нийт төр болон орон нутгийн захиргааны байгууллагад байгаа мэдээллийг хүртэх эрхийг баталгаажуулна.	Иргэн, хуулийн этгээд, засгийн газрын байгууллага мэдээлэл хүлээн авах, ашиглах, тараах, хадгалах эрх, эрх чөлөөтэй.
3. Нээлтэй засаглалыг дэмжсэн заалт						Оросын холбооны улсын төрийн мэдээлэл нээлтэй, бүх нийтэд хүртээмжтэй байна.		
4. Нээлтэй хуралдаан		Сонгуулийн үр дүнд байгуулагдсан захиргааны эрх бүхий байгууллага болон түүний нэмэлт салбар бүхий байгууллагын						

5.	Мэдээлэлд хүртэх ангилалтай	x	x				x	x	x			x
6.	мэдээлэлд хязгаарласан ангилалтай	x	x		x			Улсын нууцны хуулиар	x			x
7.	Мэдээлэл хүсэх журам	Бичгээр ба амаар	Бичгээр	Бичгээр ба амаар	Бичгээр ба амаар	Бичгээр ба амаар	Бичгээр ба амаар		Бичгээр ба амаар			Бичгээр ба амаар
8.	Мэдээлэл хүртэх үйл явцыг хөн-гөвчилсөн заалттай	x			x							
9.	Хүсэлтэд хариу өгөх хугацаа	14 хоног, шаардлагат ай үед 10 хоног сунгах	14 хоног шаардлагатай бол 2 сар	30 хоног	5 хоног шаардлагатай үед 15 хоног	Төлбөр нь мэдээдэл хайсан, хувилсан, хүргэсэн үнээс хэтрэх ёсгүй	15 хоног, 5 хоног сунгаж болох					30 хоног
10.	Мэдээлэл олж авах төлбөр	Төлбөр нь бодит үнээс хэтрэх ёсгүй	Зохих хэмжээний төлбөрийг авна.	Төлбөргүй. Зарим мэдээллийн төлбөрийг тожиролцож болно.	Зөвхөн мэдээлэл хайсан болон бэлтгэсэн зардал	Төлбөр нь мэдээдэл хайсан, хувилсан, хүргэсэн үнээс хэтрэх ёсгүй	Зөвхөн мэдээлэл-тэй холбоо-той хайсан болон бэлтгэсэн зардал	Зөвхөн мэдээлэл-тэй холбоо-той хайсан болон бэлтгэсэн зардал	Зөвхөн мэдээлэлтэй холбоотой хайсан болон бэлтгэсэн зардал			
11.	Гомдол гаргах журам	Захиргааны Дээд Шүүх	Байгууллага 14 хоногт шалгана, Захиргааны дээд шүүх 15-30 хоногийн дотор шийдвэрлэх	Шүүх	Мэдээллийн сан хамгаалсан инспектор, захиргааны шүүх	Омбудсмэн, Дээд шатны албан тушаалтан 5 хоногт шалгах, Шүүхэд 1 сарын дотор гомдол гаргах	Шүүх	Шүүх	Дээд шатны байгууллага болон албан тушаалтан, шүүх			Дээд албан тушаалтанд, Шүүх
12.	Мэдээллийн эх сурвалжиг хамгаалсан заалттай эсэх			x			x					

13	Захиргааны байгууллагын мэдээллийг хэвлэн нийтлүүлэх үүрэг	Х	Олон нийтийн мэдээллийн бюлетьн	Х	Наад зах нь жилд 1 удаа			
14	Мэдээллийн ажилтанг сургах заалт				Х		Х	
15	Мэдээлэл хариуцсан байгууллага					Мэдээллийн сан хамгаалсан инспектор	Оросын Хөл-бооны Улсын Ерөнхийлөгчийн Мэдээллийн бодлогын Хороо	
16	Мэдээлэгчийг хамгаалах заалттай эсэх							

Х- тухайн улс хуулиар зохицуулсныг тэмдэглэв.

Гуравдугаар бүлэг. Мэдээллийн эрх чөлөө ба төрийн нууц

1. “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө” хуулийн харьцуулсан судалгааны тайлан

1.1 Танилцуулга

Хүний эрх гэдэг ойлголт нь өөрөө хүний төрөлх мөн чанарыг илэрхийлдгээс гадна төрийг хуулиар хязгаарлаж, хуулиас гадуур гишгэж дураараа авирлах явдлаас урьдчилан сэргийлэх, тийм үйл ажиллагааг нь таслан зогсоох, эргээд хариуцлага тооцох үндэслэл болж байдаг билээ. Эдгээрийг бүгдийг нь иргэдийн зүгээс төрд тавьж буй хяналт гэж ойлгоно. Иргэд төрд хяналт тавих эрхээ бодитойгоор эдлэхийн тулд ардчилсан нийгмийн нэгэн тулгуур багана болох, иргэдийн харах нүд, сонсох чих болж байдаг чөлөөт, бие даасан, хүчирхэг, хараат бус хэвлэл, мэдээллийн эрх чөлөө, мэдэх эрхийг баталгаажуулах явдал юм.

“Иргэн төр, засгийн газрын мэдээллийг олж авах чадвартай байх нь ардчиллын үндсэн зарчмын нэг юм”. Чөлөөт илэрхийллийн төлөө дэлхийн кампанит ажлыг эрхэлдэг “19-р зүйл байгууллагаас” мэдээлэл нь ардчиллын хүчилтөрөгч болохыг тодорхойлсон байдаг. Ардчиллын мөн чанар нь нийгмийн гишүүд дундаасаа сонгосон хэсгээр өөрсдийгөө төлөөлүүлэн төр бариулаад, тэдний үйл ажиллагаанд ямагт идэвхитэй оролцох, хяналт тавих, хариуцлага тооцох өргөн боломжтой байх явдлаар тодорхойлогдоно. Мэдээлэлгүйгээр энэ боломж хязгаарлагдмал юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй...”⁴, “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална”⁵ гэж заасан байдаг. “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих”, “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор” гэсэн томъёоллууд нь задруулбал Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй мэдээллүүдийг хамруулна гэж ойлгогддог. Нөгөө талаар ил тод байснаараа төр засгийн байгууллага ч ажлаа илүү сайн хийдэг. Учир нь тушаал зааврыг урьдчилан таниулж, олон нийтийн оролцоотойгоор гаргах нь биелэгдэхэд нь ч дэмтэй байдаг. Олон нийтийн ухаан бодол, үзэл санаа тодорхой хэмжээгээр тусгагдсан шийдвэрийн чанар ч илүү байдаг.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжоор Монголд мэдээллийн эрх чөлөө хязгаартай бөгөөд тодорхой хугацаа заалгүй “нууц” гэсэн ангиллын дор олон нийтээс аливаа зүйлийг нууцалж болдог учраас нээлттэй байхыг амлаж буй Монголын Засгийн газрын үзэл баримтлалтай хууль тогтоомж нь зөрчилдөж байна. Онцын шаардлагагүй зүйлийг нууцалж байгаа нь төрийн албан хаагчдын дунд хариуцлагагүй байдал үүсгэж

4 Үндсэн хуульд 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт

5 Үндсэн хуульд 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт

байгааг өмнө нь “Глоб Интернэшнл” ТББ, “19 зүйл” байгууллагын хамтарсан тайлан, судлаач Сергей Радченкогийн түүвэр судалгааны үр дүнгүүд харуулдаг.

Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтын тухай хууль зэрэг ерөнхий хуулиар Монголд төрийн нууцыг хамгаалдаг бөгөөд энэ нь цаг үеэсээ хоцорсон, хүний эрхийг илүүцээр хязгаарласан учраас бид энэхүү судалгаагаар үндэсний аюулгүй байдал ба төрийн нууцын уялдаа холбоо, харилцан хамаарал, түүхэн болон уламжлалт зохицуулалт, ижил төстэй орчин нөхцөл бүхий болон дэвшилтэт зохицуулалттай улс орнуудын хуультай харьцуулан судалж, Монгол улсад төрийн нууцын хууль тогтоомжийн шинэтгэл хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлов.

Мэдээллийн эрх чөлөөний олон улсын стандарт, зарчимд тулгуурлан дүн шинжилгээ хийж, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шаардлага, мэдээллийн эрх чөлөөний стандарт, хэм хэмжээг үндэс болгон төрийн нууцтай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр тайлан бэлтгэж тодорхой санал, зөвлөмж гаргасан болно.

Судалгааны ажлын зорилго

Мэдээллийн эрх чөлөөний олон улсын стандарт, зарчимд тулгуурлан Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд дүн шинжилгээ хийж, уг хуулиудыг шилжилтийн үеийн болон бусад орны ижил төстэй хууль тогтоомжтой харьцуулан судлах, хуулийн шинэ төсөлд оруулах саналыг боловсруулахад оршино.

Судалгааны баг

Судалгааны баг нь хуульч Д.Мөнхбүрэн, Д.Оросоо, Д.Саранчимэг, Ж.Энхнасан, М.Доржханд, Г.Даваахүү, А.Түвшинтулга нарын судлаачдаас бүрдэнэ.

Судалгааны хүрээ

1. Мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх, үг хэлэх, мэдэх эрх, ил тод байдал, үндэсний аюулгүй байдал, нууцын талаарх олон улсын стандарт, хэм хэмжээ, үзэл санаа, зарчим зэрэг олон улсын эх сурвалжийг судлах
2. Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд дүн шинжилгээ хийх
3. Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг шилжилтийн үеийн болон бусад орны ижил төстэй хуультай харьцуулан судлах (1.ОХУ, 2.Киргизийн БНУ, 3.Таджикстан, 4.Туркменстан, 5.Украин, 6.Гүрж, 7.Казакстан, 8.Солонгос, 9.ИБУИНВУ, 10. ХБНГУ)

1.2 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Либертари үзэл ёсоор хүн бүр жам ёсны эрхтэй байдаг. Хувь хүний эрх нь төр засаг үүсэхээс өмнө байсан бөгөөд хүмүүс эрхээ хамгаалахын тулд төрийг бий болгосон. Төр засаг хүний эрхийг зөрчих, хязгаарлах тохиолдолд хувь хүн эсэргүүцэх эрхтэй. Иймд хувь хүн төр засагт өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, төр засгаас мэдээлэл шаардах нь зүй ёсны хэрэг болно. Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх эрх нь төр засгийг хянах, цагдах арга зам болдог.

Жакоб Буркхард (Jacob Burckhardt)-ын өгүүлснээр засгийн эрхийг хэн барьж байснаас үл хамааран засаг өөрөө нүгэлт зүйл юм. Засаг бол эрх барьж байгаа хүмүүсийг эвдэн завхруулж, эрх мэдлээ урвуулан хэрэглэхэд хүргэх хандлагатай байдаг. Зөвхөн хэмжээгүй эрхт хаад, сурвалжит язгууртан нар төдийгүй, ардчиллаар төрийн эрх барьж буй олонх ч хэтрэх тийшээ амархан ханддаг .

Төр засаг хийгээд аливаа төвлөрсөн эрх мэдэл бол аюултай зүйл юм. Иймд либертари үзэл нь төрийн төвлөрсөн эрх мэдлийг задлах, хязгаарлах хэрэгтэй гэж үздэг. Төрийн эрх мэдлийг хуулиар гурав хувааж хязгаарлалт тогтоодог, мөн төрийг ил тод, нээлттэй болгож, иргэний мэдээлэл авах эрх, мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах замаар төрийн эрх мэдэлд хяналт хязгаарлалт тогтоодог. Олон нийтэд ил тод байгаа төр засаг эрх мэдлээ зүй ёсны дагуу л хэрэгжүүлдэг. Хэрвээ төр засаг хаалттай байх юм бол төрийн эрх мэдлийг хэд хуваагаад ч нэмэргүй байх бөгөөд энэ нь зөвхөн хэлбэрийн асуудал болж хувирна. Харин мэдээллийн эрх чөлөөг хөгжүүлээд, мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг хамгаалж, төр засгийг ил тод, нээлттэй болгох юм бол төрийн эрх мэдлийг жинхэнэ утгаар нь хуваарилж, хязгаарлалт тогтоож чадна. Төрийн эрх мэдэлд хэрхэн хуваарилалт хийсэн, тэр нь яаж ажиллаж байгаа нь олон нийтэд нээлттэй харагдаж байх хэрэгтэй. Ингэж байж эрх мэдлийн хуваарилалт үр дүнгээ өгнө.

Иймд мэдээллийн эрх чөлөө нь зөвхөн мэдээлэл авах тухай хэрэг бус, засгийн эрх ард түмний гарт байх, төрийг удирдах хэрэгт иргэд оролцох, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, үзэл бодол, санал шүүмжээ төр засагт илэрхийлэх зэрэг өргөн утга агуулгатай билээ.

Үндэсний аюулгүй байдал ба Мэдээллийн эрх чөлөө

Улс, үндэстний үндэсний аюулгүй байдлын тухай үзэл санаа өнө эртний түүхэн улбаатай бөгөөд төрийн амар амгалан байдал, үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, нийгмийн эв нэгдлийг хангах, гадны түрэмгий халдлага болон бусад аюул заналаас сэргийлэн хамгаалах гэсэн утга агуулгыг илэрхийлж ирсэн байна.

Улс төр, эдийн засаг, цэрэг, нийгэм-оюун санааны болон бусад бүхий л салбарыг хамарч байсан “Хүйтэн дайн” дууссаны дараа дэлхий дахинаа эрчимтэй өрнөсөн үйл явц, хамгийн гол нь Монгол Улсын дотоод, гадаад байдалд 1990-ээд оноос хойш гарсан гүн гүнзгий өөрчлөлттэй уялдан “үндэсний аюулгүй байдал” хэмээх ойлголт орчин үеийн нийтлэг агуулга, хэмжүүрээр шинэ тутам яригдах болж, улмаар Монгол Улсад хэтдээ учирч болзошгүй аюул занал, түүнээс урьдчилан сэргийлэх арга механизмын талаар цэгцтэй нэг мөр ойлголт, бодлогыг боловсруулан, аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс, аюулгүй байдлыг хангах арга зам, түүний баталгаа зэргийг тогтоодог. Төр засаг нийтийн эрх ашиг сонирхлыг хамгаалж байгаа гэдэг утгаараа үндэсний аюулгүй

байдлыг хамгаалах үүрэг хүлээдэг. Монгол Улсын Их хурлаас 1994 онд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батлан гаргасан бөгөөд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл юм.

Тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах нь төрийн үндсэн тулгуур чиг үүрэг байдаг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль нь Монгол Улсын ард иргэд, нийгмийн бүх хэсэг бүлгийн нийтлэг ашиг сонирхлын цогцолсон илэрхийлэл мөн” гээд, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж **“Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ”** хэмээн тодорхойлжээ.

“Үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтах бөгөөд төр, ард түмний онцгой анхаарал, хамгаалалтад байна” гэжээ.

Үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлын бүтцийг ийнхүү тодорхойлохын зэрэгцээ салбар бүрт сөргөөр нөлөөлж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийг тооцож, аюулгүй байдлыг хангах арга замыг мөн тодорхойлсон байна. Тухайлбал: **“Үндэсний аюулгүй байдлын нийгэм, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зүйн аргаар дангаараа буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангана”** гэж заажээ. Үзэл баримтлалын өөр нэг чухал санаа бол болзошгүй аливаа аюул заналыг урьдчилан танин мэдэж, түүнээс сэргийлэн хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авч байх тухай санаа мөн. Өөрөөр хэлбэл, Үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэрэгсэл нь баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үндсэн дээр үйл явдлын өрнөлт, хөгжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал юм.

Түүнчлэн үзэл баримтлалд **үндэсний аюулгүй байдлын үндсэн баталгаа нь Монголын ард түмэн өөрөө, Монгол улсын төр мөн** болохыг тодорхойлон заасан нь үндэсний аюулгүй байдлыг хангахад төр, түүний нийт байгууллага, албан тушаалтан, улс төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, төдийгүй ард иргэд бүгдээрээ идэвхтэй оролцох ёстойг харуулж байна.

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь дотоод, гадаад, цаг хугацааны хувьд гэнэтийн, тодорхой хугацааны, түүхэн нэгэн үеийн, мөнхийн гэж ангилж болно. Мөн шинж чанарынх нь үүднээс объектив, субъектив, учруулах аюулын магадлалаар нь бодит болон болзошгүй гэж ангилна. Үндэсний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх бодлого нь аливаа аюулыг “болзошгүй” үед нь тодруулах, тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар объектив аюулыг арилгах, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд зааснаар:

Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал гэдэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал хангагдсаныг,

Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулиар бататгагдсан төр, нийгэм-эдийн засгийн тогтолцоо, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд, түүнчлэн хүний эрх, эрх чөлөө баталгаажсан байхыг,

Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал гэж бие хүн өөрийн хийгээд эх орон, ард түмнийхээ ашиг сонирхлын төлөө биеийн болон оюуны хүч чадавхиа бүрэн зориулах, олон улсын гэрээний дагуу хүний эрхийн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүрэг хэрэгжих нөхцөл бүрдсэн байхыг,

Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг,

Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал гэж өөрийн орны экологийн өвөрмөц нөхцөлд технологи болон мэдээлэл судалгааг улс орныхоо хөгжилд ашиглах, шинжлэх ухааны үндэсний чадамжийг дээшлүүлэх, оюуны үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг хангасан нөхцөл байдлыг ойлгоно.

Мэдээллийн аюулгүй байдал гэж төрөөс улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр гаргах, Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, ард иргэд хангагдсан, Монгол Улсын талаар гадаадад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг,

Монголын соёл иргэншлийн аюулгүй байдал гэж Монгол түмэн, Монгол төр оршин тогтнож хөгжихийн үндэс болсон үндэсний хэл бичиг, түүх, соёл, зан заншил хадгалагдах, Монгол хүн ард үүрд оршин амьдрах нөхцөл байдлыг,

Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал гэж Монгол Улсын хүн амын эрүүл мэнд, удмын сан, тогтвортой өсөлт хадгалагдаж, хамгаалагдсан нөхцөл байдлыг,

Экологийн аюулгүй байдал гэж байгаль цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байдлыг тус тус ойлгохоор тодорхойлжээ.

Монгол Улсын төр **нэгдүгээрт**: улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, **хоёрдугаарт**: Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, иргэдийг хангах буюу тийнхүү хангагдсан байх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Хүн төрөлхтний өнөөгийн хөгжлийн гол онцлог, шийдвэрлэх хүчин зүйл бол хувь хүний болон хамт олны амьдралд, бүхэл бүтэн улс гүрэн, төдийгүй дэлхийн хамтын нийгэмлэгийн амьдралд маш идэвхтэй нөлөөлж байгаа **мэдээлэл** юм. Үүнтэй уялдан мэдээллийн салбар дахь иргэн, төрийн ашиг сонирхол, учирч болох аюул занал, бусад хүчин зүйлийг ойлгож тодорхойлох нь маш чухал гэж үздэг байна.

Мэдээллийг хувь хүн, нийгэм, төрийн ашиг сонирхолд харшаар ашиглах тохиолдолд улс, үндэстэнд учирч болох хор хохирол **эд материалын хэмжээ хүрээнээс хальж, улс төр, нийгэм-эдийн засгийн, олон улсын харилцааны хүрээнд үлэмж хор уршиг учруулах үр дагавартай байж болно**. Үүнээс үүдэн иргэн, байгууллага, төр өөрөө мэдээлэл чөлөөтэй олж авах, түгээх, ашиглах эрхийг хамгаалахаас гадна мэдээллийн улсын нөөцийг хамгаалах, түүнийг ариг гамтай зарцуулах зэрэг олон асуудлыг тодорхойлсон **мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын тухай** яригдах болсон байна.

Өнөөдрийн байдлаар 1995 онд батлагдсан нууцын тухай багц хуулиуд болон 2004 онд шинэчлэн найруулсан Улсын нууцын жагсаалт батлах тухай хуулийг эс тооцвол мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин цогцоороо бүрдээгүй байна гэж

үзнэ. Иймд юуны өмнө мэдээлэл бий болгох, цуглуулах, боловсруулах, хуримтлуулах, хадгалах, хайх, түгээх, түүнчлэн мэдээлэл болон мэдээлэлжүүлэлтийг хамгаалах асуудлыг зохицуулсан хууль /хэд хэдэн хууль байж болно/ гаргах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, мэдээллийг зөвхөн нууцад хамаарах гэдэг үүднээс хуульчлан хамгаалах бус, харин мэдээллийн өнөөгийн ач холбогдлоор нь, иргэд Үндсэн хуульд заасан мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ бодитой эдлэх эрх зүйн механизмыг бүрдүүлэх том агуулгаар төр авч үзвэл зохино.

Үндэсний аюулгүй байдал алдагдах нь улс оршин тогтнох, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал алдагдах ноцтой үр дагавартай тул нууцыг чанд хамгаалах учиртай.

Үндэсний аюулгүй байдал, түүнийг хамгаалах асуудал нь мэдээллийн эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн чөлөөт урсгалд хязгаарлалт болох ёсгүй. Мэдээллийн эрх чөлөө нь үндэсний аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалснаас бусад мэдээлэлд хамаардаг ойлголт билээ. Гэхдээ үндэсний аюулгүй байдалд буюу төрийн нууцад хамааруулах шаардлагагүй, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй мэдээллийг төрийн нууцад хамааруулах нь мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа нэг хэлбэр мөн.

Олон жилийн турш, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах эрх чөлөөний хоорондын харилцаа нь шүүх болон олон улсын байгууллага, хууль тогтоогчдын шийдвэр аль алианаар нь ихээхэн судлагдсаар ирсэн. Нууцтай холбоотойгоор тогтоосон үндэсний аюулгүй байдлын хязгаарлалттай холбоотой зарчмыг өөртөө агуулсан ихэнх мэдээллүүд нь “Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах Үндэсний аюулгүй байдлын талаарх” Йоханнесбургийн зарчмуудаар хангагддаг. Энэ зарчмууд нь үндэстнүүдийн нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн эрх зүйн нийтлэг зарчмууд, төрийн үйл ажиллагааг хөгжүүлэх хүний эрхийг хамгаалах стандартууд, олон улсын эрх зүйд үндэслэгдсэн бөгөөд энэ салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн судлаачдын хэсгээс боловсруулагдсан юм. Тэдгээрт үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг нууцлах түгээмэл стандартуудыг тоймлон тогтоосон байдаг.

Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууц

Мэдээллийн салбар дахь техник, технологийн асар хурдацтай хөгжлийг дагалдан төр хүссэн, эс хүссэн ч иргэдийн мэдээлэл хүлээн авах чадавхи ардчилсан нийгэмд маш түргэн нэмэгдэж байна. Энэ тохиолдолд төр мэдээллийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын хүрээнд:

Нэгдүгээрт: иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах, ашиглах эрх чөлөө чөлөөтэй хэрэгжих орчинг бүрдүүлэх,

Хоёрдугаарт: мэдээллийн технологийн хөгжлийг даган төрийн нууцад хамаарах мэдээлэл алдагдах магадлал өндөр болсныг харгалзан төрийн нууцын хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх механизмыг улам боловсронгуй болгох, төрийн нууцын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, чангатгахад чиглэсэн зохион байгуулалтын, техникийн шинжтэй цогц арга хэмжээг иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хохироохгүйгээр авч хэрэгжүүлэх,

Гуравдугаарт: төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үндсэн зарчмууд болох хууль ёсны болон ил тод байх зарчмыг төрийн бүх шатны байгууллагад жинхэнэ ажил хэрэг болгох,

Дөрөвдүгээрт: төрийн нууцыг хамгаалах нь төрийн хүлээсэн шууд үүрэг хэдий ч энэ асуудал аливаа улс, үндэстний үндэсний аюулгүй байдлыг хангахтай шууд хамааралтай учраас төрийн нууцад хандах иргэдийн нийгмийн ухамсар, ёс зүйг шинэчлэн өөрчлөхөд илүүтэй анхаарал хандуулах болсон байна.

Йоханнесбургийн зарчмууд нь мэдээлэл хайх, олж авах, хэлэх эрхийг цаг хугацаанд нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгай шалтгаанаар хязгаарлагдаж болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэвч, үндэсний аюулгүй байдал нь мэдээлэл олж авахыг хязгаарлаж чадахгүй. Йоханнесбургийн олон зарчмууд нь дараах нууцлалын хуулийн асуудалтай холбоотой байна.

Зарчим 2: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхол

А/ хязгаарлалт нь цэргийн дайралт зэрэг гадаад эх сурвалжаас, эсвэл засгийн газрыг унагах зөрчлийг өдөөн хатгах зэрэг дотоод эх сурвалжаас, хүч хэрэглэхэд хариу үзүүлэх хүчин чадал, аюул заналын эсрэг улсын оршин тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үр дүн, бодит зорилгогүй бол үндэсний аюулгүй байдлын шалтгаан нь хууль ёсны болж зөвтгөгдөхгүй.

Б/ Ялангуяа, бэрхшээл, саад, буруу үйлдлээс засгийн газрыг хамгаалах, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нууцлах, үйлдвэрлэлийн үймээн самууныг нууцлан дарах зэргээр үндэсний аюулгүй байдалтай холбоогүй ашиг сонирхлыг хамгаалах үр дүн, бодит зорилго байвал үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар уг хязгаарлалтыг хууль ёсны гэж үзэж зөвтгөж болохгүй.

Зарчим 15: Нууц мэдээллийг задруулах талаарх нийтлэг журам

Хэрэв 1. Мэдээллийг задруулах нь бодитоор хохирол учруулаагүй, үндэсний аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулаагүй бол, 2. мэдээллийг мэдэх нийтийн ашиг сонирхол задруулснаас үүсэх хор хохирлоос илүү бол, хэн ч мэдээллийг задруулсныхаа төлөө үндэсний аюулгүй байдлын шалтгааны дор шийтгэгдэх ёсгүй.

Зарчим 16: төрийн албаны хүрээнд олж авсан мэдээлэл

Мэдээлэл олж авах гэсэн нийтийн ашиг сонирхол нь илчилснээс гарах хохирлоос илүү байвал төрийн албаны шугамаар олсон этгээд мэдээллийг илчилбэл үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар ямар нэг хохирол учруулсан гэж хэнийг ч авч хэлэлцэхгүй.

*“Үндэсний аюулгүй байдал,
Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж”
Йоханнесбургийн зарчмаас*

Дээр дурьдсан зарчмуудыг дэлхийн улс орнууд нууцын хууль тогтоомжийн шинэтгэл хийхдээ гол төлөв удирдлага болгодог байна

Мэдээлэл олж авах, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба Үндэсний Аюулгүй байдлын талаарх Йоханнесбургийн зарчимд нийцээгүй заалт буюу төрийн нууц задруулсан тохиолдолд 8 жил хүртэл хорих ял шийтгэх тухай заалт Монгол Улсын Эрүүгийн хуульд байна. Хуулийн хатуу чанга заалт нь эрх баригчдад олон нийтийн “хоточ нохойн” үүрэгтэй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг цагдан хянах боломж олгож, улмаар иргэний эрхийг зөрчдөг сөрөг талтай.

1.3. МОНГОЛ УЛСАД ҮЙЛЧИЛЖ БАЙСАН УЛСЫН НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН АКТЫН ТУХАЙД

1935 онд Сайд нарын зөвлөлийн 521 дүгээр тогтоолоор *“Хэвлэлд нийтлэх ба радиогоор нэвтрүүлэхийг шууд хориглох зүйлүүдийн дэлгэрэнгүй жагсаалт”* баталжээ. Уг жагсаалтаар хэвлэлд нийтлэх ба радиогоор нэвтрүүлэхийг хориглох зүйлийг 1) улс төр-үзэл суртлын шинж чанартай мэдээ баримтууд, 2) цэргийн чанартай мэдээ баримтууд, 3) хүн амын тухай мэдээ баримтууд, 4) эдийн засгийн чанартай мэдээ баримтууд, 5) бусад мэдээ, баримтууд гэж ангилсан байдаг. Тухайлбал, хүн амын тухай мэдээ, баримтуудад *“...улс ба аймаг, сум, багаар нас, эрэгтэй, эмэгтэйгээр нь тодорхойлсон хүн амын тоо, үйлдвэр дээр гарсан осол гэмтлийн тоо ба түүний жишээ баримт, ажилчин ангийн тоо, багш, сурагчдын дотор үзэгдсэн моральд харштай жигшүүртэй явдлууд, аймаг, хотын улсын хэмжээгээр бага, дунд сургуулиудад суралцаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тодорхой...”* зэргийг оруулсан сонирхолтой юм.

1945 оны 7 дугаар сарын 27-ны өдөр БНМАУ-ын СнЗ-ийн 51 дүгээр тогтоолоор *“Улсын нууц болж, тусгайлан хамгаалагдах мэдээнүүдийн жагсаалт”*-ыг баталсан нь улсын нууцыг тогтоосон анхны акт гэж үзэж болох юм. Үүнээс өмнө зөвхөн хэвлэлд нийтлэх, радиогоор нэвтрүүлэхийг шууд хориглох зүйлийн жагсаалтаар мэдээлэлд хяналт тавьдаг байсан байжээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1955 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн *“Улсын нууц мэдээ баримтуудын жагсаалтыг тогтоох тухай”* 521 дүгээр тогтоол батлагдсан байна. Уг тогтоолоор 1) цэргийн шинж чанартай мэдээ баримтууд, 2) эдийн засгийн чанартай мэдээнүүд, 3) бусад төрлийн мэдээ баримтууд гэсэн гурван хүрээнд нууц мэдээ баримтуудын жагсаалтыг баталсан байна.

Түүнчлэн БНМАУ-ын Их хурлын тэргүүлэгчдийн 1955 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 120 дугаар зарлигаар БНМАУ-ын нууцыг задруулбал хариуцлага хүлээлгэх тухай заажээ. Уг зарлигаар улсын нууцад холбогдох мэдээ баримтуудыг өөрт нь итгэмжилснээр буюу өөрийн албан тушаалын байдлаар эдгээр мэдээ баримтуудыг олж авч чадах хүмүүсээс уг нууц мэдээ баримтуудыг задруулсан нь эх орноосоо уравсан буюу тагнуул хийсэн гэж үзэх үндэсгүй бол зургаагаас арван хоёр жил хүртэл хугацаагаар Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерьт хорьж шийтгэх, улсын нууцад холбогдох мэдээ баримтуудыг энгийн хүмүүсээс задруулсан нь эх орноосоо уравсан буюу тагнуул хийсэн гэж үзэх үндэсгүй бол таваас арван жил хүртэл хугацаагаар Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерьт хорьж шийтгэхээр заасан байдаг байна.

СнЗ-ийн 1964 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Улсын нууц бичиг баримтын товч жагсаалт, зааврыг батлах тухай 258 дугаар тогтоол гарчээ. Уг тогтоолоор улсын нууцыг *“маш нууц-онц чухал”, “маш нууц”, “нууц”* гэсэн зэрэглэл тогтоожээ.

Энэ тогтоол нь 1992 он хүртэл үйлчилж байгаад Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн агуулга, зарчим, эдийн засаг, нийгмийн харилцааны шинэчлэл, өөрчлөлтийн бодлогод нийцүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 38 дугаар тогтоолоор хүчингүй болсон байна.

1.4. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН НУУЦ БОЛОН ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын үндэсний язгуур эрх, ашиг сонирхлыг хамгаалж байгаа гол хуулийн хувьд Төрийн нууцын тухай хууль нь хоёрдмол утгагүй, хийдэлгүй, хууль зүйн техникийн хувьд сайн боловсрогдсон нарийн тодорхой, мөн мэдээллийн эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээ, стандартад нийцсэн, Монгол Улсын иргэний мэдээлэл олж авах, олон нийтийн мэдэх эрхэд нийцсэн хууль байх учиртай юм.

1995 онд Төрийн нууцын тухай хууль батлах үед мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрх, мэдэх эрхийн тухай ойлголт, мэдээлэл Монгол Улсад сайн дэлгэрээгүй байсан юм. Мэдээллийн эрх чөлөө, мэдэх эрхийн тухай асуудал бол харьцангуй шинэ сэдэв бөгөөд манай улс мэдээллийн эрх чөлөө, мэдэх эрх, мэдээлэл олж авах эрхийн талаарх олон улсын стандарт, хэм хэмжээ, соёл, жишгээс нилээд зайтай байгаа нь нууц биш билээ.

Төрийн нууцыг тогтоох, хамгаалах

Төрийн нууцыг тогтоохдоо үндэсний аюулгүй байдал, нууцлах мэдээлэл хоёрын зохистой харьцааг алдагдуулахгүй байхыг олон улсын практик шаарддаг бөгөөд зөрчилдсөн тохиолдолд иргэдийн ашиг сонирхол хөндөгддөг.

Төрийн нууцыг тогтоох үйл ажиллагаа нь мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцын жагсаалтад хамааруулах шийдвэр гаргах, боловсруулах, нууцлах ажиллагаанаас бүрдэхээр хуульчилсан бөгөөд хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулахыг хориглосон нь эерэг заалт юм.

Төрийн нууцын тухай хуулиар үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил зэрэг хүрээний бүх мэдээллийг нууцлах бус **“нууцалбал зохих хэсэг”**-ийг нууцлах талаар заасан байх бөгөөд энэ ойлголтыг хуульд огт тайлбарлаагүй байгаагаас үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах зэрэг хүрээний нууцалбал зохих зүйл, нууцлахгүй байх зүйлийн зааг харьцаа харагдахгүй байна. Үүнээс хамааран нууцлах шаардлагагүй зарим зүйлийг ч нууцад хамааруулсан явдал байгаа болно. Иймд **“нууцалбал зохих хэсэг”** гэсэн эрх зүйн ойлголтыг тодорхойлох шаардлага харагдаж байна. Жишээ дурдвал:

Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлд төрийн нууцад хамааруулах зүйлийн хүрээг тодорхойлсон байх бөгөөд уг зүйлийн 4.5-д **“Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдсон мэдээ, баримт, материалын нууцалбал зохих хэсэг”**-ийг нууцад хамааруулахаар заажээ. Гэтэл Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар **“Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдох мэдээ, баримт бичиг”**-ийг бүхэлд нь нууцалсан. Зарчмын хувьд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль нь Төрийн нууцын тухай хуульдаа нийцэж байх ёстой юм.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн жагсаалтын 5, 9, 20, 42-д **“нууцалбал зохих хэсэг, заалт”, “нууцалбал зохих асуудал”, “нууцалбал зохих гүйцэтгэх ажил”** гэх зэргээр бичжээ. Энд **“нууцалбал зохих хэсэг”** гэдэг нь юуг хамаарч байгаа нь ойлгомжгүй байна.

Төрийн нууцыг тогтоох асуудал цаг үетэйгээ нийцсэн байх учиртай. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулж Өршөөлийн хуулийг УИХ-аас гаргасан.

Өршөөлийн хуулийн төслийг олон нийтэд үзүүлээгүй, учир нь энэ нь нууцад хамаардаг гэж тайлбарласан юм. Гэтэл Төрийн нууцын болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд Өршөөлийн хуулийн төсөл нууцад хамаарах тухай заалт байхгүй. Гэтэл энэ хуулийн төслийг нууцлах шаардлага байсан. Уг хуулийг гарахаас өмнө ямар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өршөөл үзүүлэх, үзүүлэхгүй тухай асуудал хөндөгдөж байсан бөгөөд хэрвээ нууцлахгүй бол үр дагавар нь ноцтой байдалд хүргэж болох байсан юм.

"Төрийн нууцыг хамгаалах" гэж төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг задруулахгүй байх зорилгоор өөрийн бүрэн эрхийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, арга хэрэгслийн цогцолборыг ойлгож байгаа. Төрийн нууцыг хариуцдаг, эсхүл төрийн нууцтай албан үүргийн дагуу танилцсан албан тушаалтан, иргэн төрийн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглах, төрийн нууцыг олж авах зорилгоор хайж олох, бусдад задруулахыг хориглон хуульчилсан нь нууцын хүрээг хэт өргөн хүрээнд томъёолсон энэ үед мэдээлэл хайсныхаа төлөө хариуцлага хүлээх үндэслэлийг бий болгохоор байна.

Төрийн нууцын зэрэглэл

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар 1) Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд, 2) батлан хамгаалах хүрээнд, 3) эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд, 4) тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд, 5) бусад гэсэн хүрээнд нийт 59 багц бүхий жагсаалт гаргажээ. Уг жагсаалтаар нууцын зэргийг **"Онц чухал-маш нууц", "маш нууц", "нууц"** гэж тогтоосон боловч зарим мэдээлэл нь нууцын ямар зэрэглэлд багтаж байгаа нь тодорхой бус байгаа юм. Учир нь хуульд нууцын зэрэглэл тодорхой байсаар байтал нууцын зэрэглэлийг тодорхой заахгүйгээр **"нууцалсан зэрэглэлээр"** гэсэн ерөнхий нэр томъёог хэрэглэжээ. Иймд байдлаар нийт 24 жагсаалтын зэрэглэлийг тогтоосон байгаа. Төрийн нууцад хамаарсан мэдээллийн нууцалсан зэрэглэл нь хуульд тодорхой байх ёстой. Хуульд заасан **"нууцалсан зэрэглэлээр"** гэдэг нь ойлгомжгүй нэр томъёо байх тул нэг бол үндэслэл бүхий тайлбарлах, эсхүл нууцын зэрэглэлийг тодорхой зааж оруулах хэрэгтэй юм.

Төрийн нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Төрийн нууцын зэрэглэлийг тогтоосон байх бөгөөд энэ нь төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамаарах ойлголт юм. Төрийн нууцын зэрэглэлийг тогтоосон боловч Захиргааны хариуцлагын болон Эрүүгийн хуулиар төрийн нууцыг задруулсан, хадгалах, хамгаалах журам зөрчсөн этгээдэд ямар зэрэглэлийн нууцыг задруулсан гэдгээс үл хамааран ялгамжтай бус хуулийн хариуцлага хүлээлгэхээр тогтоосон нь өрөөсгөл байна. Төрийн **"онц чухал-маш чухал"** нууцыг задруулсан этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага нь **"нууц"** зэрэглэлд хамаарах төрийн нууцыг задруулсан этгээдээс илүү байх нь зүй ёсны шаардлага юм. Мөн төрийн нууцын **"нууц"** зэрэглэлд хамаарах нууцыг задруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага нь **"онц чухал-маш нууц"** зэрэглэлийн нууцыг задруулсан этгээдээс арай хөнгөн байхаар хуульчлах хэрэгтэй юм. Учир нь **"нууц"** зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулснаас учрах хор уршгийн хэмжээ нь харьцангуй бага байх юм. Мөн **"онц чухал-маш нууц", "маш нууц", "нууц"** гэсэн нууцын зэрэглэлийн ойлголт, нэр томъёо нь тодорхой бус байгаа тул тайлбарлах шаардлагатай байна.

Нууцлах хугацаа

Нууцлах хугацааны зохицуулалтыг Төрийн нууцын жагсаалт батлах хуулиар хийсэн бөгөөд үүнийг Төрийн нууцын жагсаалтын тухай хуулийн 59 категори тус бүрээр авч үзвэл:

№	Хугацаа	Тоо, ширхэг		Хувь
1	Байнга	13		20,96%
2	60 жил	15	28	45,16%
3	50 жил	2		
4	40 жил	11		
5	30 жил	1	8	12,9%
6	25 жил	1		
7	20 жил	6		
8	15 жил	2	9	14,5%
9	10 жил	6		
10	5 жил	1		
11	Тодорхой заагаагүй	4		6,45%

Төрийн нууцын тухай хуулиар нууцын зэрэглэлийг онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэж ангилсан ч ангилал тус бүрд харгалзах категорийг харуулбал:

- 1/ онц чухал-маш нууцад - 6
- 2/ маш нууцад - 24
- 3/ нууцад – 7

Нууцалсан зэрэглэлээр /нийт-25/ категори хамаарагдахаар байна. Хуулийн байнга нууцална гэсэн хэсгийг нягтлан үзвэл нууцын зэрэглэлээс үл хамаарч байгаа нь харагдана. Өөрөөр хэлбэл, нууцалсан зэрэглэлээр гэдэгт дээрх 3 зэрэглэлийн алинд ч хамаарч болох мэдээллүүд нь байнга нууцлагдаж байна.

Төрийн нууцын жагсаалтаас харахад “үндэсний аюулгүй байдал” ба “гадаад бодлогод” хамаарах зүйлийг байнга нууцлахаар заасан нь хууль тогтоомжоор хориглосон тус улсын гадаад бодлогын талаар ард иргэд сонирхох аргагүй болж байна. Төрийн нууцын жагсаалтын 1-р заалтын дагуу Монгол Улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлын талаарх мэдээллийг байнга нууцлахаар заасан байна. Хуулийн энэ заалтыг дагаж мөрдвөөс Чингис хааны тухай өгүүлсэн Монголын нууц товчоог ч төрийн нууц гэж үзэхээс аргагүй болж байгаа бөгөөд практик дээр мэдээж 1940-1970-аад оны түүхийн талаар судалгаа хийхийг хориглосон байдаг. Монгол Улсын Төрийн нууцын жагсаалт батлах хуулийн 3-р заалтанд бүх баримт бичгийг нэг төрөл гэж үзээд ерөнхийд нь нууцлах буюу бусад оронтой харилцсан бичгийг ч хамааруулан заажээ. Энэ заалтын дагуу онцын ач холбогдолгүй бичиг баримтыг ч олон жилээр төрийн нууцад хамааруулах болж байна. Мөн жагсаалтын 5-р заалтаас харахад “төрийн дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, хоёр болон олон талын яриа, хэлэлцээний сэдэв, илтгэл, тэмдэглэл, тэдгээрт холбогдох баримт бичиг талууд өөрөөр тохироогүй бол хэлэлцээр дуустал нууцлагдахаар заасан нь бүхий л айлчлал хамаарахаар болж байна.

Монгол Улсын Төрийн нууцын жагсаалт батлах хуулийн 6-р заалтанд нэлээд нарийвчлан, олон талын болон хоёр талын харилцааны баримт бичгийг 60 жил (хоёр тал өөрөөр тохироогүй бол) нууцлахаар заасан байна. Мэдээж зөвхөн Хойд Солонгос л Монгол Улстай засгийн газрын түвшинд байгуулсан гэрээ хэлэлцээрээ 60 жил нууцлахыг шаардаж болох юм. Хамгийн гол нь хоёр орны засгийн газар хоорондын гэрээнд (олон талт гэрээг бодвол) цөөхөн тохиолдолд нууцлах заалт орсон байдаг. Одоогийн үйлчилж байгаа хуулийн 60 жил нууцлах заалт нь Монгол Улсын гадаад бодлогын талаарх үзэл баримтлал, бусад оронтой харилцсан баримт бичгийг олон нийт мэдэх аргагүйд хүргэж байна. Уг хуулийн 13-р заалтанд Монголын засгийн газрын хэрэглэдэг нууц шифр, криптографын боловсруулалтыг нууцлахаар заасан байна. Нууц шифрийн кодыг тайлж унших нь элбэгших хандлагатай байгаа учраас шифрийн кодын байнга өөрчлөх хэрэгтэйг дурдах нь зүйтэй юм. Монголчуудын хэдэн арав, зуун жилийн өмнө хэрэглэж байсан нууцыг тайлах түлхүүр үг, код зэргийг нууцлахаар заасан нь тус орны иргэдийг мэдээлэл олж авахыг хориглосон шаардлагагүй заалт болсон байна.

Төрийн нууцын жагсаалт батлах хуулийн 2-р заалтаар нууцлалын хугацааг тодорхойлж, Монгол Улсын батлан хамгаалах салбарын үзэл баримтлал, стратеги, цэргийн үйл ажиллагааны тактик зэрэгт хамаарах баримт бичгийг (гол төлөв 40 жилээр) нууцалсан байна. Хэдийгээр эдгээр баримт бичиг нууцлалын зэрэгт хамаарч болох ч хугацаа нь 40 жилээр байх шаардлагагүй мэт санагдана.

Тагнуул болон сөрөг тагнуулын үйл ажиллагаатай холбоотой заалтыг (Жагсаалтанд дурдсанаар 60 жил ба байнга нууцлах ангилалд багтсан) өөрчлөн олон нийтийн хяналт дор харьяалах агентлагуудын эрхлэх ажиллагааны хүрээнд шилжүүлбэл зохино. Барууны орнуудад тагнуулын мэдээллийг 30 жилийн дараа нууцын ангиллаас хасдаг ба зарим тохиолдолд тагнуулчдын амь насыг хамгаалах үүднээс энэ хугацааг 70 жил хүртэл сунгах нь бий. Энэхүү тодорхойгүй заалтыг төр иргэдийнхээ мэдээлэл хүлээн авах эрхийг хориглох нэг ёсны цензур болгон ашиглахаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Төрийн нууцын жагсаалтын цаг хугацааны ангилал нь 1998 онд батлагдсан Архивын тухай Монгол улсын хуулийн 25.7 ба 25.8 заалт тодруулбал, засгийн газрын үйл ажиллагааны талаарх баримт бичгийг олон нийтэд 30 жилийн дараа, онцгой тохиолдолд 50 жилийн дараа, хувь хүний амьдралтай холбоотой бол 70 жилийн дараа нээлттэй болгоно гэсэн заалтуудтай бүдүүлгээр зөрчилдөж байгааг дурдах нь зүйтэй юм.

Төрийн нууцын тухай хуулийн үйлчлэх хүрээ, хязгаар

Төрийн нууцын болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг 1995 онд анх батлан гаргаж, 2004 онд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг шинэчлэн баталсан билээ.

Хууль нь батлагдсан өдрөөс эхлэн үйлчилж эхэлдэг, 1995 онд батлагдсан Төрийн нууцын тухай хууль нь батлагдсан цаг хугацаанаас хойш үйлчлэх учиртай. Энэ хуулийг буцааж хэрэглэх заалт байхгүй. Тэгвэл 1995 оноос өмнө бий болсон төрийн нууц бүхий мэдээлэлд энэ хууль үйлчлэх үү, үгүй юу гэдэг нь тодорхой биш. Хууль зүйн хувьд энэ хууль батлагдсан цаг хугацаанаас эхлэн бий болсон нууцын асуудалд үйлчлэх бөгөөд харин нөгөө талаар төрийн нууцыг бий болсон цаг хугацаанаас нь үл хамааран хамгаалах учиртай билээ. Энэ зааг ялгааг энэ хуулиар нарийн тодорхой гаргаж өгөөгүй байна.

Манай судалгааны баг Зэвсэгт хүчний төв архиваас 1939-1945 оны дайны үеийн төлөвлөгөөтэй танилцах хүсэлт гаргахад улсын нууцад хамаарах тул болохгүй гэсэн хариулт өгсөн юм. 1939-1945 оны үеийн баримт нь одоо төрийн нууцад хамаарч байгаа гэхэд эргэлзээтэй хэрэг бөгөөд энэ мэдээллийг нууцлах хандлага, сонирхол байсаар байгааг харуулж байгаа юм. Тэгээд ч 1939-1945 оны баримтад 2004 онд батлагдсан Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль үйлчилж байна гэхэд эргэлзээтэй юм.

Төрийн аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д *“Нууц гэдгээр халхавчлан зөрчил дутагдлыг нуун дарагдуулах нь улс орны эрх ашигт харш гэж Монгол Улсын Ерөнхий аудитор үзвэл уг мэдээллийг авах эрхтэй байгууллага, албан тушаалтанд нь танилцуулж, холбогдох арга хэмжээ авахыг санал болгож болно”* гэж заасан нь төрийн нууц гэдэг нэрийн дор зөрчил дутагдлыг нуун дарагдуулах явдалтай тэмцэх чухал механизм болжээ.

Төрийн нууцад хамааруулсан боловч олон нийтэд ил болсон мэдээлэл

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн (2004 он) 1 дүгээр зүйлд буюу Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд төрийн нууцад *“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал”* нь хамаарах тухай заасан байдаг. Гэтэл Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг батлах, нийтлэх тухай 1994 оны 6 сарын 30-ны өдрийн УИХ-ын тогтоолоор энэ нь олон нийтэд аль хэдий нь нээлттэй болсон байдаг. Түүнчлэн олон нийтэд төлбөртэйгээр суулгаж өгч байгаа *“Findlaw”* гэх хуулийн программын мэдээллийн санд (хууль, УИХ-ын тогтоол, олон улсын гэрээ, УДШ-ийн тогтоол гэсэн мэдээллийн төрөлтэй) уг нууцад хамааруулсан гэх үзэл баримтлал нь орсон байдаг юм. Тэр ч байтугай энэ нь эргээд практиктай зөрчилдөж байгаа нь “Өдөөн тандах судалгааны тайланд дурдагдсан “Хөх ном”-нд хэвлэгдэж, нийтэд ил болсноор давхар нотлогдож байна.

Мөн өөр нэг жишээ дурьдвал, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 32-р зүйлд 1:100000-аас илүү нарийвчлалтай масштабын байр зүйн зургийг төрийн нууцад хамааруулан, хугацааг байнга хэмээн заасан боловч өнөөдөр энэ төрлийн зургийг интернэтээс шууд татаад авч болж байна. Энэ нь Төрийн нууцтай холбоотой хуулиуд маань цаг үеэсээ нилээд хоцорч байна гэдгийг харуулж байгаа хэрэг. Нөгөө талаар нууцын жагсаалтыг нарийвчлах шаардлага байгааг харуулж байгаа юм. Учир нь цэргийн болон байлдааны зориулалттай байр зүйн зургийг нууцлах шаардлагатай. Гэтэл 1:100000-аас илүү нарийвчлалтай масштабын байр зүйн зургийг ерөнхийд нь төрийн нууцад хамааруулсан нь оновчгүй юм.

Дээр дурдсан мэдээллийг үнэн хэрэгтээ төрийн нууцад хамааруулах шаардлага бага юм. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд төрийн нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг нууцалсан гэж үзэж болох бөгөөд эцэстээ уг мэдээлэл *“өөрөө”* олон нийтэд янз бүрийн эх сурвалжаас ил тод болж байгаа байдал харагдаж байгаа юм. Түүнчлэн манай зарим багш, судлаачид Төрийн нууцын хуулиар нууцын зэрэглэлд хамаарах мэдээллийг гадаадын орнуудын нээлттэй архив, судалгааны бичиг баримтуудаас чөлөөтэй олж авсан ч тохиолдол байдаг. Эндээс нууцлах шаардлага гэдэг бол өөр ойлголт гэдэг нь харагдаж байгаа болно. Үнэхээр нууцлах шаардлагатай мэдээллийг нууцалсан бол ийм асуудал гарч ирэхгүй.

Төрийн нууцад хамааруулах шаардлагагүй мэдээлэл

Төрийн нууцын жагсаалт батлах хуулийн жагсаалтын 4-д *“Гадаад орон, олон улсын байгууллагатай Монгол Улсын Засгийн газар, Төв банк санхүүгийн салбарт хамтран ажиллах болон өр, зээл тусламжтай холбоотой гэрээ хэлэлцээрийн төсөл, тэдгээрийн боловсруулалтын шатанд хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа”*-г нууцын жагсаалтад оруулжээ. Энд дурдсан нууцад хамаарч буй мэдээлэл нь уг баримт бичиг хүчин төгөлдөр болсноор нууц биш болох ажээ. Нэгэнт эдгээр баримт бичиг нь хүчин төгөлдөр болсноор төрийн нууц биш болох юм бол түүнийг төрийн нууцад хамааруулах ямар шаардлага байгаа нь ойлгомжгүй юм.

Мөн хуулийн жагсаалтын 37-д *“Шинжлэх ухаан, технологийн ололтыг дотоод, гадаадад дамжуулах лицензийн гэрээтэй холбоотой баримт бичиг”* нь нууцын жагсаалтад оржээ. Гэтэл нууцлах хугацааг талуудын байгуулсан гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол 10 жил байхаар заасан нь ойлгомжгүй юм. Нэгэнт төрийн нууцад хамаарах мэдээлэл юм бол түүнийг нууцлах хугацааг аль нэг талуудын байгуулсан гэрээ, хэлэлцээрээр бус хуулиар тогтоох ёстой гэж үзэж байна. Үнэн хэрэгтээ энэ мэдээлэл нь төрийн нууцад хамааруулах шаардлага бага гэдгийг харуулж байгаа юм. Шинжлэх ухаан, технологийн ололтыг дамжуулах лицензийн гэрээг төрийн нууцад хамааруулах шаардлага байхгүй юм.

Төрийн нууцыг ил болгох

Төрийн нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлд Төрийн нууцыг ил болгох асуудлыг зохицуулсан байдаг. Хуулийн 21.1-д *“Төрийн нууцыг ил болгох” гэж төрийн нууцыг УИХ-ын шийдвэрээр төрийн хамгаалалтаас гаргахыг хэлнэ*” гэж заажээ. Төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтоодог, харин төрийн нууцыг ил болгохдоо хууль гаргахгүйгээр УИХ тогтоол гаргаж болохоор хоёрдмол утга хуульд орсон байна. УИХ-ын тухай хуулийн 36 дугаар зүйлд УИХ-ын шийдвэрт хууль, УИХ-ын тогтоол хамаарах тухай заалт бий. Төрийн нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4-д *“Үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс төрийн нууцыг яаралтай ил болгох шаардлага гарсан тохиолдолд Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч уул асуудлыг шийдвэрлэнэ”* гэж заажээ. Энэ заалтаар Монгол Улсын Ерөнхийлөгчид төрийн нууцыг ил болгох эрх хэмжээ олгосон байна.

Төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтоодог, мөн төрийн нууцыг ил болгохдоо хууль гаргаж нууцын жагсаалтаас хасдаг байх учиртай. Гэтэл хуулиар тогтоосон төрийн нууцыг хуулиас доогуур хүчин чадалтай эрх зүйн актаар ил болгохоор заасан нь төрийн нууцын эрх зүйн байдлыг дордуулсан гэж үзэх үндэстэй болно.

Төрийн нууцын тухай хуульд заасан *“үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс төрийн нууцыг яаралтай ил болгох шаардлага”, “нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцлах шаардлагагүй болсон”* гэсэн ойлголтууд нь тодорхой бус байх тул эдгээр хууль зүйн нэр томъёог тодорхойлох шаардлагатай юм. Харин зөвхөн үндэсний аюулгүй байдлын үүднээс бус ер нь “Төрийн нууцыг ил болгох шаардлага” гэсэн эрх зүйн ойлголт байх хэрэгтэй.

“Төрийн нууцыг яаралтай ил болгох шаардлага” гэдэгт төрийн нууцад хамаарч буй мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноор үндэсний аюулгүй байдалд хор

хохирол учруулахгүй бөгөөд задруулахгүй байх нь олон нийтийн эрх ашигт ноцтой хохирол учруулахаар шалтгааны улмаас нууцыг яаралтай ил болгох асуудлыг ойлгож болох юм. Харин **“нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцлах шаардлагагүй болсон”** гэдэгт тухайн мэдээллийг нууцалж байсан үндэслэл, хэрэгцээ, шаардлага үгүй болсон, цаашид нууцлах үндэслэл, хэрэгцээ байхгүй байгаа байдлыг ойлгож болох юм. Гэхдээ бидний энэ томъёолол сайн болсон гэж үзэхгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Монголд төрийн нууцыг тогтоож, хамгаалж буй гол шалгуур нь **“задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц”** мэдээллийн төрийн нууцад хамааруулдаг явдал. Гэхдээ зарим тохиолдолд үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахгүй мэдээлэл багтсан байхыг үгүйсгэхгүй. Задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг задруулснаар үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулбал энэ нь нууцлах шаардлагатай мэдээлэл гэдэг нь ойлгомжтой, харин уг мэдээллийг задруулснаар үндэсний аюулгүй байдалд хор хохирол учрахгүй бол энэ нь нууцлах шаардлагагүй болсон мэдээлэл байна гэсэн үг юм. Ийнхүү нууцлах шаардлагагүй болсон, олон нийтэд ил болгосноор үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахгүй болсон мэдээллийг задруулсны төлөө хэн нэгэн хариуцлага хүлээх ёсгүй юм.

Төрийн нууцад хамаарах буюу түүнтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосон нь үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахаар ч түүнийг ил болгоогүйгээс учрах хохирлын хэмжээнээс давж байвал төрийн нууцыг яаралтай олон нийтэд ил болгодог зохицуулалт хийх, уг мэдээллийг ил болгосны төлөө хариуцлага хүлээхгүй байх, мөн олон нийтийн мэдэх эрх, олон нийтийн эрх ашиг нь төр буюу үндэсний аюулгүй байдлын эрх ашгаас илүү хөндөгдөж байгаа тохиолдолд төрийн нууцыг ил болгодог байх, үүнийг олон нийтэд нээлттэй болгосноор хэн нэгэн хариуцлага хүлээдэггүй байх зарчмыг хуульд тусгаж өгөх хэрэгтэй юм.

2006 оны 9 дүгээр сард АНУ-ын **“Вашингтон Пост”** сонин АНУ-ын тусгай албаны нууц тайланг олон нийтэд ил тод хэвлэсэн. **“Вашингтон Пост”** сонин энэ тайланг Ерөнхийлөгч Ж.Бушийн их ойрын хүнээс авсан гэдгээ зарласан. Энэ тайланг олон нийт уншаад Ерөнхийлөгч Ж.Бушийн хэлдэг байсан **“...АНУ урьд өмнөхөөсөө илүү найдвартай хамгаалалтад байгаа...”** гэдэг үгэнд эргэлзэж, шүүмжлэлтэй хандаж эхэлсэн гэдэг. Энэ тайлан нь нууц мэдээлэл байсан бөгөөд олон нийтэд ил тод болсноос хойш хэдхэн хоногийн дараа АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш шийдвэр гаргаж уг тайланг нууц мэдээллийн жагсаалтаас хассан юм.

Төрийн нууцын тухай хуульд зааснаар төрийн нууцыг ил болгох нэг үндэслэл нь **“нууцлах хугацаа дуусгавар болсон”** явдал аж. Төрийн нууцын жагсаалт батлах хуульд заасан нууцын жагсаалтад буй мэдээллийг зарим тохиолдолд тодорхой хугацаагаар нууцлах тухай заасан. Нууцад хамаарч буй мэдээллийг байнга бус тодорхой хугацаагаар нууцалж буй тохиолдолд уг мэдээллийг нууцад хамааруулж эхэлсэн цаг хугацаа нь олон нийтэд тодорхойгүй байгаа юм. Нэгэнт нууцад хамааруулж эхэлсэн цаг хугацаа нь тодорхой бус учир дуусах хугацааг нь тооцох боломжгүй болно. Энэ байдал нь үнэн хэрэгтэй байнга нууцалж байгаатай адил хэрэг юм. Тодорхой хугацаагаар нууцалсан мэдээллийг нууцлах хугацаа дууссаны дараа иргэд уг мэдээллийг олж авах эрхтэй байх ёстой. Иймд нууцлах хугацаатай холбоотой харилцааг нарийн тодорхой, ойлгомжтой болгож, олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай нь харагдаж байна.

Архивын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д **“Архивт байгаа хуулиар хамгаалсан төрийн болон бусад нууцад холбогдох баримтыг үүссэн цагаас нь**

хойш 30 жил өнгөрсний дараа нийтэд ашиглахыг зөвшөөрнө”, 25.8-д “Үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримтыг 50 жил, иргэдийн хувийн амьдрал, эд хөрөнгийн байдалд холбогдолтой баримт бичгийг 70 жил өнгөрсний дараа нийтэд ашиглуулна” гэсэн заалт байна. Архивын байгууллага гэдэг бол улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, танин мэдэхүйн зорилгод ашиглах архивын баримтыг хүлээж авах, хадгалах, хамгаалах, зориулалтын дагуу ашиглуулах үүрэг бүхий байгууллага байдаг. Архивын байгууллагын үндсэн зарчим бол олон нийтэд нээлттэй байх явдал. Төрийн нууцад хамаарахгүй буюу төрийн нууцын жагсаалтаас хасагдсан баримтыг ашиглахад архивын хуулиар цаг хугацааны хувьд хязгаарлалт тогтоож байгаа нь төр, байгууллага, хувийн нууцад хамаарахгүй мэдээллийг хайх, олж авах иргэний эрхэд нийцэхгүй байна.

Архивын тухай хуульд заасан *“үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримт”* гэдгийг хэрхэн ойлгох нь ойлгомжгүй учраас зөрчил үүсгэж байна. Учир нь үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримтыг Төрийн нууцын тухай хуулиар хамгаалдаг. Төрийн нууцын тухай хуульд хамаарахгүй хэрнээ *“үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримт”* гэдэгт ямар баримт хамаарах нь ойлгомжгүй байна. Төрийн нууцын тухай хууль тогтоомжоор нууцлаагүй бол энэ төрлийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байх ёстой бөгөөд цаг хугацааны хувьд ашиглахад хязгаарлалт тогтоож байгаа нь үндэслэл муутай байна.

Төрийн нууцыг задруулах

Төрийн нууцын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5-д *“Төрийн нууцыг олж авах зорилгоор хайж олох, бусдад задруулахыг хориглоно”* гэж заасан бөгөөд энэ заалтыг зөрчсөн тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалт уг хуульд байхгүй байна.

Харин Захиргааны хариуцлагын тухай хуулийн 34 дүгээр зүйлд Улсын нууц хадгалах, хамгаалах журам зөрчих гэсэн заалт байдаг. Уг зүйлд зааснаар төрийн нууц хадгалах, хамгаалах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000-50000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулахаар заажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд *“Төрийн нууц задруулах”* (87 дугаар зүйл) гэмт хэргийг заажээ. Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлийн 87.1-д *“төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх”, 87.2-т “энэ хэргийн улмаас хүнд хор уршиг хохирол учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх”*-ээр заажээ. *“Төрийн нууц задруулах”* гэмт хэргийн субъект нь төрийн нууцыг итгэмжлэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд байхаар хуульд заасан байна. *“Төрийн нууцыг итгэмжлэн хариуцсан этгээд”* гэдэгт албан үүрэг, гэрээний үндсэн дээр уг нууцыг шууд гардан хариуцаж хадгалах, хамгаалах ажиллагаа явуулах, судалгаа шинжилгээ хийх зэрэг хуулиар эрх олгогдсон этгээд, харин *“албан тушаалын хувьд төрийн нууцыг мэдсэн этгээд”* гэдэгт уг нууцыг шууд гардан хариуцаж ажиллах эрх, үүрэггүй боловч өөрийн эрхэлж байгаа албан тушаалын хувьд уг нууцтай танилцах, тусгай даалгавраар ажил шалгах зэргээр мэдэх хууль ёсны эрхтэй болсон этгээд, *“Ажил үүргийн хувьд төрийн нууцыг мэдсэн этгээд”* гэдэгт уг нууцыг шууд гардан хариуцах

буюу албан тушаалын хувьд танилцах эрх бүхий албан тушаал эрхлэхгүй боловч ажил үүргийн хувьд мэдэж болох туслах, техникийн чанартай ажил үүрэг гүйцэтгэдэг (бичээч, олшруулагч, бичиг хүргэгч г.м) хүмүүсийг ойлгох нь зүйтэй гэж Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн ухааны доктор Г.Совд агсаны **“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”**-т бичжээ.

Эрүүгийн хуульд зааснаар бол төрийн нууц задруулах гэмт хэргийг төрийн нууцыг итгэмжлэн хариуцсан, албан тушаалын болон ажил үүргийн хувьд мэдсэн этгээд үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээх бөгөөд энэ нь төрийн нууцыг итгэмжлэн хариуцах үүрэг хүлээгээгүй, албан тушаал, ажил үүргийн хувьд төрийн нууцыг хариуцах, танилцах хууль ёсны эрхгүй этгээд болох сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны хувьд төрийн нууц бүхий мэдээллийг олон нийтэд ил болгосон тохиолдолд эрүүгийн хариуцлагад татагдахгүй байх үндэстэй гэсэн үг юм. Энэ нь олон улсын хэм хэмжээ, жишигт нийцсэн зохицуулалт мөн боловч практик дээр байдал арай өөр байдаг ажээ.

1.5. ТӨРИЙН НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ДЭЭР ГАРСАН НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

Өдөр тутмын сонинууд дээрх “Төрийн нууц”-тай холбоотой мэдээлэл:

Төрийн нууц, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой мэдээллийг өдөр тутмын сонингоос шүүж үзэхэд:

Өдрийн сонин (хуучнаар Ардын эрх) 1990.07.014 “Маш нууц! Хэлж болохгүй”
-Энэ жил хичнээн хүнийг цаазаар аваачиж, хэдийг өршөөж уучилсан бэ

- Маш нууц! Хэлж болохгүй ... АИХТ-ийн нэгэн ажилтан сурвалжлагч хоёрын дунд ийм яриа боллоо.

Онц жигшүүртнийг нийтийн өмнө жигшүүлэн цээрлүүлдэггүй юмаа гэхэд тогтоол гүйцэтгэсэн тухайгаа, эсвэл өршөөж уучилсан тухайгаа ард түмэндээ ил тодорхой мэдээлдэг болцгооё. Сэтгүүлчдийн дунд энэхүү мэдээллийг задруулахыг хүсээд зогсохгүй, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулинд цаазаар авах ял гүйцэтгэх журам, ажиллагаа, гүйцэтгэсэн тухай баримт бичгийг байнга нууцлахаар заасан боловч сэтгүүлчийн хүссэн мэдээлэл нь тогтоол гүйцэтгэсэн, эсвэл уучилсан эсэх, хэдэн хүн зэрэг мэдээллийг хүссэн байна. Төрийн нууц гэх нэрийн дор хавтгайруулан ойлгож, мэдээллийг хэт нууцлах гэж оролдох нь утгагүй юм.

1993.08.31 №137(637) “Алдагдсан Монгол орон минь” Б.Нацагдорж–Маш нууцын тухай өгүүлэхэд - Хүүхдийн эндэгдэл, малын хорогдол, цэргийн насанд хүрэгчдийн тоо гээд хянахгүй юмгүй байсан үе бий. Хожим сонсвол 300 гаруй зүйл байсан гэдэг. Тэгвэл энэ бүхэн өнөөдөр салхинд хийсэх мэт алга боллоо. Ардчилсан хувьсгалын үед өрийн данснаас аваад олон нууцыг нээсэн. Түрүүчийн Засгийн газраас “Улсын нууцын тухай” 206 тоот тогтоол (47 зүйлийг улсын нууцад хамруулсан), түүнийг хэрэгжүүлэхээр УАБХЕГ-гаас батлан гаргасан “Улсын нууцыг хадгалж, хамгаалах заавар” төдийгөөр улсын нууцыг бүрэн хамгаалж чадна гэж үү. Барилга хот байгуулалтын сайдын дэргэдэх Улсын геодези, зураг зүйн газар (УГЗЗГ)-т нууц зургийн хадгалалт, хамгаалалт ямар байгаатай УАБХЕГ танилцахад улсын нууцтай холбоотой 60 гаруй зураг дутаж хууль зүйн дагуу шалгахад тус газарт хяналтын албаны даргаар ажиллаж байсан Дэмбэрэл 48 ширхэг байр зүйн нууц зургийг гадаадынханд худалдсан нь тогтоогдож эрүүгийн хэрэг үүсгэгдэн мөрдөн байцаах газар шилжжээ. Нууц хадгалалт манайд ёс төдий байна. Өнөөдөр бид улсынхаа түүхийг шинэчлэж үнэн зөвөөр нь сөхөж чадаагүй л байна. Тэгсэн мөртлөө үнэт баримтаа хэдэн ногооноор үнэлж “худалдсаар” л байх уу. Ийм байдлаар төр маань алсыг харсан бодлоготой, өөрийн гэсэн мөртөй байж чадах уу. Монголд өөрийн гэсэн нууц байж, түүнийгээ хуульчлан хамгаалах цаг болсон санагдана.

Энд 2 санаа гарч байна.

1. Байр зүйн зураг гэж ерөнхийлөн заасан нь өнөөдөр нууцлах шаардлагатай эсэх тухай асуудлыг бий болгосон байна. Учир нь интернэтээс байр зүйн 1:100000-аас илүү нарийвчлалтай масштабтай зургийг авч үзэж болж байна. Гэвч энэ нь батлан хамгаалах хүрээнд хамаарч байгааг анхаарах хэрэгтэй. Нэгэнт төрийн нууц гэж хуульчилж өгсөн бол түүнийг хамгаалж, нууцалж чаддаг байх хэрэгтэй байна.

1995.01.18 №09(968) Нууцалсан бол харин ч бусдын сонирхол татах байсан ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Энхсайхан МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал яагаад нийтлэгдсэн тухай Ц.Жаргалсайханд ярилцлага өгчээ. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалтай холбоотой мэдээлэл байнга төрийн нууц байхаар Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дэх хэсэгт заажээ. Гэвч энэ нь нууцлалд орох шаардлагагүйн улмаас өнөөдөр хэн хүссэн нь олж мэдэх боломжтой болоод байна.

Өдрийн сонин, 2005.12.24 №308(2129), “Ийгл”-ийн сэтгүүлч Г.Батжав: Тагнуул, татвар, нийгмийн даатгалын хэлтэстэй холбоотой нууц материалыг олонд дэлгэнэ. Нэгэнт төрийн нууц тухайн нууц хариуцсан албан тушаалтны буруугаас ил болсон тохиолдолд сэтгүүлч түүнийг хэвлэх нь хариуцлага тооцох үндэслэл болохгүй. Энэ нь Эрүүгийн хуулинд заасан төрийн нууц задруулах гэмт хэргийг субъектын шинжийг бүрдүүлэхгүй юм.

2000.10.24. №250 /503/, Улсын нууц задруулсан бас нэг хэрэг шалгагдаж байна. Батлан хамгаалахын их сургуулийн хилийн цэргийн сургуулийн нууцын архивын ажилтан Б.Цэндбаатар улсын нууц задруулсан хэрэгт холбогджээ. Тус сургуулийн III дамжааны оюутан Н.Түвшинжаргал түүнээс улсын хилийн тухай ном, бичиг баримт авчээ. Гэтэл Түвшинжаргалаас мөн сургуулийн III дамжааны оюутан Отгонбаатар уг материалыг авч яваад сургуулийнхаа соёлын төвд хаяж үрэгдүүлсэн байна. Шинжээчид үрэгдсэн ном, бичиг баримт нь улсын нууцад хамаарна гэсэн дүгнэлт гаргажээ. Ийнхүү Б.Цэндбаатар, Н.Түвшинжаргал нарт Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэн улсын нууц задруулсан хэмээн шалгаж байгаа аж. Харин Отгонбаатарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

2006.10.04 №244 /2378/, Засгийн газар нууц асуудал хэлэлцэнэ. ...хэлэлцэх асуудлын жагсаалтын 13, 14 дүгээрт Ерөнхий сайд М.Энхболд, Сангийн сайд Н.Баярсайхан нарын танилцуулах асуудал ямар нэгэн нэргүйгээр нууц хэмээх тодотголтойгоор бичигджээ. ...Тэгэхээр энэ нь сүүлийн үед яригдах болсон Засгийн газрын өөрийнх нь хувь заяаны асуудал юмуу, өөр нэгэн мөнгө цаастай холбоотой ноцтой асуудал байж болохыг үгүйсгэхгүй. Хэрэв олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал бол нээлттэй байх учиртай. Мөнгө санхүүтэй холбоотой байгаа учир олон нийтийн анхаарлыг татах учиртай.

Өнөөдөр сонин, 1998.11.14. №222 /516/, Д.Чимэд-Юндэн: Тагнаж чагнадаггүй тагнуулын байгууллага гэж байдаггүй. Сур: Тагнасан, чагнасан гэдэг чинь харамсалтай нь илэрчихээд байгаад гол нь байгаа юм биш үү. ҮАБХГ гэдэг бол дээд зэргийн нууцлалтай байх ёстой баймаар. Гэтэл танай байгууллагаас нууц алдагдаад байна шүү дээ?

ЧЮ: - энэ нь манай байгууллагад ажиллаж байгаа зарим нэг хүмүүсийн боловсрол, мэдлэг, нийгмийн төлөвшил, нууц хадгалж байгаа байдлаас болж буй нь үнэн. Мөн гаднаас ямар нэг байдлаар мэдээлэл олж авч буй юм ч бий. Ардчилсан нийгэм, олон намын тогтолцооны үед ажиллах туршлага дутагдаж, хувийн атгаг занд хөтлөгдөх явдал ч гарч байгаа нь нууц алдагдахад хүрч байгаа юм. Энэ нь төрийн нууцын хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгааг харуулж байна.

Санжаасүрэнд холбогдох хэрэг

2005 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Эмнести Интернэшнлээс нэгэн уриалга гаргасан юм. Тэр нь Хуульч, хүний эрхийг хамгаалагч Лодойсамбуугийн Санжаасүрэнийн талаарх асуудал байлаа.

Л.Санжаасүрэн нь тухайн үед зүрхний өвчний улмаас маш хүнд байдалтай шоронд байхдаа эмнэлгийн тусламж анхаарал аваагүй байна. Тэрээр 2004 оны 11 дүгээр сард төрийн нууц задруулсан гэмт хэрэгт ялагджээ. Эмнести Интернэшнл үзэхдээ: тэрээр үйлчлүүлэгчийнхээ эрхийг хамгаалсныхаа л төлөө баривчлагдаж хоригдсон гэж үзжээ.

Тэрээр Монголын тагнуулын ажилтанд баривчлагдсан хүнийг хамгаалж, эрүү шүүлт эдэлж байсан үйлчлүүлэгчдээ тусалсан учраас төрийн нууц задруулсан гэж тооцогдоход хүрчээ. 2005 оны 4 дүгээр сард Л.Санжаасүрэн нь Монгол Улсын Дээд шүүхэд давж заалдсан боловч ялагджээ.

Тэрээр шоронд байхдаа сонинд өгсөн ярилцлагадаа: түүнийг маш олон хоригдолтой өрөөнд байлгасан, хүч хэрэглэж байсан, маш хүнд нөхцөлд байгаагаа хэлжээ. Баттай эх сурвалжаас үзвэл, Л.Санжаасүрэн нь зүрхний өвчинд сөрөг нөлөөтэй, маш муу нөхцөл байдалд байжээ.

Л.Санжаасүрэн нь 2003 оны 5 дугаар сарын 15-нд Монголын тагнуулын байгууллагын ажилтанд Францаас баривчлагдаж ирсэн Дамирангийн Энхбатыг өмгөөлж байжээ. Д.Энхбат нь 1998 онд гарсан С.Зориг агсныг алсан хэрэгт сэжиглэгдэж байжээ.

Л.Санжаасүрэн нь Д.Энхбатыг зурагтаар Тагнуулын Ерөнхий газрын эрүүл шүүлт, түүнийг баривчилсан талаар дэлгэрэнгүй ярихад нь туслалцаа үзүүлсэн байдаг. Иймээс хоёуланг нь төрийн нууц задруулсан гэж үзэж 2004 оны 10 дугаар сард шорон хорьсон байдаг. Л.Санжаасүрэнг 18 сараар хорьж, Д.Энхбатыг 3 жилээр хорих ял оногдуулжээ.

Эмнести Интернэшнл байгууллагын уриалгын дагуу ерөнхийлөгчийн уучлалаар суллагдсан байна.

Улс төржсөн тагнуулууд

Өдрийн сонин, 2004 оны 1 дүгээр сарын 22

Өнгөрсөн онд сайд Ц.Нямдоржийн тагнуулын хэрэг, Францаас баригдаж ирсэн Д.Энхбатын гэх хэргүүд ихээхэн улс төржиж, олон нийтийн анхаарлыг татаж байв. Үүнээс ХЗДХЯ-ны сайд Ц.Нямдоржтой холбоотой гэгдэх хэргийг анхан шатны шүүх шийдвэрлэв. ТЕГ-ын дарга асан генерал Баатарыг улсын нууц задруулсан, хүн гүтгэсэн гэх хоёр зүйл ангиар буруутган хөнгөнийг нь хүндэд нь багтааж нийт долоон жил шоронд хорихоор яллалаа. Харин Д.Энхбаттай холбоотой гэх хэрэг өнөө хэр үргэлжилсээр байна. Сөрөг хүчин Д.Энхбаттай холбоотой хэргийг улс төржүүлэн дэвэргэж байна гэж үзэж байгаагаа ТЕГ хэвлэлийн төлөөлөгчөөрөө дамжуулан хоёр ч удаа илэрхийлсэн. Үүний дараагаар С.Зоригийн гэгдэх болсон хэргийг мөрдөх ажлын хэсгээс шинэ оны дараахан ТЕГ-ынхантай ижил утга агуулгатай мэдэгдэл хийлээ. Эдгээр мэдэгдлүүдийн дараагаар нэлээд хугацаанд дэлгэрэнгүй ярилцлага өгч хэвлэлийн бага хурал хийлгэсэн байна. Маргалдагч талуудын мэдэгдэл, тайлбаруудаас харах юм бол аль нь хүмүүсийг араасаа дагуулах гэж мэрийхийн хажуугаар хэн хэнд нь л олон нийтээс нуух ямар нэг юм байгаад түүнийгээ тойруулж хана хэрэм босгоод байгаа мэт санагдаж байна. Д.Энхбатыг өнгөрсөн оны 5 дугаар сард Франц улсаас баривчлан авчирсан нь урьд хүчний байгууллагынхан Америкаас “ард” хэмээх Батсүхийг, ОХУ-аас “Сэлэнгийн”

хэмээх Баатаржавыг дүүтэй нь баривчлан авчирч байсантай адилхан хэдий ч энэ удаа хэтэрхий улс төржиж байгаагаар онцлогтой байгаа юм. Батсүх, Баатаржав нарыг харь орноос зардал чирэгдэл гарган баривчлан авчирснаа хүчний байгууллагынхан С.Зоригийн хэрэгтэй холбочихдог болохоор олон нийт ч дуугаа хураачихдаг байж. Энэ удаа бас л С.Зоригийн хэрэгт биз гээд олон нийт Д.Энхбатыг төдийлөн ойшоохгүй байж болох л байсан. Гэтэл Д.Энхбатын өмгөөлөгчөөр хурандаа Л.Санжаасүрэн ажиллах болсноос хойш энэ хэрэг шууд л хүний эрхийн асуудал болон босч ирлээ. Л.Санжаасүрэнг Монголын хүний эрхийн байгууллагууд дэмжиж, тэр ч бүү хэл маргаанд Европын холбоо, Франц улсыг хамруулж, үүгээрээ Д.Энхбаттай холбоотой гэх хэрэг нь олон улсын шинж чанартай болж хувирсан. Хэдийгээр өмгөөлөгч Санжаасүрэн өөрийн үйл ажиллагаагаа хүний эрхийг хамгаалахтай холбон тайлбарлаж байгаа ч цаад зорилго нь арай өөр зүйлд байна гэх сэтгэгдэл төрөхөөр байна. Л.Санжаасүрэн хорихын эмнэлэгт үйлчлүүлэгчтэйгээ уулзах үедээ нууцаар видео бичлэг хийж, түүнийг нь “25 дугаар суваг” телевиз болон зарим хэвлэлээр бүрэн эхээр нь нийтэлж нэвтрүүлсэн. Уг бичлэгт Д.Энхбат байн байн “... тагнуулынхан намайг Зоригийн хэрэгт хүчээр холбогдуулаад надаар дамжуулан Ч.Энхтайван, тэгээд М.Энхсайхан нарыг энэ хэргийг захиалсан болгуулаад улмаар Ардчилсан намыг сонгуульд унагах гээд байна” гэж байв. Үүнээс үзэхэд Л.Санжаасүрэн Д.Энхбатаар чухам энэ үгийг хэлүүлэх нь түүний өмгөөллийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг байсан гэж ойлгогдохоор байна. Харин энэ бүхний хариуд ТЕГ-аас манай ажилтнууд “С.Зоригийн хэрэгт ахиц гаргахаар ажиллаж байгаа. Гэтэл Ардчилсан намын удирдлагууд, өмгөөлөгч Санжаасүрэн гэх мэт хүмүүс саад хийгээд байна” гэсэн утга агуулгатай мэдэгдэл хийсэн. Аль аль нь л ноцтой гэмээр мэдэгдлүүд. Үнэхээр л мөрдөгчид С.Зоригийн хэргийг шалгах явцдаа амжилт олж, гэмт хэрэгтнийг барих гэхээр улс төрчид, элдэв хүний эрхийг хамгаалагчид гарч ирээд саад хийгээд байгаа бол муу л хэрэг. Харин Д.Энхбатын ярьсан хэлсэн шиг хүчний байгууллагынхан өөрсдийн гарын дор орсон хүнээр зохиомол мэдүүлэг гаргуулж, түүнийгээ улс төрийн зорилгоор ашиглах гэж байгаа бол бүр ч муу хэрэг болох юм. Юутай ч одоогоор сонгуулийн өмнө Ардчилсан намын дарга М.Энхсайханыг С.Зоригийн хэрэгт барих юм гэнэ гэсэн цуу яриа үнэмшилтэй нь аргагүй дэлгэрчихээд явж байна. Дээрх шил шилээ даран хөврөх адал явдлуудаас харахад нэг бол хүчний байгууллагынхан үнэхээр Зоригийн хэргийн учгийг атгаад авсан эсвэл уг хэрэгт ямар нэг хүчилсэн, зохиомол элемент оруулснаар сонгуулийн өмнө сөрөг хүчний удирдагчдын нэр хүндийг унагах гэж байна гэж үзэж болохоор байна. Сонгуулийн өмнө хэн нэг улс төрчийг Зоригийн хэрэгт хамаатуулан барьж хорих зэргээр авирлаж байгаад сонгууль өнгөрсний дараа уг хэрэг яасан нь мэдэгдэхгүй замхраад алга болчихдог явдал урьд гарч байсан. Тухайлбал, Э.Бат-Үүлийг барьж хориод дараагаар нь тавиад явуулчихсан. Юу болсон тухай мөрдөн байцаалтын нууц гээд цагдаа ч, Бат-Үүл ч ганц ч үг дуугараагүй. Үр дүнд нь хүмүүсийн нэлээд хэсэг нь Бат-Үүлийн талаар таагүй ойлголттой хоцорсноор барахгүй, уран бүтээлчид үүнийг нь шүүрэн авч уран сайхны кино хүртэл хийгээд 2004 оны сонгуулийн өмнө ард түмэндээ бэлэг барьж байна. Энэ бүхний дүнд Э.Бат-Үүл хувь хүнийхээ болон нэртэй улс төрчийн хувьд ихээхэн хохирсон. Хэрэв С.Зоригийн хэргийг мөрдөх ажиллагаа Э.Бат-Үүлд тохиолдсон шиг байдлаар одоо М.Энхсайхан дээр ирэх гэж байгаа бол Ардчилсан нам, М.Энхсайхан, Л.Санжаасүрэн нарын зүгээс Д.Энхбатын хэргийг улс төржүүлж байгаа нь юуны буруу байх билээ. Хүн нэр төрөө тухайн нөхцөл байдалд тохирсон арга хэлбэрээр л хамгаална шүү дээ.

1.6. ГАДААД ОРНЫ НУУЦЫН ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийг ардчилалд шилжилтийн үеийн болон бусад орны ижил төстэй хуультай харьцуулан судлав.

Үүнд: 1.ОХУ, 2.Киргизийн БНУ, 3.Таджикстан, 4.Туркменстан, 5.Украин, 6.Гүрж, 7.Казакстан, 8.Солонгос, 9.ИБУИНВУ, 10.ХБНГУ зэрэг улсыг хамруулав.

Судалгааны энэ хэсэгт дараах асуудлыг онцгойлон анхаарч дүгнэлт, харьцуулалт хийлээ. Үүнд:

- Төрийн нууц /Улсын нууц/-ын тодорхойлолт
- Нууцын хамрах хүрээ
- Нууцлах хугацаа
- Нууцлалыг ил болгох
- Нууцыг тогтоох субъект г.м

Төрийн нууцыг тодорхойлсон байдал

Судалгаанд хамрагдсан улсуудаас Туркменстан, Украин, Киргиз, Гүрж, Казакстан зэрэг улс нь төрийн нууцыг тодорхойлсон бөгөөд гол томъёолол нь зөвхөн мэдээлэл гэснээрээ манай хуулиас ялгаатай байна. Туркменстан, Киргиз, Казакстаны хуульд төрийн нууцын жагсаалтад орсон мэдээлэл нь нууц гэсэн бол Украин, Гүржийн хуульд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах мэдээлэл гэж нарийвчилсан байна.

Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийн 3-р зүйлд "Төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийн томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа **мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ**" гэж тодорхойлсон. Энэ нь мэдээлэл төдийгүй баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хүртэл төрийн нууцад хамаарах бөгөөд дээрх хүрээ нь бусад орны хуулийн хамрах хүрээнээс өргөн байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалтын тухай хуулийн хамрах цар хүрээ маш өргөн. Бараг бүх зүйлийг "төрийн нууц" гэсэн ангилалд хамруулсан.

ОХУ, Украин, Туркменстан, Таджикстаны хуулийг харьцуулан үзэхэд бүтцийн хувьд ижил төстэй байсан ба агуулгын хувьд ОХУ, Украин, Таджикстаны хуульд нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг шууд тогтоож өгсөн байна. Харин Туркменстан, Киргизийн хууль нь нилээн ерөнхий заалтуудтай байсан болно. Украин, Гүржийн хууль нь илүү их дэлгэрэнгүй нэр томъёоны тайлбарыг нарийвчлан гаргасан, нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах гэх мэт технологийн үе шатны зохицуулалтын журмыг тодорхой тусгаж оруулснаараа онцлогтой байна.

Төрийн нууцын хамрах хүрээ

Төрийн нууцын хамрах хүрээг ОХУ, Украин, Гүрж улсад нийтлэг байдлаар:

- батлан хамгаалах /цэргийн/ салбар
- шинжлэх ухаан, техник, эдийн засгийн салбар
- эдийн засаг, улс төрийн гадаад харилцаанд тагнуул, сөрөг тагнуул, эрэн сурвалжлах үйл ажиллагаа гэж байгаа бөгөөд энэ нь Монгол улсын төрийн нууцын хүрээг томъёолсонтой нэлээд төсөөтэй боловч Украин, Монгол улсын хуулинд “үндэсний аюулгүй байдал” гэж тусгайлан оруулсан байна.

Дээр дурьдсан хүрээ тус бүрт хамаарах мэдээллийг Гүрж болон Монгол улсын хуульд тусгайлан оруулсан нь зарим талаар хууль зүйн ойлголт, нэр томъёогоо тодорхойлоогүй, тодорхой болгоогүйгээс манай нууцын хуулиуд хэт ерөнхий, зөрчилдөөнтэй байгаа байдал харагдаж байв.

Манай хуулиар масштабаас хамаараад газрын зураг бүгд нууцад хамаарахаар байхад, Казахстан, Тажикстан болон Украины хууль тогтоомжинд газрын зургийн нууцлалтай холбоотой заалтууд орсон байх бөгөөд гэвч энэ нь зөвхөн цэрэг, дайны зориулалтаар ашиглах тохиолдол буюу эсвэл эдийн засгийн мэдээлэл агуулсан үед (Казахстан, Тажикстан) газрын зургийн өгөгдлүүдийг нууцалсан байдаг. Бусад орнуудын хууль тогтоомжид газрын зургийн нууцлалтай холбоотой заалтууд ороогүй байна. Харин ч төрийн нууцын тухай Гүржийн хуулинд “цэргийн зориулалттай тусгай газрын зургаас бусад” газрын зургийг нууцад ангилахыг хориглосон (8.3 зүйл) байна.

Тагнуул болон сөрөг тагнуулын нууцлалын үйл ажиллагаатай холбоотой Төрийн нууцын жагсаалтын 4 зүйл (39, 40 ба ялангуяа 43 заалтууд)-ийг төрийн хэлмэгдүүлэлтийн ангилалд хамаарах өөрийн орны иргэдийн эсрэг болон хүний эрхийг хөсөрдүүлэхэд хэрэглэж болохгүйг анхааруулсан заалт дагалдах хэрэгтэй.

19-р зүйл байгууллагын “Үндэсний аюулгүй байдал, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл хүртэх тухай Йоханнесбургийн зарчим”-ын 1-д “Үндэсний аюулгүй байдал, хувь хүний нууц болон бусад ашиг сонирхлын үүднээс мэдээллийн чөлөөтэй урсгалыг олон улсын эрх зүйн дагуу хязгаарлаж болно.⁶ Гэхдээ үндэсний аюулгүй байдлыг эрх бүхий байгууллагаас өргөн хүрээнд буруу ашиглаж ирсэн түүхтэй. Иймд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон мэдээллийн эрх чөлөөг хангахын тулд үндэсний аюулгүй байдлын хүрээг тодорхой, явцуу хүрээнд тодорхойлвол зохино. Эдгээр зарчмууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг үндэсний аюулгүй байдлын үүднээс дараах нөхцөлд хязгаарлаж болно гэж заасан. Хэрэв энэ нь "тухайн улс оршин тогтноход эсхүл газар нутагт нь хүч хэрэглэхээр заналхийлэхэд болон тэр заналхийлэлд хариу цохилт өгөхөд" нөлөөлж байгаа бол⁷. Үндэсний аюулгүй байдалд учруулах хохирол болон бусад хууль ёсны зорилго олон нийтийн мэдээлэлтэй байх зорилгоос давамгайлснаас бусад тохиолдолд мэдээллийг нээлттэй болгох нь зүйтэй. Учир нь олон нийтийн ашиг сонирхол байнга давамгайлдаг.⁸ Үндэсний аюулгүй байдалд хохирол учрах нь тодорхой байсан ч олон нийтэд мэдээллийг нээх нь илүү үр ашигтай байвал мэдээллийг задална. Ийм тохиолдолд үндэсний аюулгүй байдалд учрах

6 Article 19 Йоханнесбургийн зарчим: Үндэсний аюулгүй байдал, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон мэдээлэл хүртэх тухай /Лондон1995 он, 10 дугаар сар / Зарчим 1с, Обзёрвер ба гиадан болон Англи хоорондох маргааныг үз. 1998 оны 6 дугаар сарын 9 , Өргөдлийн дугаар 22678/93 /Хүний эрхийн Европын шүүх/

7 Ibid., зарчим 2/a/.

8 Олон нийтийн мэдэх эрх, тэмдэглэл 78, зарчим 4

хохирлыг мэдээлэлтэй байх олон нийтийн ашиг сонирхолтой харьцуулан жигнэж үзвэл зохино.

Монголын Төрийн нууцын хуулийн 5 дугаар зүйлийн ихэнх заалт нь их өргөн утгатай. Зохисгүй нууцын зарим жишээг дор дурьдвал:

- жил тутам цэрэгт элсүүлдэг хүмүүсийн тоо /5.2.7./
- улсын нөөцийн хэмжээ /5.3.2./
- цаазаар авах ялыг гүйцэтгэх журам /5.5/

Ийм мэдээллийг ихэнх ардчилсан оронд олж үзэх боломжтой байдаг бөгөөд Монгол Улсад үүнийг төрийн нууцад хамруулах үндэслэлийг олоход төвөгтэй. Ихэнх тохиолдолд эдгээр мэдээллийг нээлттэй болгох олон шалтгаан байдаг. Жишээ нь, улсын нөөцийн тухай мэдээллийг задлах нь эдийн засгийн хөгжилд тустай байж болно. Дүгнэж хэлэхэд, төрөөс мэдээлэл нууцлах зарим шалтгааныг тогтоосон ч гэсэн олон нийтийн аливаа зүйлийг мэдэх ашиг сонирхол байнга давамгайлдаг.

Төрийн нууцын тухай хуульд хохирол учрах болон олон нийтийн ашиг сонирхол давамгайлах 2 шалгуур хоёул байхгүй байна.

Нууцалж болохгүй мэдээллийн хүрээ

Төрийн нууцын тухай Монгол, Тажикстан улсын хуулинд юуг төрийн нууц гэж үзэх ёсгүйг ангилан ялгасан заалт ороогүй байна. Энэхүү судалгааг явуулах үүднээс хянан үзсэн бусад орны ижил төстэй хуулиудаас харья.

Төрийн нууцын тухай Оросын Холбооны Улсын хуулинд үүн дээр нэмэлт болгосон хоёр чухал заалт орсон байдаг (7 зүйл), алт болон бэлэн мөнгөний нөөц (1), төрийн өндөр, дээд тушаалын албан хаагчдын эрүүл мэндийн байдлыг төрийн нууц гэж үзэх ёсгүй гэж заажээ. Оросын Нууцын хуульд:

- Онц байдал, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулах үйл явдлууд, байгалийн гамшиг, тэдгээрийн талаарх урьдчилсан мэдээлэл
- Хүрээлэн байгаа орчин, эрүүл мэнд, эрүүл ахуй, боловсрол, соёл, хөдөө аж ахуйн байдал, түүнчлэн гэмт хэргийн нөхцөл байдал
- Онцгой эрх, төрөөс иргэд, албан хаагч, байгууллага, аж ахуйн нэгжид олгож буй хөнгөлөлт, нөхөн төлбөр
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа тухай баримт
- ОХУ-ын валютын нөөц, алтны нөөцийн хэмжээ
- Төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндийн байдал
- Төрийн байгууллага, түүний албан тушаалтны хууль бус үйлдлийн тухай мэдээллийг нууцалж болохгүй гэжээ.

Киргиз, Украин зэрэг улсын хуулиудад мөн ийм төсөөтэй заалтууд оржээ.

Туркменстанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, түүнчлэн хувь хүний аюулгүй байдал, эрүүл мэндэд нь аюул учруулж болох мэдээллийг нууцад хамааруулж болохгүй гэж хуульчилсан байна.

Орос, Туркменстаны хуулиар иймэрхүү төрлийн мэдээллийг төрийн нууц гэж үзсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр тусгасан байгаа нь хэрэгжилтийг нэлээд өндөрсгөж байгааг харуулж байна.

Казакстаны хуульд Төрийн албан тушаалтан, агентлагийн хууль бус үйл ажиллагаа буюу зүй бус үйлдэл, шударга ёсыг зөрчсөнийг нуун дарагдуулсан мэдээллийг нууцлахыг хориглосон байдаг бол Монгол Улсад иймэрхүү төрлийн бүх материал төрийн нууцад хамаарч, халхавч маягаар хэрэглэгддэг.

Гүржид олон улсын гэрээ хэлэлцээр, мөн байлдааны зориулалттай тусгай газрын зургаас бусад газрын зургийг төрийн нууцад хамааруулж болохгүйг заасан нэмэлт заалт оржээ. Монголд 1:100000 нарийвчлалтай газрын зургийг байнга нууцлах төрийн нууц гэж үздэг ба яамд, засгийн газрын агентлагууд мэдээлэл түгээхийг зааварчилсан дотоод журмаа мөн гол төлөв төрийн нууцад хамааруулсан байдаг.

Гүржид мөн Төрийн өндөр дээд албан тушаалтны эрүүл мэндийн байдал, авилга, албан тушаалтнуудын хууль бус үйлдэл, гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг нууцалж болохгүй гэжээ.

Германд Мэдээллийн эрхчлөөний хуулиараа гол зохицуулалтаа хийгээд, хариуцлага хэсгээ Эрүүгийн хуулинд суулгаж өгсөн нь дэвшилттэй буюу аль болох нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй нь харагдаж байна.

ХБНГУ-ын эрүүгийн хуулиар “Бие даасан, ардчилсан үндсэн хуулийн журам болон олон улсын зэвсэгт хяналт тавих гэрээг зөрчсөн Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай гэрээ хэлэлцээр байгуулсан талуудаас нуун дарагдуулсан баримтуудыг төрийн нууцад хамааруулахгүй” гэж хуульчилсан нь нэлээд онцлог бөгөөд дэвшилттэй зохицуулалт болж байна.

Германы Мэдээллийн эрх чөлөөний хуульд задалж болохгүй мэдээллийн хүрээг заасан байдаг. Үүнд:

1. Хэрэв мэдээллийг задалсан нөхцөлд олон улсын харилцаа, Германы Зэвсэгт хүчний цэргийн аюулгүй байдал, дотоодын болон гадаадын аюулгүй байдлын сонирхол, санхүүгийн монополийн эсрэг болон журамлах эрх бүхий газрын хяналт тавих үүрэг, гадаад санхүүгийн хяналтын асуудал, хууль бус гадаад худалдаанаас урьдчилан сэргийлэх гэсэн арга хэмжээ, одоо явагдаж буй хууль эрх зүйн үйл явц, хүн бүр шударга хуулийн үйлчилгээ авах эрх, ба эрүүгийн, засаг захиргааны болон сахилга батын холбогдолтой мөрдөн байцаалтын үйл ажиллагаа зэрэгт хохирол учрахаар байвал.

2. Хэрэв мэдээллийг бусдад задруулснаар олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах бол

3. Хэрэв Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд нууцлах шаардлага тавьсан бол эсвэл Агентлагт итгэх итгэл буурах бол

4. Хэрэв тухайн мэдээлэл нь хуулийн зохицуулалтын эсвэл Ангилсан Мэдээллийн талаарх Материалын болон Байгууллагын Хамгаалалтын Ерөнхий Захиргааны Зохицуулалтын дагуу нууцад хамаарах эсвэл мэргэжлийн холбогдолтой болон тусгай албан ёсны нууцад хамаарах

5. өөр төрийн байгууллагаас нэг удаа өөрсдийн үйл ажиллагаанаас гадуур мэдээлэл өгөхийг шаардах

6. Хэрэв мэдээллийг задалснаар нийгмийн даатгалын институтын эдийн засгийн сонирхол болон эдийн засгийн ажил хэрэгт холбогдох холбооны засгийн газрын санхүүгийн сонирхлыг хөндөх бол

7. Нууц мэдээлэл авах, хүртэх гэсэн санал тавьж цуглуулсан үед гуравдагч талын нууцлалыг хадгалах сонирхол нь хүчин төгөлдөр байсан тохиолдолд

8. Холбооны Засгийн Газрын Тагнуулын газар, агентлагууд болон бусад төрийн агентлагууд Германы Аюулгүй Байдлын Актын 10 (3)-р зүйлд заасны дагуу гүйцэтгэж байгаа бол

Дээр дурьдсанаас бусад бүх мэдээлэл нээлттэй, ил тод байдаг байна.

ОХУ, Туркменстан, Киргиз, Гүрж, Казакстаны хуулиудад нууцалж болохгүй мэдээллийн хүрээг тодорхойлсон нь, Украин, Казакстан улсын хуулиудад нууцад хамаарах мэдээлэл олж авах хүсэлт гаргах, нууц мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан нь манайд жишиг болохоор байна.

Нууцлах хугацаа

Судалгаанд хамрагдсан улс орнуудын нууцын хуулиудыг аваад үзэхэд нууцлах хугацаа гэж хатуу тогтоогоогүй хуультай улс нь ОХУ, Туркменстан, Казакстан зэрэг байгаа бөгөөд эдгээр улсын хуулийн дэвшилттэй заалт нь 5 жил тутамд нууцад хамаарах эсэхийг шалгаж, зэрэглэлийг хянаж, шаардлагагүй гэж үзвэл ил болгодог байна. Харин Украин, Гүрж зэрэг улсад нууцлах хугацааг зэрэглэлээс хамааруулан Украинд 30 жилээс хэтрэхгүйгээр, Гүржид 20 жилээс ихгүй байхаар хуульчилсан байхад Монгол Улсад 60 хүртэл жил буюу бусад орноос 2-3 дахин урт хугацаагаар, зарим категорийг байнгын нууц гэж “хар авдар”-т хийжээ.

Нууцлалын хүрээнд Монголын хууль тогтоомжийг бусад орнуудын хуультай харьцуулж үзвэл ихэнх орнуудад нууцлах баримт бичгийн хугацааг Төрийн нууцын жагсаалтаар бус харин Төрийн Нууцын тухай хуулиндаа тодорхойлдог зүй тогтлын ялгаа харагдаж байгаа юм. Гэсэн мөртөө Төрийн нууцын тухай Монголын хуулинд өөрт нь, төрийн нууцын ангиллын талаар заалт ороогүй байна.

Төрийн нууцын тухай Монголын хуулинд ангиллын хугацааны заалт ороогүй байдаг нь Киргизстан болон Туркменстаны ижил төстэй хуультай адил байгаа юм.

Казахстанд баримт бичгийг нууцлах хугацааны хязгаар 30 жилээс хэтрэхгүй. (20.3 зүйл).

Гүржид: тусгайлан хөтөлсөн онц чухал баримт бичгийг 20 жил, маш нууц баримт бичгийг 10 жил, нууц баримт бичгийг 5 жил нууцлахаар заасан. (14.1 зүйл).

Орос улс бусад ихэнх оронд хэвшиж тогтсон нууцлалын 30 жилийн хугацааг баримталдаг. Үүнээс харахад Орос Монголын харилцаатай холбоотой баримт мэдээллийг одоо Оросын архиваас нээлттэй үзэж болох болсон бөгөөд харин Монголд төрийн нууц хэвээр байгаа юм (13-р зүйл).

Таджикстаны нууцын систем маш эдрээтэй 7 төрлийн нууцлалын хугацаа заасан байдаг ч (гэхдээ л Монголын 10 заалтыг бодвол арай цөөн). Монголоос гадна зөвхөн Тажикстан улс л баримт бичгийг тодорхойгүй хугацаанд нууцлахыг нээлттэй зөвшөөрдөг бөгөөд (10.1 зүйлээр).

Украины хуулиар тусгайлан хөтөлсөн баримт бичгийн нууцын ангиллын хугацаа 30 жил, (маш нууц) 10 жил, (нууц) 5 жил хүртэл байхаар заажээ (13-р зүйл).

Гүржид онц чухал нууцын ангиллын хугацаа 30 жил, маш нууц 10 жил, нууц 5 жилээс хэтрэхгүй байхаар хуульчилсан.

Ихэнх орнуудын тухайлбал, Казахстан, Туркменстан зэрэг улсын хууль тогтоомжийн давуу тал нь ангиллын хугацааг албан ёсоор тавихаас зайлсхийж, “төр болон ард түмний ашиг сонирхол” эсвэл “онцгой нөхцөлд” л байнга нууцлахыг зөвшөөрсөн байх

бөгөөд харин бусад орнуудын хууль тогтоомж нь нууцын ангиллын хугацаа дууссаны дараа нээлттэй болгох зарчим баримталдаг аж.

Бусад улсын хуулинд нууцын хугацааг (30-аас ихгүй жил) шууд зааж өгсөн байх, нууцыг ил болгох үндэслэл, журмыг нарийвчлан заасан байх гэх мэт зохицуулалтыг хийжээ. Мөн нэг нийтлэг зүйл нь аливаа мэдээллийг нууцад хамааруулах нь буруу, шаардлагагүй, хүний эрхийг зөрчиж байна гэж үзвэл иргэд шүүхэд хандан шийдвэрлүүлэхээр зохицуулалт хийжээ.

Нууцлах хугацаа нь дуусгавар болмогц уг мэдээллийг нууц бус болгодог байх зохицуулалт байна. Нууцын зэрэглэлд хамааруулсан мэдээллийг ил болгох процесс нь хагас автомат Барууны ихэнх орнуудад хэрэглэдэг хуультай төстэй хуулийг Монгол улс батлах нь зүйтэй юм. Маш чухал тоо баримт дурдагдаагүй тохиолдолд хэсэг хугацаа өнгөрсний дараа засгийн газрын баримт бичгүүдийн нууцын зэрэглэл автоматаар цуцлагдах болно. Онцгой тохиолдолд асуудлыг хянуулахаар Үндэсний Аюулгүйн Зөвлөлд хүргүүлэх ба Улсын Их Хурал эцсийн шийдвэрийг гаргана. Энэхүү процедур нууцын ангиллын хугацаа дууссан мэдээллийг нууцлах гэсэн засгийн газрын оролдлогыг мухардалд оруулж чадах юм. ОХУ, Туркменстан, Казакстан зэрэг улсын хуулиадад байгаа шиг тодорхой (3-5 жил тутам) хугацаанд нууцынхаа хүрээ, жагсаалтыг эргэн харж, нягталдаг байхаар хуульчлах нь зүйтэй юм.

Нууцыг ил болгох

Гүрж, ОХУ-д төрийн нууцыг ил болгох үндэслэлийг тогтоосон байна. Үүнд:

- олон улсын нөхцөл байдлын улмаас тухайн мэдээллийг ил болгохоор үүрэг хүлээсэн
- тухайн мэдээллийг нууцлах шаардлагагүй болсон
- тогтоосон хугацаа дуусгавар болсон

Монгол Улсад нууцын ангилалд хамаарах мэдээллийг ил болгох талаар Төрийн нууцын тухай Монгол Улсын хуулинд:

- цаашид нууцлах шаардлагагүй гэж үзэх нөхцөл байдал шинээр үүсэх
- ангиллын нууцлах хугацаа дуусах
- бусад үндэслэл гэж тодорхойлжээ.

Нууцын зэрэглэлд хамааруулсан мэдээллийг ил болгох ажиллагааг засгийн газрын эрх мэдэлтнүүдэд хариуцуулваас (ялангуяа Улсыг аюулаас хамгаалах байгууллага) ямар ч баримт бичгийг нийтэд нээдэггүй гэдгийг бусад орны туршлага харуулж байна. Улсыг аюулаас хамгаалах байгууллага нь угаасаа нууцыг хамгаалах нэрийн дор хүнд суртал гарган байнга нууцлахыг боддог юм.

Монгол Улсад Төрийн нууцын хуулиар нууцад хамаарах мэдээллийг хайж олох нь хариуцлага хүлээх үйлдэл байдаг бол Украин, Казакстан улсын хуулиудад нууцад хамаарах мэдээлэл олж авах хүсэлт гаргах, нууц мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулсан нь эх сурвалжтай холбоотой аливаа хэрэг маргаан дээр шүүх хуралдаан дээр үр дүнтэй ашиглагдаж болох ач холбогдол бүхий зохицуулалт гэж үзэж байна. Учир нь манайд авилга, ялангуяа төрийн нууцтай холбоотой хэргийн нотлох баримт “хар авдар”-наас гарч ирж, үнэн мөнийг тогтоож чадахгүй байгаа практикийг өөрчлөхөд чухал нь харагдаж байна.

1.7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг эрх зүйн зарчим, онол, практик, орчин үеийн чиг хандлагатай нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Үүнд:

1. Төрийн нууцын хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчим бодит утгаараа хэрэгжихгүй байна, өөрөөр хэлбэл, төрийн нууцыг тогтоохдоо хууль тогтоомжид нийцсэн, цаг үеэ олсон байж чадахгүй байна.

2. Монгол Улсын Төрийн нууцын болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Архивын тухай хуульд орсон зарим хуулийн нэр томъёо, ойлголт нь тодорхой тайлбар байхгүй байгаа нь зөв ойлгох, хэрэглэхэд эргэлзээтэй байна. Тухайлбал, “нууцлал зохих хэсэг”, “үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс төрийн нууцыг яаралтай ил болгох шаардлага”, “нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцлах шаардлагагүй болсон”, “задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээлэл”, “нууцлах хугацаа дуусгавар болсон”, “үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримт” зэрэг болно. Эдгээр ойлголт, нэр томъёог тайлбарлах шаардлагатай юм. Төрийн нууцын хуулин дахь зарим зохимжгүй утгыг боловсронгуй болгох хэрэгтэй. Тухайлбал, Төрийн нууцыг нууцлах. Мөн Төрийн нууцыг ил болгох гэсэн зүйлийн “нууцлах хугацаа дуусгавар болсон”, “хуульд заасан бусад үндэслэл” гэсэн үндэслэлүүд, “яаралтай ил болгох шаардлага гарсан онцгой тохиолдолд” зэрэг нь тодорхойгүй байна.

3. Төрийн нууцтай холбоотой 41 хуулийг судалж үзэхэд “улсын нууц”, “төрийн нууц” гэж ялгаатай байдлаар томъёолж заасныг нэг мөр болгож, “төрийн нууц” гэж хэвшүүлэх хэрэгтэй.

4. Төрийн нууцын болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар төрийн нууцад хамааруулж байгаа мэдээлэл нь зайлшгүй нууцлах шаардлагатай мэдээлэл байх ёстой ч хуулийн хэт ерөнхий зохицуулалтаас болж төрийн нууцад хамааруулах шаардлагагүй мэдээлэл ч “хар авдарт” орж байгаа юм. Үндэсний аюулгүй байдалд буюу төрийн нууцад хамааруулах шаардлагагүй, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй мэдээллийг төрийн нууцад хамааруулах нь мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа нэг хэлбэр мөн. Иймд мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур үзүүлэлтийг хуульчлах хэрэгтэй юм.

5. Төрийн нууцад хамаарахгүй боловч чухал гэж үзсэн мэдээллийг нууцлах сонирхол, хандлага, төрийн байгууллагуудад хүчтэй хэвээр байгаа нь мэдээлэл олж авах эрхийг хязгаарлаж буй хамгийн гол шалтгаан юм. Энэ нь төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар тогтоосон нууцын жагсаалт, нууцад хамаарах мэдээллийн хүрээ хэт өргөн, ерөнхий байгаатай холбоотой бөгөөд төрийн албан хаагчид ямар ч мэдээллийг төрийн нууц гэж өгөхгүй байх боломжийг бүрдүүлж байгаа болно. Иймд төрийн нууцын жагсаалтыг нарийн, тодорхой болгож, Төрийн нууцад хамаарахгүй мэдээ, баримт бичиг, эд зүйл, үйл ажиллагааг нэрлэн зааж өгөх нь зүйтэй. Ингэснээр төрийн нууцын өргөн хүрээлэлд аливаа мэдээг хамруулж ойлгох гэсэн эрх бүхий албан тушаалтны хууль бус ажиллагааг хязгаарлахад дөхөмтэй байна.

6. Төрийн нууцын тухай хуульд нууцад хамааруулах хүрээг таван бүлэгт ангилсан байх бөгөөд Төрийн нууцын жагсаалтын хуулинд энэхүү ангиллыг дахин давтаж, дэлгэрүүлсэн нь ач холбогдолгүй болжээ. Иймд Төрийн нууцын тухай хуульд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар ангиллыг тогтоохоор зааж, энэхүү хэсгийг хасах

нь утга агуулга давхцах, хоёрдмол утга гарах явдлаас зайлсхийхэд тустай юм. Хоёр хуулийн уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй.

7. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулинд нийт 13 нууцын төрөлд “байнга” гэсэн хугацаа тогтоосны үндэслэл нь харагдахгүй байна. Нууцалсан зэрэглэлээр гэж нууцын зэрэглэлийг тогтоочихоод нууцлах хугацааг байнга гэсэн нь тохиромжгүй байна. Онц чухал-маш нууц, маш нууц зэрэг нууцын зэрэглэлд хамаарахгүй нууц зэрэглэл бүхий мэдээллийг байнга хугацаагаар нууцалдаг явдлыг зогсоох хэрэгтэй.

8. Нууцлах хугацаа хэзээ дуусч байгаа нь тодорхойгүй, 1995 оны төрийн нууцын хууль, 2004 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиас өмнөх хугацаанд нууцлагдсан төрийн нууцын хувьд ямар хууль үйлчлэх нь тодорхойгүй байгаад зохицуулж, ямар мэдээлэл нь хэзээнээс хэдий хүртэл нууцлахыг иргэд мэдэх боломж нь чөлөөтэй байх ёстой. Нууцлах хугацаа 60 жил, байнга гэж хэт урт байгааг багасгаж, 30 жилээс ихгүй байхаар тогтоох зохимжтой. Төрийн нууцыг цаашид нууц хэвээр байлгах эсэх асуудлыг 5 жил тутамд хянаж, шинэчилдэг механизм тогтоох чухал байна.

9. Төрийн нууцын хуулийн 5 дугаар зүйлд хохирол учирсны шалгуур болон олон нийтийн ашиг сонирхол давамгайлах гэсэн шалгуур алга байна. Нууцын зэрэглэлийг хохирлын хэмжээгээр шалгуур болгон онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэж ангилсан боловч үүний үр дагавар буюу ач холбогдол нь тодорхой бус байна. Жил тутмын цэргийн дайчилгааны тоо, цаазаар авах ялыг гүйцэтгэх журмыг төрийн нууцын жагсаалтаас хасах, байр зүйн зураг гэдгийг цэргийн байр зүйн зураг болгон тодотгож өгөх.

10. Архивын байгууллага гэдэг бол улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, танин мэдэхүйн зорилгод ашиглах архивын баримтыг хүлээж авах, хадгалах, хамгаалах, зориулалтын дагуу ашиглуулах үүрэг бүхий байгууллага байдаг. Төрийн нууцад хамаарахгүй буюу төрийн нууцын жагсаалтаас хасагдсан баримтыг ашиглахад архивын хуулиар цаг хугацааны хувьд хязгаарлалт тогтоож байгаа нь төр, байгууллага, хувийн нууцад хамаарахгүй мэдээллийг хайх, олж авах иргэний эрхэд нийцэхгүй байна. Архивын тухай хуульд заасан “үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримт” гэдгийг хэрхэн ойлгохыг тайлбарлах, давхардал, хийдлийг халах нь зүйтэй. Төрийн нууцын тухай хууль тогтоомжоор нууцлаагүй бол энэ төрлийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байх ёстой бөгөөд цаг хугацааны хувьд ашиглахад хязгаарлалт тогтоож байгааг зохицуулах нь чухал болно.

11. Төрийн нууцыг задруулсан бол Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын хуульд заасан хариуцлагыг хүлээлгэж, гэм буруутай этгээдийг цээрлүүлэх ёстой ч энэ нь хэт ерөнхий байдалтай болжээ. Иймд хариуцлагын хэмжээг нууцлалын зэрэглэл, хор уршиг, шалгуур зэргээр ангилж, ялгавартай тогтоох нь урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр дүнтэй механизм болно.

12. Нууц гэдгээр халхавчлан зөрчил дутагдлыг нуун дарагдуулах нь улс орны эрх ашигт харш гэж үзвэл иргэн, байгууллага гомдол хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх эрхийг хуульчилж өгөх нь маш чухал баталгаажуулалт болно.

1.8. Хавсралтууд

Хавсралт №1

Өмнөд Солонгос БНУлс

Өмнөд Солонгост төрийн нууцтай холбоотой асуудлыг зохицуулдаг хоёр үндсэн хууль байх бөгөөд 1/ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2/ Төрийн байгууллагад байгаа мэдээллийг задруулах талаарх хууль байна. Үндэсний аюулгүй байдлын хууль нь 1948 онд анх батлагдсан бөгөөд түүнээс хойш хэд хэдэн удаа хянагдсан байна. Үндэсний аюулгүй байдлын хуулийн 3, 4 дүгээр зүйл нь “тагнуул”, “төрийн эсрэг” үйл ажиллагаа явуулах гэмт хэрэгт удаан хугацаагаар шоронд хорих, цаазаар авах ял оноохоор заасан, гэхдээ эдгээр нэр томъёо нь хуулиндаа маш бүдэг тодорхойлогддог, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө ямар нэг зөрчил гаргалгүйгээр хэрэгжүүлснийхээ төлөө хүмүүс ихэвчлэн хорих ял авдаг байна. Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу “төрийн эсрэг” байгууллага гэдэг нь “тушаал гаргах, хяналт тавих бүтэцтэй, засгийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой эсвэл төрийн үйл ажиллагаанд саад болохоор байгуулагдсан Солонгосын БНУ-ын гадна болон дотор байгуулагдсан нэгдэл, бүлэг” гэж тодорхойгддог. Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу Хойд Солонгос нь улс гэгдэхээсээ илүү “төрийн эсрэг” байгууллага гэж тодорхойлогддог. “Төрийн нууц”-ын тодорхойлолт нь маш бүрхэг, ихэнх тохиолдолд Өмнөд Солонгост олон нийтэд авч болох мэдээллийг оруулдаг.

Эмнести Интернэшнл байгууллагаас Өмнөд Солонгосын Үндэсний аюулгүй байдлын хуулин дахь үндэсний аюулгүй байдлыг дэмжих засгийн газрын хэрэгцээ, шаардлагыг ойлгож байгаа боловч олон улсын хүний эрхийн стандартын дагуу хуулиндаа нэмэлт оруулж, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нь хамгаалахыг уриалж байна.

Төрийн байгууллагад байгаа Мэдээллийг задруулах талаарх хууль нь 1996 онд батлагдаж, 1998 оны 1 дүгээр сард хүчин төгөлдөр болсон. Энэ хууль нь иргэдийг төрийн байгууллагад байгаа мэдээллийг авах хүсэлт гаргахыг зөвшөөрөх хууль зүйн баталгаа нь болж өгдөг.

Энэхүү Хуулийн хүрээ нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой байгууллагын олж цуглуулсан, бий болгосон мэдээлэлд хамаарахгүй. Үүнд 8 төрлийн ангилал байдаг: бусад актаар тодорхойлсон нууцууд; үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, дипломат харилцаанд хохирол учруулж болох мэдээлэл; хувь хүн, өмч, олон нийтийн аюулгүй байдалд бодит гэм хор учруулж мэдэх мэдээлэл; гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах талаарх мэдээлэл; аудит, хяналт шалгалтын мэдээлэл гэх мэт засгийн газрын байгууллагын ажиллагаанд бодит бэрхшээл саад учруулж болох мэдээлэл, хувь хүний талаарх хувийн мэдээлэл, худалдааны болон олон нийтийн ашиг сонирхолд бодит хохирол учруулж болох худалдааны нууцууд, үл хөдлөх хөрөнгийн наймаа, бараа хураах зэрэг задруулбал хувь хүнд бодит хохирол учруулж болох мэдээлэл орно.

Агентлагууд нь мэдээллийг задруулах эсэхийг тодорхойлох, мэдээллийг задруулах асуудлыг хэлэлцэх хороог байгуулах ёстой. Төрийн байгууллагын задруулахыг хориглосон мэдээллийнх нь төлөө иргэд давж заалдаж болно.

Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө

Ихэнхи улс төрийн хэлэлцүүлгүүд хязгаарлагдаагүй байхад Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу Засгийн газар, эрх мэдэлтний Коммунист, эсвэл Хойд Солонгосын талаарх үзэл санааг илэрхийлэхийг хязгаарладаг.

Хэдийгээр Засгийн газар хэвлэл, мэдээлэлд шууд хяналт тавихгүй ч гэсэн шууд бус нөлөөлөл тавих нь үргэлжилсээр л байна. Зарим албан тушаалтнууд сэтгүүлчдийг Засгийн газрыг шүүмжлэн бичихийг хориглож, түрэмгийгээр байнга лоббидож байна.

Өмнөд солонгосын жишиг хэрэг

Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу үүссэн шударга бус явдал: Профессор Парк Чанг-хий-гийн хэрэг

Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуух шийтгэл

1995 оны 6 дугаар сарын 15-нд профессор Парк Чанг-хийг Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу ялласан. Түүнийг Японы оршин суугч солонгосын иргэн Сие Тай-су-тай уулзаж, түүнд “төрийн нууц”-ыг дамжуулсан, түүнээс мөнгө авсан хэрэгт яллажээ. Сие Тай-суг “төрийн эсрэг” байгууллагын тушаалыг авсан гэж яллажээ (Энэ нь үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу “төрийн эсрэг” байгууллага гэж тодорхойлсон хойд солонгосын засгийн газар гэсэн утгатай).

Профессор Парк Чанг-хийн Сие-Тай-Суд дамжуулсан “төрийн нууц” гэдэг нь хэдийн олон нийтийн эзэмшлийн мэдээлэлд орсон мэдээлэл байсан. Эдгээр нь Өмнөд солонгосын сонины хуулбар, ерөнхийлөгч Ким Яанг-сэмийн фото зураг, Өмнөд солонгос дахь оюутнуудын талаарх улс төр, хөдөлмөрийн шилжилтийн талаарх ярилцлагын агуулга зэрэг байсан юм.

Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу “төрийн нууц” гэдэгт Хойд солонгост ашигтай байж болох ямар ч мэдээлэл орж болно гэж тодорхойлогдсон. Энэ томъёолол нь Өмнөд солонгосын шүүхэд маш өргөн хүрээнд тайлбарлагддаг бөгөөд ямар утгатайг нь мэдэхэд маш хэцүү юм. Олон нийтийн эзэмшилд хамаарч буй мэдээлэл нь “төрийн нууц” гэж шүүхэд тооцогдох бөгөөд энэ тайлбар нь үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нь зөрчиж, Өмнөд солонгост өргөнөөр тархаад буй бусад мэдээллийг дамжуулсныхаа төлөө хүмүүсийг хориход хүргэсэн Үндэсний аюулгүй байдлын хуулийн дагуу авч үзэх хэргүүдийн шалтгаан болоод байна.

Их Британийн Умард Ирланд Нэгдсэн Вант улс

Англид Төрийн нууцын талаарх 1989 оны Акт голлох үүрэгтэй үйлчилдэг.

1989 оны Акт нь түүнчлэн төрийн мэдээллийн тодорхой хэлбэрүүдийг хууль бусаар олж авах явдлаас урьдчилан сэргийлэх үндсэн зорилгын хүрээнд, мөн 1911 оны актын нэгэн хэсэг болсон арга хэрэгслээс бусад аргаар албан тушаалтан бусад этгээдүүд мэдээллийг эрх мэдэлгүйгээр задруулахаас урьдчилан сэргийлэх үндсэн агуулгад гол анхаарлаа чиглүүлдэг.

1989 оны Акт нь 1911 оны Төрийн нууцын талаарх Актын 2 дугаар хэсгийн Шинэчлэлийн хүрээнд батлагдсан. Шинэчлэлийн үндсэн агуулга нь төрийн мэдээллийг эрх мэдэлгүйгээр задруулах явдал нь гэмт хэргийн шинжтэй болохыг тодорхойлсон. Засгийн газраас санал болгож буй зорилго нь одоогийн хуулийн хүрээг нарийвчлах, улмаар төрийн мэдээллийг эрх мэдэлгүйгээр задруулах нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй болохыг тодорхой илэрхийлсэн.

Төрийн нууцыг илүү сайн хамгаалахын тулд энэхүү Акт нь эрх мэдэлгүйгээр бичиг баримтыг задруулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах төрийн албан хаагч болон Хатан хааны албан хаагчид үүргээ үл биелүүлэх, хууль бусаар бичиг баримтад хориг тавих нь гэмт үйлдлийн шинжийг бий болгох явдлыг бүрдүүлжээ.

1989 оны Төрийн нууцын Актаар хамгаалагдсан мэдээллийн 4 ангилал байна. Үүнд:

- Аюулгүй байдал, тагнуултай холбоотой мэдээлэл
- Батлан хамгаалахтай холбоотой мэдээлэл
- Олон улсын харилцаа, гадаад улс орон, олон улсын байгууллагаас ирсэн нууц, итгэмжит мэдээлэл
- Гэмт хэрэг, тусгай мөрдлөгийн бүрэн эрхтэй холбоотой мэдээлэл

Аюулгүй байдал, тагнуул

Энэ сэдэвт орж буй аюулгүй байдал, тагнуултай холбоотой гэдэгт аюулгүй байдал, тагнуулын ажиллагаа, түүний нэг хэсэг, түүнд дэмжлэг үзүүлж буй ажил зэрэг нь хамаарна. Аюулгүй байдал, тагнуултай холбоотой мэдээлэлд эдгээр ажиллагаагаар болон дэмжлэг үзүүлж буй хүмүүс, бусад этгээдийн шилжүүлсэн болон тэдгээрт байгаа мэдээлэл хамаарна.

1989 оны Акт нь аюулгүй байдал, тагнуулын ажиллагаа гэж юу болохыг тайлбарлаагүй байдаг. Гэхдээ бичигдмэл хуулиар дараах ажиллагааг оруулж болохоор заадаг. Үүнд: Аюулгүй байдлын ажиллагаа, Нууц тагнуулын ажиллагаа, Төв штабын Ерөнхий нийгэмлэгийн ажиллагаа.

Батлан хамгаалах

Батлан хамгаалахтай холбоотой мэдээллийн ангилалд орсон асуудлууд нь хэмжээ, хэлбэр, зохион байгуулалт, байлдааны тушаал, ажиллагаа, төрийн бэлэн байдал, Хатан хааны зэвсэгт хүчний сургалт; зэвсэг, хадгалалт, хүчний бусад зэвсэг, түрэмгийлэн эзлэлт, үүнтэй холбоотой судалгаа; батлан хамгаалах бодлого, стратеги, цэргийн

төлөвлөгөө, тагнуул; дайны үед хэрэг болох үйлчилгээ, чухал хангамжийг дэмжих арга хэрэгсэл, төлөвлөгөө.

Олон улсын харилцаа

Олон улсын харилцаа нь улс хоорондын, олон улсын байгууллага хоорондын, нэг болон хэд хэдэн улс хооронд, нэг болон хэд хэдэн ийм байгууллага хоорондын харилцааг агуулж, мөн өөр нэг улс, олон улсын байгууллагатай харилцаж буй Нэгдсэн вант улсын харилцаанд нөлөөлөх чадвартай олон улсын байгууллага, Нэгдсэн Вант улсаас бусад улстай холбоотой ямар нэг мэдээлэл хамаарахаар тодорхойлогдсон байна. Олон улсын байгууллага гэж зөвхөн улсууд л гишүүнээр элсдэг байгууллагыг ойлгох бөгөөд ийм байгууллагын ямар нэг салбарт мөн хамааралтай байна.

Гэмт хэрэг, тусгай мөрдлөг

Энэ дөрөв дэх ангилал нь нэлээд олон төрөлтэй. Үүнд эрх мэдэлгүйгээр задруулсан дараах мэдээлэл хамаарна:

1. гэмт хэрэг үйлдсэний үр дагавар
2. хууль ёсны үйлдлээс гадуур өнгөрөхөд дэмжлэг үзүүлж буй арга хэрэгсэл, хууль ёсны хамгаалалтад буй хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх бусад үйлдэл, ажиллагаа
3. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сэжигтэй этгээдийг яллах, цагаатгахтай харшлах үйлдэл

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь

1989 оны Төрийн нууцын талаарх акт нь Хүний эрхийн Европын конвенцийн 10 дугаар зүйлээр хамгаалагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд хөндлөнгөөс оролцох явдлыг хуульчилсан. 10/2/ дугаар зүйлээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэрэгжилтийг дараах байдлаар илэрхийлсэн:

Хуулиар тодорхойлогдсон, гэмт хэрэг, эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахын тулд, бусдын эрх, нэр хүндийг хамгаалахын тулд, нууц итгэмжит мэдээллийг хамгаалахын тулд, шүүхийн шударга байдал, бүрэн эрхийг дэмжихийн тулд ардчилсан нийгэм, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, олон нийтийн аюулгүй байдалд шаардлагатай байх зорилгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдал нь ял шийтгэл, хязгаарлалтууд, нөхцөл байдалд илрэлээ олж болно.

Төрийн нууцын Акт ба Мэдээллийн эрх чөлөөний тухай акт

Төрийн нууцын акт, Мэдээллийн эрх чөлөөний актын хоорондын харилцан нөлөөллийн үндсэн цэг нь 1989 оны Төрийн нууцын актын дагуу эн тэргүүний гэмт хэрэг гэж тодорхойлогдсон элемент болох мэдээллийг задруулахыг зөвшөөрөх утгыг илэрхийлнэ. Энэ нь мэдээллийн 4 ангилалд орсон мэдээллүүдийг хэлж байгаа юм. Энд эхний алхам нь ямар мэдээллийг задруулах тухай асуудал юм. Төрийн нууцын актаар хориглолтын заалтуудыг тогтоох эсэх асуудал гарч ирнэ. Дараах мэдээллийг задруулахыг Төрийн нууцын хуулиар хориглосон. Үүнд:

1. Аюулгүй байдлын ажиллагаа, түүний дагуу бий болсон мэдээллийг чөлөөлөх,

2. Үндэсний аюулгүй байдлыг батлан хамгаалах зорилгоор задруулахаас чөлөөлөгдөх шаардлагатай мэдээлэл,
3. Хатан хааны зэвсэгт хүчний аюулгүй байдал, үр нөлөөт байдал, хүчин чадал, колонийн хүчний хамтын ажиллагаа, Английн арлуудын батлан хамгаалалд хортой нөлөө үзүүлж болох мэдээлэл,
4. Олон улсын харилцаанд хортой нөлөө үзүүлж болох мэдээлэл,
5. Бусад улс, тодорхой олон улсын байгууллагаас ирсэн нууц итгэмжит мэдээлэл,
6. Тодорхой мөрдлөг, гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой мэдээлэл,
7. Хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл.



2. "ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ НӨХЦӨЛ БОЛОМЖ" СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2.1 Оршил

"Иргэний мэдээлэл олж авах боломж нөхцөл" судалгааг "Глоб Интернэшнл" төрийн бус байгууллаас АНУ-ын ЭСЯ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн "Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө" төслийн хүрээнд хийсэн юм.

Судалгааг судлаач, сэтгүүлч, жирийн иргэдээс бүрдсэн баг хийж гүйцэтгэв. Судалгааны баг Монгол Улсын Үндсэн хууль, соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрт тунхагласан иргэний мэдээлэлтэй байх эрх чөлөөний үзэл баримтлал, мөн чанарыг удирдлага болгож, мэдээллийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээ, зарчимд тулгуурлан ажилласан юм.

Лондон хот дахь 19-р зүйл байгууллага (ARTICLE 19) олон улсын хэм хэмжээ тогтоосон "Олон нийтийн мэдэх эрх: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хууль тогтоомжийн зарчим"⁹ боловсруулжээ. НҮБ-ын Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгч эдгээр зарчмыг 2000 онд тавьсан илтгэлдээ дэмжсэн.¹⁰ Эдгээр зарчмыг дараах байдлаар дүгнэн хэлж болно:

1. **Мэдээлэл аль болох нээлттэй байх:** Хууль тогтоомжид мэдээллийг боломжийн хэрээр дээд зэргээр нээлттэй болгох тухай заалт оруулах.
2. **Нийтлэх үүрэг:** Төрийн байгууллага нь өөрийн санаачилгаар үндсэн мэдээллээ нийтлэх үүрэгтэй
3. **Нээлттэй төрд дэмжлэг үзүүлэх:** Төрийн байгууллага нь нээлттэй төрд идэвхтэй дэмжлэг үзүүлнэ.
4. **Хамаарахгүй зүйлийн хүрээг хязгаарлах:** Үл хамаарах зарчмыг явцуу хүрээнд төрийн "ашиг сонирхол"-д "хохирол" учруулахгүй байх үүднээс тодорхойлох.
5. **Мэдээлэл олж мэдэх процесст дэмжлэг үзүүлэх:** Мэдээлэл авах хүсэлт шаардлагыг аль болох шуурхай, шударга биелүүлэх, мэдээлэл олгохоос татгалзсан тохиолдолд энэ шийдвэрийн эсрэг хараат бус байгууллагад хандан давж заалдах эрхээр хангах.
6. **Зардал:** Хувь хүний мэдээлэл хүсэх эрхийг хэт өндөр үнэ тогтоож хязгаарлах ёсгүй.
7. **Нээлттэй хурал:** Төрийн байгууллагын хурал нийтэд нээлттэй байх ёстой.
8. **Мэдээллийг нээлттэй болгох жишиг тогтоох:** Мэдээлэл боломжийн хирээр дээд зэргээр нээлттэй байх зарчимд үл нийцэх хууль тогтоомжийг өөрчлөх.
9. **Шүгэлдэгчийг хамгаалах:** Шүгэлдэгч буюу болж бүтэхгүй зүйлийн талаар мэдээлсэн этгээдийг хамгаалах ёстой.

9 Лондон 1999, 6 дугаар сар

10 Өөрийн гэсэн үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дэмжих болон хамгаалах тухай Тусгай илтгэгчийн илтгэл DOC. E/CN.4/2000/63, 2000 оны 1 дүгээр сарын 18, параграф 43

2.2. Судалгааны хэрэгцээ, шаардлага

“Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд...НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн” хэмээн НҮБ-ын Ерөнхий ассемблейн анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоолд заасан билээ.

Хүний эрхийг дээдэлдэг ардчилсан нийгмийн амин сүнс нь нээлттэй мэдээлэл юм. Тийм ч учраас мэдээллийг ардчиллын хүчилтөрөгч гэдэг. Мэдээлэл бол ардчилал, эрх чөлөө, шударга ёс, хөгжил дэвшлийн баталгаа билээ.

Манай улс иргэдийнхээ мэдээлэлтэй байх эрх, мэдээллийн эрх чөлөөг Үндсэн Хуулиар баталгаажуулсан. Иймд иргэддээ мэдээллээр үйлчлэх нь төрийн үндсэн үүргийн нэг юм.

Гэвч Монгол Улсад нээлттэй мэдээллийн соёл хэвшээгүй, төрийн байгууллагад мэдээллийг нууцлах хуучин сэтгэлгээ байсаар байгаа нь хөгжил дэвшилд саад учруулж байна. Ялангуяа төрийн нууц нэрээр иргэдэд ил байх ёстой энгийн мэдээллийг ч нууцалсаар байна.

Иймд иргэдийн төрийн байгууллагаас мэдээлэл олж авах боломж нөхцөлийг тодорхойлон судлах нь чухал юм.

2.3. Судалгааны зорилго

Судалгаа нь Монгол Улсад жирийн иргэний мэдээлэл олж авах боломж нөхцөлийг судалж, бодит дүр зургийг харуулах зорилготой байв.

Энэ явцад судалгааны баг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн ашиглалт хэр байгаа, иргэдэд нээлттэй, ил байх ёстой мэдээллийг төрийн байгууллагууд нууцалдаг эсэх, хэрэв нууцалдаг бол үндэслэл, шалтгааныг илрүүлэн тогтоох, мэдээлэл хүсэх, олж авах шатанд тохиолдож буй хүндрэл бэрхшээлийг тодруулах зорилт тавьсан болно.

2.4. Судалгааны арга

Судалгаанд төрийн байгууллагаас мэдээлэл хүсэн өдөөн тандах аргыг ашиглав. Судалгааны баг тухайн мэдээллийг эзэмшиж, хадгалж буй холбогдох байгууллагад хандан утсаар холбогдох, биеэр очиж мэдээлэл авах хүсэлт тавьсан юм. Хүссэн мэдээлэл дотор төрийн нууцад хамрагдах мэдээлэл ч байсан юм. Харин ийм мэдээллийг хайх, хүсэх нь хуулиар хатуу шийтгэл хүлээлгэх нөхцөл болдог тул судалгааны багийн хувьд тодорхой эрсдэл хүлээсэн болохыг тэмдэглэе. Тухайн хүссэн мэдээллийг заавал олж эзэмших нь судалгааны багийн зорилго байгаагүйг тэмдэглэх нь зүйтэй.

Судалгааны баг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг судлан мэргэжлийн хуульч, мэргэшсэн судлаачдаас зөвлөгөө авч судалгааны ерөнхий чиглэлийг тодорхойлсон билээ.

Дээрх нэр бүхий хуультай танилцах явцад урьд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжуудыг судлах шаардлага зайлшгүй гарсан тул “БНМАУ-ын нууцыг задруулбал хариуцлага хүлээлгэх тухай” БНМАУ-ын Их Хурлын тэргүүлэгчдийн 120-р зарлиг (1955.12.15); “Улсын нууц мэдээ баримтуудын жагсаалтыг тогтоох тухай” БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 521-р тогтоол (1955.12.08); түүний хавсралт “Улсын нууц бичиг баримтын товч жагсаалт зааврыг батлах тухай” БНМАУ-ын СнЗ-ийн 250-р тогтоол (1954.5.22) зэрэг бичиг баримтыг судлав.

Өдөөн тандах судалгаа хийхдээ судалгааны баг мэдээлэл хүсэх байгууллагыг сонгох, хүсэх мэдээллийн ангиллыг тодорхойлох шалгуурыг олон улсын хэм хэмжээнд тохируулан боловсруулсан юм.

Судалгааны баг төрийн байгууллагад хадгалагдаж буй дор дурдсан мэдээлэл иргэдэд нээлттэй байх ёстой гэж үзсэн юм.

1. Төрийн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны тухай зайлшгүй ил байх мэдээлэл
2. Төрийн байгууллагад хадгалагдаж буй олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, тэдний сэтгэл санаа зовоож буй мэдээлэл
3. Төрийн байгууллагад хадгалагдаж буй албан ёсны бичиг баримт
4. Төрийн байгууллагын албан хаагч, ажилтнуудын ажил үүрэгтэй холбоотой мэдээлэл

2.5. Судалгааны хугацаа, хүрээ

Судалгааг 2006 оны 7-р сарын 1-нээс хоёр сарын хугацаанд хийв. Судалгааны хүрээнд доорх нэр бүхий төрийн 13 байгууллагад хандаж мэдээлэл олж авахыг зорив. Үүнд:

- Тагнуулын ерөнхий газрын архив
- Батлан хамгаалах яамны архив
- Улсын мэргэжлийн хяналтын газар
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар
- Монгол Улсын Их Сургууль
- Гадаад харилцааны яамны архив
- Байгаль орчны яам
- Үндэсний аудитын газар
- Монгол банк
- Боловсрол соёл, шинжлэх ухааны яам
- УИХ-ын тамгын газар
- Улсын прокурорын ерөнхий газар, Нийслэлийн прокурорын газар
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба.

2.6. Мэдээллийн ангилал

Судалгааны баг төрийн нэр бүхий 13 байгууллагаас 15 төрлийн мэдээлэл олж авах хүсэлт гаргасан юм. Мэдээлэл нээлттэй, ил байх олон улсын хэмжээний зарчмуудыг үндэслэн Төрийн байгууллагуудаас хүсэх мэдээллээ дараах төрлүүдэд хувааж үзсэн болно.

Нийт 15 мэдээллээс:

- Иргэнд нээлттэй байх ёстой 12
- Төрийн нууц 3

Иргэнд нээлттэй байх ёстой 12 мэдээллээс:

- Олон нийтэд зайлшгүй ил байх ёстой мэдээлэл 3
- Олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл 6
- Олон нийтийн санаа зовниж буй мэдээлэл 2
- Хуулиар ил тод болох ёстой мэдээлэл 1

2.7. Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнд төрийн байгууллагаас ердөө 4 мэдээлэл олж авсан юм. Иргэдэд нээлттэй байх ёстой 12 мэдээллээс олж авсан 2, харин хуулиар төрийн нууц гэж хамгаалагдсан 3 мэдээллийн 1 нь нээлттэй болсон байв.

Төрийн байгууллага иргэдэд нээлттэй байх ёстой 9 мэдээллийг өгөхөөс татгалзсан байна. 3 мэдээллийг өгөхөөс татгалзаагүй боловч судалгааны багт өгөөгүй байна.

Мэдээллийн ангилал	Хүсэлтийн тоо	Авсан	Татгалзсан	Аваагүй
Зайлшгүй ил байх	3	2	1	
Олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн	6	1	3	2
Олон нийтийн санаа зовоож буй	2	0	2	0
Хуулиар ил тод болсон байх ёстой	1	0	0	1
Төрийн нууц	3	1	2	
Нийт	15	4	8	3

Төрийн байгууллагууд иргэнд нээлттэй байх ёстой 9 мэдээллийг өгөхөөс татгалзжээ. 3 мэдээллийг өгөхөөс татгалзаагүй боловч янз бүрийн шалтгаанаар судалгааны баг олж авч чадаагүй.

Мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгаан (9 мэдээллээс):

- Төрийн нууц гэсэн 6 (1)
- Байгууллагын нууц гэсэн 1
- Иргэд танилцаж байсан практик байхгүй 1
- Шалтгаангүйгээр татгалзсан 1
- Татгалзаагүй боловч олж авч чадаагүй мэдээлэл:
- Вэб сайтад байгаа гэсэн боловч байхгүй 1
- Судлаачдад төлбөртэй өгч болох, өндөр үнэтэй 1
- Шалтгаангүй 1

2.8 Хүссэн мэдээлэл, үр дүн

№	Ангилал	Хүссэн мэдээлэл	Хандсан газар	Үр дүн
1	Ил байх ёстой	Хүн амын хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд хийсэн сүүлийн шалгалтуудын материал	Улсын мэргэжлийн хяналтын газар	Татгалзсан Төрийн нууц учраас
2	Ил байх ёстой	2002 онд шинэчлэгдэн боловсруулсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд УИХ-ын гишүүд саналаа өгсөн байдал	УИХ-ын тамгын газар	Авсан (мэдээлэл веб-сайтад бий)
3	Ил байх ёстой	Агаар хөрсний бохирдлын судалгааны дүн	Байгаль орчны яам	Авсан (судалгааны дүн товхимол болон хэвлэгдсэн)
4	Ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл	МУИС-д хандиваар суралцаж буй оюутны тоо	Монгол Улсын Их Сургууль	Татгалзсан Байгууллагын нууц учраас
5	Ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл	1970-аад оны эхээр Югославын Ерөнхийлөгч Броз Тито БНМАУ-д айлчилсан айлчлалын үеийн протокол	Гадаад хэргийн яам	Татгалзсан нууц учраас
6	Ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл	1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч ноён Уэллсийн айлчлал	Гадаад хэргийн яам	Авсан Төлбөр шаардаагүй)
7	Ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл	МИАТ-т аудитын шалгалт хийсний тайлан	Үндэсний аудитын газар	Татгалзсан Веб сайтад бий гэсэн ч байгаагүй
8	Ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл	Гадаадад төрийн тэтгэлгээр сурч буй оюутнуудын талаарх мэдээлэл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Татгалзсан

9	Ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл	Сэтгүүлч Б.Ханддолгор, А.Эрдэнэтуяа нарыг шүүсэн шүүх хурлын тэмдэглэл	Улсын прокурорын ерөнхий газар	Аваагүй Судлаачид байгууллагын бичиг, төлбөр төлсөн тохиолдолд авч болно
10	Олон нийтийн санаа зовнисон мэдээлэл	Монгол Улсаас ОХУ-д төлөх их өрийг эцэслэн шийдсэн яриа хэлэлцээрийн тэмдэглэл	Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Татгалзсан Нууц биш боловч иргэд танилцаж байсан практик үгүй учир
11	Олон нийтийн санаа зовнисон мэдээлэл	Монгол Улсад жилд хичнээн хүнийг ямар журмаар цаазалдаг талаар мэдээлэл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	Татгалзсан Төрийн нууц учраас
12	Хуулиар ил болох ёстой мэдээлэл	Бэлэн мөнгө хэвлэх, устгах болон алт, эрдэнэсийн зүйл, бэлэн мөнгө тээвэрлэх зам, цаг хугацаа, хамгаалах хүч, хэрэгслийн тухай мэдээ, баримт бичиг	Монгол банк	Аваагүй Татгалзаагүй ч мэдээлэл өгөөгүй
13	Төрийн нууц	Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, номлол	Гадаад хэргийн яам	Авсан Төрийн нууц гэж татгалзсан ч номын хавсралт болон хэвлэгдсэн байсан
14	Төрийн нууц	Бодоо, Данзан нарыг цаазаар авсан тухай баримтууд	Тагнуулын ерөнхий газар	Татгалзсан Төрийн нууц учраас
15		1939-1945 оны дайны үеийн төлөвлөгөө, холбогдох баримтууд	Батлан хамгаалах яам	Татгалзсан Төрийн нууц учраас

2.9 Кейс

1) Тагнуулын ерөнхий газар

Тус газрын архивт орох хүсэлтээ илэрхийлэхэд жижүүр нь холбогдох ажилтныг дуудаж уулзуулав. Өнгөрсөн зууны эхний хагасын улс төрийн хэлмэгдүүлэлт, ялангуяа Монгол Ардын Намыг үүсгэн байгуулахад идэвхтэй оролцож явсан төр, нийгмийн зүтгэлтэн Бодоо, Данзан нарыг цаазаар авсан тухай баримтуудтай иргэний хувьд танилцах боломж байгаа эсэх талаар лавлахад тус газрын нэрээ хэлэхээс татгалзсан ажилтан «Манай архив иргэдэд нээлттэй. Гэхдээ зөвхөн улсын нууцад хамааралгүй болсон мэдээлэлтэй л танилцаж болно. Бодоо, Данзан нарыг цаазаар авсан процессын тухай мэдээллийг өгөх боломжгүй» гэсэн хариулт өгөөд хүсэлт гаргасан бичгийг маань буцааж өглөө.

2) Батлан хамгаалах яам

1939-1945 оны дайны үеийн төлөвлөгөө, холбогдох баримтуудтай танилцах хүсэлтэд Зэвсэгт хүчний төв архивын дарга Зоригт (утас 451249) «Улсын нууцад хамаарна. Мэдээлэл өгөх боломжгүй» гэсэн аман хариулт өглөө.

3) Улсын мэргэжлийн хяналтын газар

УМХГ-т хандан хүн амын хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд хийсэн сүүлийн шалгалтуудын материалтай танилцах хүсэлт тавихад «Улсын нууц» гэсэн хариулт өглөө. Өдөр тутмын «Ардын эрх» сониноор дамжуулан уг мэдээллийг авах оролдлого хийхэд мөн адил хариулт өгсөн байв.

4) Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Монгол Улсаас ОХУ-д төлөх их өрийг эцэслэн шийдсэн яриа хэлэлцээрийн тэмдэглэлтэй танилцах хүсэлтэд, «Ийм төрлийн мэдээлэлтэй иргэд танилцаж байсан практик байхгүй. Гэхдээ энэ нь үзэж болохгүй гэсэн үг биш. Их өрийн тухайд бол бүх материал ГХЯ-нд байгаа. Тийшээ ханд» гэсэн аман хариу өгөв. ГХЯ-ны архивын ажилтан Гантулга «Засгийн газрынханд байгаа. Манайд эдгээр материал ирээгүй» гэж хариуллаа. Өдөр тутмын «Өнөөдөр» сонины сэтгүүлчдээр уг баримттай танилцах оролдого хийлгүүлсэн боловч мөнөөх байдал давтагдав.

5) МУИС

Тус сургуульд хандиваар суралцаж буй оюутны тоог мэдэх хүсэлтэд санхүүгийн албаны ажилтан нь «Одоо хандивын оюутан авахаа больсон. Тэгээд ч байгууллагын нууц» гэсэн хариулт өгөв.

6) Гадаад хэргийн яамны архив

1970-аад оны эхээр Югославын Ерөнхийлөгч Броз Тито БНМАУ-д айлчилсан айлчлалын үеийн протоколтой танилцах хүсэлтэд ГХЯ-ны архивын ажилтан (утас 263196) «Судлаачид суугаад нууцын зэрэглэлгүй материалтай танилцаж болно. Гагцхүү

төлбөр төлөх ёстой. Хуулиар нууцын зэрэглэлд оруулаагүй бүх материал нээлттэй» гэв.

7) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба

Монгол Улсад жилд хичнээн хүнийг ямар журмаар цаазалдаг талаар мэдээлэл авах хүсэлтэд тус газрын тогтоол гүйцэтгэх газрын дарга, хурандаа Х.Уламбаяр «Төрийн нууцын жагсаалтаар энэ төрлийн мэдээлэл байнгын нууцлалын зэрэгт хамаардаг» гэсэн хариуг амаар өгөв.

8) Гадаад хэргийн яам

ГХЯ-ыг хоёр зорилготойгоор зорьсон юм. Энэ нь нэгдүгээрт, Төрийн нууцын хуулиар байнгын нууцлалд байх ёстой Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, номлол, хоёрдугаарт 1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч ноён Уэллсын айлчлалын талаар мэдээлэл цуглуулах байлаа. Хамгийн амар ажил нь ноён Уэллсын айлчлалын талаарх мэдээллийг олж авах байв. Гадаад хэргийн яамны архивын ажилтан Нэргүй (утас 262397) гэдэг хүнтэй уулзаж хэрэг зоригоо хэлэхэд уриалгахан аргагүй хавтастай хэрэг авчирч «Энэ мэдээллийг хүмүүс маш их сонирхож ирдэг. Харамсалтай нь тэр үед тэмдэглэл хөтөлдөггүй байсан. Ийм хэдхэн мэдээ бий. Айлчлалын тухай гэрэл зураг, бичлэг бий. Гэрэл зургийг тарифын дагуу мөнгө төлөөд хувилуулж болно. Бичлэгийг ч гэсэн мөн адил үзэж болно» гээд хэдэн зураг үзүүлсэн юм. Нэгэн дээр нь ноён Уэллс монгол дээл өмсчихсөн, инээмсэглэсэн, нүдэнд дулаахан хүн харагдана лээ.

Даяаршлын өнөө үед гадаад бодлогын үзэл баримтлал, номлолыг яагаад нууцалсныг бид ихэд сонирхсон юм. Уул нь улс орон бүр гадаад бодлогодоо ямар үнэт зүйлийг баримталж буйгаа ил тод зарлах нь зүйд нийцэх мэт. Энэ асуудлаар ГХЯ-ны хэд хэдэн хүнтэй уулзахад тодорхой хариулт өгч мэдэхгүй байсан. Яамны хамгаалалтын албаны ажилтан утсаар Хэвлэл мэдээллийн албатай холбож өгөхөд нэг эмэгтэй хэн болоод ийм нууц мэдээллийг сонирхож байгаа юм, ямар учиртай юм, үүнийг мэдэх шаардлагагүй ээргээр зааварлав. Харамсалтай нь хамгаалалтын албаны ажилтан хэн рүү, хэд гэсэн дугаар руу залгаж байгаагаа хэлээгүй учир би хэнтэй ярьснаа мэдээгүй хоцорсон юм. Ингээд хэд хэдэн хүнтэй холбогдсоны эцэст Бодлого төлөвлөлт, мэдээлэл, үнэлгээний газрын дарга Г.Төмөрчулуун гэдэг хүнтэй уулзахыг надад зөвлөв. Г.Төмөрчулуунтай уулзаж байхад олон улсын харилцаа судлаач Д.Баярхүү орж ирээд «Тэр баримтлал манай яамны цэнхэр номонд хэвлэгдчихсэн ш дээ» гэв. Ингээд намайг Гадаад хэргийн төв архивын С.Цэцэгмаа гэдэг хүн дээр аваачиж, би Гадаад хэргийн яамны цэнхэр ном гэгчийг 5000 төгрөгөөр худалдаж авсан юм. Төрийн нууц гэгдэх мэдээлэл номонд хавсралт болоод хэвлэгдчихсэн байгааг миний бие хараад ихэд гайхсан.

9) Байгаль орчны яам

Агаар хөрсний бохирдлын судалгааны дүнтэй танилцах зорилгоор БОЯ-ны байгаль орчин, байгалийн нөөцийн хэлтсийн мэргэжилтэн доктор М.Сарантуяатай уулзсан (265615) болно. Яг судалгааны дүн манай яам дээр байдаггүй, харин судалгааны мониторинг бий гээд надад 3 ширхэг ном өгөөд ашиглаж дууссаныхаа дараа эргүүлж өгөөрэй гэсэн.

10) Үндэсний аудитын газар

МИАТ-т аудитын шалгалт хийсэн дүнтэй танилцах зорилгоор Улсын аудитын газрыг зорилоо. ҮАГ-ын тамгын хэлтсийн шинжээч Я.Наранцэцэгтэй уулзахад сүүлийн үед МИАТ-т иж бүрэн аудитын шалгалт хийгээгүй, хамгийн сүүлд 1999 онд хийгдсэн, сүүлд хэсэгчилсэн шалгалтууд хийгдсэн гэлээ. Шалгалтын дүнгүүд манай газрын веб-сайтад байрлагдсан байгаа гэсэн боловч чухам ямар хаягаар орохыг мэдэхгүй байлаа. Ингээд веб хариуцсан ажилтан Ганхуяг удахгүй ажилдаа орно, тэр үед 261745 утсаар лавлаарай гэв.

ҮАГ-ын веб сайт руу <http://www.mnao.pmis.gov.mn> хаягаар орж, сонирхсон тайлангаа үзэж болох байна. Энэхүү сайтад 2002 оноос хойш хийгдсэн шалгалтын тайлангууд байрлагдсан аж. Гэвч тэрхүү веб-сайтад МИАТ-ыг шалгасан тухай мэдээлэл байсангүй.

11) УИХ-ын тамгын газар

УИХ-ын гишүүд тодорхой нэг хуульд саналаа өгсөн байдалтай танилцахаар УИХ-ын тамгын газартай холбогдсон юм. Тэгэхдээ 2002 онд шинэчлэгдэн боловсруулсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг сонгож авав. Ингээд сүлжээний инженер Эрдэнэбат гэдэг хүнтэй холбогдоход <http://www.parl.gov.mn/home.php?loc=detail.php&val1=pid&val2=20> хаягаар орж тэр мэдээллээ авч болохыг хэлсэн. Ер нь УИХ-ын веб-сайт цэгцтэй, мэдээлэл сайтай, дэлгэрэнгүй тэмдэглэлтэй санагдсан. Сүлжээний инженер түүнчлэн манай номын санд хурлын бичлэгүүд байдаг, чөлөөтэй үзэж болно, гэхдээ урьд өмнө нь иргэн тэр бичлэгийг үзэж байсан практик үгүй гэв.

12) Улсын прокурорын ерөнхий газар, Нийслэлийн прокурорын газар

Сэтгүүлчдийг шүүсэн, тэр дотроо Б.Ханддолгор, А.Эрдэнэтуяа нарын шүүх хурлын тэмдэглэлийг үзэхээр Сүхбаатар дүүргийн шүүх дээр очиж лавлахад шүүх хурлын материалууд Улсын прокурорын ерөнхий газрын архивт байгаа гэлээ. УПЕГ-ын Эрүүгийн хэргийн төв архивт очиж сонирхож буй асуудлаа хэлэхэд дарга зөвшөөрвөл болно гэв. Ингээд УПЕГЭХТА-ын дарга Хуяг гэдэг хүнтэй уулзахад (утас 324984) манай архивт 2002 оны 9-р сараас өмнөх материалууд хадгалагдаж байгаа, тэрнээс өмнөх материалууд Нийслэлийн прокурорын газрын архивт хадгалагдаж байгаа, таны сонирхсон мэдээлэл бол хувь хүний нууц учир өгч болохгүй, шүүх хурлын тэмдэглэлээр яах гэсэн юм гэлээ. Судалгааны зорилгоор ашиглах гэсэн юм гэхэд байгууллагаасаа албан бичиг авчир, тэгвэл болно гэв.

Үүний дараагаар НПГ-ын архивыг зорилоо. Тус архив даваа, пүрэв гаригт иргэдэд үйлчилдэггүй, мягмар гаригт 9-11 цаг, лхагва гаригт 14-18 цагт хүсэлт хүлээн авдаг, баасан гаригт 9-12, 14-16 цагт лавлагаа, материал олгодог. Өөрөөр хэлбэл иргэдэд бараг үйлчилдэггүй шахам газар ажээ. Долоо хоногт иргэдэд ердөө 11 цаг үйлчилдэг, үүний 6 цагт нь хүсэлт хүлээн авч, 5 цагт нь материал олгодог. 2004 оны 5-р сард хэрэг нь шийдэгдсэн А.Эрдэнэтуяагийн шүүх хурлын тэмдэглэлтэй танилцахаар төгсөх курсын оюутнаа явуулахад ямар зорилгоор сонирхож байгааг нь лавлажээ. Курсын ажил хийхэд хэрэгтэй гэхэд ийм сэдвээр курсын ажил бичиж байгаа гэсэн бичиг сургуулиасаа авчир гэв. Харин сургуулийн захирал, оюутан тийм сэдвээр курсын ажил бичнэ гэсэн бичиг дээр тамга дардаг журамгүй, харин энэ бол манай оюутан мөн гэсэн бичиг дээр тамга дарж болно гэж учирласан юм. Гэтэл оюутан маань тэр бичгийг барьж очиход

судалгаа, эрдэм шинжилгээний зориулалтаар архив ашиглахад 20 мянган төгрөг төлөөд шүүх хурлын тэмдэглэлтэй танилцаж болно гэв. Тэгэхдээ архив ашиглахыг хүссэн анкет бөглөж өгөх ёстой аж. Архив ашиглах зөвшөөрөл авахын тулд архивч Энхтуяа, Нийслэлийн прокурорын газрын тамгын хэлтсийн дарга Б.Дагвасүндэлтэй (утас 325582) уулзсан болно.

13) Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

БСШУЯ-аас гадаадад төрийн тэтгэлгээр сурч буй оюутнуудын талаарх мэдээлэл авахыг хүссэн. Гадаадын их, дээд сургуулиудыг хариуцсан мэргэжилтэн Мөнхбаттай (утас 263449) уулзахад бүх мэдээлэл БСШУЯ-ны веб-сайтад бий гээд өөр мэдээлэл өгөхөөс татгалзав.

14) Монгол банк

Монгол Улсын Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд «Бэлэн мөнгө хэвлэх, устгах болон алт, эрдэнэсийн зүйл, бэлэн мөнгө тээвэрлэх зам, цаг хугацаа, хамгаалах хүч, хэрэгслийн тухай мэдээ, баримт бичиг» нь «Маш нууц» зэрэглэлд хамаарах бөгөөд 5 жилийн хугацаатай нууцлагдах ёстой ажээ. БНМАУ-ын үед гүйлгээнд байсан мөнгөн тэмдэгтүүдийг хэрхэн устгасан талаарх мэдээлэл олж авахаар Монгол банкныг зорьсон болно. Хүсэлтийнхээ дагуу Монгол банкны бэлэн мөнгө судалгааны газарт өргөдөл бичсэн. Ийм мэдээллийг хувь хүнд өгөхгүй гэсэн учир МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимээс явж байна гэхэд хариуг дээрх хаягаар ирүүлнэ гэсэн. Мэдээж, хоёр долоо хоноход ямар ч хариу МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд ирээгүй. Хүссэн мэдээллээ авахаар Монгол банкинд дээр хэд хэд очихдоо албаны нэг ч хүнтэй уулзаж чадаагүй. Бүх асуудлыг ресепшнээр дамжуулан харилцаж байсан. Уул нь өргөдөл Монгол банкны бэлэн мөнгө, судалгааны газрын бичиг хэрэг хариуцсан ажилтан Ган-Очир гэдэг хүнээр (утас 318330, 313330) дамжин холбогдох албан тушаалтанд очих ёстой аж.

2.10 Судалгааны явцад тохиолдсон хүндрэл, бэрхшээл:

1. Хүнд суртлын шат дамжлага ихтэй (элдэв төрлийн бичиг шаардах, анкет бөглүүлэх, өргөдөл бичүүлэх г.м.) Иргэний хувьд төрийн байгууллагуудаас мэдээлэл авахад хаанахын ямар байгууллага төлөөлж буйг лавлах, хуулийн этгээдийн тодорхойлолт шаардах, уулзах захиалга өгөөд очиход тухайн албан тушаалтан ажлын байрандаа байхгүй байх, удаан хугацаагаар хүлээлгэн чирэгдүүлэх явдал түгээмэл байна. Сонирхсон асуудлаараа тодорхой албан тушаалтантай уулзах боломж сул ажээ (зарим албан газар ресепшнээр дамжих, эсвэл хамгаалалтын албаны ажилтан цаад хүнтэйгээ утсаар яриулах).

2. Иргэдээс бичгээр хүсэлт авч, сонирхсон мэдээлийнх нь тухай хариуг бичгээр өгөх соёл хэвшээгүй тул хэн нэгэн албан тушаалтан амаар хариу өгдөг, бичгээр хариу өгөхийг хүсэхэд «Бид таны хүсэлтэд зохих хариуг нь өгчихлөө шүү дээ. Бичиг цаасны хэрэг юу байна» гэж гайхшрах нь түгээмэл ажиглагдлаа.

3. Архивууд аливаа мэдээллийг төлбөртэй өгдөг болсон нь зарим иргэдийн хувьд бодитой хүндрэл учруулж байна. Төлбөрийн үнэ тарифыг үндэсний архивын газраас баталсан журмын дагуу тогтоодог гэх боловч харилцан адилгүй байх нь ажиглагдав.

4. Улс хоорондын яриа хэлэлцээр зэрэг томоохон асуудлыг иргэд сонирхож, танилцах, үзэхийг хүсдэггүй учраас зарим газар (ялангуяа Засгийн газар, УИХ-ын түвшинд)-ын албан тушаалтнууд урьд өмнө нь ийм практик байхгүй гэж гайхшрах, эргэлзэх явдал ажиглагдаж байна.

5. Төрийн нууцын тухай хууль нь хэтэрхий өргөн хүрээг хамарснаас, нөгөө талаар төрийн нууцыг задалсан тохиолдолд учруулсан хохирлыг нь эс харгалзан эрүүгийн хэрэг үүсгэх хууль эрх зүйн орчин үйлчилж байгаа учраас аливаа мэдээллийг өгөхөөс зайлсхийж, элдэв тайлбар хийх явдал элбэг байна.

6. 2004 онд батлагдсан Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль нь гарсан өдрөөсөө хойш хүчин төгөлдөр гэж үзвэл өмнөх нууцлагдсан баримтуудыг ямар хууль эрх зүйн үндэслэлээр нээлттэй болгох вэ гэдэг асуудал орхигдсон байгаа тул 70-80 жилийн өмнөх Бодоо, Данзангийн хэрэг хүртэл хаалттай хэвээр байгаа парадокс ажиглагдав.

7. Албан тушаалтан бүр ямар учраас ийм мэдээлэл сонирхож буйг хууль мэт асууж шалгаана. Ер нь л албан тушаалтнууд ямар учиртай хүн яах гээд ийм юм сонирхоод байдаг юм бэ гэсэн уцаарлангуй өнгө яасаар (ялангуяа утасны цаанаас) тээршаасан янзтай хүлээн авдаг нь гэм биш зан болжээ.

8. Хэрэв тухайн мэдээлэл ном, товхимол болон худалдаанд гарсан бол мэдээлэл өгөхөөс татгалзах нь харьцангуй бага байна. Учир нь түүнийгээ борлуулах нь ашигтай.

9. Олон албан тушаалтан веб гэдэг бүх юм байдаг нэг юм бий гэсэн ойлголттой, өөрсдөө ч түүнийхээ хаягийг мэддэггүй атлаа вебэд байгаа, веб рүү ор гэдэг моод дэлгэрчээ. Яг шаардлага хангасан мэдээлэлтэй веб цөөн юм. Зарим вебийг ашиглахад хүндрэлтэй. Тухайлбал УАГ-ын вебэд байрлуулсан шалгалтын дүнтэй танилцахын тулд заавал Adobe Acrobat Reader программыг интернетээс татаж авах шаардлагатай. Дундаж хурдтай буюу удаан сүлжээтэй газар энэ программыг татаж авахын тулд 1-4 цаг шаардагдах аж. Албан газрууд ихэвчлэн сүүлийн хэдэн жилд л вебтэй болсон байх

бөгөөд ихэнхдээ 2000 оноос өмнөх мэдээлэл тэнд байхгүй. Өмнөх мэдээллийг хаанаас яаж олох нь тодорхойгүй.

10. Зарим албан тушаалтан хариуцсан ажлаа сайн мэдэхгүй байна. Монгол Улсын гадаад бодлогын номлол, баримтлалыг сонирхоход ГХЯ-ны хэвлэл мэдээллийн албаны ажилтан ийм нууц мэдээллээр яах гэсэн юм гэж байхад тэр нь яамных нь «Цэнхэр ном»-нд хэвлэгдчихсэн байх жишээтэй.

11. Албан газруудын архив иргэдэд үйлчилдэггүй нь жигтэй санагдлаа. Харин төлбөр аваад судлаачид үйлчилж байна. Иргэн хүн тодорхой зорилгогүйгээр сонирхлынхоо журмаар ямар ч мэдээлэлтэй танилцаж болохгүй аж. Мэдээлэлтэй танилцахын тулд заавал судлаач болж, аль нэг албан байгууллагаас тамга тэмдэг бүхий бичиг авчирч, бас дээр нь багагүй хэмжээний мөнгө төлөх ёстой болж байгаа юм.

2.11. Дүгнэлт

Олон улсын хуулиар үндэсний аюулгүй байдал, хувийн нууц, бусад зарим ашиг сонирхлыг мэдээллийн чөлөөт урсгалыг хязгаарлах хууль ёсны үндэслэл болгохыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Судалгааны баг Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактын 19-р зүйлд заасан “үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын нэр төрийг зөрчсөн” зэрэг үндэслэлд харшлаагүй мэдээллийг төрийн байгууллагаас хүссэн юм.

Судалгааны дүн Монголд энгийн иргэдийн мэдээлэл олж авах эрх туйлын хязгаарлагдмал байгааг харуулав.

Төрийн нууцтай холбоотой хуулиудаар олон нийтийн ашиг сонирхол, тэдний санаа зовоосон мэдээллийг үндэслэлгүй нууцалж байна. Иргэдэд нээлттэй байх ёстой энгийн мэдээллийг ч төрийн нууцын халхавч дор нууцалж байгаа нь харагдав.

Мэдээлэлтэй байх эрх бүх иргэнд адил тэгш үйлчлэхгүй байна

Эцэст нь тэмдэглэхэд, төрийн нууцтай холбоотой хуулиуд нь орчин үеийн хөгжлийн шаардлагад нийцэхгүй, ардчилал, хүний эрхийн мөн чанар, зарчмуудад харшилж байгаа тул нэн даруй өөрчлөх шаардлагатай байна.

Монгол Улсын төр Үндсэн Хууль, бусад хууль, Засгийн газрын Мөрийн хөтөлбөр, Үйл ажиллагааны төлөвлөгөө, Хүний эрхийн, Авилгын эсрэг зэрэг үндэсний хөтөлбөр, Улаанбаатарын Тунхаглал зэрэг баримт бичигт амалсан ёсоор ил тод засаглалыг хангах, Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлах, нууцын хуулиудад өөрчлөлт оруулах амлалтаа хэрэгжүүлэх талаар шуурхай арга хэмжээ авахыг шаардаж байна.



3. "ӨӨРЧЛӨЛТӨД ДУУДАХ НЬ" УРИАЛГА

УИХ-ын гишүүний хувьд ТА үүнийг хийж чадна!

Аюулгүй байдлын бодлогод иргэний нийгмийн саналыг харгалзан үзэх:

- Үндэсний аюулгүй байдал, түүнтэй холбоотой асуудлаар өөрийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн саналыг харгалзан ашигтай байдлаар тусгах механизмыг УИХ-д бий болгох,
- Үндэсний аюулгүй байдал, түүнтэй холбоотой асуудал хариуцсан байнгын хороо, дэд хорооны ажилд тус дэмжлэг үзүүлэх зорилгоор зохих үйл ажиллагаа явуулах чадвар бүхий байгууллага, ТББ, ХМХ-ийг дэмжих хууль тогтоомж батлах ажлыг зохистой нөхцөлд дэмжих,
- Аюулгүй байдал, мөн энэ салбарт хамаарагдах асуудлаар шийдвэр гаргахдаа олон нийттэй идэвхтэй хамтран ажиллах бодлого баримтална.

Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулж, хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих:

- Аюулаас хамгаалах асуудалд хамаатай ямар нэг хязгаарлалт байгаа тохиолдолд олон улсын хүний эрхийн зарчмыг хөндөхгүй байхад анхаарал хандуулах,
- Мэдээллийн эрх чөлөөний хуулийг батлагдсан байх,
- Төрийн нууцын хуулийг мэдээллийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэн батлах.

УИХ иргэдийн төлөөллийн эрх мэдлийн хувьд үндэсний аюулгүй байдлыг хангахад дараах зүйлд анхаарал хандуулан ажиллах нь илүү үр дүнд хүргэнэ.

1. Иргэний нийгмийн байгууллагыг аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд татан оролцуулах

Иргэний нийгэм бол ардчиллын үйл явцад маш чухал ач холбогдолтой, ардчиллын гол илэрхийлэл, үндсэн шалгуур болдог. Иргэний нийгмийн бүлэглэлүүд нь аюулгүй байдлын асуудалтай холбоотой шийдвэр гаргах, бодлого боловсруулахад идэвхитэй оролцож чадна. УИХ, Засгийн газар улс орны аюулгүй байдал, зэвсэгт хүчин, цагдаа, тагнуулын байгууллагын талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт ТББ, судалгааны байгууллагыг татан оролцуулахыг дэмжих ёстой.

Төрийн бус байгууллага, судалгааны байгууллагууд нь аюулгүй байдлын салбарт парламентийн ардчилсан хяналтыг сайжруулахад дараах байдлаар хувь нэмрээ оруулж болно. Үүнд:

- Аюулгүй байдлын салбар, цэргийн асуудлууд, батлан хамгаалах талаарх мэдээлэл, бие даан хийсэн судалгаа зэргийг парламент, мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд хүргэх;
- Аюулгүйн салбарт хууль тогтоох, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх ажиллагааг хянах, урамшуулах;
- Нийгэмд бүхэлд нь хамаатай аюулгүй байдлын энэхүү чухал асуудлуудыг улс төрийн хэлэлцэх асуудлын нэг болгох;
- Сургалт, семинар явуулснаар парламентийн мэдлэг, ур чадварыг бий болгох чадавхийг нэмэгдүүлэх;

- Аюулгүй байдлын салбарын бодлого, батлан хамгаалах төсөв, төсвийн бүрдэлт, эх сурвалжийг бий болгоход засгийн газрын баримталж байгаа бодлогын талаар мэргэжлийн хүмүүст өөр өөр санал бодол хэлэх боломж олгох, олон нийтийн хэлэлцүүлэг хийх, бодлогын чанартай асуудлаар өөр боломжтой хувилбарыг бий болгох;
- Үндэсний аюулгүй байдлын бодлогын талаар гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийг хэлэлцэх;
- Олон нийтийн боловсролыг сайжруулах, олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудалд ард түмний альтернатив хэлэлцүүлэг явуулах.

2. Хараат бус хэвлэл, мэдээллийн үр нөлөөг дээшлүүлэх

Хараат бус мэдээллийн хэрэгсэл нь олон нийт, тэдний улс төрийн төлөөлөл мэдээлэл сайтай байж шийдвэр гаргахад тус дэмжлэг болдог. Мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдлын салбарын ардчилсан хяналт, ил тод байдлыг сайжруулах, аюулгүй байдлын асуудлаар олон нийттэй харилцаатай байхад нь УИХ-д тусална.

Ардчилал, сайн засаглалын үүднээс авч үзвэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл аюулгүй байдлын талаарх асуудлаар олон нийтийн ашиг сонирхол бүхий мэдээлэл цуглуулах, түгээх эрхтэй бөгөөд мэдээлэл нь үнэн зөв, нягт нямбай, шударга байх ёстой.

3. Бичиг баримтыг олон нийтийн хүртээл болгох нь

Сайн засаглалын зарчмын дагуу парламентийн түвшинд хэлэлцэж буй гол асуудлуудын талаар олон нийт мэдээлэлтэй байснаар ардчилсан хяналт үр өгөөжтэй байна.

Аюулгүй байдлын салбарт олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй байж болох төрөл бүрийн мэдээлэл, мэдээ баримт, бичиг баримтыг ойлгомжтой хэлбэрээр түгээх. Доорх бичиг баримт нээлттэй байж болох юм. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлын бодлого зэрэг стратегийн ач холбогдол бүхий бичиг баримтууд;
- Батлан хамгаалах төсөв (нууц төсвийг хамруулалгүйгээр);
- УИХ-аар хэлэлцсэн аюулаас хамгаалах салбартай холбогдол бүхий голлох хэлэлцүүлэг, шийдвэр, санал, хууль тогтоомжийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацсан мэдээ мэдээлэл;
- Аюулгүй байдлын салбарын асуудлаарх УИХ, Байнгын хорооны хуралдаан, хэлэлцүүлгийг (хаалттай хуралдаанаас бусад) дамжуулан мэдээлэх, ингэхдээ хаалттай хуралдаанаар хэлэлцэх асуудал, болох цаг хугацааг мэдээлэх,
- Аюулгүй байдлын асуудлаарх УИХ-ын шалгалтын тухай мэдээ, мэдээлэл,
- Аюулгүй байдлыг хангах албадын үйл ажиллагаа хэрхэн явагдаж буй талаар гаргасан УИХ-ын жилийн илтгэл, тайлан,
- Аюулгүй байдлын салбарын талаар ерөнхий аудитын тавьсан тайлан. Ингэхдээ зарим нэг онцгой үйл ажиллагааны тухай илтгэлийг оруулахгүй байж болох ба дээрх илтгэлийг сонгогдсон хороодод өгөхийг шаардах, ерөнхий аудитын тайлангийн дагуу Засгийн газраас авсан арга хэмжээний жагсаалт,
- Олон улсын, улс хоорондын гэрээний талаарх мэдээлэл,

- Аюулгүй байдлын асуудлын талаар (төсөв, олон улсын байгууллагын гишүүн болох, цэрэг татлага, цэргийн зориулалттай худалдаа г.м.) УИХ-ын гишүүн, жигүүр тус бүрийн санал өгсөн байдлын тухай мэдээлэл,
- Мэдээллийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомжийг батлах.

4. УИХ-ын үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах

Зөвхөн УИХ-аас, эсвэл Засгийн газраас олон нийт рүү хандсан нэг талын урсгалтай мэдээллийн үр өгөөж муу байдаг. Тиймээс олон нийтэд аюулгүй байдлын асуудлаар өөрсөдтэй нь санал солилцох боломжийг УИХ бий болгох шаардлагатай. Хоёр талын мэдээлэл, харилцаа холбоо дараах үр дүнд хүргэнэ.

- Олон нийтийн оролцоо, байнгын хяналтыг бий болгоно.
- Парламентийн үйл ажиллагаанд олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.
- Удирдлагын буруутай үйл ажиллагааг хянах боломжтой болно.
- Хууль тогтоомж, төр засгийн бодлогыг хууль ёсны болгон, олон нийтийн дэмжлэг авахад дөхөмтэй болгож, ардчиллыг тогтворжуулна.

Хоёр талын мэдээллийн харилцааг УИХ-ын мэдээлэл, сонсгол хийх, мэдээллээр хангах ажиллагааг хянах, телевизийн ярилцлага хийх, УИХ-ын судалгааны албанаас тухайлан бэлтгэсэн мэдээллийг хороодын гишүүдэд түгээх зэрэг хэлбэрээр бий болгож болно.

Уриалгыг Монгол Улсын Үндсэн Хууль, ил тод байх талаар авсан Монголын Засгийн газрын амлалтууд, энэ төслийн үйл ажиллагааны үр дүн, Парламент хоорондын холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих төвөөс хамтран Парламентийн гишүүдэд зориулан хэвлэсэн гарын авлагыг иш үндэс болгон боловсруулж, “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө” дугуй ширээний ярилцлагад оролцогсад бид УИХ-ын гишүүдэд хандан ӨӨРЧЛӨЛТӨД ДУУДАЖ БАЙНА.

Улаанбаатар хот
2006.12.20



ХЭВЛЭЛД БЭЛТГЭСЭН:

Х.Наранжаргал

Д.Мөнхбүрэн

“ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ САН”-д эхийг бэлтгэж хэвлэв.

Хэвлэлийн хуудас: 16/1, 9

Хэвлэсэн тоо: 600